

# ЕСҮСИЙН АМЬДРАЛ БА ҮЙЛЧЛЭЛ

Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй Христэч удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Курс хичээлийг боловсруулсан: Др. Рэндэлл Д. МакЕлвэйн

Зохиогчийн эрх © 2023 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх Гурав дахь хувилбараас монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, А. Ариунаа

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Гуравдагч талын материалууд нь тус тусын зохиогчийн эрх болон зөвшөөрөлтэй.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2013 хувилбараас ашиглав.

### **Зөвшөөрөлтэй холбоотой заавар:**

Дараах зааврын дагуу энэхүү курс хичээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1) Хичээлийн агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2) Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3) Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү хичээлийг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4) Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр хичээлийг орчуулж болохгүй.

# Гарчиг

Курсын тойм.....	5
(1) Үйлчлэлд бэлтгэгдэх нь .....	7
(2) Есүстэй адил залбирах нь .....	25
(3) Есүстэй адил удирдах нь.....	41
(4) Есүстэй адил зааж сургах нь .....	59
(5) Есүстэй адил номлох нь .....	77
(6) Есүс ба Бурханы хаанчлал .....	91
(7) Есүстэй адил хайрлах нь.....	111
(8) Загалмай ба Амлал .....	129
(9) Өв үлдээх нь.....	153
Хаанчлалын сайнмэдээ (номлол).....	169
Санал болгох эх сурвалжууд.....	179
Даалгаврын тэмдэглэл.....	181



# Курсын тойм

Энэхүү курс хичээлээр Есүсийн амьдрал, үйлчлэлийг өнөөгийн амьдрал, үйлчлэлийн үлгэр дуурайл болгон суралцана. Ингэхдээ Сайнмэдээний номуудыг бүхэлд нь авч үзэхгүй ч, Есүсийн үйлчлэлийг харуулдаг тодорхой хэсгүүдээс суралцаж, өнөөгийн үйлчлэлдээ сургамж авах болно. Хэрэв та Христийн амьдралыг илүү дэлгэрэнгүй судлахыг хүсвэл номын ард байрлах “Санал болгох эх сурвалжууд” хэсэгт жагсаасан номуудыг үзнэ үү.

Хэрэв та бүлгээр суралцаж байгаа бол материалыг ээлжлэн уншиж болно. Ингэхдээ үе үе зогсож, ангийн хэлэлцүүлэг хийгээрэй. Ангийн удирдагчийн хувьд та судалж буй материалаас гадуур яриа өрнүүлэхгүй байхад анхаарах үүрэгтэй. Хэлэлцүүлэг бүрд тодорхой хугацаа зааж өгөх нь тустай.

**Хэлэлцүүлгийн асуултууд** болон **ангийн үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Та эдгээрийн аль нэгэнд оролцохдоо холбоотой асуулт (ууд)-ыг асууж, суралцагчид хариулж ярихад нь туслаарай. Утга учиртай яриа, хэлэлцүүлэгт цаг гаргана уу. Үүнгүйгээр суралцагчид Есүсийн үйлчлэлээс суралцахдаа өнөөгийн үйлчлэлтэйгээ холбож чадахгүй байж магадгүй юм.

Курсын туршид **Бичвэрийн** олон багц эшлэлүүдийг үндсэн хэсэгт болон зүүлт тайлбар хэсэгт жагсаасан байгаа. Ангид чангаар унших эшлэлүүдийг мөн ► тэмдгээр тэмдэглэсэн. Суралцагчид урт багц эшлэлүүдийг хичээлээс өмнө уншсан байх хэрэгтэй. Харин богино хэсгүүдийг ангид уншина.


**“Сайтар ажиглах нь”** гарчигтай хэсэг нь хичээлийн хэлэлцүүлэгтэй холбоотой тусгай сэдвүүд рүү хандуулна.

Хичээл бүрд нэгээс хоёр **даалгавар** өгөгдөнө. Хэрэв суралцагч нь **Shepherds Global Classroom** байгууллагаас **гэрчилгээ авахыг** хүсвэл тухайн хичээлүүдэд хамрагдаж, даалгавруудаа бүрэн хийсэн байх шаардлагатай. Курсын төгсгөлд даалгавруудаа бүрэн хийснийг тэмдэглэх маягт хавсаргасан байгаа.

Энэхүү курсын нэг зорилго нь суралцагчдыг багш болоход бэлтгэх юм. Ангийн удирдагч нь суралцагчдад заах ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгох хэрэгтэй. Жишээлбэл, ангийн удирдагч нь хичээлийн богино хэсгийг үе үе суралцагчдаар заалгаж болох юм.

## Израилын газрын зураг<sup>1</sup>

- (1) Тир
- (2) Цезарь Филипп
- (3) Галил (бүс нутаг)
- (4) Канаа
- (5) Капернаум
- (6) Назар
- (7) Декаполь (бүс нутаг)
- (8) Самари (бүс нутаг)
- (9) Йордан гол
- (10) Еммау
- (11) Йерусалим
- (12) Бетлехем
- (13) Эргийн нутгууд
- (14) Төвийн өндөрлөг газрууд
- (15) Иудейн цөл
- (16) Сөнөсөн тэнгис
- (17) Галил нуур
- (18) Газар дундын тэнгис



---

<sup>1</sup> “Израилын газрын зураг”-ийг SGC байгууллага NED, SRTM, NASA болон Bible Geocoding (CC BY 4.0) зэрэг нээлттэй мэдээллийн санг ашиглаж бүтээсэн болно. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.flickr.com/photos/sgc-library/52344178339>, public domain (CC0) вебсайтаас үзэх боломжтой.

# 1-р хичээл

## Үйлчлэлд бэлтгэгдэх нь

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Бидний үйлчлэлийн үлгэр дуурайл нь Есүс гэдгийг таньж мэдэх болно.
- (2) Өөрийн дуудсан хүмүүсээ бэлтгэдэг Бурханы хэмжээлшгүй эрх мэдэлд талархах болно.
- (3) Бурхан өөртөө сонгосон үүрэг хариуцлага бүхий дуудлагад нь буулт хийх болно.
- (4) Сорилтыг ялан дийлэх Есүсийн арга замыг дагана.

### Хичээлд бэлтгэх

*Матай 1-4, Лук 1-3 болон Иохан 1-р бүлгүүдийг унших.*

### Үйлчлэлийн зарчим

Бурхан дуудсан хүмүүсээ дуудсан үйлчлэлд нь бэлтгэдэг.

### Танилцуулга

Энэ курсээр бид Есүсийг өнөөгийн үйлчлэлийн үлгэр дуурайл болгон суралцах болно. Есүс “Миний та нарт үйлдсэн лугаа адил та нарыг үйлд хэмээн Би ийм дуурайл өгөв” (Иохан 13:15) хэмээжээ. Есүсийн дэлхий дээрх амьдрал дагалдагчдад нь үлгэр дуурайл болсон.

Паул энэ зарчмыг ойлгосон. Филиппой хотын итгэгчид хоорондоо зөрчилдөж байгааг сонсоод Паул Есүсийн жишээг онцлон тэмдэглэжээ. “Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай” (Филиппой 2:5). Хэрэв эдгээр Христэд итгэгчид Есүсийн үлгэр дуурайлыг дагавал, тэдний даруу байдлаар чуулган дахь зөрчил шийдвэрлэгдэнэ гэдгийг Паул мэдэж байсан.

Еврей сэтгүүлч Давид Плоцыг Африк руу аялж явахад онгоц нь Малавийн нисэх буудалд саатжээ. Тэнд нэгэн Африк пастор Плоцтой танилцаж, гэртээ аваачин, хоёр өдрийн турш цай хоолоор дайлж зочлохдоо түүнд Есүс Мессиагийн талаар гэрчлэн ярьжээ. Хожим нь Давид Плоц “Би энэ хүний итгэдэг аль ч зүйлд нь итгэдэггүй, гэхдээ түүний итгэл үнэмшил нь намайг бишрүүлсэн. Түүний дотор Христ хөдөлж байгааг мэдэрсэн. Тийм ч учраас тэр харийн хүнийг хүлээн авч, гэртээ зочилж, хооллож хувцасласан юм” хэмээн өгүүлжээ. Бид Есүсийн үлгэр дуурайлыг дагахаар дуудагдсан гэдгийг энэ Африк пастор ойлгосон байлаа.

Энэ курс нь Есүсийн амьдралыг цогцоор нь судлах хичээл биш, харин өнөөгийн бидний үйлчлэлд үлгэр дуурайл болох Есүсийн амьдралын хэсгүүдэд төвлөрч суралцана. Бид Есүсийн үлгэр дуурайлаар үйлчлэлээ хэрхэн хийхийг сурах болно.

Энэхүү эхний хичээлээр Есүсийн үйлчлэлийн бэлтгэл үеэс суралцана. Энэ нь Бурхан дуудсан хүн бүрээ дуудсан үйлчлэлдээ бэлтгэдэг зарчмыг харуулдаг.

### **Бурхан өөрийн Зарцыг гэр бүлийн нөхцөл байдалд нь бэлтгэсэн.**

► Гэр бүлийнхээ гарал үүсэл, бага насны амьдралаа бодож үзээрэй. Бурхан таны амьдралын өнгөрсөн туршлага, гарал үүслийг хэрхэн үйлчлэлд бэлтгэхэд ашигласан бэ?

Сайнмэдээн дэх угийн бичгүүд нь хэмжээлшгүй эрх мэдэлтэй Бурхан Есүсийг төрөхөөс олон зуун жилийн өмнөөс Зарцынхаа замыг бэлтгэж байсныг харуулдаг. Есүсийг төрөхөөс өмнө Бурхан түүний ирэх замыг бэлдсэн юм.

Угийг бичгүүд нь “Есүс хэн байсан бэ?” гэсэн асуултад хариулдаг бөгөөд Абрахам, Давидын ач холбогдлыг тусгадаг. Абрахам нь Есүсийн удам угсаанд чухал байр суурь эзэлдэг. Учир нь Бурхан “Газар дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно” (Эхлэл 12:3) хэмээн Абрахамд амлажээ. Энэхүү амлалт нь Назарын Есүсээр дамжин биелсэн юм.

Давидын сэнтий мөнхөд тогтоно хэмээн Бурхан амласан учраас угийн бичигт Давид чухал байр суурийг эзэлдэг (2 Самуел 7:16). Давид хаан ширээнд сууснаас хойш 500 гаруй жилийн дараа Есүс мэндэлжээ. Матай, Лук бичээчид Давидад өгсөн амлалтын биелэл нь Есүс юм гэдгийг өгүүлжээ.

### **Есүс Давидын Хүү болой (Матай 1:1-17)**

Грек Шинэ гэрээнд, Матайн Сайнмэдээний эхний хоёр үг нь Матайн цаг үеийн уншигчдад Эхлэл номыг сануулах байдлаар бичигдсэн (Эхлэл 2:4, Эхлэл 5:1). Эхлэл ном бүтээлийн дээгүүрх хэмжээлшгүй эрх мэдэлтэй Бурханыг танилцуулдаг шиг Матай бүхий л түүхийн туршид хэмжээлшгүй эрх мэдэлтэй Бурханыг танилцуулдаг. Матайн Сайнмэдээн дэх угийн бичиг нь Израилын бүхий л түүх Мессиаг төрөхөд чиглэгдсэн болохыг харуулдаг.

Матайн угийн бичигт 14 нэр бүхий гурван бүлэг нэрсийг тэмдэглэсэн байдаг. Энэ нь иудейчүүдийн санаж тогтооход хялбар нийтлэг бичлэгийн арга юм. Эдгээр тогтсон бүлэг нэрс нь суралцагчдад нэрсийн урт жагсаалтыг цээжлэхэд тусалдаг. Матайн удам судрыг уншигчид энэ жагсаалтанд Абрахамаас Иосеф хүртэлх бүх өвөг дээдсийг оруулаагүй гэдгийг мэдэж байсан. Матайн Сайнмэдээнд “Эцэг болой” гэсэн хэллэг давтагддаг бөгөөд энэ нь аль ч удам угсааг хэлж байх боломжтой. Иудейчүүдийн угийн бичигт зарим үеийг алгасан тэмдэглэх нь нийтлэг үзэгдэл юм. Матай Есүсийн удам угсааны чухал ач холбогдолтой хүмүүст анхаарал хандуулж, бусад нэрсийг оруулалгүй тэмдэглэжээ.



Матай зарим удам угсааг оруулалгүй, харин оронд нь нэлээн сонирхолтой нэрсийг багтаасан. Матай эдгээр нэрсийг зорилготойгоор сонгожээ. Жишээлбэл, Матай дөрвөн эмэгтэйн нэрсийг жагсаан бичсэн. Энэ нь иудейн угийн бичигт ердийн бус зүйл байв. Эдгээр жагсаалтад буй эмэгтэйчүүд нь хүмүүсийн боддог сайн, зүй зохистой гэсэн хүлээлтэд тэнцэхгүй хүмүүс байв. Рахаб, Рут хоёр харь хүмүүс байсан бол Тамар, Рахаб, Батшеба нь бэлгийн ёс бус ичгүүртэй харилцаанд нэр холбогдсон байлаа.

Үүнтэй адил жагсаалтад буй зарим эрчүүд ч гутамшигт зүйлсэд нэр холбогджээ. Иуда Тамарыг ичгүүрт байдалд оруулсан. Иекониагийн удам угсаа Израилын хаан ширээнээс хасагджээ (Матай 1:12, Иеремиа 22:30). Хамгийн сонирхолтой нь, Матай Давидыг агуу амжилтуудаар нь бус, харин Уриагийн эхнэрээс төрсөн Соломоны эцэг хэмээн тодорхойлсон байдаг.

Эдгээр нэрс нь Есүсийг нүгэлт хүн төрөлхтөнтэй хамт байгаагаар танилцуулдаг. Бурхан Хүүгээ өөгүй төгс гэр бүлээр дамжуулан энэ дэлхийд төрүүлээгүй, харин эгэл жирийн нүгэлт хүмүүсийн үр удам болгон авчирчээ. Иудейн удирдагчид Есүсийн төрөлтийг нэр хүндгүй төрөлт хэмээн шоолж, зохисгүй нэгэн хэмээн Түүнээс татгалзсан юм (Иохан 8:41, 48). Бурхан нүгэлт удам угсаанаас гаралтай хүнийг ч агуу зорилгоо биелүүлэхийн тулд ашиглаж болно гэдгийг Матай харуулан бичжээ.

► Манай соёлд хүний гарал үүсэлтэй холбоотой ямар зүйлс тухайн хүнийг доогуур үнэлэхэд хүргэдэг вэ?

Бурхан голдуу хүмүүсийн хүлээлтэд хүрэхээргүй гарал үүсэлтэй нэгнийг өөртөө үйлчлүүлэхээр дууддаг. Гэр бүлийн нөхцөл байдал, гарал үүслээсээ болж ашиглагдах боломжгүй хүн гэж байдаггүй. Хүнийг бага дорд гэж үзэхэд хүргэдэг тухайн хүний гэр бүлийн нөхцөл байдал, гарал үүслийн зарим зүйлс нь Бурханд огт хамаагүй ч байх боломжтой.

### **Есүс Адамын Хүү болой (Лук 3:23-38)**

Матай “Иудейчүүдийн хаан”-ы угийн бичгийг Абрахамд хамааруулж тэмдэглэсэн. Харин Лук Есүсийн угийн бичгийг Адамд хамааруулан бичжээ. Энэ нь Лук Есүсийг “Хүний хүү” хэмээн онцолсонтой нийцдэг. Лукийн угийн бичигт Есүсийн хүмүүн чанарыг онцлон бичсэн байдаг. Лук энэхүү угийн бичгээ Есүс соригдсон түүхийн өмнөхөн бичжээ. Энэ нь уншигчдад эхний Адамын бүтэлгүйтсэн талбарт хоёр дахь Адам болох Есүс амжилтыг олсон гэдгийг сануулдаг.

### **Матай ба Лукийн угийн бичгийг “Сайтар ажиглах нь”**

Матай 1-р бүлэг болон Лук 3-р бүлэг дэх Есүсийн угийн бичиг өөр ялгаатай бичигдсэн. Матай Абрахамаас Соломон хаанаар дамжуулан Иосеф хүртэл тэмдэглэжээ. Лукийн хувьд Иосефоос Натан (Давидын хөвгүүдийн нэг) хүртэл ухраан улмаар Адам хүртэл тэмдэглэсэн байна.

Угийн бичгүүд нь Абрахамаас Давид хүртэл адил бичигдсэн ч. Харин Давидаас Иосеф хүртэл хоёр удам угсаа өөр өөрийн шугамыг дага. Энэхүү ялгаа нь Матай Иосефын удам угсааг тодруулж тэмдэглэсэнтэй, харин Лук Мариагийн<sup>2</sup> удам угсааг тодруулан бичсэнтэй холбоотой юм.

Матайн Сайнмэдээн дэх Иосефийн хааны угсаа гарвалыг хөөвөл Соломон хүртэл үргэлжилдэг. Энэ нь Матайн Сайнмэдээн дэх “Есүс бол Хаан” хэмээх сэдэвтэй яв цав тохирдог. Энэ нь Иосефоор дамжин ирэх ёстой Есүсийн хууль ёсны угсаа гарал юм.

Лукийн Сайнмэдээн дэх Мариагийн угсаа нь Давидын хүү Натанаас гаралтай бөгөөд “бие махбодын” угсаа гарлыг тэмдэглэжээ. Энэхүү угийн бичиг нь Лукийн Есүсийг “Хүний Хүү” хэмээн онцлон харуулахыг зорьсон сэдэвтэй нь яв цав тохирдог. Үүнийг харуулахын тулд Лук Мариагаар дамжин ирсэн Есүсийн бие махбодын угсаа гарлыг тэмдэглэжээ. Иудейчүүдийн угийн бичигт эмэгтэй хүний удам угсааг тогтоохдоо ч эрэгтэй нэрийг ашигладаг байсан тул тэрээр “Иосефын хүү” гэсэн хэллэгээр эхлүүлжээ.

Мариагийн угсаа гарал нь Давидтай цусан төрлийн холбоотой бол, Иосефын удам угсаа нь Соломоноор залгамжилсан хаан ширээний эрхийг олгодог.

### **Бурхан өөрийн Зарцыг гэр бүлийн нөхцөл байдалд нь бэлтгэсэн (үргэлжлэл)**

#### **Есүс Бурханы Хүү болой (Иохан 1:1-18)**

Иоханы Сайнмэдээ нь тэнгэрлэг угийн бичгээр эхэлдэг бөгөөд Есүсийг Бурханы Хүү байсан хэмээн танилцуулдаг. “Есүсийн амьдрал нь... Түүнийг төрөх мөчид эхлээгүй. Тэрээр тодорхой үүрэг даалгаврыг биелүүлэхийн тулд урьд өмнө оршин байсан төлөв байдлаасаа энэ дэлхийд ирсэн юм.”<sup>3</sup>

Хуучин гэрээнд Израилын ард түмэн Бурханы оршихуйг Асрын дээгүүр бүрхэх үүл байгаагаар хардаг байжээ. Одоо Бурхан бидний дунд Есүс Христийн бодгаль байдлаар амьдарч байна (Иохан 1:14). Бурханы тэнгэрлэг алдар нь одоо хүний дүрээр илчлэгдсэн.

Үг мөнхөд оршин байсан: “Үг Бурхантай хамт байсан агаад Үг нь Бурхан байв” (Иохан 1:1). Эцэг Хүү хоёр өнө мөнхийн нөхөрлөлд амьдарч байсан.<sup>4</sup> Тэгвэл Есүс яагаад бидний ертөнцөд ирсэн юм бэ? Эцэгийг илчлэн харуулахын тулд. Эцэгийг хэн ч хараагүй, харин Есүс Түүнийг бидэнд мэдүүлсэн юм (Иохан 1:18). Бид Есүсийг харахдаа Эцэгийг хардаг (Иохан 14:9).

---

<sup>2</sup> Бусад тайлбаруудын талаар дараах вебсайтаас дэлгэрүүлж үзнэ үү <http://www.gotquestions.org/Jesus-genealogy.html>, 2021 оны 3-р сарын 22-нд хандсан.

<sup>3</sup> J. Dwight Pentecost, *The Words and Works of Jesus Christ*. (Grand Rapids: Zondervan, 1981), 28

<sup>4</sup> Иохан 1:3 эшлэл нь Ёховагийн гэрчүүдийн Есүс бол бүтээгдсэн нэгэн гэдэг тайлбарыг үгүйсгэдэг. Харин Есүс бүтээлийн эхэнд оршин байсан юм. “Бүх юм Түүгээр буй болсон. Буй болсон юмсаас Түүнгүйгээр буй болсон юмс гэж нэг ч үгүй.”

Өнөөдөр олон хүн Есүсийг хайрт найз, харин Эцэгийг хатуу шүүгч мэтээр дүрсэлдэг. Гэсэн хэдий ч Иохан 1-р бүлгээс Есүсийн зан чанар нь Эцэгийн зан чанартай адилхан гэдгийг харж болно. Бид Есүсийг харахдаа, Эцэгийг хардаг.

### **Бурхан өөрийн Зарцыг гайхамшигт төрөлтөөр дамжуулан бэлтгэсэн**

Есүс ойролцоогоор НТӨ 5 онд Иудейн Бетлехемд төржээ.<sup>5</sup> Ромын хүн амын тооллого явагдсан учраас Иосеф Бетлехем рүү аялсан. Тооллогын зорилго нь Ромын хяналтад байдаг бүс нутгуудын татварын бүртгэлийг хангах явдал байв.

Ромчууд хүмүүсийг ажиллаж, амьдарч буй хотод нь бүртгэдэг нийтлэг аргатай байжээ. Гэсэн хэдий ч, бослого тэмцэл гаргахдаа түргэн иудейчүүдтэй эв найртай байхын тулд Ром Иудейн бүс нутагт иудей хүмүүс өөрсдийн төрөл төрөгсдийн гэртээ бүртгүүлдэг аргыг хэрэглэхийг нь зөвшөөрчээ. Үүнээс улбаалж Иосеф, Мариа хоёр Назараас Бетлехем хүртэл 100 км замыг туулсан. Хэдийгээр зөвхөн өрхийн тэргүүн эрэгтэй хүн бүртгүүлэх шаардлагатай байсан ч Иосеф Мариаг Бетлехемд авчирчээ. Магадгүй Иосеф Мариаг Назарын жижиг тосгонд хов жив ярьдаг хөршүүдтэй нь үлдээхийг хүсээгүй бололтой.

Бурхан зорилгоо биелүүлэхийн тулд дэлхийн үйл явдлуудаар дамжуулан ажилладаг. Бурханы зорилгыг биелүүлэхийн тулд Бурханыг мэдэхгүй харийн хаанаар иудейчүүдийн хүн амын тооллогыг “сонгуулжээ”. “Хааны зүрх ЭЗЭНий мутарт усны урсгал хаа таалсан зүгтээ Тэр түүнийг чиглүүлэх” (Сургаалт үгс 21:1). Бурханы хаанчлалын ажилчдын хувьд энэ нь хэдийгээр хорон муу хүмүүс бүгдийг хяналтдаа байлгаж байгаа мэт харагдаж болох ч Бурхан зорилгоо биелүүлдэг гэдэгт итгэх итгэлийг өгөх учиртай.

Энэхүү татварын тооллого нь Есүсийг төрөхөд Бурхан дэлхийг хэрхэн бэлтгэснийг харуулдаг олон жишээнүүдийн нэг юм. Бурхан Грекийн эзэнт гүрний соёл уламжлал, Ромын эзэнт гүрний эрх зүйн тогтолцоо, Иудейн итгэл үнэмшил дэх шашны зарчмуудыг ашиглан, бидний ертөнцийг Мессиагийн төлөө бэлтгэжээ. Энэ талаар судлахын тулд Shepherds Global Classroom байгууллагын *Шинэ гэрээтэй танилцах нь*<sup>6</sup> курсын 1-р хичээлийг үзнэ үү.

### **Хоньчдын айлчлал (Лук 2:8-20)**

Есүсийг төрсөн талаарх мэдээг хамгийн түрүүнд хүлээн авсан хүмүүс бол Бетлехемийн гадна хонио манаж байсан хоньчид байв. 1-р зууны үеийн ихэнх иудейчүүд хоньчдод таагүй ханддаг байснаас үзвэл энэ нь үнэхээрийн сонин содон үзэгдэл байлаа. Хоньчид нийгэмд маш доогуур байр суурьтай байсан тул Иудейн шүүх тэдний гэрчлэлийг хүлээж

---

<sup>5</sup> Грегориин хуанли нь 1582 он хүртэл боловсруулагдаагүй байжээ. Энэхүү хуанли нь нарийвчлал багатай бөгөөд ойролцоо он цагийг заадаг. Агуу Херод ойролцоогоор НТӨ 4 онд нас баржээ. Энэхүү цаг хугацааг үндэслэн Есүсийн төрсөн өдрийг ойролцоогоор НТӨ 5-6 он гэж үзэх боломжтой.

<sup>6</sup> Available from <https://www.shepherdsglobal.org/> вебсайтаас харах боломжтой

аваагүй. Лук “Хэрэв хоньчдыг хүлээн авсан юм бол Бурханы хаанчлалд өөр **хэнийг ч** хүлээн авах боломжтой!” хэмээн хоньчдын талаар онцлон бичжээ. Тэнгэрэлч нар “Би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайхан мэдээг та нарт авчирлаа” (Лук 2:10) хэмээн өгүүлсэн.

Сайнмэдээ нь дан ганц үндэстэн (Израил) эсвэл нийгмийн аль нэг анги давхаргаар хязгаарлагддаггүй. Сайнмэдээ бүх хүмүүст зориулагдсан. Энэ сэдэв Лукийн Сайнмэдээний бүх хэсэгт агуулагддаг. Лук нийгмээс гадуурхагдсан хүмүүст Есүс үйлчилж байгаа талаар Закхай, самаричууд, эмэгтэйчүүдэд үйлчилсэн түүхүүдийг онцлон өгүүлсэн байдаг.

### **Мэргэдийн айлчлал (Матай 2:1-12)**

Матайн Сайнмэдээ нь анх иудей хүмүүст зориулагдан бичигджээ. Харин Лук бүх хүмүүсийн төлөөх Есүсийн сургаалд анхаарлаа хандуулсан байдаг. Матай тэнгэрлэг хаанчлалын талаарх Есүсийн сургаалыг анх онцлон бичсэн. Матай хоньчдын оронд зурхайч, мэргэдийн айлчлалыг харуулахыг зорьжээ. Энэхүү айлчлал нь Есүсийн гэрийнхэн байнгын амьдрах гэр оронтой болсны дараа, магадгүй Түүнийг төрснөөс хойш хэдэн сарын дараа тохиосон болов уу (Матай 2:11). Энэ нь хоёр нас хүрээгүй эрэгтэй нялх хүүхдүүдийг алах Херодын тушаал гарсан цаг үетэй ч тохирдог.

Зурхайч мэргэд нь од эрхсийн онцгой содон зүй тогтлыг гярхай ажиглаж судалдаг хүмүүс байжээ. Тухайн цаг үед аялах нь аюултай байсан ч тэд тэнгэрт үзэгдсэн хачирхалтай тэмдгийг судалж мэдэхээр алс холын аялалд гарчээ.

Мэргэд Иудейн хааныг логикийн хувьд олж болох газар хэмээн Йерусалимд анх иржээ. Херод өөрийн боломжит өрсөлдөгчийн талаарх мэдээг сонсоод тэр өөрөө төдийгүй Йерусалим даяар түүнтэй хамт түгшин сандарчээ (Матай 2:3). “Йерусалим даяар” гэсэн хэллэгээр хожим Йерусалимд шашны удирдагчид Есүсийг үгүйсгэж эсэргүүцэхийг урьдчилан дүрсэлжээ.

Мэргэдийн айлчлал нь Мессиаг харь үндэстнүүдэд харуулах анхны танилцуулга байв. Энэ тэмдгээс болж түгшиж санаа зовнисон хүмүүсээс ялгаатай нь мэргэд энэхүү тэмдэгт итгэлээр хандсан юм. Есүс зөвхөн Иудейн хаан байхаар бус, бүх үндэстний хаан болон ирсэн.

Есүсийг хүндлэхээр хэдэн мэргэд ирснийг Матай өгүүлээгүй. Харин уламжлалд гурван мэргэн гэж хэлэгдсэн нь Матай 2:11-д өгүүлдэг гурван бэлэг өгсөн үйл явдлаас улбаатай. Бэлэг тус бүр нь Есүсийн үйлчлэлийн зарим хэсгийг төлөөлдөг.

- Алт нь хаанд зориулагддаг бэлэг. Гэсэн хэдий ч Есүс хаан сэнтийнээс бус, загалмай дээрээс хаанчлах болно.
- Гүгэл нь тахилчид зориулагддаг бэлэг. Тахил өргөхөд гүглийг үнэртэн болгож ашигладаг байжээ. Есүс бүх хүмүүсийг Бурханы оршихуйд орох боломжтой болгосон тахилч болж ирсэн.

- Мирр нь нас барсан хүнийг тослоход зориулагддаг. Есүс бүх хүний төлөө амиа өргөхөөр төрсөн юм.

### **Бурхан өөрийн Зарцыг хамгаалсан**

Есүсийг төрөхөөс өмнө тэнгэрэлч Иосефын зүүдэнд үзэгдэж, Бурханы төлөвлөгөөг илчилсэн. Мэргэдийн айлчлалын дараа тэнгэрэлч Иосефыг Египет рүү зугтахыг анхааруулав. Тэрээр гэр бүлийн хамт Херодыг нас барах хүртэл (ойролцоогоор НТӨ 4) Египетэд байжээ.

Агуу Херод олон талаараа үр нөлөөтэй захирагч байв. Тэр иудейчүүдийг хүндэлдэг төдийгүй тэдний хоол ундтай холбоотой хууль дүрмийг ч дагадаг нэгэн байж. Мөн тэрээр Есүсийн амьдарч байсан цаг үеийн туршид үргэлжилсэн Сүмийг сэргээн засварлах ажлыг эхлүүлсэн. НТ 25 оны үед тохиосон өлсгөлөнгийн үеэр Херод өөрийн мөнгөөр Иудейн өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст хоол хүнс авч өгч байжээ.

Гэсэн хэдий ч Херод аймшигтай харгис хэрцгий хүн байжээ. Тэр өөрийн эхнэрүүдийн нэг Мириамне болон түүний ээж Александраг өөрийнх нь эсрэг хуйвалдсан гэж сэжиглээд хороосон. Херод гурван хүүгээ нас бие гүйцэх үед нь өөрт нь аюул заналхийлэл авчирна гэж үзээд мөн хороож байжээ. Түүн шиг харгис хэрцгий хүний хувьд Бетлехемийн нялх хүүхдүүдийг алах нь гайхахаар зүйл биш юм. Албан тушаалаа хадгалж авч үлдэхийн тулд хэдэн зуун хүүхдийг хөнөөх нь түүнийг бага зэрэг ч эвгүйцүүлсэнгүй.

Херодын харгислал түүнийг үхэх хүртэл нь үргэлжилжээ. Түүний үхэл ойрхон болсон үед тэр Йерусалимын тэргүүлэх иргэдийг баривчилж, өөртэйгээ хамт үхүүлэхийг тушаажээ. Ингэснээр түүний нас барах өдөр гашуудлын өдрийн баталгаа болно гэж тэр итгэж байв (Харин оронд нь Херодын бэлэвсэн эхнэр хоригдлуудыг сулласнаар энэ өдөр нь Палестин даяар тэмдэглэлт өдөр болж хувирчээ).

Херодыг нас барсны дараа түүний эзэмшил газар нутгийг гурван хүү нь хуваан захирчээ. Антипас Галил болон Переаг, Филипп Палестины зүүн хойд бүс нутгийг, Архел нь Иудей, Идум болон Самарийг тус тус захирчээ. Эртний түүхчид Архелын талаар тэр эцгийнхээ бүх сул талуудыг авсан ч, ганц ч сайн шинж чанарыг нь өвлөж аваагүй гэж өгүүлдэг.

Иудейчүүд түүнд дургүйцэж, Цезарьт гомдол мэдүүлсэн учраас НТ 6 онд түүнийг захирагчийн албан тушаалаас чөлөөлжээ. Түүнээс хойш Иудейг Понти Пилат зэрэг Ромын захирагчид захирах болсон байна.

Херодыг нас барсны дараа Иосефыг Израил руу буцаж ирэхийг зааварлахын тулд тэнгэрэлч түүний зүүдэнд дахин үзэгдсэн. Гэсэн хэдий ч Архел эцэг Херодын адил аюултай байсан тул Иосеф Бетлехем рүү буцахын оронд гэр бүлээ Назарт аваачжээ.

► Жон Весли бага байхдаа шатаж буй гэрээсээ гайхамшгаар аврагджээ. Бурхан түүнийг онцгой зорилгын төлөө хамгаалсан гэдэгт тэр итгэдэг байв. Весли өөрийгөө “галаас

авагдсан цуцал” (Зехариа 3:2) гэж хэлэх дуртай байжээ. Ангийнхаа гишүүдийг Бурхан хэрхэн гайхамшигтай арга замаар эсвэл хангамжаар үйлчлэлд нь хамгаалж тусалсан талаар түүхээ ярихыг урамшуулаарай.

### **Сайтар ажиглах нь: Матай 2:23**

Есүсийн үйлчлэл нь Хуучин гэрээний эш үзүүлэгчүүдийг биелүүлсэн талаар Матай бусад Сайнмэдээнүүдээс илүү олон удаа дурджээ. Матай иудейчүүдэд хандан бичихдээ Есүс бол амлагдсан Мессиа байсан гэдгийг харуулахыг зорьжээ:

- Есүс онгон бүсгүйгээс төрсөн (Матай 1:22-23) Исаиа 7:14-ийн биелэл.
- Есүс Бетлехемд төрсөн (Матай 2:5-6) Мика 5:2-ын биелэл.
- Египетийг зорьсон аян (Матай 2:14-15) Хосеа 11:1-ийн биелэл.
- Бетлехемийн нялх хүүхдүүдийг хөнөөсөн (Матай 2:16-18) Иеремиа 31:15-ын биелэл.
- Йерусалимд орж ирсэн (Матай 21:1-5) Зехариа 9:9-ийн биелэл.

Эш үзүүлэгийн биелэл тал дээр тайлбарлахад төвөгтэй жишээ Матай 2:23-д гардаг. Матай “Тэгээд Назар гэгдэх хотод очиж суурьшив. Назарынх гэж Тэр дуудагдах болно гэж эш үзүүлэгчдээр айлдуулсан нь ийнхүү биелэгджээ.”

Төвөгтэй зүйл нь Мессиаг Назарынх гэж нэрлэх тухай Хуучин гэрээний эш үзүүлэгч тэмдэглэгдээгүйтэй холбоотой. Энэ эшлэл хоёр утга санааг тодруулсан байх боломжтой:

1. Есүсийн цаг үед Назар нь бусдын анхааралд өртөхөөргүй жижиг тосгон байв (Иохан 1:46). Иудейчүүд өөрсдийн Мессиаг худалдааны бүс нутаг болох Галилаас бус, харин Иудейгээс ирнэ гэсэн хүлээлттэй байжээ (Иохан 7:41, 52). Харин үнэн хэрэгтээ Есүс Назар мэт үл тоомсорлогддог газраас ирснээр Исаиа 49:7 болон Исаиа 53:3 зэрэг эшлэлийн биелэл болжээ.
2. Исаиа 11:1-д Мессиаг “мөчир” байх болно хэмээн эш үзүүлжээ. Мөчир гэдэг еврей үг нь (*незер*) “Назар” гэдэг үгтэй маш төстэй сонсогддог. Матайн иудей уншигчдын хувьд энэ нь үг холбох аргаар бичигдсэнийг төвөггүй ойлгодог байсан байх.

### **Бурхан өөрийн Зарцын замыг бэлтгэх нэгнийг бэлдсэн**

Баптисч Иохан Есүсийн үеэл байв. Иоханы түүх түүний эцэг Захариа үндэстнийхээ өмнөөс утлага уугиулж байснаас эхэлдэг бөгөөд энэ нь тахилч хүний хамгийн хүндтэй үүргүүдийн нэг юм (Лук 1:9).

Захариа энэхүү ариун үүргээ гүйцэтгэж байх үед утлагын тахилын ширээний баруун талд тэнгэрэлч үзэгдсэн. Өргөл өргөх үед нь энд Бурхан зогсож байсан хэмээн Иудейн

уламжлалд өгүүлсэн байдаг. Хүү гуйсан Захариагийн залбирал хариултаа авсан гэдгийг тэнгэрэлч Габриел түүнд хэлжээ.

Елизабет хүүхэд төрүүлэх нас өнгөрсөн тул Захариа тэнгэрэлчийн амлалтад эргэлзсэн. Захариа итгэлгүй байснаасаа болоод Иоханыг төрөх хүртэл ярьж чадахгүй байжээ. Захариа тахилч, Бичвэрийг судалдаг хүн байсан учраас Хуучин гэрээнд өгүүлэгддэг Ханна болон Рахелын түүхийг мэддэг байх ёстой төдийгүй эхнэр Елизабетынх нь хэвлийг Бурхан гайхамшигтайгаар нээх болно гэсэн амлалтад итгэх ёстой байв.

Үүнээс 30 жилийн дараа Иохан үйлчлэлээ эхлүүлжээ. Тэрээр Йерусалимд тахилчаар үйлчлэхийн оронд Иудейн цөлд эш үзүүлэгчээр үйлчилсэн юм. Иохан Мессиагийн өмнө замыг бэлдэхээр илгээгдсэн нэгэн байв. Иоханыг номлоход хүмүүс “Иохан амлагдсан Мессиа мөн үү?” гэж асуудаг байжээ. Харин тэр тэдэнд “Надаас илүү хүчирхэг Нэгэн ирж байна. Би Түүний шаахайн үдээсийг ч тайлах үнэ хүндгүй” (Лук 3:16) гэж хариулсан юм. Боолын хамгийн дорд үүргүүдийн нэг нь эзнийхээ шаахайг арчлах байсан ч Иохан “айсуй нэгэн надтай зүйрлэшгүй агуу тул би энэ дорд үүргийг ч гүйцэтгэх зохисгүй” хэмээжээ. Иохан даруугаар үйлчлэх үлгэр дуурайлыг харуулсан.

Бичвэрийн бүхий л хэсгээс Бурхан хэн нэгэнд замыг бэлтгэхийн тулд хүмүүсийг ашиглаж байгаа тухай харж болно. Барнаб, Паулын жишээг харцгаая. Саул Христэд итгэгчдийг хавчиж байх үед Барнаб хэдийн чуулганд танигдсан нэр хүндтэй удирдагч болсон байлаа. Чуулганыг хавчдаг түүнд бараг итгэх хүн байхгүй үед Барнаб Паулд итгэл хүлээлгэсэн. Тэднийг анхны илгээлтийн аяллаа эхлүүлэх үед Үйлс номд “Барнаб, Саул нарыг” (Үйлс 13:2) гэж тэмдэглэсэн бол, удалгүй тэднийг “Паул, Барнаб нарыг” (Үйлс 13:43 болон түүнээс хойш) хэмээн дурдах болжээ. Барнаб эхэндээ багийнхаа удирдагч байсан бол, тэр Паулыг удирдагч болоосой гэж хүсжээ.

Заримдаа таны үүрэг оролцоо баптисч Иохан эсвэл Барнабынхтай адил өөр хэн нэгний замыг бэлтгэх байж болох юм. Бурхан таныг хаана ч ашиглахаар сонгосон бай, та хамгийн сайнаараа үйлчлээрэй. Хэрэв Бурхан танд туслах үүргийг оногдуулсан бол тэрхүү үйлчлэлээс бүү татгалзаарай. Бурхан таныг хамгийн үр нөлөөтэйгээр ашиглаж чадна гэдэгт та итгээрэй.

Өөрийн дагалдагчдыг Есүс рүү чиглүүлснээр баптисч Иохан даруу байдлаа харуулсан (Иохан 1:35-37). Багшаа хүндэлдэг, олон дагалдагчидтай байх нь рабби хүний зорилго байтал баптисч Иохан өөрийн дагалдагчдыг илүү агуу багш руу хандуулжээ. Өөрөөсөө агуу нэгнийг бусдад заах нь түүний ажил үүрэг гэдгийг Иохан сайн ойлгож байв. Түүний дагалдагчид Есүсийг дагахаар одохыг тэр харж байлаа. Түүний зорилго бол өөрийнх нь алдар нэр бус, харин Бурханы хаанчлал байсан юм. Христэд итгэгч удирдагчдын хувьд бидний зорилго бол өөрсдийн амжилт бус, харин хүмүүсийг Есүс рүү чиглүүлэх явдал гэдгийг хэзээ ч мартах ёсгүй.

## Сайтар ажиглах нь: Нүглээ гэмших нь ямар утга учиртай вэ?

► Матай 3:1-6 эшлэлийг унших.

Иохан гэмших тухай номлож байсан. Өнөө цагт зарим хүмүүс гэмшлийг зөвхөн оюун бодлоо өөрчлөх гэж хэлдэг. Өөрсдийгөө итгэгч гэж үздэг олон хүмүүст өөрчлөгдсөн амьдралын тэмдэг маш бага харагддаг.

Харин “гэмших” гэдэг нь оюунлаг шийдвэрээс хавьгүй илүү утга учиртай. Шинэ гэрээний бичээчид “гэмших” гэдэг үгийг Хуучин гэрээний эш үзүүлэгчдийн адилаар ашигласан. Энэ нь амьдралаа бүрэн өөрчлөх гэсэн үг юм. Шинэ гэрээнд гэмшлийг:

- Өөрийн бодол санаа, итгэл үнэмшлээ өөрчлөх **болон**
- Өөрийн үйлдэл, амьдралын хэв маягаа өөрчлөх гэж хэлдэг.

Хэдэн жилийн өмнө гэм нүгэлтэй амьдралаараа алдартай Америкийн нэгэн поп дуучин “Би Христэд итгэгч болсон, Сүнсээр ч дүүрсэн. Би өмнө нь хийдэг байсан зүйлээ хийсээр байгаа ч одоо би Христэд итгэгч болсон. Хэрэв би энэ хорвоог орхивол тэнгэрийн улсад очих болно” гэж ярьж байжээ. Энэ хүний “гэмшлээс” амьдралынх нь хэв маягт орсон ямар ч өөрчлөлт байсангүй. Энэ нь жинхэнэ гэмшил биш юм.

Гэмшил нь бидний амьдралын хэв маягийг өөрчилдөг хэмээн Иохан сургасан. Иохан баптисм хүртэхээр ирсэн хүмүүсээс гэмшилд зохистой байдлаар биеэ авч явахыг шаарддаг байв (Лук 3:8). Баптисм нь “Би итгэж байна, тиймээс одоо надад баптисм хүртээ” гэдэг хоосон зан үйл байж таарахгүй. Баптисм нь жинхэнэ гэмшил болон өөрчлөгдсөн амьдралыг гэрчлэх ёстой.

## Бурхан өөрийн Зарцыг сорилтоор дамжуулан бэлтгэсэн

Сорилтыг даван туулсан Есүсийн ялалт нь биднийг сорилттой тулгарах үед үлгэр дуурайл болдог. “Есүс ... диаволд соригдохын тулд Сүнсээр цөл уруу хөтлөгдөв” (Матай 4:1). Олны төлөөх үйлчлэлээ эхлэхийн өмнөхөн Есүс соригдсон. Бусдад зааж номлохоосоо өмнө Есүс Эцэгийнхээ хүсэлд бүрэн дуулгавартай байдлаа харуулсан юм.

Матай Есүсийн соригдсон түүхийг Түүний баптисм хүртсэний яг дараахан тохиож байгаагаар өгүүлдэг. Хамгийн хүнд хэцүү сорилтууд ихэвчлэн бидний сүнслэг ялалтын дараа тохиолддог. Елиа Кармел уулан дээрх ялалтынхаа дараахан цөхрөнгөө барж, эргэлзэхэд хүрсэн (1 Хаад 18-19).

Лук Есүсийн удам угсааг Адамд хамааруулсныхаа дараахан Түүний соригдсон түүхийг өгүүлдэг. Адам бүтэлгүйтсэн ч, харин Хүний Хүү Есүс ялалт байгуулсныг Лук харуулдаг (Лук 3:38). Есүс хүн төрөлхтөнтэй өөрийгөө адилтгаж, эгэл жирийн итгэгчид ч нүглийг хэрхэн ялан дийлж чадахыг үлгэрлэн харуулжээ.



## **Сорилтууд**

### **Чулууг талх болгох сорилт**

Есүсийг тэнгэрлэг хүч чадлаа ашиглан чулууг талх болгохын тулд Сатан сорьсон юм. Есүсийг Эцэгтээ найдахын оронд өөрийн эрх ашгийн төлөө хүч чадлаа ашиглахад Сатан уруу татжээ. Есүс хооллох эрхээ Эцэгтээ дуулгавартайгаар өгсөн юм.

“Би эрхээ хамгаалж, хүч чадлаа нотлох болно” гэж хэлдэг хүмүүст бид алга ташдаг. Гэвч жинхэнэ хүч чадал нь хүний хүслээ Бурханы хүсэлд орхиход оршдог гэдгийг төгс Хүмүүн харуулсан юм.  
- Г. Кэмпбел Морган-аас авсан

Анхны Адам идэх ёсгүй хоолыг идэхээр уруу татагдаж, Бурханд дуулгаваргүй хандсан бол хоёр дахь Адам итгэмжит байжээ.

### **Сүмийн орой дээрээс үсрэх сорилт**

Есүсийг Сүмийн орой дээрээс үсрүүлэхээр Сатан сорьсон (Кидроны хөндийгөөс 91м өндөр). Хүүгээ хамгаалах амлалтаа биелүүлэхийг Эцэгээс шаардах нь хүмүүсийг алмайруулах байв.

Эцэгийнх нь амлалтыг шалгахын тулд Есүсийг Сатан сорихдоо Дуулал 91:11-12 дахь амлалтыг эш татжээ. Хэрэв энэхүү сорилтод Есүс автсан бол Эцэгээ өөрийн зарц болгож, өөрийнхөө хүлээлт шаардлагыг Түүнд тулгах байлаа.

Есүс Дуулал 91 дэх амлалтыг буруу нөхцөл байдалд ашиглахаас татгалзсан юм. Есүс Сатанд “Бурхан ЭЗЭНээ бүү сорь” гэсэн Дэд хууль 6:16 эшлэлээр хариулжээ. Бурханы хүүхдүүдийн хувьд бид Бурханы хүч, эрх мэдлийг өөрсдийн зорилгод ашиглахыг шаардаж болохгүй.

### **Сайтар ажиглах нь: Жинхэнэ итгэл**

Зарим Христэд итгэгчид “Номд буй амлалт бүхэн минийх” гэж хэлдэг. Бичвэр дэх амлалт бүр үнэн боловч бид “Энэ амлалт энэ нөхцөл байдалд хамаатай юу?” гэж үргэлж асуух ёстой. Дуулал 91-д буй амлалт нь Түүний цөлд тулгарсан нөхцөл байдлын төлөөх Бурханы хүсэл биш гэдгийг Есүс мэдэж байсан юм. Бид Бурханы хүчийг захирах гэж оролдохын оронд харин жинхэнэ итгэлээр Бурханы амлалтыг сахиж байгаа гэдэгтээ хэрхэн баттай байж чадах вэ?

### **(1) Бид Бурханы Үгийг мэдэх ёстой.**

Библи дэх амлалтын хам сэдэв, амлалттай холбоотой нөхцөл байдлуудын талаар илүү ихийг мэдэх тусам бид үүнийг нөхцөл байдалдаа хэрэгжүүлж болох, болохгүйг сайн дэнсэлж чаддаг болдог.

Зарим амлалтууд нь тодорхой нөхцөл байдалд, тодорхой хүмүүст өгөгдсөн байдаг. Хуучин гэрээнд хэрэв Израил гэрээндээ үнэнч байвал биет ерөөлүүдийг өгнө гэж Бурхан амласан байдаг. Тэдний газар нутагт үр жимс ихээр боловсорч, агуулах сав нь дүүрч, цэрэг арми нь ялалт байгуулах гэх мэт. Шинэ гэрээн дэх амлалтууд нь ихэвчлэн

сүнслэг ашиг тустай холбоотой өгөгдсөн. Зарим хүмүүс үүнийг сурахдаа сэтгэл дундуур байж болох ч, бид үүнд баярлах учиртай. Материаллаг хөгжил дэвшил нь зөвхөн түр зуурын үнэ цэнтэй бол, харин сүнслэг хөгжил дэвшил нь мөнхийн үнэ цэнтэй. Бурханд найддаг итгэл нь Бурхан бидний хүслийг биелүүлэхийн тулд бус, харин Тэр амлалтаа өөрийн арга замаар биелүүлнэ гэдэгт итгэдэг.

## **(2) Бид ерөнхий болон тодорхой амлалтуудыг ялган таних ёстой.**

Бид ерөнхий амлалтыг уншихдаа Бурхан бидний тодорхой нөхцөл байдалд амлалт өгч байгаа эсэхийг асуух хэрэгтэй. Зарим амлалтууд нь ерөнхий ч, бүгдэд зориулагдаагүй байдаг.

Дуулал 103:3-д “Бүх өвчнийг чинь илааршуулдаг” хэмээн Бурханыг магтан алдаршуулсан. Зарим итгэгчид энэ эшлэлийг Бурхан итгэгч хүн бүрийн бүх өвчнийг эдгээх амлалтыг өгсөн гэж итгэдэг. Гэсэн хэдий ч, Бичвэр бидэнд бие махбодын өвчин болгон эдгэрдэг гэж харуулдаггүй. Паул эдгэрэхийн төлөө залбирахад Бурхан “Үгүй” гэж хэлсэн (2 Коринт 12:7). Заримдаа Бурхан хүүхдүүдийнхээ өвчнийг эдгээхийг сонгодог бол заримдаа тэдэнд зовлон зүдгүүрийг үүрэхийн тулд нигүүлсэл өгөхийг сонгодог ажээ.

Хаанд өчсөн гурван еврей залуу хүү адил бид хариу үйлдэх ёстой юм. Небухаднезар хаан галт зууханд тэднийг хаяна гэж сүрдүүлэхэд тэд “Бидний үйлчилдэг Бурхан биднийг аврах бол дүрэлзсэн галтай зуухнаас ч хаантан таны гараас ч биднийг Тэр аварна. Хэдийгээр тэгэхгүй байсан ч, өө хаантан, бид бурхдад тань үйлчлэхгүй мөн таны босгосон алтан хөрөгт мөргөхгүй гэдгийг та мэдсүгэй гэв” (Даниел 3:17-18). Бурханд тэднийг чөлөөлөх хүч байгаа гэдгийг тэд мэдэж байсан. Хэдий Бурхан өөр замыг сонгосон байсан ч тэд Түүнд итгэмжтэйгээр үйлчлэхэд бэлэн байв.

Бурхан хүүхдүүдээ бие махбодын зовлонгоос чөлөөлж чадна, гэхдээ Тэр үргэлж ийм замыг сонгодоггүй. Бурхан Библийн амлалтыг танд тусгайлан зориулсан гэдгийг тодорхой болгох хүртэл та Түүний хийхээр сонгосон зүйлд итгэж найдаарай. Элч Иохан “Бид Түүний хүслийн дагуу юу ч гуйсан, Тэр биднийг сонсдог нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юу ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохоо мэднэ” (1 Иохан 5:14-15) гэсэн амлалтыг өгчээ.

Библийн амлалт бүр минийн тодорхой нөхцөл байдалд хамаатай гэж бид бодож болохгүй. Итгэл нь “би Түүний хүслийн дагуу асуух болно” гэж хэлдэг. Би амлалт бүрийг хувийн амлалт гэж хүлээж авах ёсгүй. Харин үүний оронд энэ амлалт миний нөхцөл байдалд зориулагдсан эсэхийг асуух хэрэгтэй юм.

## **(3) Бид Есүсийн нэрээр залбирах ёстой.**

Есүс “Та нар нэрээр минь юу ч гуйсан, Эцэг Хүүгээр алдаршуулагдахын тулд Би түүнийг үйлдэнэ” (Иохан 14:13) гэж амласан юм. Есүсийн нэрээр залбирна гэдэг нь таны залбирал Есүсийн чухалчилдаг зүйлс, Түүний хүсэл ба зан чанартай нийцэж байхыг хэлдэг. Бурханд алдрыг авчрах зүйлсийн төлөө Есүс залбирдаг байжээ. Бид ч бас

ийнхүү залбирах ёстой. Хэрэв бидэнд жинхэнэ итгэл байвал, бид өөрсдийн хүслээс илүү Бурханы алдрыг эрэлхийлэх болно.

Эцэгийг алдаршуулахын төлөө залбирна гэдэг нь бидний амьдрал дахь Бурханы эцсийн зорилгод захирагдаж байна гэсэн үг юм. Бурхан Израилд “Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм» гэж ЭЗЭН тунхаглаж байна” (Иеремиа 29:11) хэмээн амласан юм. Энэхүү амлалт нь Израил Вавилоны цөллөгт 70 жил байх үед өгөгдсөн амлалт гэдгийг бид санах хэрэгтэй. Вавилонд боолчлогдох нь ч Бурханы ард түмэнд сайн сайхныг авчрах болно; Зовлон зүдгүүр дундаа ч Израил Бурханыг дуудахад Тэр тэднийг сонсох болно.

Энэ амлалт өнөөдөр бидэнд хэрэгжих боломжтой юу? Хариулт нь тийм! Бурханы зан чанар өөрчлөгддөггүй. Тэр хүүхдүүддээ сайн сайхныг авчирдаг. Тохиолдож буй бүх зүйл сайхан байх албагүй ч амьдралд тохиолдох бүх зүйлд Бурхан өөрийн зорилгыг хэрэгжүүлдэг гэдгийг бид мэддэг учраас Есүсийн нэрээр итгэлтэйгээр залбирч чадна.

### **Бурхан өөрийн Зарцыг сорилтоор дамжуулан бэлтгэсэн (үргэлжлэл)**

#### **Сорилтууд (үргэлжлэл)**

##### ***Дэлхийн хаанчлалуудыг санал болгосон***

Сатаны эцсийн сорилт нь Есүстэй **тохиролцож**, Түүнд ирээдүйн хаанчлалдаа загалмайгүйгээр хүрэх арга замыг санал болгосон явдал юм. Есүс Сатаны өмнө өвдөг сөгдөөд, загалмайн зовлонг туулахгүй өнгөрч болох байв. Харин Есүс түүнд Дэд хууль 6:13, “Бурхан Эзэндээ чи мөргөж, зөвхөн Түүнд үйлчил” (Матай 4:10) хэмээн хариулсан юм.

#### **Сорилтыг ялан дийлсэн Есүсийн ялалт**

Сорилт дунд Есүсийн харуулсан үлгэр дуурайлаас суралцахдаа бид Есүсийг бүрэн дүүрэн хүн байсан гэдгийг санах учиртай. Тэр “... харин нүгэлгүй атлаа бүх талаар...” соригдсон юм (Еврей 4:15).

► 1 Коринт 10:13 болон Еврей 4:15 эшлэлийг унших. Сорилтын талаар эдгээр эшлэлд юу гэж заасан бэ?

1 Иохан 2:16-д сорилт нь махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал зэргээс үүдэлтэй болохыг элч харуулжээ. Есүс энэ бүх талбарт соригдсон билээ.

- Есүсийг өлссөн үед Сатан махбодыг нь талхаар сорьжээ.
- Сатан Есүст дэлхийн хаанчлалуудыг үзүүлж, нүдийг нь сорьсон.
- Сатан, Есүсийг олон түмнийг алмайруулах гайхалтай үйл хийхэд сорьж, амьдралын бардамналд уриалав.

Сорилтыг ялан дийлсэн Есүсийн үлгэр дуурайл биднийг соригдох үед загвар болдог. Сорилтыг ялан дийлэхэд Есүсийн ашигласан гурван хэрэгслийг анзаарч хараарай.

### **Ариун Сүнсний хүч**

Есүс Ариун Сүнсний удирдамжийн дагуу алхсан. Сүнс өөрөөр нь хийлгэхийг хүссэн зүйлийг Тэр хийсэн. “Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн...” (Лук 4:1).

Есүс дэлхий дээрх үйлчлэлийнхээ туршид Ариун Сүнсний хүчээр үйлдэж байв. Тэр Сүнсний хүчээр чөтгөрүүдийг хөөн зайлуулж байсан (Матай 12:28). Бурхан “... Назарын Есүсийг Ариун Сүнс ба хүч чадлаар тосолсон хийгээд Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм” (Үйлс 10:38).

Есүс дэлхий дээрх үйлчлэлээ Ариун Сүнсний хүчээр хийсэн. Хэрэв бид сорилтын эсрэг хүчтэй зогсохыг хүсвэл Ариун Сүнсний хүч чадал дотор амьдрах ёстой.

### **Залбирлын хүч**

Есүс 40 хоног мацаг барьж, залбирсны дараа сорилтод орсон. Залбирал Түүнийг сүнслэг тулаанд бэлтгэжээ. Дараагийн хичээлээр бид Есүсийн амьдрал ба үйлчлэлд залбирал чухал байр суурьтай байсан талаар сурах болно. Хэрэв Есүс залбиралд түшиглэж байсан бол бид ч залбирахгүйгээр сүнслэг ялалтыг хүлээх боломжгүй биш үү?

Залбирлын амьдралдаа анхаарахаа больсон үед Сатан ихэвчлэн бидэн рүү довтолдог. Хэрэв бид амин чухал залбирлын амьдралаа анхаарч хадгалахгүй бол сорилтын өмнө сул дорой байх болно гэдгийг тэр мэддэг.

### **Үгийн хүч**

Есүс сорилт бүрд Бичвэрийн үгсээр хариулсан. Тэр эдгээр Бичвэрийг яаж мэдсэн бэ? Еврей хүүхдүүдийн бага насны боловсролын нэг хэсэг нь “Тора”-г цээжлэх байжээ. Есүс соригдох үедээ Бичвэрийн үгсийг маш хурдан санажээ.

Христэд итгэгчид бид Бурханы Үгийг зүрх сэтгэлдээ суулгах ёстой юм. Сорилтын үед Бичвэр бидэнд уруу татлагатай нүүр тулах хүчийг өгөх болно.

Сорилттой тулгарахдаа Есүс бидэнд байдагтай адил хэрэгслийг ашиглажээ. Бид Есүсийн адилаар Сүнс, залбирал, Үгийн хүчээр сорилттой нүүр тулах хэрэгтэй. Эдгээр зэвсэггүйгээр бид Сатаны дайралтад бүдрэх болно.

### **Сайтар ажиглах нь: Биежилт (Есүс хүн болсон)**

Эртний Христэд итгэгчид Есүсийг Бурхан байсан гэдэгт нийтээрээ санал нэгддэг байлаа. Хэдийгээр Ариус зэрэг тэрс үзэлтнүүд Есүсийн Бурхан чанарыг үгүйсгэж байсан ч ортодокс итгэгчид Есүсийг Бурхан байсан хэмээн заадаг байжээ.

Түүнчлэн ортодокс христитгэл нь Есүсийг бүрэн дүүрэн хүн байсан гэж заасан. Энэ онол сургаалыг ихэвчлэн тэрс үзэлтнүүд үгүйсгэдэг байв. Өнөө цагт ч олон эвангелчүүд Есүсийн хүмүүн мөн чанарыг нухацтай авч үздэггүй. Олон итгэгчид Есүсийг бүрэн дүүрэн Бурхан байсан гэж үздэг ч, Түүний хүмүүн мөн чанар нь бодит байгаагүй гэж хэлдэг. Есүс хүний биеийг зээлснээс биш, бүрэн дүүрэн хүн байгаагүй гэж тэд үздэг.

Зарим номлолын жишээ дүрслэлүүд нь энэхүү худал санааг дэмжихэд хувь нэмэр болдог. Зарим номлогчид тариачны дүр эсгэж аялдаг хааны тухай домгийг өгүүлдэг. Гэсэн хэдий ч Есүс хүний дүр эсгэсэн Бурхан байгаагүй юм. Тэр бидний нэг хэсэг болж ирсэн.

Есүсийн хүмүүн чанарын талаарх онол сургаал нь бидний христитгэлийн амьдрал туршлагад чухал ач холбогдолтой юм. Хэрэв Есүс бүрэн дүүрэн хүн байгаагүй бол Түүний амьдрал бидний хувьд бодит загвар байх боломжгүй. Нэгэн теологич үүнийг "Хэрэв Есүс үнэхээр бидэнтэй адил биш бол бид түүн шиг байхаас чөлөөлөгдөнө"<sup>7</sup> хэмээн өгүүлсэн байдаг.

Олон хүн санаатай нүгэлд бид байнга бүдэрдэг гэж итгэдэг. Харин эгэл жирийн итгэгчид ч Ариун Сүнсний хүчээр нүглийг ялж чадна гэдгийг Есүс хүмүүн чанараараа харуулсан юм.

Хэрэв Есүс эвдэрч сүйдсэн хүн төрөлхтөн бидний нэг хэсэг болсон бол, мөн Тэрээр Сүнсний хүч хэрэгтэй бидний хэрэгцээг мэдэрсэн бол, бидэнтэй адил соригдсон юм бол сорилтыг даван туулсан Түүний ялалт нь бидний өдөр тутмын амьдралд хэрхэн ялалт байгуулахыг харуулдаг. Ариун Сүнсээр дамжуулан бид ялалтын амьдралаар амьдарч чадна.

► Есүсийн Бурхан чанарын тухай онол сургаал эсвэл Түүний хүмүүн чанарын талаарх онол сургаал хоёрын аль нь танд ойлгоход хэцүү байна вэ? Эдгээр онол сургаал нь бидний итгэлийн амьдрал ба үйлчлэлд хэрхэн чухал болох талаар ярилцана уу.

### **Дүгнэлт: Бурхан өөрийн Зарцыг бэлтгэдэг**

Энэхүү хичээлээр бид Бурхан Есүсийн үйлчлэлийн замналыг хэрхэн бэлтгэсэн талаар үзлээ. Түүний удам угсаагаар, Ромын эзэнт гүрнээр, гайхамшигт төрөлтөөр, баптисм Иоханы үйлчлэлээр, тэр ч байтугай сорилтоор дамжуулан Бурхан Есүсийн замыг бэлтгэжээ.

Бид энэхүү үнэнийг Библиэс дахин дахин олж хардаг. Паулын жишээнээс олж харж болно. Тэр Ромын Тарс хотод өссөн бөгөөд хүүхэд ахуй цагаасаа харь үндэстний найз нөхөдтэй байжээ. Ихэнх иудейчүүдээс ялгаатай нь Паул харь үндэстнүүдтэй учир зүйгээ амархан олдог байжээ.

---

<sup>7</sup> Cherith Fee Nordling, "Open Question" *Christianity Today*, April 2015, 26-27

Паулын эцэг нь Ромын иргэн байсан учраас тэр Ромын иргэн гэсэн эрхэм хүндтэй эрхийг олж авсан байна. Харин түүний ээж иудей хүн байсан учраас Паул Хуучин гэрээний Бичвэрүүдэд бага наснаасаа сургагджээ. Тэр оюуны өндөр чадавхитай нэгэн байсан бөгөөд агуу рабби Гамалиелын дор еврейн теологид суралцжээ. Ром гаралтай тэрбээр Грек хэл болон Грекийн гүн ухаантнуудын онол сургаалыг ч судалсан.

Ийм угсаа гаралтай хүнийг Бурхан харь үндэстнүүдэд илгээлтийн эзэн болгон дуудсан нь гайхах зүйл биш юм. Төрсөн цагаас нь Бурхан Паулыг харь үндэстнүүдийн төлөөх анхны Элч болгон бэлтгэжээ. Энэ үйлчлэлд зориулж Бурхан түүнийг хэрхэн бэлтгэсэн талаар бодож үзээрэй:

- Ромын иргэншил нь Паулыг чөлөөтэй аялах боломжтой болгосон.
- Паул еврей, грек хэл сурсан нь түүнд Шинэ гэрээний хамгийн гүн гүнзгий номуудыг бичих багаж хэрэгсэл болжээ.
- Паул Грекийн гүн ухааныг судалсан нь түүнийг Афин зэрэг газруудад Грекийн сэтгэгчидтэй мэтгэлцэхэд бэлтгэл болжээ.

Магадгүй та “Бурхан надад Паул шиг өндөр боловсрол мэдлэг өгөөгүй. Надад сайн сайхан гэр бүл ч байхгүй” гэж хэлж болох юм. Гэхдээ энэ нь зүгээр! Та тэгвэл 1-р зууны чуулганы өөр нэгэн удирдагчийг хараарай.

Симон загасчилж, загасны наймаа хийж өсжээ. Түүнд Паулын адил боловсрол, оюуны чадвар байсангүй. Үнэндээ ойлгоход хэцүү зарим зүйлийг Паул бичсэн гэж хожим нь Петр өгүүлсэн байдаг (2 Петр 3:15-16). Гэвч Бурхан Петрийг хүчирхэг байдлаар ашигласан юм. Паулын гүн гүнзгий үгсэд дарагдсан хүмүүс Петрийн энгийн номлолыг ойлгож чадна.

Бурхан таныг үйлчлэх талбарт тань бэлтгэсэн. Хэрэв та өөрийн бэлтгэл сургуулилалт, мэдлэг боловсрол, Бурханы танд өгсөн бүх зүйлийг Түүний төлөө зориулбал Тэр таныг зорилгынхоо төлөө ашиглах болно. Бурхан дуудсан хүмүүсээ дуудсан үйлчлэлд нь бэлтгэдэг.

## 1-р хичээлийн даалгаврууд

(1) Энэ хичээлээр бид сорилтыг ялан дийлсэн Есүсийн үлгэр дуурайлыг харсан. Доор өгөгдсөн эхний хүснэгтэд сорилтыг ялан дийлж чадсан гурван хүний жишээг Библиэс жагсаана уу. Сорилттой тулгарахад тэдэнд хүч өгсөн нэг зүйлийг анзаарч хараарай. Дараа нь сорилтод бүдэрсэн хүмүүсийн гурван жишээг Библиэс жагсаан бичнэ үү. Тухайн тохиолдол бүрд тэднийг бүдрэхэд хүргэсэн нэг хүчин зүйлийг тодорхойл.

(2) Жагсаасан жишээн дээрээ үндэслэн сорилтын талаар номлол эсвэл Библийн хичээл бэлтгэ. Есүсийн үлгэр дуурайл болон хүснэгтэд жагсаасан жишээнүүдээ оруулаарай.

Сорилтыг ялан дийлсэн	Бичвэр	Ялахад юу нөлөөлсөн бэ?
Иосеф (бэлгийн харилцааны цэвэр ариун байдал)	Эхлэл 39-р бүлэг	Бурханд төвлөрсөн (Эхлэл 39:9)

Сорилтод бүдэрсэн	Бичвэр	Ялагдахад юу нөлөөлсөн бэ?
Петр (Есүсийг үгүйсгэсэн)	Лук 22:54-62	хэт өөртөө итгэлтэй байдал (Лук 22:31-34)





## 2-р хичээл

### Есүстэй адил залбирах нь

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Есүсийн амьдрал ба үйлчлэлд залбирал чухал байсныг таньж мэдэх.
- (2) Есүсийн сургаалаас залбирлын талаарх зарчмуудыг суралцах.
- (3) Бидний өнөөгийн үйлчлэлд залбирал ямар чухал болохыг ухаарах.
- (4) Залбирдаг хүн болох бодит алхмуудыг хөгжүүлэх.

#### Үйлчлэлийн зарчим

Есүстэй адил үйлчлэхийг хүсвэл бид Есүстэй адил залбирах ёстой.

#### Танилцуулга

Профессор Ховард Хендрикс залбирлын талаарх номлолдоо энэхүү ятгалгын үгсийг хэлсэн байдаг:

Таныг Библиэ *залбирахгүй* уншихад Сатан тийм ч их дургүйцэхгүй. Учир нь ийм Бичвэрийн уншлага таны амьдралыг хэзээ ч өөрчлөхгүй. Харин та үүнийг маш сайн мэддэг учраас энэ нь танд сүнслэг бардамналыг өгч магадгүй юм.

Таныг *залбирахгүйгээр* итгэлээ хуваалцахад ч Сатан дургүйцэхгүй байж мэднэ. Учир нь тэр Бурханы талаар хүмүүст ярихаас хүмүүсийн талаар Бурханд ярих нь хамаагүй чухал гэдгийг мэддэг.

Таныг *залбирахгүйгээр* нутгийн чуулганы үйлчлэлд оролцоход ч Сатан дургүйцэхгүй. Учир нь та хэдий идэвхитэй байж болох ч их зүйлийг хийж чадахгүй.<sup>8</sup>

Есүсийн дэлхий дээрх үйлчлэлийн гол цөм нь залбирал байв. Залбирлаас илүү дээр тавигдах зүйл гэж үгүй. Есүсийн үйлчлэл нь тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах харилцаанд нь үндэслэгдсэн байлаа. Тэрээр энэхүү харилцаагаа залбирал, Бурхантай дотно нөхөрлөх байдлаар хөгжүүлж хадгалдаг байжээ.

► Энэ хичээлийг сурахаас өмнө өөрийн амьдрал, үйлчлэл дэх залбирлын үүрэг оролцоог цэгнэж үзээрэй. Асуух:

- Миний залбирлын амьдрал тогтвортой байна уу?

“Залбирал бол сүнсний гимнастик юм.”  
- Самуел Звемер  
“Исламын төлөөх Элч”

<sup>8</sup> Howard G. Hendricks, “Prayer – the Christian’s Secret Weapon.” Веритасд дахин хэвлэгдсэн, January 2004, номоос ашиглав.

- Би залбирлынхаа тодорхой хариултыг хамгийн сүүлд хэзээ харсан бэ?
- Миний залбирлын амьдралд тохиолддог хамгийн том сорилтууд юу вэ?
- Би залбирлын амьдралдаа өсөж байна уу?

## **Есүсийн залбирлын үлгэр дуурайл**

Есүс үйлчлэлийнхээ чухал мөчүүдэд залбирч байсныг бид Түүний үйлчлэлийн бүхий л хэсгээс хардаг. Сайнмэдээний номуудад Есүс залбирсан талаарх 15 тодорхой тохиолдлыг өгүүлсэн байдаг. Есүсийн амьдралд залбирал нь хэзээ ч хоёрдогч зүйл байгаагүй, харин Түүний амьдралын төв байсан юм.

Лук бусад бичигчдээс илүү ихээр Есүсийн үйлчлэл дэх залбирлын талаар онцолж бичсэн. Есүс арван хоёр дагалдагчаа сонгохын өмнө шөнөжин залбирсан талаар зөвхөн Лук өгүүлсэн байдаг (Лук 6:12). Түүнчлэн Есүс Петр, Иаков, Иохан нарыг уул руу дагуулж, залбирах үед дүр төрх нь хувирч өөрчлөгдсөн талаар зөвхөн Лук өгүүлдэг (Лук 9:28). Түүний залбирлын талаар онцолж бичсэн зүйлс Үйлс номд ч үргэлжилдэг бөгөөд анхны чуулганы залбирлын үүрэг оролцооны тухай Лук 35 удаа дурдсан байдаг.

## **Есүсийн өдөр тутмын үйлчлэл дэх залбирал**

► Марк 1:32-39 эшлэлийг унших.

Есүсийн үйлчлэлийн эхэн үед тохиолдсон энэхүү түүх нь залбирал үйлчлэл хэрхэн хоорондоо холбоотой байдгийг харуулдаг. Энэхүү хүүрнэлийн үйл явцыг анзаарч хараарай. Өмнөх орой нь Есүсийн байрлаж байсан байшингийн гадаа хүмүүс цуглаарахад Тэр олон хүнийг эдгээжээ.

Маргааш өглөө нь Есүс үүрээр босож, эзгүй газарт залбирахаар явсан. Симон Петр Түүнийг хайж олоод “Бүгд Таныг эрж байна” гэхэд Есүс “Цөмөөрөө зэргэлдээх суурингуудад очигцооё. Би тэнд ч бас тунхаглах болно. Учир нь Би үүний төлөө ирсэн билээ гэж айлдав.” **Залбирлыг нь үйлчлэл дагалддаг** байсан нь Есүсийн үйлчлэлийн загвар байв.

Үйлчлэлийн загвар ийм байх ёстой. Залбиралгүйгээр бидний үйлчлэл сүнслэг байдлын хувьд цөхөрч туйлдахад хүрдэг. Үйлчлэлгүйгээр бидний залбирлын амьдрал өөртөө төвлөрсөн аминч болж хувирдаг. Бид эргэн тойрныхоо хүмүүсийн хэрэгцээнд үйлчлэх оролдлого чармайлтаа гээдэг. Залбирал, үйлчлэл нь хамтдаа холбоотой байх ёстойг Есүс харуулсан.

## **Шийдвэр гаргах үеийн залбирал**

► Лук 6:12-16 эшлэлийг унших.

Есүсийн үйлчлэлийн хамгийн чухал шийдвэрүүдийн нэг нь арван хоёр элчээ сонгох байлаа. Есүсийн номлолыг сонсдог олон мянган хүмүүс дотроос дагалдагчид гэж нэрлэгдэх Түүнд ойр байсан олон хүн байжээ (Иохан 6:60, 66). Түүний дагалдагчдаас

72 хүн Есүсийн номлох аяллыг төлөөлөх хэмжээний ойр байв (Лук 10:1). Гэсэн ч Есүс арван хоёрыг л элчээр сонгосон юм.

Арван хоёр элч Есүстэй их цагийг хамт өнгөрүүлдэг байсан. Дэлхий дээрх үйлчлэлийнх нь төгсгөл хүртэл тэд Түүнтэй хамт байв. Түүнийг дээш өргөгдсөний дараа элч нарын арван нэг нь анхны чуулганы удирдагчид болцгоосон. Арван хоёрыг сонгох нь маш чухал шийдвэр байжээ. Есүс ямар нэгэн ном бичээгүй, ямар ч сургууль байгуулаагүй. Чуулганы төлөөх Түүний алсын хараа эдгээр хүмүүсээр биелэх учиртай байлаа.

Есүс арван хоёр элчээ сонгохын өмнө юу хийсэн бэ? Тэр залбирсан. Чухал шийдвэртэй нүүр тулахдаа Есүс шөнөжин залбирчээ. Хэрэв Бурханы Хүүд чухал шийдвэр гаргахын өмнө шаргуу залбирах нь чухал байсан бол, биднийг шийдвэр гаргахад залбирал нь ямар чухал үүрэгтэй байх бол!

### **Зовж шаналах үеийн залбирал**

► Матай 26:36-46 эшлэлийг унших.

Есүс баривчлагдахаасаа хэдхэн цагийн өмнө залбирахаар Гетсеманид очжээ. Залбирлаар Тэр зовлон зүдгүүрт өөрийгөө бэлтгэжээ. Есүс хүмүүн чанарынхаа зовлонгоос зайлсхийхийн тулд бурхан чанараа хэзээ ч ашиглаагүй юм. Ингэхийн оронд Тэрээр зовлон зүдгүүрийг давах хүчийг олж авахаар залбиралд түшиглэжээ.

Цэцэрлэгт залбирсан Есүсийн залбирал нь өнөөгийн бидэнд үлгэр дуурайл болдог. Түүний залбирал нь хийсвэр байгаагүй. Есүс бодитоор зовж шаналж байсан. Есүс өвдөлт зовлонд хүмүүн байдлаар хандаж, хариу үйлдсэнийг ойлгох нь танд урам зориг өгч байна уу? Зовлонтой нүүр тулахдаа Есүс тайвшралын төлөө залбирчээ:

Тэр цэцэрлэгт “Өө Эзэн минь, Таны өмнөөс зовж шаналахаар намайг сонгосонд би маш их талархаж байна” гэж залбираагүй. Үгүй ээ, харин Тэр уй гашуу, айдас, хаягдаж, цөхрөлд орсон тийм байдлыг туулсан юм. Гэсэн хэдий ч, Тэр орчлон ертөнцийн төвд хайрын Бурхан, Эцэг нь амьдардаг гэдгийг мэддэг учраас юмс хэрхэн үзэгдэж буйгаас үл хамааран, Түүнд найдаж тэвчсэн юм.<sup>9</sup>

Зовлон зүдгүүртэй нүүр тулахдаа бид байгаагаасаа илүү хүчтэй мэт дүр эсгэх шаардлагагүй. Иов шиг бид гомдсондоо үйлж болох юм. Хүмүүн чанараараа Есүс ч мөн адил зүйлийг хийсэн! Гэсэн хэдий ч бидний хайртай тэнгэрлэг Эцэг маань бүгдийг бүрэн хянаж байгаа тул бид Есүсийн адил итгэмжит хэвээр үлдэж чадна.

Залбирлаар бид Эцэгийн хүслийг хүлээн авч чаддаг. Зовлон зүдгүүртэй нүүр тулсан Есүсийн залбирлын болон зовлон зүдгүүрийн үед бидний залбирлын гол түлхүүр нь Эцэгийн хүсэлд бууж өгөх явдал юм: “Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог гэж” Тэр залбирсан.

---

<sup>9</sup> Philip Yancey, *The Jesus I Never Knew* (Grand Rapids: Zondervan, 1995), 161

## **Залбирлын талаарх Есүсийн сургаал**

Есүс залбирлын ач холбогдлыг өөрийн үлгэр дуурайлаар харуулаад зогсохгүй, сургаалынхаа үлэмж хэсгийг залбиралд хандуулсан байдаг. Дагалдагчдынхаа сүнслэг амьдралд залбирал амин чухал болохыг Есүс мэдэж байсан. Тийм ч учраас Тэр дагалдагчдаа залбирахад зааж сургасан.

### **Есүсийн уулан дээрх сургаал**

► Матай 6:1-18 эшлэлийг унших.

Есүс уулан дээрх номлолдоо ядууст өглөг өгөх, залбирах, мацаг барих гэсэн гурван сүнслэг үйл ажиллагааны талаар заажээ. Энэ нь Есүс дагалдагчдаасаа хүлээж байсан ердийн үйл ажиллагаа гэдгийг сургаалаас нь тодорхой харж болно. Есүс “Хэрэв чи ядууст өгвөл...” эсвэл “Хэрэв чи залбирвал...” юм уу “Хэрэв чи мацаг баривал...” гэж хэлээгүй. Тэр тэднийг өгөөмөр, залбирдаг, сахилга баттай дагалдагчид байгаасай гэж хүсэн хүлээж байв.

Хэрэв эдгээр сахилга батууд нь ялзарсан сэдлээс үүдэлтэй бол энэ нь утга учиргүй болохыг Есүс харуулжээ. “Хоёр нүүрт” гэдэг нь эрт цагт олон янзын баг зүүж, өөр өөр дүрд тоглодог жүжигчнийг хэлдэг байжээ. Ингэж бусдын өмнө “шашинлаг дүрд тоглох” нь боломжтой юм.

- Өгөөмөр байдлаараа бусдыг гайхшруулахын тулд ядууст өгөх нь боломжтой зүйл юм. Есүс тийм хүмүүст “тэд шагналаа бүрэн авсан” гэжээ.
- Гоё чамин үгсээр сонсогчдод сэтгэгдэл төрүүлэхүйц залбирах нь ч боломжтой юм. Есүс тийм хүмүүст “тэд шагналаа бүрэн авсан” хэмээжээ.
- Бусдад сүсэг бишрэл, сахилга батаа гайхуулахын тулд мацаг барих ч боломжтой. Есүс тийм хүмүүст “тэд шагналаа бүрэн авсан” гэж хэлсэн юм.

Дээрх тохиолдол тус бүрд тухайн хүн ядууст өгөхдөө, залбирч, мацаг барихдаа бусдад гайхуулж, сэтгэгдэл төрүүлэхийн тулд эдгээрийг хийжээ. Хүмүүст ихэд сэтгэгдэл төрүүлсэн бол энэ нь түүний шагнал байв. Тиймээс тэр хүн Бурханаас ямар ч шагнал авахгүй юм.

Эдгээр сүнслэг сахилга батыг хэрэгжүүлэх сэдэл нь бидний тэнгэрлэг Эцэгийг баярлуулах учиртай. Ядууст өглөг өгөх, залбирах, мацаг барих бидний шагнал бол Бурхан өөрөө юм. Дэлхийлэг сайшаал, алга ташилтын төлөө бид эдгээр сүнслэг сахилга батыг үйлдэх ёсгүй. Харин үүний оронд Бурханы төлөөх улам бүр гүнзгийрэх хүсэл тэмүүлээр бид эдгээрийг үйлддэг.

Есүс дагалдагч нартаа энгийн бөгөөд шууд байдлаар залбирахыг заасан:

Тэнгэр дэх, бидний Аав аа, Таны алдар ариунаар дуurstугай. Таны хаанчлал иртүгэй. Таны таалал тэнгэрт шигээ газарт бас биелтүгэй. Бидний өдөр тутмын хүнсийг Өнөөдөр бидэнд хайрлаач. Бид өртөнгүүдээ уучилсан адил өөрсдийн

минь өрийг уучлаач. Биднийг уруу татлагад бүү автуулаач, ёрын муугаас гэтэлгээч. Хаанчлал, хүч чадал, алдар суу мөнхөд Таных. Амен (Матай 6:9-13).

Энэ нь Матай 6:7-8 эшлэл дэх Есүсийн буруушаасан утга учиргүй хоосон үг хэллэгээр, ухаангүй давтах залбирал биш юм. Харин оронд нь бидний залбирлыг чиглүүлэх ёстой хандлагын загвар болдог залбирал юм.

### ***Харилцаа***

“Тэнгэр дэх, бидний Аав аа” гэдэг нь бидний Бурхантай ойр дотно харилцаатай байгааг харуулдаг. Бурханыг алс хол байгаа гэхээс илүүтэй хүүхдүүддээ сайн бэлэг өгөх дуртай Эцэг гэдгийг нь бид таньж мэддэг (Матай 7:11). Энэ хэллэг нь ойр дотно байдал (“бидний Аав аа”) болон эрх мэдэл (“Тэнгэр дэх”) аль алиныг нь харуулдаг. Бурхан бол сүр жавхлантай, мөн бодгаль юм.

### ***Хүндлэл***

“Таны алдар ариунаар дуurstугай” гэдэг нь тэнгэр дэх Эцэг ба бидний хоорондын ялгааг харуулдаг. Бурхан хэдийгээр хайр дүүрэн Эцэг боловч, Тэр ариун билээ.<sup>10</sup> Номлогчийн үгс дэх мэргэн хүний сурснаар, бид Бурханы оршихуйд хүндэтгэх, эмээх сэтгэлээр ойртон очих учиртай (Номлогчийн үгс 5:2).

### ***Захирагдах***

“Таны хаанчлал иртүгэй Таны таалал тэнгэрт шигээ газарт бас биелтүгэй” гэдэг нь бидний Түүний эрх мэдэлд захирагдах хүслийг төлөөлдөг. Бурханы хүсэл тэнгэрт төгс биелдэг шиг газар дээр биелээсэй гэж бид залбирах хэрэгтэй юм.

### ***Хангамж***

Дэлхий дээрх хүмүүсийн дийлэнх хувь нь хоол хүнснийхээ төлөө өдөр бүр ажиллах ёстой байдаг. “Бидний өдөр тутмын хүнсийг өнөөдөр бидэнд хайрлаач” гэдэг нь өдөр бүр Эцэгт итгэж найдахыг хэлдэг. Хүүхдүүд нь учраас Тэр бидний хэрэгцээг хангана гэдэгт бид итгэдэг.

### ***Гэмшил***

“Бид өртөнгүүдээ уучилсан адил өөрсдийн минь өрийг уучлаач” Лук 11:2-4 эшлэлд үүнтэй адил залбирлыг “Бидэнд өртэй бүхнээ бид уучилдаг учир бидний нүглийг мөн уучлаач” хэмээн тэмдэглэсэн байдаг. Нэгэнт бидний нүгэл нь Бурханд өр гэж тооцогддог болохоор (Колоссай 2:14) Матай болон Лук номд ижил утгаар бичигджээ.

Бусдыг өршөөж уучилснаар бид Бурханы уучлалыг олж авдаг гэсэн утгаар Есүс энд заагаагүй. Харин бид уучлагдсан учраас бидэнд муу зүйл хийсэн хүмүүсийг сайн дураараа уучилдаг. Есүсийн заасан өршөөл үзүүлдэггүй зарцын тухай сургаалт зүйрлэл

---

<sup>10</sup> “ариунаар” гэдэг нь “ариун” эсвэл “тусгаарлах” гэсэн утгатай үг.

нь бидний уучлал болон бидний бусдыг уучлах хүсэл хоорондын хамаарлыг харуулдаг (Матай 18:21-35).

### **Ялалт**

“Биднийг уруу татлагад бүү автуулаач ёрын муугаас гэтэлгээч” гэдэг нь сорилт, уруу татлагыг ялахын төлөөх залбирал юм. Бурхан хүүхдүүдээ хэзээ ч сорьдоггүй (Иаков 1:13), харин бидний хүн нэг бүр сорилт, уруу татлагатай тулгарах болно (1 Петр 1:6-7). Тэр үед Бурхан биднийг тэсвэрлэхийн аргагүй тийм сорилтод орохыг хэзээ ч зөвшөөрөхгүй (1 Коринт 10:13).

### **Зоримог залбирах тухай Есүсийн сургаал**

► Лук 11:1-13 эшлэлийг унших.

Лук Эзэний заасан залбирлын дараа хүүхдүүдээ сайн бэлэг өгөх дуртай Эцэгт хандан зоримог байдлаар залбирахыг бидэнд заадаг сургаалт зүйрлэлийг өгүүлсэн. Ойрхи Дорнодын соёлд зочиндоо санаа тавихын тулд хөршөөсөө зээлдэг тохиолдол түгээмэл байлаа. Хэрэв тухайн хүн зоригтой асуувал хөрш нь хэрэгцээтэй бүхнийг нь өгөх боломжтой байж. Тухайн хүсэлтэд “Үгүй” гэж хэлэх нь энэ соёлд бүдүүлэгт тооцогдоно. Хэдий хөршийнхөө гэрийнхний тухыг алдуулахыг хүсэхгүй байгаа ч тэр хүн тусламж гуйхаас татгалздаггүй.

Бурхан зоригтойгоор асуудаг хүүхдүүдээ эдгээр сайхан бэлгүүдийг бүр хавьгүй илүү арга замаар өгөхийг хүсдэг. Энэ сургаалт зүйрлэлд гардаг хүн зоримог байдлаар асуудаг шиг бид тэнгэрлэг Эцэгтээ ийнхүү итгэлтэйгээр хандаж чадна. Яагаад? Бурхан бидний хүсэлтээс татгалзах нь Түүнд ичгэвтэр учраас биш, харин бид гуйх, хайх, тогших зөвшөөрлийг Түүнээс хүлээн авсан учраас тэр юм (Лук 11:9).

### **Сайтар ажиглах нь: Еврейчүүдийн заах хэв маяг**

Лук 11:1-13 эшлэлд зочиндоо өгөх хоол хүнс хэрэгтэй байгаа хөршдөө туслахыг хүсдэггүй, орноосоо ч өндийдөггүй нэгэн хүний талаарх түүхийг Есүс өгүүлдэг.

Энэхүү сургаалт зүйрлэлийг ойлгохын тулд та эхлээд еврейчүүдийн заах хэв маяг болох “арай бага ба илүү агуу” гэсэн санааг ойлгох хэрэгтэй. Энэ нь “Хэрэв А (арай бага) нь үнэн бол, Б (илүү агуу) нь **бүр илүү** үнэн байх ёстой” гэсэн санаа юм. Өнөөдөр бид “Хэрэв хүн өлсөж байгаа танихгүй хүнийг хооллож байгаа бол (А), хайраар дүүрэн эцэг хүн өөрийн хүүхдүүдээ **бүр ч илүү** ихээр хооллож санаа тавихгүй гэж үү (Б)” гэсэн утгатай.

Энэ сургаалт зүйрлэлийг уншихдаа “Бурхан тэрхүү залхмаар хөрштэй яг адил юм. Хэрвээ би Түүнийг сайн ятгаж чадвал залбиралд минь заавал хариулна” гэж бодож болохгүй. Есүс тэрхүү залхмаар найзыг тэнгэрлэг Эцэгийн хүсэлтэй харьцуулан харуулж байна. Хэрэв дэлхийн хөрш чинь зоримог хүсэлтэд чинь хариу өгч байгаа бол тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ **бүр илүү** ихээр хариулахгүй гэж үү!

## **Залбирлын талаарх Есүсийн сургаал (үргэлжлэл)**

### **Зоримог залбирлын талаарх Есүсийн сургаал (үргэлжлэл)**

#### ***Залбирал нь харилцаа юм.***

Хэрэв Бурхан хүүхдүүдийнхээ залбиралд хариулахыг хүсдэг бол яагаад Түүний хариулт заримдаа хойшлогддог вэ? Гуй, хай, тогш гэсэн үгс одоо цаг дээр, тушаал хэлбэрээр бичигдсэн. Энэ нь бид үргэлжлүүлэн гуйсаар, хайсаар, тогшсоор байх ёстой гэсэн үг юм. Яагаад?

Нэг шалтгаан нь залбирал бол гуйлт хүсэлтүүдийн жагсаалт биш. Залбирал нь бидний тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах тасралтгүй харилцаа билээ. Паул бидэнд “Тасралтгүй залбир” (1 Тесалоник 5:17) гэж тушаасан шиг Есүс биднийг үргэлжлүүлэн гуйж, хайж, тогшсоор бай гэж тушаасан. Бурхантай тасралтгүй харилцах энэхүү яриагаар дамжуулан бидний харилцаа улам гүнзгийрч өсдөг. Залбирал бол хүсэлтийн жагсаалтаас ч илүү зүйл бөгөөд энэ нь харилцаа юм.

“Залбирал нь юм гуйж, хүссэн зүйлээ авах тухай биш юм. Харин залбирал нь Бурханаас асууж, бидэнд хэрэгтэй зүйлийг авах тухай юм.”  
Филип Янси

#### **Тууштай залбирлын талаарх сургаалт зүйрлэл**

Лук 17-р бүлэгт фарисайчууд Есүсээс Бурханы хаанчлал хэзээ ирэх талаар асуудаг. Есүс тэдэнд хариулахдаа онцгой тэмдгүүдийг хүлээх хэрэггүй бөгөөд оронд нь “Бурханы хаанчлал нь та нарын дунд байна гэв” (Лук 17:20-21). Бурханы хаанчлал нь Есүсийг дагаж буй хүмүүсийн дотор аль хэдийн ирсэн байв.

Дараа нь Есүс дагалдагч нартаа хандаж, Бурханы хаанчлалын талаар заажээ. Тэд Есүсийг улс төрийн хувьд төд удалгүй хаанчилж эхэлнэ гэсэн хүлээлттэй байв. Харин Есүс тэднийг хүлээхэд бэлтгэсэн бөгөөд энэ нь Түүний үхлээс хойш ч хамаатай байжээ. Хүлээж байхдаа тэд залбиралд тууштай байж, сэтгэл алдрахгүй байх ёстой. Үүний дараа Есүс итгэмжит залбирлын талаарх түүхийг өгүүлжээ.

► Лук 18:1-8 эшлэлийг унших.

Эрт үеийн хот суурин газрын шүүгчид хэзээнээс л ажлаа шударга хийдэггүй байжээ. Авлига өгөхөөс нааш хэнийг ч сонсдоггүй байв. Энэ бэлэвсэн эмэгтэйд тэдэнд өгөх мөнгө байгаагүй учраас шүүгчид түүний хэрэг явдлыг сонсохоос татгалзжээ. Гэсэн хэдий ч энэ тууштай эмэгтэй бууж өгөлгүй асуусаар байлаа. Эцэст нь шударга бус шүүгч түүнд “Түүнийг өмгөөлөхөөс, эс тэгвээс тэр ирж үргэлж надад төвөг удах вий” гэжээ.

Энэхүү сургаалт зүйрлэл нь зоримог хөршийн тухай сургаалт зүйрлэл шиг “арай бага ба илүү агуу” заах хэв маягийг ашигласан байна. Та энэ сургаалт зүйрлэлийг уншихдаа дараах байдлаар ойлгож болно:

- Бурхан бол шударга бус шүүгч бус. Бидний Эцэг сонгосон хүмүүстээ шударга байдлыг өгөхийг хүсдэг.
- Бид бол бэлэвсэн эхнэр биш. Тэр танил биш хүн байсан бол, бид Бурханы хүүхдүүд.
- Тэр эмэгтэй шүүгчтэй уулзах боломжгүй байсан бол, бид Есүсээр дамжуулан Бурханд хандах боломжтой болсон.

“Залбирал бол  
Бурханы  
дурамжхан байдлыг  
даван гарах явдал  
бус, харин Түүний  
хүсэлтэй байдлаас  
зуурах юм.”  
- Мартин Лютер

Энэ нь ялгаатай байдлыг харуулж буй сургаалт зүйрлэл юм. Шударга бус шүүгч хүртэл тууштай бэлэвсэн эмэгтэйд хариулж байгаа бол, тэнгэр дэх бидний Эцэг хүүхдүүдийнхээ залбиралд бүр илүү ихээр хариулах нь лавтай.

### **Даруу залбирлын талаарх сургаалт зүйрлэл**

► Лук 18:9-14 эшлэлийг унших.

Есүсийн дараагийн өгүүлсэн сургаалт зүйрлэл нь “Өөрсдийгөө зөвт хэмээн өөрсдөдөө итгээд, бусдыг басамжлагч хэсэг” хүмүүст зориулагджээ. Энэхүү сургаалт зүйрлэл нь залбирлын зөв хандлагын тухай заадаг.

Энэ сургаалт зүйрлэлийн санааг “Өөрийгөө өргөмжилдөг бүгд номхруулагдаж, харин өөрийгөө даруу байлгагсад өргөмжлөгдөнө” гэсэн төгсгөл хэсгээс нь харж болно. Өөрсдийнх нь зөвт байдлын улмаас залбирал нь хариултаа авдаг гэж фарисайчууд боджээ. Харин өөрсдөд нь зөвт байдал байхгүй тийм хүмүүс Бурханы нигүүлслийн ачаар залбиралдаа хариулт авдаг гэдгийг Есүс харуулж байна. Залбирлын хариултыг хэн ч хүртэх зохистой биш юм. Харин Бурхан юуг ч хүртэх зохисгүй хүмүүсийг нигүүлслийнхээ улмаас сонсож, залбиралд нь хариулдаг.

### **Хэрэгжүүлэлт: Христэд итгэгчийн амьдрал дахь залбирал**

Христтэй адил хүмүүс залбирлын хүмүүс байдаг. 19-р зууны Ливерпүүлийн бишоп Ж.К. Райл түүхийн туршид хамгийн агуу нөлөө үзүүлсэн Христэд итгэгчдийн амьдралыг судалжээ. Эдгээр хүмүүсийн зарим нь баян, зарим нь ядуу байсан гэж тэр хэлсэн. Зарим нь боловсролтой, зарим нь боловсролгүй байв. Зарим нь калванист, зарим нь арминианчууд байсан. Зарим нь сүмийн тогтсон ёслолтой, зарим нь чөлөөт байв. “Гэсэн хэдий ч эдгээр хүмүүст нийтлэг нэг л зүйл байсан. Тэд бүгдээрээ залбирлын хүмүүс байлаа.”<sup>11</sup>

Чуулганы түүхийн туршид Христтэй адил хүмүүс нь залбирлын хүмүүс байсаар иржээ. Христэд итгэгч агуу удирдагч Е.М. Баундс өглөө бүр 4:00-7:00 цагийн хооронд залбирдаг байсан. Тэрээр “Ариун Сүнс арга хэлбэрээр бус, харин хүмүүсээр дамждаг.

<sup>11</sup> Matt Friedeman, *The Accountability Connection*. (Wheaton, Illinois: Victor Books, 1992), 37 –д эш татсан.



Тэр техник төхөөрөмж дээр бус, харин хүмүүс дээр ирдэг. Тэрээр төлөвлөгөөг бус, харин хүмүүсийг, залбирлын хүмүүсийг тосолдог”<sup>12</sup> хэмээн бичсэн байдаг.

Жорж Мюллер олон мянган хүүхдүүдэд зориулж асрамжийн газар ажиллуулсан. Тэр хэзээ ч өөр хүнээс тусламж гуйхгүй, харин зөвхөн залбиралд найдна гэж шийдсэн байв. Тэр зөвхөн залбирлаар дамжуулан 7,000,000 гаруй долларыг хүүхдүүдийн төлөө хүлээн авчээ. Зөвхөн асрамжийн газруудыг дэмжээд зогсохгүй тэр бусад олон үйлчлэлд олон арван мянган долларыг зориулж өгсөн байдаг. Жорж Мюллер залбирлын хүчийг мэддэг хүн байлаа.

### **Бид яагаад залбирдаг вэ?**

#### ***Бид Бурханаас хамааралтай учраас залбирдаг.***

Есүс хүмүүн байдлаараа Эцэгтэйгээ харилцахын тулд залбирахыг түшиглэж байсан. Залбирал бол Бурханаас хамааралтай үйл юм. Энэ нь бид өөрсдөдөө биш, харин Бурханд найдаж байгааг харуулдаг.

► Матай 26:31-46 эшлэлийг унших.

“Хэрэв та залбиралгүйгээр ямар ч зүйлийг хийж чадах бол энэ нь үнэхээр хийх зохистой зүйл мөн үү?”  
- Др. Ховард Хендрикс

Симон Петрийн бүтэлгүйтэл нь залбирал ямар чухал болохыг харуулдаг. Есүс дагалдагч нартаа “Та нар энэ шөнө Надаас болж бүгд бүдрэх болно” гэж анхааруулж байсан. Есүс Петрт шууд хандан “Симон оо, Симон оо, үзтүгэй, чамайг буудай мэт шигшихийн тулд Сатан зөвшөөрөл гуйсан” (Лук 22:31) гэж анхааруулсан. Петр хоёр сул талаасаа болж унажээ.

- 1. Петр өөртөө хэт итгэлтэй байсан.** Тэр “Танаас болж бүгд бүдэрлээ ч би хэзээ ч бүдрэхгүй гэхэд.... би Тантай хамт үхэх ёстой болсон ч Таныг үгүйсгэхгүй” (Матай 26:33, 35) гэж хэлж байсан. Бардам зан нь өөрийнхөө хүчинд хэт эрдэх байдлыг Петрт олгожээ.
- 2. Петр залбирсангүй.** Петр өөрийнхөө хүчинд эрдсэн тул Бурханд найдсангүй. Тэр Есүстэй хамт залбирахын оронд унтаж орхисон. Бид Бурханаас бүрэн хамааралтай гэдгээ ухамсарласан үедээ чин сэтгэлээсээ залбирдаг. Дик Ийстмен “Зөвхөн залбирлаар л бид асуудал бэрхшээлүүдээ Бурханд бүрэн даатгадаг”<sup>13</sup> гэжээ.

<sup>12</sup> Edward M. Bounds, *Power Through Prayer*. (Kenosha, Wisconsin: Treasures Media, n.d.), 2

<sup>13</sup> Dick Eastman, *The Hour That Changes the World*. (Grand Rapids: Baker Book House, 1995), 12

### ***Бурханыг бүр илүү мэдэхийн тулд бид залбирдаг.***

Орчин цагийн чуулганы нэг томоохон сул тал бол Бурханы талаарх бидний гүехэн мэдлэг юм. Ихэнхдээ бидний залбирлын хүсэлт маань зөвхөн материаллаг хэрэгцээ, хувийн биелүүлэх зүйлсээс бүрддэг. Бидний олонхи нь “Бурхан минь, миний хүүхдүүдийг өөрийн дүр төрх рүү хэлбэржүүлж өгөөч” гэдгээс илүү “Бурхан минь, миний хүүхдүүдэд сайн ажил олоход нь туслаач” гэж залбирахад их цагийг зарцуулдаг. Бид сүнслэг эдгэрлээс илүүтэй бие махбодын эдгэрлийн төлөө шаргуу залбирдаг. Энэ нь бид залбирлын жинхэнэ утга учрыг маш бага ойлгодог гэдгийг харуулж байна.

“Бид залбирлыг өөртөө ямар нэг зүйл олж авах арга хэрэгсэл гэж үздэг.

Харин Библи дэх залбирлын санаа бол Бурханыг өөрийг нь таньж мэдэх явдал юм.”

- Освальд Чемберс

Залбирлын үндсэн зорилгуудын нэг бол Бурханыг илүү ихээр мэдэх явдал юм. Залбирал дотор бид Бурханы зүрх сэтгэлтэй адил болж хөглөгддөг. Бурханаар хүссэн зүйлээ хийлгэх нь залбирал биш юм. Бурханы хүсэж байгааг бид хүсэх хүртэл Бурханы зүрх сэтгэлийн талаарх мэдлэгийг залбирал бидэнд өгдөг.

Бидний залбирал ба хүсэл нь Бурханы хүсэлд бүрэн нийцэх үед “Та нар юуны төлөө залбиран гуйна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно” (Марк 11:24) хэмээн Есүс хэлжээ. Бидний зүрх сэтгэл Бурханы сэтгэлтэй нийцэж эхлэх учраас бид буруу сэдлээр эсвэл Бурханы хүслийг эсэргүүцэх зүйлсийг асууж залбирахгүй (Иаков 4:3 болон 1 Иохан 5:14). Энэхүү Бурханы зүрх сэтгэлийн талаарх мэдлэг нь байнгын залбирлаар дамжин ирдэг.

Пуританчууд “бид залбирах хүртлээ залбирах ёстой” гэж хэлдэг байжээ. Өөрөөр хэлбэл, бид хоосон үгсийг орхиж, Бурханы оршихуйд орохын тулд хангалттай удаан, тэвчээртэйгээр залбирах ёстой гэсэн санаа юм. Бид Бурханыг баярлуулах хүртлээ залбирах ёстой.

► Залбирал танд Бурханы болон Түүний хүслийн талаар гүн гүнзгий мэдлэг өгч байсан үеийн талаар ярина уу.

### **Бид хэрхэн залбирах вэ?**

Есүсийн залбирлын үлгэр дуурайлд суралцсанаар бид үр нөлөөтэй залбирах чухал сургамжуудыг авах болно.

### ***Бид тэвчээртэй залбирдаг.***

Есүс Бурханы Хүү байсан. Түүний залбирлын амьдралыг “Эцэг минь, та намайг юу хийгээсэй гэж хүсэж байна?” гэж залбираад л тэр даруй хариугаа авдаг тийм хялбар, энгийн залбирал мэтээр хүмүүс ойлгодог. Гэтэл оронд нь Есүс арван хоёр элчийг сонгохын өмнө шөнөжин залбирч байсныг бид хардаг. Бид Түүнийг Гетсемани цэцэрлэгт

залбирал дотор тэмцэлдэж байсныг мэднэ. Залбирал, Есүсийн залбирал ч мөн адил тэвчээр, цаг хугацааг шаардаж байв. Залбирал бол Бурханыг хүлээх явдал юм.

Гленн Паттерсон залбирлаар хүлээх тухай, үүний ач холбогдлын талаар “Биднийг хүлээж байх зуур Бурхан бидний дотор юу хийж байгаа нь бидний залбирлаараа хүлээж байгаа зүйлтэй адил чухал юм. Хүлээх нь Бурхан биднийг хэн байлгахыг хүсэж байгаагчлан буй болгох үйл явцынх нь хэсэг байдаг” гэж хэлжээ. Бид Бурханыг хүлээх тусам Түүнийг илүү сайн мэдэхэд суралцдаг.

Дуулал 37:1-8-д залбирлын талаарх чухал сургамжууд бий. Эдгээр тушаалуудыг үзнэ үү:

- Санаа бүү зов.
- Эзэнд итгэ.
- Эзэнд баярлагтун.
- Эзэнд замаа даатга.
- Түүнд итгэж найд.
- Эзэн дотор дуугүй бай.
- Түүнийг тэвчээртэйгээр хүлээ.
- Уурлахаа боль.
- Санаа бүү зов (давтан!)

Эдгээр тушаалууд нь таны төлөө санаа тавьдаг, зүрхний чинь хүслийг танд өгөх (Дуулал 37:4) Бурханд тэвчээртэйгээр итгэж найдахыг заадаг. Тэвчээртэй залбирлаар дамжуулан бид Бурханы хүсэж буй итгэж найддаг хүмүүс болдог.

### ***Тууштай залбирлын жишээ***

Жорж Мюллер итгэлийн амьдралынхаа эхэн үед таван найзаа итгэгч болоосой гэж залбирч эхэлсэн. Олон сарын дараа тэдний нэг нь Эзэн рүү ирсэн. Арван жилийн дараа өөр хоёр нь итгэгч болов. Дөрөв дэх найз нь аврагдах хүртэл 25 жил зарцуулагджээ.

Мюллер тав дахь найзынхаа төлөө үхэх хүртлээ залбирсан. Тэр 52 жилийн турш найз нь Христийг хүлээн аваасай гэж залбирахаа хэзээ ч зогсоогоогүй юм! Мюллерийн оршуулгаас хэдхэн хоногийн дараа тав дахь найз нь аврагджээ. Мюллер тууштай залбиралд итгэдэг байв.

“Хүмүүс бидний уриалгыг үл тоомсорлож, бидний номлолыг үгүйсгэж, хэлэлцүүлэг санааг маань эсэргүүцэж, бидний хүмүүсийг дорд үзэж болно. Харин тэд бидний залбирлын өмнө хүчин мөхөстдөг.  
- Ж. Сидлов Бакстер

### ***Бид даруугаар залбирдаг.***

Есүс “Миний хүслээр бус, харин Таныхаар болог” (Лук 22:42) гэж залбирсан. Есүс Эцэгийнхээ төгс хүсэлд найдаж болно гэдгийг мэддэг байв.

Залбирал бол даруу байдлын үйл юм. Бид бусдад өөрсдийн мэргэн ухаанаар тусалж чадахгүй учраас бусдын төлөө залбирдаг. Бид Бурханд найдвараа тавих учиртай.

Түүнчлэн бид амьдралаа өөрсдийн хүчээр удирдаж чадахгүй учраас бид өөрсдийнхөө төлөө ч залбирдаг. Бид Бурханыг түших ёстой.

Бидэнд Бурханы тусламж хэрэгтэйг залбирал ойлгуулдаг. Амьдралын асуудал бэрхшээлүүдээ өөрсдийн чадлаар шийдвэрлэнэ гэдэгтээ итгэлтэй байгаа хүн үнэн сэтгэлээсээ залбирах нь юу л бол. Бид амьдралаа өөрсдийнхөө хүчээр удирдаж чадахгүй гэдгээ ухаарсан үедээ бид даруугаар залбирдаг.

Бидний залбирал Бурханд бүрэн найдсан, даруу хандлагатай байх ёстой. Бид Бурханаас залбирлын хариултаа амар тайван ба баталгаа дотор хүлээж чадна. Учир нь хүүхдүүддээ хамгийн сайн сайхныг хүсдэг, бидэнд хайртай тэнгэрлэг Эцэгтээ хандан бид залбирдаг шүү дээ. Амьдрал ба үйлчлэлээс ирэх дарамт шахалт дунд даруу залбирал нь Бурханд чимээгүйхэн найдах итгэлийг өгдөг.

### **Бид хувьчлан залбирдаг.**

Есүс дагалдагч нартаа “бидний Аав аа” хэмээн Бурханд хандан хүнийхээ хувьд залбирахыг заасан. Жинхэнэ залбирал нь бодгаль шинжтэй. Паул Мюллер “Олон хүн Бурханд бус, харин залбирахад анхаарлаа төвлөрүүлдэг учраас залбиралд суралцахдаа түүртдэг”<sup>14</sup> гэжээ. Бид ихэнхдээ Бурхантай ярихаас илүүтэй “залбирлыг хэлдэг.” Энэ нь залбирахдаа “хоосон үг” (Матай 6:7) хэрэглэхгүй байхыг заасан Есүсийн анхааруулгын гол утга учир юм.

Оройн хоолны ширээн дээр цээжилсэн үг хэллэгтэй хүн ирж байна гэж төсөөлье. Тэрээр “Би гэр бүлийнхэнтэйгээ яриа өрнүүлэхийг хүсэж байгаа тул хэлэх үгээ бэлдэж цээжилсэн” гэж хэлвэл ямар сонсогдож байна. Мэдээж энэ бол жинхэнэ ярилцлага байж таарахгүй. Хүн хэрэглэх үгэндээ биш, харин ширээ тойрон сууж буй хүмүүст анхаарлаа хандуулах нь зөв зүйтэй.

Өөрсдөө бичсэн, эсвэл бусад хүмүүсийн бичсэн залбирал нь залбиралд багтаах ёстой сэдвүүдийг санахад бидэнд тусалж болох ч, залбирал нь цээжилсэн үгсээс илүүтэй Бурханд төвлөрөх ёстой. Залбирал нь систем биш, харин харилцаа юм. Иймд залбирал бодгаль чанартай байх учиртай.

### **Бид хэрхэн залбирлын хүмүүс болох вэ?**

5-р зууны үед Ромын язгууртан Анисиа Фалтониа Проба гэгч хүн Августинаас залбирлын талаар зөвлөгөө авахыг хүсжээ. Проба хэрхэн залбирлын хүн болж болохыг мэдэхийг хүссэн. Августин залбирлын тухай мэргэн зөвлөгөө бүхий урт захидлыг түүнд явуулжээ.<sup>15</sup> Энэ хэсэгт бид Августины залбирлын зарчмуудаас суралцах болно.

---

<sup>14</sup> Paul E. Miller, *A Praying Life: Connecting with God in a Distracting World*. (Colorado Springs: NavPress, 2009)

<sup>15</sup> Philip Schaff, ed. *The Confessions and Letters of St. Augustine: Nicene and Post-Nicene Fathers, First Series, Volume 1*. (Buffalo, New York: Christian Literature Publishing Company, 1886), 459-469

### ***Ямар хүн залбирлын хүн болж чадах вэ?***

Нэгд, залбирч буй хүн өөр ямар ч нөөц, эх сурвалжгүй хүн байх ёстой гэж Августин хэлжээ. Залбирдаг хүн зөвхөн залбирлыг л түшиглэнэ.

Проба нь Ромын хамгийн нөлөө бүхий, чинээлэг хүний бэлэвсэн эхнэр байжээ. Түүний гурван хүү нь Ромын консулаар ажиллаж байв. Августин Пробад “өөрийгөө энэ дэлхийд хоосорч, хаягдсан гэж тооцоорой” хэмээн бичжээ. Бид хичнээн чинээлэг, хүчирхэг, амжилттай байсан ч Бурханы өмнө сул дорой, арчаагүй байдлаа хүлээн зөвшөөрөх ёстой. Эс бөгөөс бидний залбирал татвар хураагчийнхтай адил бус, харин фарисайн залбиралтай адил байх болно.

### ***Бид юуны төлөө залбирах ёстой вэ?***

Августин Пробад сонирхолтой зөвлөгөө өгсөн. Тэрээр “Аз жаргалтай амьдралын төлөө залбир” гэж хэлж. Энэ нь хувиа хичээсэн сонсогдож болох ч, жинхэнэ аз жаргал зөвхөн Бурханаас ирдэг гэж Августин тайлбарласан байдаг. “Жинхэнэ аз жаргалтай хүн бол хүссэн бүхэн нь байгаа ч, зохисгүй, хор хөнөөлтэй зүйлсийг хүсэж шунадаггүй” тэр хүн юм гэжээ.

Христэд итгэгч хүн аз жаргалтай хүн юм. Учир нь түүнд Бурхан байгаа бөгөөд Бурхан түүнд байлгахыг хүсээгүй зүйлийг тэр өөртөө байлгахыг хүсдэггүй. Дууллыг бичсэн хүнтэй адил бид Бурханы оршихуйд сэтгэл хангалуун байдаг.

ЭЗЭНээс миний гуйсан, эрэх ганцхан зүйл гэвэл ЭЗЭНий гоо сайхныг харж, сүмд нь бясалган, амьдралынхаа бүхий л өдрүүдэд ЭЗЭНий өргөөнд суух явдал (Дуулал 27:4).

Хэрэв бид бүхнээс илүү Бурханы оршихуйг үнэхээр хүсэмжилдэг бол Бурхан бидэнд өөрийгөө өгснөөр бидний гүн гүнзгий хүсэл тэмүүллийг хангах болно гэдгийг мэдэх тийм аз жаргалын төлөө залбирч чадна!

### ***Хүнд хэцүү цаг үед бид хэрхэн залбирах вэ?***

Паул “учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй... ” (Ром 8:26) тийм үе тулгарна гэдгийг мэдэж байсныг Августин Пробад сануулжээ. Бид ямар ч тусламжгүй, арчаагүй байдалд байх үедээ хэрхэн залбирах вэ?

Августин Бичвэрийн гурван хэсгээс өгүүлдэг. (1) Тэрээр Паулын “махбодод... өргөс” буй бөгөөд үүнээсээ аврагдахын төлөөх түүний залбирлын жишээг онцолсон. Бурхан түүнийг чөлөөлөхийн оронд “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” хэмээн амласан. Паул цааш нь “Иймд Христийн хүч надад орших тул би ихэд баяртайгаар мөхөсдөлөөрөө илүү сайрхана... Учир нь би хэзээ мөхөсдөнө, тэр үедээ хүчтэй байдаг” (2 Коринт 12:8-10) хэмээн гэрчилжээ.

(2) Августин Гетсеманид залбирсан Есүсийн үлгэр дуурайлыг дурдсан. Есүс өөрийн хүслийг Бурханд захируулсан. Есүс чөлөөлөлтийн төлөө “Эцэг минь, болж өгвөл Надаас

энэ аягыг өнгөрүүлээч” гэж хэлээд, төгсгөлд нь “Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог” (Матай 26:39) хэмээн залбирчээ.

(3) Төгсгөлд нь Августин Ром 8:26-г заасан. Бид хэрхэн залбирахаа мэдэхгүй байх үед Ариун Сүнс бидний зүрх сэтгэлийг удирдан чиглүүлдэг. Сүнс бидний сул дорой байдалд тусалж, үгээр илэрхийлшгүйгээр ёолон бидний төлөө зуучлан залбирдаг. Үгээр илэрхийлж чадахгүй тийм үед Ариун Сүнс бидний залбирлыг Эцэгт авчрахад, Тэр хүлээн авч, Бурханы зорилгын дагуу дуудагдсан хүмүүсийн сайн сайхны төлөө бүх зүйлсийг хамтад нь ажиллуулдаг (Ром 8:26-28).

### **Дүгнэлт: Та хэрхэн залбирахаа мэдэхгүй байх үед**

Заримдаа чимээгүй байх нь таны хийж чадах хамгийн сайн зүйл байх үе бий.<sup>16</sup> Та залбирахыг хүсдэг ч, яаж гэдгээ мэдэхгүй, залбирал амнаас гарахгүй тийм үе байдаг. Ийм үед юу хийх вэ? Нэг нууц нь Христ бидний Агуу Тэргүүн Тахилч гэдгийг ойлгох явдал юм.

Евангелийн итгэгч хүмүүсийн хувьд, бүх итгэгчид тахилч гэдэгт бид итгэдэг. Энэхүү Шинэчлэлийн агуу онол сургаал нь бидний хүн нэг бүр Эцэгт хандах боломжтой гэдгийг заадаг. Гэсэн хэдий ч, энэ онол сургаал буруугаар ойлгогдвол сүнслэг төвөгтэй байдалд хөтөлж, “Би хангалттай залбирсан уу? Би үнэхээр өөрийн хийх зүйлээ хийж байна уу?” гэх зэрэг эргэлзээнд хүргэх боломжтой.

2013 онд болсон нэгэн конференц дээр профессор Алан Торранс эдгээр асуултуудтай нүүр тулж, тэмцэлдэж байгаа талаараа ийнхүү гэрчлэн ярьсан юм.

2008 оны 1-р сард миний эхнэр Жэйн хорт хавдраар нас барсан. Тэр минь хамгийн гайхалтай Христэд итгэгч эмэгтэй, эхнэр, ээж байсан юм. Хорт хавдар нь биеэр нь тархаж, өвдөж үхэхийг нь харах хэцүү, хүүхдүүд маань ээжийгээ зовж байгааг харах аймшигтай хэцүү байж билээ. Би уй гашуун дунд яаж залбирах, юуны төлөө залбирахаа ч мэдэхээ больсон үе байлаа. Би яаж залбирахаа мэдэхгүй байсан.

Тэр үед Христийн тахилчийн үйлчлэл миний ярьж чадахаас ч илүү их тус болсон юм. Би Жэйнийг тэвэрч өргөх үед дээш өргөгдсөн тахилч (Есүс Христ) бидний өмнөөс зуучлан залбирч байлаа. Бид Түүний оршихуйд амарч чаддаг билээ.

Тэр үед миний залбирдаг байсан гуйлт Эзэний заасан залбирал байв. Би энэ залбирлыг зөвхөн ганцаараа залбираагүй. Түүнчлэн “Тэнгэр дэх **миний** Аав аа, та миний байгаа газраас дэндүү хол байна” гэж залбираагүй, харин Ариун Сүнсээр дамжуулан би “Тэнгэр дэх, **бидний** Аав аа, Таны алдар ариунаар дуurstугай. Таны хаанчлал иртүгэй. Таны таалал... биелтүгэй” гэж залбирсан юм.

---

<sup>16</sup> Энэ хэсгийг Marc Cortez, *Everyday Theology* номоос ашиглав.

Христийн үргэлжилсээр буй тахилчийн үйлчлэлийн ач холбогдлыг олж илрүүлэх нь сайнмэдээ бидний амьдрал, мөргөл хүндэтгэлийн бүх хэсгийг хувьсган өөрчилдөг гэдгийг таньж мэдэх явдал юм.

Бүх итгэгчдийн тахилчийн үйлчлэлийг ярихдаа бид өөрсдийн сүнслэг хүчээр Эцэгт ойртон очих ёстой гэж бодвол энэ нь буруу ойлголт юм. Энэ бол алдаа. **Христээс өөр зуучлагч бидэнд хэрэггүй** гэдгийг бүх итгэгчдийн тахилчийн үйлчлэл онцолдог. Тэр бол бидний төлөө зуучлан залбирагч бөгөөд бидний дутуу дулимаг залбирах оролдлогыг хүлээн авч, Эцэг хүлээн авахуйц тахил золиос болгон өргөдөг Нэгэн билээ. Бидний залбирал Сүнсээр хүчирхэгждэг бөгөөд бидний Тэргүүн тахилч Есүс Христээр зуучлан хүрдэг.

Хэрхэн залбирахаа мэдэхгүй байгаа бол бүү цөхөр. Бидний төлөө залбирч, бидний хажууд өвдөг сөгдөн, Эцэгт зуучилж, бидний хэлж чадахгүй зүйлийг хэлдэг Нэгэн бидэнд бий.

## **2-р хичээлийн даалгаврууд**

(1) Библийн эшлэл хайх програм эсвэл конкорданс ашиглан Библиэс залбирлын гурван жишээг олоорой. Залбирал бүрийг Эзэний заасан залбиралтай харьцуулж үз. Библи дэх бусад залбирлууд Эзэний заасан залбирлын аль хэсэгтэй тохирч байна вэ? Дараагийн хуудас дахь хүснэгтийг ашиглан олж харсан зүйлээ бичнэ үү.

(2) Нэг сарын турш залбирлын тэмдэглэл хөтөл. Залбиралдаа урам хугарсан тухайгаа, залбирлаар ялалт байгуулсан болон залбиралд өгсөн Бурханы хариулт зэргийг тэмдэглээрэй. Залбирлын амьдралдаа өсөхөд урам болох үүднээс энэ тэмдэглэлийг ашиглаарай.

Библийн дагуух Залбирал	Бичвэр	Залбирлын хэсгүүд
Нехемиагийн залбирал	Нехемиа 1:5-11	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцаа: “гэрээгээ сахигч”</li> <li>• Хүндлэл: “Аугаа хийгээд сүрдэм Бурхан”</li> <li>• Захирагдах: “зарцынхаа залбирлыг”</li> <li>• Хангамж: “зарцдаа зориулан энэ өдрийг амжилттай болгон”</li> <li>• Гэмшил: “Израилын хөвгүүдийн нүглийг улайж байна”</li> </ul>



## 3-р хичээл

### Есүстэй адил удирдах нь

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Есүсийг агуу удирдагч болгосон зан чанаруудыг таньж мэдэх болно.
- (2) Бурханаас өгөгдсөн дуудлага, үүрэг даалгавар нь түүний өдөр бүрийн эрхэмлэх зүйлсийг тодорхойлдог болохыг хүлээн зөвшөөрөх.
- (3) Ирээдүйн удирдагчдыг сургах, үйлчлэлийн багийг бүрдүүлэх үйл явцыг боловсруулах.
- (4) Өөрийн удирдаж буй хүмүүстээ үйлчлэх үүргээ үнэлж сурах.

#### Үйлчлэлийн зарчим

Удирдагчид бусдад үйлчилж байхдаа Есүстэй хамгийн адилхан байдаг.

#### Танилцуулга

*Удирдлага* гэдэг нь хүчтэй мэдрэмжийг өдөөдөг үг юм. Дэлхийлэг сэтгэлгээгээр хүмүүс удирдлагын тухай бодохдоо эрх мэдэл, албан тушаалыг чухалчилдаг. Тэдний хувьд удирдагч байх нь “Босс” байх явдал. Амбицтай удирдагчид өндөр албан тушаалд хүрч, хамгийн дээд цол хэргэмийг хүртэхийг хүсдэг. Ингэж боддог пасторууд ч байх боломжтой. Тэд чуулганаа илүү том болгох, өндөр албан тушаал, илүү их хүндлэлийг олж авахад гол анхаарлаа хандуулдаг.

Энэхүү дэлхийлэг сэтгэлгээний хариу болгон зарим Христэд итгэгчид *удирдлага* гэсэн нэр томъёоны эсрэг хариу үйлдлийг үзүүлдэг. Нэгэн пастор “Би чуулгандаа удирдагч байхыг хүсэхгүй байна. Би зүгээр л үйлчлэхийг хүсэж байна” гэж хэлжээ. Хэдийгээр түүний мэдэгдэл даруухан сонсогдож болох ч, энэ нь чуулганд нь ямар ч зорилго, чиглэлгүй байдлыг үлдээсэн юм. Бүх байгууллага, чуулгануудад хүртэл удирдагч хэрэгтэй.

*Пастор* гэдэг үгийн язгуур утга нь “хоньчин” гэдгийг пасторууд санаж байх ёстой. Хоньчин хүний ажил тийм ч дурламаар сайхан ажил биш! Хоньчин хүн элдэв үнэртэй хоньдтойгоо өдрийг өнгөрөөдөг. Түүний хийдэг зүйлсэд хоол, ус олох, тэнүүчилж одсон хургануудтайгаа хөөцөлдөх, гэмтэж бэртсэн хоньдоо анхаарч асрах гэх мэт уйтгартай ажлууд багтдаг.

Хоньчин хүн чухал үүрэг гүйцэтгэдэг. Хоньчин олон хүнд хүчир дорд ажлуудыг хийдэг ч хонин сүргээ аюулгүйгээр удирдан чиглүүлэх бүр илүү хүнд үүрэг хариуцлага хүлээдэг. Хонин сүрэг хоньчноос хамаардаг бөгөөд тэр бол удирдагч хүн юм.

Есүс жинхэнэ удирдагчийн хамгийн төгс үлгэр дуурайлыг харуулсан. Тэрээр даруухнаар үйлчилдэг хоньчин байсан ч, гүн гүнзгий зорилготой байв. Тэр хүчтэй байсан ч, мөн энэрэх сэтгэлээр дүүрэн байлаа. Тэр албан тушаал хайгаагүй ч, өөрийн үүрэг даалгавар, эрхэм зорилгодоо итгэл төгс байсан юм. Есүс үйлчлэгч-удирдагчдад үлгэр дуурайлыг харуулсан.

► Өөрийн хувьчлан таньдаг хамгийн амжилттай удирдагчийн талаар бодож үзээрэй. Энэ хүнийг сайн удирдагч болгосон гурав, дөрвөн шинж чанарыг жагсаана уу. Эдгээр шинж чанаруудыг Есүсийн үйлчлэлээс харж болох уу? Эдгээр шинж чанарууд таны үйлчлэлээс харагддаг уу?

Жинхэнэ удирдлагад даруу үйлчлэл багтдаг гэдгийг Есүс харуулсан. Даруу байдал нь сул дорой байдал эсвэл шийдэмгий бус байх гэсэн үг биш юм. Есүс хүчтэй хүн байсан. Сайнмэдээний номуудад Есүсийн эрх мэдлийг дахин давтан харуулдаг.<sup>17</sup> Хэдий тийм боловч Есүс хүндлүүлэхийг шаардаж бус, харин үйлчилснээр эрх мэдлийг олж авсан юм. Дагалдагч нар нь хаанчлал дахь байр суурийн талаар маргалдах үед Есүс:

Харийнхны хаад ард олноо ноёрхдог бөгөөд эрх баригчид нь “Буянтнууд” хэмээгддэг. Харин та нар тийм байж болохгүй. Та нарын дунд хамгийн агуу нь хамгийн өчүүхэн нь мэт болог, удирдагч нь зарц мэт байг. Ширээнд тухлагч, үйлчлэгч хоёрын хэн нь агуу вэ? Ширээнд тухлагч нь биш гэж үү? Харин Би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг (Лук 22:25-27).

Энэ хичээлээр бид Есүсийг агуу удирдагч болгосон шинж чанаруудаас үзэж, Түүний үлгэр дуурайлыг дагаснаар хэрхэн илүү үр нөлөөтэй удирдагчид байхад суралцах болно.

### **Үр нөлөөтэй Христэч удирдагч өөрийн үүрэг даалгаврыг мэддэг**

Агуу удирдагч нь тов тодорхой үүрэг даалгавартай нэгэн бөгөөд тэрхүү эрхэм зорилгодоо нэгэн үзүүрт сэтгэлээр төвлөрдөг. Есүс өөрийн үүрэг даалгаврыг мэдэж байсан. Марк 10:45-д Түүний үүрэг даалгаврын талаар “Учир нь Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ...” гэж дүгнэсэн байдаг.

Есүс олон нийтэд зориулж номлосон анхны сургаалдаа Исаиагийн эш үзүүлсэн үүргийг биелүүлэхээр ирсэн гэдгээ сонсогчдод:

“Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах,

---

<sup>17</sup> Матай 7:28-29, Марк 1:22-28, Лук 4:32-36, Лук 20:1-8

сохруудад хараа оруулах, дарамтад байгсдыг чөлөөлөхийн сацуу, Эзэний тааламжит жилийг тунхаглахын тулд болой гэж уншаад..." (Лук 4:18-19, Исаиа 61:1-3-аас эш татсан) ийн өгүүлжээ.

Есүсийн үүрэг даалгавар нь түүний өдөр тутмын шийдвэрүүдийг чиглүүлдэг байв. Түүнийг Иудейгээс Галил руу аялах үед үүрэг даалгавар нь Түүний замыг удирдан чиглүүлсэн. Иудей раббичууд самаричуудыг бузартсан гэж үздэг байсан тул тэднээс зайлсхийж, ихэвчлэн Йордан голын зүүн эрэг дагуу аялдаг байжээ. Гэсэн хэдий ч, үүрэг даалгавар нь Есүсийн замыг самари эмэгтэйтэй уулзаж, Бурханы нигүүлслийг хуваалцахад хөтөлсөн. Үүний улмаас Тэр Самариар дамжин өнгөрөх шаардлагатай болжээ (Иохан 4:4). Христэч удирдагчийн хувьд таны үүрэг даалгавар өдөр тутмын тань шийдвэрүүдийг чиглүүлэх ёстой.

Удирдагч хүний хувьд таны гүйцэтгэж чадахаас ч илүү их хийх зүйл бий. Та чухалчлах зүйлсээ хэрхэн тодорхойлдог вэ? Та бүх зүйлийг хийж чадахгүй, бүгдийг **хийх ч ёсгүй**. Өөрийн эрхэм зорилгын дагуу боломжуудаа та үнэлж үзэх учиртай. Удирдагч бүрд "Хийх" болон "Хийхгүй" гэсэн хоёр төрлийн жагсаалт байх хэрэгтэй. "Хийх" ажлын жагсаалтад таны гүйцэтгэх ёстой зүйлс багтсан байх бол "Хийхгүй" жагсаалтад таны анхаарлыг үүрэг даалгавраас тань холдуулах зүйлс багтдаг. Өөр хэн нэгнийг эдгээр зүйлсийг хийлгэхээр дуудаж болох ч, харин та тэр хүн нь биш юм. Таны үүрэг даалгавар өдөр тутмын тань чухалчлах зүйлсийг чиглүүлэх ёстой.

Элч Паул бол өөрийн үүрэг даалгавраа мэддэг удирдагчийн үлгэр дуурайл юм. Паул Ромын эзэнт гүрний гол хотуудад чуулган байгуулахаар дуудагджээ. Тэр өөр хэн нэгний суурин дээр барихыг хүсээгүй, харин сайнмэдээг сонсоогүй хүмүүст хүргэхийг хүссэн (Ром 15:20). Энэхүү үүрэг даалгавар нь Паулыг хаашаа аялахыг, тухайн газар оронд хэр удаан байхыг, түүнчлэн түүний номлол сургаалыг ч чиглүүлж байв. Паулын үүрэг даалгавар нь шийдвэр бүрийг нь чиглүүлсэн.

► Эдгээр асуултуудын дагуу ярилц:

- Бурханы танд өгсөн үүрэг даалгавар юу вэ? Үүрэг даалгавраа цөөн үгээр дүгнэж хэлнэ үү.
- Таны үйлчлэлд нэгддэг хүмүүст та тэрхүү үүрэг даалгаврынхаа талаар мэдэгдсэн үү?
- Таны өдөр тутмын шийдвэрүүдийг таны үүрэг даалгавар чиглүүлдэг үү?

### **Үр нөлөөтэй Христэч удирдагч бусад удирдагчдыг сургаж бэлтгэдэг**

Есүс үйлчлэлийнхээ эхнээс хэсэг хүмүүсийг няхуур сонгож, Эцэг рүүгээ буцсаны дараа Түүний үйлчлэлийг үргэлжлүүлэх дагалдагчдаа сургаж бэлтгэсэн. Эдгээр дагалдагчид Түүнээс суралцаж, Түүнтэй хамт цагийг өнгөрөөж, Түүнтэй хамт үйлчилж, Түүний сургаалыг дэлхий даяар түгээжээ. Есүс эдгээр дагалдагчдаа өөрийн дүр төрхөөр тамгалж, дараа нь өөрийн чуулганыг байгуулахад ашигласан юм.

Лук үйлчлэлийн бэрхшээл дарамтын талаар “тэр хооронд хүмүүс үй түмээрээ хуран цуглаж, нэг нэгнээ гишгэчин байв. Тэр эхлээд шавь нартаа...” (Лук 12:1) хэмээн тэмдэглэсэн. Мянга мянган хүнд үйлчлэх нь илүү бахдалтай байж болох ч Есүс дагалдагч нартаа үйлчлэх ажлаа орхигдуулж байгаагүй юм. Тэрээр хаанчлалыг байгуулахын тулд дагалдагч нараа чуулганыг удирдахад сургах ёстой гэдгийг мэдэж байлаа. Дагалдагчдыг сургаснаар бид дараа үеийн удирдагчдыг бэлтгэдэг.

“Есүс ямар ч ном бичиж үлдээгээгүй. Харин элч нар гэгдэх хүмүүст сургаалаа заасан юм.”  
- Виллиам Барклей

Паул ч мөн үүнтэй адил замналыг үргэлжлүүлсэн. Тэр олон хүмүүст хандан номлодог байсан ч хот болгонд цөөн удирдагчдыг бэлтгэхэд анхаарлаа хандуулж байсан. Энэ нь өнөөгийн удирдагчдад ч дуурайх загвар болдог. Паул пасторуудыг ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэхээр дуудагдсан гэж хэлсэн байдаг (Ефес 4:12). Пастор хүн чуулганы бүх ажлыг хийх үүрэгтэй биш, харин тэр гишүүдийг чуулганы ажилд сургаж, бэлтгэх үүрэг хариуцлагатай. Үр нөлөөтэй удирдагчид бусад удирдагчдыг сургадаг.

### **Дагалдагчдыг халамжлах Есүсийн загвар**

#### **Халамжлагч хүн дагалдагчдыг няхуур сонгодог<sup>18</sup>**

► Иохан 1:35-51, Иохан 2:1-11, Матай 4:18-22, Лук 5:1-11, Лук 6:12-16-г унших.

Та эдгээр эшлэлийг уншиж байхдаа үйл явцыг анзаарч байна уу? Есүс олон нийтэд үйлчлэх эхний долоо хоногтоо Андрей, Иохан хоёрыг өөрийг нь дагахад урьжээ. Андрей Симон Петрийг Есүс рүү авчрав. Натанаелыг олж авчирдаг Филиппийг Есүс дуудсан (Иохан 1:35-51). Энэ нь тэдний дуудлагын анхны үе шат юм. Тэд Есүсийг хүлээн зөвшөөрч байсан ч, хараахан тогтвортой дагалдагчид болоогүй байсан. Энэ бол Есүсийг дагах дуудлага байв. Хожим нь Есүс тэднийг бүтэн цагийн дагалдагч байхаар дуудах болно.

Иохан 2-р бүлэг нь энэхүү үйл явцын чухал үе шат юм. Канаа дахь хуримын ёслол дээр Есүс дагалдагч нартаа өөрийн алдрыг илчилсэн. Бусад зочид гайхамшгийн талаар мэдээгүй ч, харин энэ тэмдэг нь Түүний дагалдагч нарт зориулагдсан байв. Дагалдагчид нь Түүнд найдвараа тавихын тулд Есүс тэдэнд өөрийгөө илчилжээ. “Шавь нар нь Түүнд итгэсэн юм” (Иохан 2:11).

Матай 4:18-22-д болж байгаа үйл явдал Есүс Назараас Капернаумд буцаж ирээд номлож эхэлсний дараахан тохиожээ (Матай 4:12-17). Галилын эргээр явж байхдаа Есүс Симон, Андрей, Иаков болон Иоханыг дуудсан. “Тэд тэр даруй тороо орхиж, Түүнийг дагалаа” (Матай 4:20). Иохан 1-р бүлэг дэх анхны дуудлагын дараа эдгээр

---

<sup>18</sup> Robert Coleman, *The Master Plan of Evangelism*. (Grand Rapids: Baker Book House, 1963) номоос ашиглав.

дагалдагчид загасчны ажлаа үргэлжлүүлэн хийсээр байжээ. Одоо Есүс тэднийг “үүнээс хойш чи хүмүүсийг загасчлах болно...” (Лук 5:10) хэмээн үйлчлэлд дуудаж байна.

Энэ үйл явцын дараагийн үе шат нь Есүс арван хоёр элчийг сонгосон явдал юм. Есүс олон дагалдагч нар дундаас (Иохан 6-р бүлэгт “шавь” гэж нэрлэгдсэн) хамгийн ойрын хамтрагчид болох арван хоёрыг сонгожээ.

Есүс арван хоёр элчийг сонгохдоо яарсангүй. Энэ үйл явц хэдэн сарын турш үргэлжилсэн бололтой. Энэ нь Есүст тэдэнтэй хүн нэг бүрчлэн цагийг өнгөрөөх боломжийг олгожээ. Удирдагч нь тухайн хүнийг таньж мэдэхэд цаг хугацаа зарцуулалгүйгээр залгамжлагчаар хурдан сонгох тохиолдол олон гардаг. Ухаалаг удирдагч тухайн хүний удирдлагын чадварыг үнэлэх боломжтой тодорхой ажил үүргийг даалгаж өгдөг.

### **Халамжлагч хүн дагалдагч нартайгаа хамт цагийг өнгөрүүлэх ёстой**

► Олон хүнд хүрэх, эсвэл цөөн хүмүүсийг халамжлахын аль нь илүү сонирхолтой вэ? Урт удаан хугацааны туршид аль нь илүү чухал вэ? Есүс яагаад арван хоёр хүнд ийм их цаг зав хүчин чармайлтыг гаргасан бэ?

Есүс арван хоёр элч нарт ихэнх цагаа зориулдаг байв. “Есүс арван хоёрыг томилон элч хэмээсэн нь тэднийг **Өөртэйгөө хамт байлгаж**, тунхаглуулахаар илгээх, чөтгөрүүдийг зайлуулах эрх мэдэлтэй байлгахын тулд байлаа” (Марк 3:14-15). Эхлээд тэд Түүнтэй хамт цагийг өнгөрөөж, арга барилыг нь сурдаг байж. Зөвхөн ингэсний дараа л тэд үйлчлэлд илгээгдэхээр бэлэн болох байв.

Марк Есүсийн Галилаар явсан аяллын нэгийг тэмдэглэсэн байдаг: “Хэн нэгэнд үүнийг мэдэгдэхийг Есүс хүссэнгүй [Тэр тэнд байсан], учир нь Есүс шавь нартаа зааж” (Марк 9:30-31) байсан. Есүс гол анхаарлаа олон нийтэд хүрэх хөтөлбөр боловсруулахад бус, харин чуулганыг удирдах хүмүүсийг хөгжүүлэхэд хандуулжээ.

Есүс мянга мянган хүмүүст номлож байсан ч, Түүний нэн тэргүүний ажил нь цөөн хэдэн хүнийг ирээдүйн үйлчлэлд бэлтгэх явдал байв. Сургалт нь жижиг бүлэгт төвлөрвөл илүү үр дүнтэй гэдгийг Есүс мэддэг байсан. Роберт Коулмэн “Таны үйлчлэл өсөн нэмэгдэх тусам хүмүүсийг хувьчлан дагалдуулахад цаг гаргах нь илүү **хэцүү** болдог. Гэхдээ үйлчлэл тань өсөх тусам хувьчлан дагалдуулахад цаг гаргах нь илүү чухал байх болно.”

Сайнмэдээний номуудыг уншихдаа Есүс хамгийн багадаа гурван дагалдагчаа өөртөө ойр байлгахгүйгээр үйлчлэл хийсэн тохиолдол маш ховор болохыг та харах боломжтой. Есүс дагалдагч нартаа зааж сургахаар ихэвчлэн эзгүй зэлүүд газарт дагуулж явдаг байв. Дэлхий дээрх үйлчлэлийнх нь төгсгөл ойртох тусам Есүс дагалдагч нартайгаа илүү их цагийг өнгөрөөсөн. Йерусалимд өнгөрөөсөн сүүлчийн долоо хоногт Есүс ихэнх цагаа дагалдагч нартайгаа хамт байхад зориулжээ. Эдгээр эрчүүдийг сургах нь Түүний хамгийн чухал ажлуудын нэг байв.

“Дагалдагч хүн бол багшийнхаа тоосыг иддэг хүн юм” гэсэн нэгэн еврей зүйр үг бий. Дагалдагч хүн багштайгаа маш ойрхон алхдаг учраас багшийнхаа хөлийн тоосыг залгих нь түгээмэл байж. Багшийн идсэнийг дагалдагч нь иддэг, багшийнхаа явсан газарт дагалдагч нь явдаг. Дагалдагч багшийнхаа сургаал, үлгэр дуурайлыг дагаж мөрддөг нэгэн юм. Есүсийн дагалдагчид багшийнхаа зан чанарыг олж авах хүртлээ Түүнтэй хамт цагийг өнгөрөөжээ. Хожим нь тэд “Христийнхэн” гэж нэрлэгдэх болно. Багштайгаа адил болно.

Үүний адилаар Паул үргэлж Тимот, Тит, Лук, Тухик зэрэг дагалдагчидтайгаа хамт байсан. Паул тэдэнтэй цагийг өнгөрөөж, тэднийг үйлчлэлд сургасан.

Дахин хэлэхэд энэ нь өнөөдөр бидэнд үлгэр жишээ, загвар болж байна. Та үйлчлэлээ хийхдээ багийнхаа залуу гишүүдийг таныг дагахад урамшуулж чадна. Ингэснээр тэд үйлчлэлд суралцах болно. Нэгэн амжилтанд хүрсэн чуулганы удирдагч “Би үйлчлэлийн аялалд явахдаа өөрөөсөө залуу үйлчлэгчийг авч яваагүй тохиолдол нэг ч байгаагүй. Ирээдүйн чуулганы удирдагчийг сургах нь миний хийж буй үйлчлэлтэй адил чухал юм” гэж хэлсэн байдаг. Энэ пастор үр нөлөөтэй удирдагчид бусад удирдагчдыг сургадаг гэдгийг ойлгожээ.

### **Халамжлагч хүн дагалдагч нартаа үйлчлэлийн үлгэр жишээг харуулах ёстой**

Дагалдагч нарынхаа хөлийг угаасны дараа Есүс “Миний та нарт үйлдсэн лугаа адил та нарыг үйлд хэмээн Би ийм дуурайл өгөв” (Иохан 13:15) гэжээ. Есүс үлгэр жишээгээр заасан. “Үүнийг хий” гэж хэлэх нь хангалтгүй гэдгийг Тэр мэдэж байсан. Үүнийг **яаж** хийхийг бид харуулах ёстой. Есүс үүнийгээ хийж харуулах хүртлээ дагалдагч нараасаа ямар ч зүйлийг хийхийг асуугаагүй.

Дагалдагч нар нь Есүсийн залбирахыг хараад “Эзэн... залбирахыг... бидэнд зааж өгөөч” (Лук 11:1) хэмээн асуусан юм. Есүс залбирлын талаар зүгээр нэг хичээл заагаагүй. Тэр залбирсан. Түүнийг залбирахыг хараад дагалдагч нар залбирлыг ойлгохын тулд цангаатай болж эхэлсэн. Суралцагч хүмүүст ийм цангаа үүсвэл тэд илүү сайн сурдаг!

Есүс номлолдоо Бичвэрийг ашиглаж байгааг дагалдагч нар сонсож байсан. Есүс Хуучин гэрээнээс байнга дурддаг байв. Тэрээр Библийг номлох үлгэр жишээг харуулсан. Дагалдагч нар энэхүү хичээлд суралцсан болов уу? Мэдээжийн хэрэг! Үйлс 2-р бүлэгт Петр номлохдоо Иоел, Дуулал 16 болон Дуулал 110-ыг дурджээ. Бичвэрт үндэслэсэн номлолыг Петр Есүсээс суржээ. Үйлс ном дахь номлол бүр нь Хуучин гэрээнээс эш татсан байдаг.

Паул ч үүнтэй адил арга барилыг дагасан. Тэрээр “Та нар миний жишээг харсан. Миний үлгэр дуурайлыг дага”<sup>19</sup> хэмээн дахин давтан хэлсэн байдаг. Паул үлгэр жишээгээр

---

<sup>19</sup> 1 Коринт 11:1, Филиппой 3:17, Филиппой 4:9-д эдгээр жишээг дурджээ.

заасан. Тит, Тимот зэрэг дагалдагч нар халамжлагч Паулын үлгэр дуурайлыг дагаж, пасторын ажилд суралцжээ.

Өнөө цагт, бид зааж сургаж буй хүмүүстээ үйлчлэлийн үлгэр дуурайлыг харуулах ёстой. Тэд бидний амжилт, алдааг хардаг. Хамгийн гол нь алдаагаа хүлээн зөвшөөрч, суралцаж байгаа бидний зан чанарыг тэд ажиглаж байдаг. Дагалдагч нар бидний үлгэр жишээг харснаар үйлчлэлийн бодит байдалд суралцдаг.

### **Халамжлагч хүн дагалдагч нартаа үүрэг хариуцлага хүлээлгэх ёстой**

► Матай 10:5-11:1 эшлэлийг унших.

Анхнаасаа Есүс дагалдагчдыг үйлчлэлд бэлтгэх зорилготой байсан. Өөрийг нь дага гэж дуудахдаа Тэр тэднийг хүний загасчид болгохыг зорьжээ (Матай 4:19).

Есүстэй хамт байсан эхний жилийнхээ ихэнх хугацаанд дагалдагч нар Түүний үйлчлэлийг ажиглаж байсан. Тэд Түүний үлгэр жишээнээс суралцсан. Тэднийг ажигласны дараа Есүс дагалдагчдыг үйлчлүүлэхэр илгээсэн. Матай 10-р бүлэг нь Есүс дагалдагч нартаа хэрхэн үүрэг хариуцлагыг хүлээлгэж байгаа тухай өгүүлдэг.

#### **Тэр тэдэнд эрх мэдлийг өгсөн (Матай 10:1).**

Дагалдагчдыг илгээхийн өмнө Есүс тэдэнд өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх эрх мэдлийг өгчээ. Заримдаа удирдагчид тусалж буй хүмүүсийнхээ эрх мэдэлд найдаж чаддаггүй. Гэсэн хэдий ч **эрх мэдэлгүй үүрэг хариуцлага нь таны сургаж буй хүмүүсийг эрэмдэг болгодог**. Бид туслагчиддаа хариуцлагыг нь биелүүлэхэд хангалттай эрх мэдэл өгөөгүй бол тэдэнд хариуцлага хүлээлгэж болохгүй.

#### **Тэр тэдэнд тодорхой заавруудыг өгсөн (Матай 10:5-42).**

Есүс дагалдагч нартаа “Хаанчлалыг түнхагла” гэсэн тодорхой захиасыг өгчээ. Тэдний даалгавар тодорхой байсан. Есүс тэднээс юу хийхийг хүлээж байгааг тэд сайн мэдэж байлаа.

Есүс дагалдагч нарыг хаана үйлчлэх ёстой талаар хэлэхдээ Израилын гэрийн төөрсөн хоньдод гэж хэлсэн байдаг. Хожим нь тэд харь үндэстнүүдэд номлох байсан ч, үйлчлэлд дөнгөж суралцаж байгаа тэднийг гэрийнхээ ойроос эхлэхийг Есүс захижээ. Бид суралцагч хүмүүсээ амжилтанд хүргэхийн тулд чадах бүхнээ хийх ёстой. Хийж гүйцэтгэхэд хялбар ажлаас эхэл. Есүс боломжтой зорилтуудыг тавьсан.

Есүс дагалдагчдад хавчлагын талаарх зааврыг ч мөн өгсөн. Хавчлага нь дагалдагчид үйлчилж чадаагүй учраас биш, харин Есүсийг дагах дуудлага нь Түүнийг дагагчид болон эсэргүүцэгчдийн хооронд хагарал авчирдаг учраас ирэх болно.

#### **Есүс тэднийг баг болгон илгээсэн (Марк 6:7).**

Үйлчлэл дэх багуудын ач холбогдлыг Есүс харуулсан. Тэрээр дагалдагчдыг баг болгон хоёр хоёроор нь илгээжээ. Хэдэн сарын дараа Есүс 72 дагалдагчдыг мөн хоёр хоёроор

нь баг болгон илгээв (Лук 10:1). Энэ нь анхны чуулганы үйлчлэл дэх үлгэр жишээ болсон. Петр, Иохан хоёр хамтдаа үйлчилсэн. Барнаб, Саул хоёр хамтдаа аялсан. Паул, Силас хоёр мөн хамтдаа үйлчилжээ.

### **Халамжлагч хүн дагалдагч нартаа зөвлөж чиглүүлэх ёстой**

Дагалдагч нар үйлчлэлээсээ буцаж ирээд Есүст тайлагнасан (Марк 6:30). Даруй дагуулж эхлэх нь дагалдагч нараа сургах Есүсийн сургалтын чухал хэсэг байв. Үүрэг хариуцлага хүлээлгэх нь хангалтгүй. Харин үр нөлөөтэй удирдагч хүн дагалдагчийнхаа гүйцэтгэлийг үнэлэх болно. Үнэлгээ хийхгүйгээр ажил даалгах нь муу гүйцэтгэлийг дагуулдаг.

► Матай 17:14-21 эшлэлийг унших.

Ховард Хендрикс “Алдаа гаргах нь суралцах үйл явцын чухал хэсэг” гэж заасан. Дагалдагчид “Бид яагаад энэ хүүгээс чөтгөрийг зайлуулж чадсангүй вэ” гэж асуухад Есүс тэдэнд итгэлийн талаар сургасан байдаг. Есүсийг тэнгэрт өргөгдсөний дараа биш, харин одоо үйлчлэлийнхээ эхний үе шатанд ингэж бүтэлгүйтэж байгаа нь тэдний хувьд хамаагүй дээр байсан юм!

Үр нөлөөтэй чиглүүлэг нь үнэлгээг багтаасан байдаг. Дагалдагч даалгавраа биелүүлээгүй тохиолдолд түүнийг шууд багаас хөөж явуулахгүй. Харин оронд нь тэрхүү бүтэлгүйтлийн шалтгааныг судалж, цаашид сайжруулах төлөвлөгөө гаргах учиртай.

Есүс Лук 9-р бүлэгт энэхүү загварыг харуулсан:

- 9:1-6-д Есүс арван хоёр дагалдагчийг илгээсэн.
- 9:10-д тэд аяллынхаа талаар Түүнд тайлагнасан.
- 9:37-43-д дагалдагчид чөтгөрийг зайлуулж чадалгүй бүтэлгүйтсэн.
- 9:46-48-д Есүс тэдэнд Бурханы хаанчлалын агуу байдлын талаар сургасан.
- 9:49-50-д Есүс Иоханыг үйлчлэл дэх тааруу шийдвэрийнх нь улмаас зэмлэсэн.
- 9:52-д Есүс үйлчлэлийнхээ бэлтгэлийг хангуулахаар дагалдагчдыг Самарийн суурин руу илгээсэн.
- 9:54-55-д Есүс Иаков, Иохан хоёрыг дахиад нэг тааруу шийдвэрийнх нь улмаас зэмлэв.
- 10:1-д Есүс томоохон бүлэг хүмүүсийг үйлчлүүлэхээр илгээсэн.

Есүс заах, үүрэг даалгавар өгөх, үнэлгээ явуулах зэргийг ээлжлэн хийдэг байв. Тэр дагалдагч нараа бүтэлгүйтэхэд нь шантарч орхиогүй. Харин Тэрээр тэдний бүтэлгүйтлийг заах сургамж болгон ашигладаг байв.



Паул хожим нь адил жишгийг дагасан байдаг. Тэрээр Титийг Крет арлын чуулганыг удирдуулахаар, Тимотыг Ефест пастораар тус тус томилсон. Дараа нь тэр тэдэнд нэмэлт сургалт явуулахаар захидлуудыг бичжээ. Паул илгээлтийн анхны аяллаараа байгуулсан чуулгануудаа эргэж, тэднийг зааварлаж чиглүүлэхийн тулд хоёр дахь аяллаа эхлүүлж байсан юм (Үйлс 15:36).

Энэхүү загвар өнөө цагт ч үр нөлөөтэй хэвээр байна. Олон удирдагчид залуу үйлчлэгчдийг заавар чиглүүлэг, тэдэнд хариуцлагатай байх харилцаагүйгээр илгээдэг бөгөөд илгээснийхээ дараа тэднийг бүтэлгүйтэхэд гайхдаг. “Би хичээл заасан болохоор тэд үүнийг зөв хийх болно” гэж бид бодож болохгүй. Заавар чиглүүлэг нь тасралтгүй үйл явц юм. Хэрэв та удирдагчдыг сургахыг хүсвэл заавар чиглүүлэгт цаг зарцуулах ёстой.

Ховард Хендрикс шинэхэн ажилчдыг сургах дөрвөн үе шатыг жагсаасан байдаг:

1. **Хэлж өгөх:** Агуулгыг зааж өгөх. Есүс хаанчлалын сургаалыг дагалдагч нартаа номлож байсан.
2. **Харуулах:** Үйлчлэлийн үлгэр дуурайлаар хангах. Есүс дагалдагч нартаа үйлчлэхийг харуулж байсан.
3. **Дадлагажих:** Үйлчлэл нь шууд заавар чиглүүлэг дор явагдана. Есүс дагалдагч нараа үйлчлүүлэхээр илгээгээд, дараа нь тэдний туршлагад үнэлгээ өгдөг байжээ.
4. **Хийх:** Үйлчлэл нь шууд заавар чиглүүлэггүйгээр явагдана. Пэнтекостын дараа дагалдагчид Есүсийн шууд заавар чиглүүлэггүйгээр үйлчлэл хийсэн.

► Та дагалдагч нараа удирдлагад сургах талаар юу хийж байна вэ? Бидний суралцаж буй эдгээр үе шатуудын алийг нь үр нөлөөтэйгээр хийж байна вэ? Аль үе шатуудыг сайжруулах шаардлагатай байна? Ирээдүйн удирдагчдыг халамжлах тал дээр хэрхэн илүү үр нөлөөтэй байж болох талаар бүлгээрээ ярилцана уу. Үйлчлэлийнхээ хүрээнд удирдагчдыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй болох хүртлээ энэхүү хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх хэрэгтэй.

### **Бидний дагалдагчид бусад дагалдагчдыг төрүүлэх ёстой**

Есүс дагалдагч нартаа “Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс гаргаж, үр жимс чинь үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон...” (Иохан 15:16) хэмээн өгүүлжээ. Дагалдагчдыг олон дагалдагч төрүүлэхэд Есүс сургаж бэлтгэжээ.

► Матай 13:31-32 эшлэлийг унших.

Гичийн үрийн тухай Есүсийн сургаалт зүйрлэлд Бурханы хаанчлал анхны хэмжээтэйгээ харьцуулшгүй том болж өсөх тухай өгүүлсэн байдаг. Өчүүхэн гичийн үр нь төсөөлж байснаас хамаагүй илүү том ургамал болж ургадаг шиг чуулган хэний ч төсөөлж

байгаагүйгээр өсөх болно. Хуучин гэрээнд тэнгэрийн шувууд үүрээ засдаг модны тухай өгүүлсэн бөгөөд энэ нь олон үндэстнийг багтаасан агуу хаачлалыг төлөөлдөг (Даниел 4:12 болон Езекиел 31:6). Дагалдагчид үржин олшрох тусам чуулган анхны хэмжээнээсээ хавьгүй илүү өсөж томрон бүх үндэстэнд хүрнэ хэмээн Есүс амласан байдаг.

Др. Роберт Коулмэн бидний үйлчлэлийн эцсийн үнэлгээ нь үржин олшроход байгаа юм гэж бичжээ. Тэрээр “Эцсийн дүндээ бид бүгдээрээ амьдралаа хэрхэн үржүүлж олшруулсан бэ гэдэгтээ үнэлэлт дүгнэлт хийх ёстой болдог. Бидэнд даалгасан тэдгээр хүмүүс Агуу захирамж дахь алсын харааг хүлээн авч, үүнийг бусдад заах итгэмжит үйлчлэгч нарт дамжуулах болов уу? Бидний үйлчлэл тэдгээр хүмүүсийн гар дээр тун удахгүй очино шүү дээ.”<sup>20</sup>

### **Сайтар ажиглах нь: Тэргүүн Тахилч Есүсийн залбирал**

Есүсийн зуучлан залбирлын дунд хэсэгт дагалдагчдынхаа төлөө онцлон залбирсан хэсэг бий (Иохан 17:6-19). Энэхүү залбирал дагалдагч нарыг халамжлах талаарх Есүсийн арга барилтай холбоотой үнэ цэнтэй сургамжуудыг заадаг.<sup>21</sup>

#### **(1) Хамгийн түрүүнд бид халамжилж буй хүмүүсээ хамгаалах ёстой.**

Есүс “Тэдэнтэй хамт байхдаа Би... тэднийг хамгаалж байсан” гэж залбирчээ. Сайнмэдээний номуудад Есүс дагалдагч нараа аюулаас сэрэмжлүүлж 20 гаруй удаа хэлсэн байдаг. Тэр тэднийг алдаанаас хамгаалсан. Бид дагалдагч нараа сургахдаа тэдний ертөнц дэх аюулаас нь тэднийг хамгаалах ёстой. Бидний сургалт амьдралд ойр байх ёстой.

► Танай ахуй соёлд залуу үйлчлэгч нарт ямар аюул бэрхшээл тулгарч байна вэ? Та халамжлагч хүний хувьд тэднийг эдгээр аюулд өртөхгүй байхад нь хэрхэн бэлтгэх вэ?

#### **(2) Халамжилж буй хүмүүсээ өсөж төлөвших үед нь бид итгэл хүлээлгэх хэрэгтэй.**

Есүс “Тэднийг Та ертөнцөөс аваач гэж Би гуйхгүй, харин муу муухайгаас хамгаалахыг гуйж байна” (Иохан 17:15) гэж залбирсан. Дагалдагч нар нь сорилттой тулгарах болно гэдгийг Есүс мэдэж байсан ч, сургасан хүмүүстээ итгэлтэй байжээ. Сургаж буй залуу удирдагч нартаа бид итгэж сурах ёстой. Энэ нь биднийг дарангуйлах удирдлагын арга барилаас татгалзаж, бусдад чухал шийдвэрүүдийг гаргахад нь итгэл хүлээлгэхийг шаарддаг.

Ажит Фернандо удирдагч хүн дагалдагчдаа харах хоёр өнцөг байдаг гэж хэлсэн.

---

<sup>20</sup> Robert Coleman, “The Jesus Way to Win the World: Living the Great Commission Every Day.” Evangelical Theological Society, 2003.

<sup>21</sup> Ajith Fernando, *Jesus Driven Ministry* (Wheaton, Illinois: Crossway Books, 2002), 172-173 номоос авсан.

- Сул дорой удирдагчид дагаж буй хүмүүсийнхээ сул тал дээр анхаарлаа хандуулдаг.
- Харин үр нөлөөтэй удирдагчид дагалдагчдынхаа давуу тал дээр анхаарлаа хандуулахын зэрэгцээ сул тал дээр нь үргэлжлүүлэн ажилладаг. Үр нөлөөтэй удирдагчид бусдыг “найджарын нүдээр” хардаг.

### **(3) Дагалдагчдаа сургаж бэлтгэсний дараа бид тэднийг ертөнцөд үйлчлүүлэхээр илгээдэг.**

Есүс “Та Намайг ертөнцөд илгээсний адилаар Би мөн тэднийг ертөнцөд илгээв” (Иохан 17:18) хэмээжээ. Пентекостоос хойш дагалдагч нар Есүсийн тэдэнд даалгасан агуу үүрэг даалгаврыг эхлүүлжээ. Бид дагалдагчдыг халамжилдаг бөгөөд ингэснээр тэд сайнмэдээ хэрэгцээтэй ертөнцөд үүнийг аваачдаг.

Есүс “Би тэднээр алдаршуулагдлаа” (Иохан 17:10) гэж залбирсан. Бид сургасан хүмүүсээ илгээхдээ Есүс алдрыг авч буй эсэхийг шалгах хэрэгтэй. Өөрийн сургаж бэлтгэсэн хүмүүсээсээ өөртөө алдар хүндийг авахаар бид уруу татагдаж болох юм. Бусдыг дагалдуулах чадвараараа бид алдар хүндийг өөртөө олж авахаар соригдож ч болзошгүй. Харин эдгээрийн оронд алдар хүнд нь зөвхөн Бурханд очиж буй эсэхийг бид шалгах учиртай.

### **Хэрэгжүүлэлт: Үйлчлэлийн багийн үнэ цэн**

Есүсийн жишээ үйлчлэл дэх багуудын ач холбогдлыг харуулдаг. Багийн үйлчлэлд залуу хамтран ажиллагсдыг халамжлах болон мөр зэрэгцэн үйлчилдэг пасторуудтай харилцаагаа байгуулах аль аль нь багтдаг. Бид бусад хүмүүстэй харилцаатай байхаар бүтээгдсэн. Багууд яагаад ийм чухал байдаг вэ?

### **Багууд тэнцвэрийг өгдөг**

Есүс өөр өөр угсаа гаралтай хүмүүсийг сонгосон. Петр, Иохан хоёр байнгын өрсөлдөгчид байв. Матай Ромын төлөө ажиллаж байсан бол Зеалот гэгдэх Симон ромчуудыг Иудейгээс хөөж гаргахыг хүсдэг байлаа. Эдгээр эрчүүд эсрэг тэсрэг хүмүүс байв. Дагалдагч нараа сонгохдоо Есүс хоорондоо ялгаатай бүлэг хүмүүсийг сонгожээ.

Хэдийгээр бид ийм эсрэг тэсрэг хүмүүстэй нэг багт байх нь ямар хэцүү байдгийг олонтоо олж хардаг ч, эдгээр ялгаатай хувьт чанаруудын давуу талыг үл тоомсорлож болохгүй. Элч Петр томоохон тунхаглал хийхдээ хурдан байсан бол Томас, Андрей зэрэг болгоомжтой элч нар түүнийг тэнцвэржүүлж байлаа. Анхны чуулганы удирдлагад эдгээр ялгаатай хувьт чанарууд ашиг тусаа өгсөн.

Ухаалаг удирдагчид өөр хоорондоо ялгаатай гарал үүсэлтэй хүмүүсийг багтаа олж авчирдаг. Хүчтэй баг нь чуулганы удирдлагыг олон талаар хүчтэй болгодог. Багийн нэг гишүүн санхүүгийн талаар илүү сайн ойлголттой байж болох юм. Өөр нэг нь бусадтай хувьчлан харилцахдаа гаргууд байж мэднэ. Мөн өөр нэг гишүүн Библийн гүн гүнзгий

ойлголттой байх боломжтой. Чуулганд тэнцвэртэй удирдлагыг бий болгохын тулд эдгээр хүмүүс хамтдаа хэрэгтэй.

### **Багууд нь ухаалаг зөвлөгөө өгдөг**

Дагалдагч нараа сургахдаа Есүс чуулганы суурийг тавьж байгаагаа мэдэж байлаа. Пэнтекостын дараа анхны чуулган олон хүнд хэцүү шийдвэрүүдтэй нүүр тулах болно. Дагалдагчид эдгээр шийдвэрийг гаргахдаа бие биедээ хэрэгтэй гэдгийг Есүс мэдэж байв.

Чуулганд тулгарч байсан анхны шийдвэрүүдийн нэг нь “Харь үндэстний итгэгчид хэрхэн чуулганы нэг хэсэг болох вэ? Тэд Иудейн хуулийг бүх талаар сахиж мөрдөх шаардлагатай юу?” зэрэг байлаа. Хэдийгээр энэ нь бидэнд энгийн мэт санагдаж болох ч хэцүү шийдвэр байсан юм. Энэ нь хувийн сонголттой холбоотой асуудал биш бөгөөд хоол хүнс, хозлолын талаарх хууль зааврууд нь Хуучин гэрээнд үндэслэгдсэн байлаа. Энэхүү шийдвэр нь урт хугацааны үр дагавруудыг дагуулсан юм. Өнөөдөр та бидэнд ч энэ шийдвэр нөлөөлсөн. Хэрэв Йерусалимын зөвлөл өөрөөр шийдвэрлэсэн бол өнөөдөр харь үндэстний итгэгчид иудейн хуулийг сахиж мөрдөх шаардлагатай болох байсан.

Үйлс 15-р бүлэгт анхны чуулган энэ чухал асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг харуулдаг. Олон янзын үзэл бодлыг сонссоны дараа тэд нэг шийдэлд хүрсэн. Элч нар харь үндэстний чуулганд илгээсэн захидалдаа гаргасан шийдвэрээ тайлбарлахын тулд маш сайхан үг хэллэг ашиглажээ “Учир нь Ариун Сүнс болон бидэнд... зүйтэй” (Үйлс 15:28). Сүнс чуулганы удирдагчдыг цуглуулж, санал бодлоо хуваалцах боломжийг олгож, дараа нь бүлгийг зөв шийдвэрт хөтлөх замаар удирдсан байна.

Сургаалт үгс номыг бичсэн хүн шийдвэр гаргахад олон тооны санаа бодол чухал болохыг онцолжээ.

- Мунхгийн зам нүдэнд нь зөв. Мэргэн нэгэн зөвлөгөөг сонсох (Сургаалт үгс 12:15).
- Олон зөвлөхтэй аваас аврагдах (Сургаалт үгс 11:14).
- Дайтваас мэргэн удирдамжийг дага. Зөвлөхүүд арвин аваас ялалт ирнэ (Сургаалт үгс 24:6).

Энэ бол чуулганы удирдагч нарын хувьд чухал зарчим билээ. Хэрэв та бусдыг сонсохыг хүсдэггүй бол Сургаалт үгс таныг мунхаг нэгэн гэж хэлж байна. Мунхаг нэгэн үргэлж өөрийгөө зөв гэж боддог бол, харин мэргэн хүн бусдыг сонсохыг хүсдэг.

Хэрэв багийн зорилго нь ухаалаг зөвлөгөө өгөх юм бол биднээс өөрөөр сэтгэдэг хүмүүс хэрэгтэй. Багаа сонгохдоо бид өөрсдийнхөө хуулбарыг хайх хэрэггүй. Бидэнтэй үргэлж амархан санал нэгддэг хүмүүс бидэнд хэрэггүй.

### **Багууд урам зоригийг өгдөг**

Номлогчийн үгс номд багийн ашиг тусыг тодорхойлохдоо “Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр билээ. Тэгвэл тэдний зүтгэл сайнаар хариулагдах болно. Хэрэв тэд

хамтдаа ойчих аваас нэг нь нөгөөгөө босгоно. Харин ганцаар байгч унахад түүнийг босгох хүн үгүй тул, хөөрхий” (Номлогчийн үгс 4:9-10).

Чуулган эсэргүүцэлтэй тулгарах үед элч нар бие биенээ урамшуулсан. Лук “нэг санаагаар” гэсэн хэллэгийг чуулганы анхны гишүүдийн харилцан дэмжлэгийг тайлбарлахдаа ашиглажээ.

Агуу илгээлтийн эзэн Хадсон Тэйлор энэ зарчмыг харуулсан. Тэйлор Хятад руу үйлчлэх хүсэл тэмүүлэлтэй явсан ч удалгүй шантарчээ. Түүнийг санхүүгээр дэмждэг зарим хүмүүс тусламж илгээхээ больсон байна. Түүнээс өмнө очсон илгээлтийн эзэд түүнийг шүүмжилсээр байлаа. Их Британийн засгийн газар хүртэл түүний ажлыг эсэргүүцэв. Сүйт бүсгүй нь түүнд Англиас захидал бичихдээ илгээлтийн эзэнтэй гэрлэх эсэхдээ эргэлзэж байгаагаа илэрхийлсэн. Тэйлор урам хугарч, гэртээ харихад бэлэн байв.

Харин тэр үед Шотландын настай илгээлтийн эзэн Виллиам Бернс Хадсон Тэйлортой хамт Хятадын гүн рүү сайнмэдээний аялал хийхдээ долоон сарыг хамт өнгөрөөжээ. Тэр хоёр хамтдаа аялж, хамтдаа залбирч, хамтдаа номлодог байв. Тэрхүү аяллын үеэр Тэйлор Хятадын төлөөх алсын хараагаа дахин олж авчээ. Жон Поллок түүний талаар “Виллиам Бернс Хадсон Тэйлорыг өөрөөс нь аварсан юм” хэмээн бичсэн байдаг.

Хадсон Тэйлор хожим нь Хятадын Дотоод Илгээлт байгууллагыг үндэслэсэн бөгөөд орчин үеийн хамгийн агуу илгээлтийн эздийн нэг гэдгээрээ олонд танигджээ. Харин Виллиам Бернсын талаар хүмүүс бараг мэддэггүй. Гэсэн ч Виллиам Бернс Хятадын Дотоод Илгээлт байгууллагын мянга мянган хүмүүсийг итгэлд авчирсан үйл хэргийн гавьяаны тодорхой хэсгийг хүртэх зохистой хүн юм. Багууд урам зоригийг өгдөг.

### **Багууд хариуцлагын харилцааг бий болгодог**

Бидний хүн нэг бүрд харж чадахгүй хэсэг бий. Өөрөө олж харж чаддаггүй шинж чанарууд юм. Бид гэр бүлийнхээ гарал үүсэл, итгэгч болохоос өмнөх амьдрал, мөн хувийн зан араншинтай холбоотой гэх зэрэг сул талуудаа үйлчлэлд гарахдаа хамт авчирдаг. Тэдгээр нь бидний үйлчлэлд нөлөөлдөг.

Бид өөрсдийнхөө эдгээр сул талуудыг олж харахгүй байж болох ч, багийн бусад гишүүд бидний үйлчлэлийг сүйрүүлж болзошгүй эдгээр асуудлын талаар анхааруулж чадна. Еврей номыг бичигч Христэд итгэгчдийг сайн үйлсийн төлөө бие биенээ бадраадаг хүмүүс гэж хэлсэн (Еврей 10:24) байдаг. “Бадраах” гэдэг үгийн анхдагч грек язгуур нь хэн нэгнийг чичлэх, өдөөх гэсэн утгатай үг байжээ. Заримдаа энэ нь тийм ч таатай биш байдаг. Бид бүгдээрээ чичлүүлэх дургүй ч, хариуцлагын харилцаа бол үнэ цэнтэй юм. Христэд удирдагч хүн бүрд “Энэ чинь ухаалаг бус үйлдэл. Чи үүнийг дахин нягталж үзэх хэрэгтэй” гэж хэлэх дор хаяж нэг хүн байх хэрэгтэй.

Дундад зууны үеийн сүм хийдүүд, Веслийн ангийн уулзалтуудаас орчин үеийн Амлалтаа сахигчид зэрэг бүлгүүдийг хүртэл Христэд удирдагчид нь хариуцлагын харилцааг хөгжүүлж ирсэн эртний уламжлалтай. Долоо хоног бүрийн хариуцлагын харилцаа нь өнөөгийн чуулганы удирдагчдад ашиг тусыг үзүүлсээр байна. Үүнийг нэг

нэгийн уулзалт, жижиг бүлгүүдээр болон утсаар ч хийх боломжтой. Энэхүү хариуцлагын харилцаа нь биднийг хэт холдохоос өмнө сүнслэг аюулаас сэрэмжлүүлж чадна.

Сайн хариуцлагын харилцаа нь хамтрагч бүрээс бүрэн үнэнч байдал, хамтрагчид хоорондын бүрэн нууцлалыг шаарддаг. Хариуцлагын харилцаандаа ашиглах олон асуултуудын жишээг та олж үзэх боломжтой. Нэг жагсаалтад дараах асуултууд багтсан байна. Үүнд:

- Энэ долоо хоногт та Бурхантай тогтмол цагийг өнгөрөөсөн үү?
- Энэ долоо хоногт үнэнч байдлаа сахиагүй ямар нэгэн зүйл болсон уу?
- Энэ долоо хоногт таны бодлын амьдрал цэвэр тунгалаг байсан уу?
- Энэ долоо хоногт та бэлгийн харилцааны нүгэл үйлдсэн үү?
- Энэ долоо хоногт та эхнэрийнхээ (эсвэл нөхрийнхөө) төлөө ямар чухал зүйл хийсэн бэ?
- Энэ долоо хоногт та үл итгэгч хүнтэй итгэлээ хуваалцсан уу?
- Та эдгээр асуулт болгонд үнэнч шударгаар хариулсан уу?

Уруу татагдах үед багийн хариуцлагын харилцаа нь чухал байдаг. Паул залуу пасторт хандан хэрхэн урт удаан үргэлжлэх үйлчлэлийг байгуулах талаар зөвлөж захидал бичжээ. Паул Тимотод “Залуу насны дур хүслүүдээс зүгт. **Цэвэр зүрхнээс Эзэнийг дуудагчдын хамт** зөвт байдал, итгэл, хайр ба амар тайвныг мөшгө” (2 Тимот 2:22) хэмээн анхааруулсан байдаг. Эзэнийг цэвэр зүрхнээсээ дууддаг Бурханыг дагаж буй бусад хүмүүстэй нэгдэх нь Тимотын сүнслэг амьдралд ашиг тустай гэдгийг Паул ойлгож байсан.

► Хэрэв та үйлчлэлийн багийн нэг хэсэг бол багаас олж авсан ашиг тусын заримаас хуваалцана уу. Үйлчлэлийн багийн нэг хэсэг байхад ямар бэрхшээл тулгардаг вэ?

### **Багтай ажиллах нь**

Есүс тэс өөр өөр зан чанартай хүмүүсийн бүлгийг нэгдмэл баг болгожээ. Есүс тэдний ялгаатай байдлыг авч, анхны чуулганыг удирдаж чадах багийг бүтээсэн юм. Чуулганд Петрийн зоримог удирдлага, Филиппийн намуун зөөлөн сүнс хэрэгтэй байв. Удирдагч хүнд тулгардаг томоохон бэрхшээлүүдийн нэг нь хэсэг бүлэг дагалдагчдыг баг болгох явдал юм.

Шри Ланкийн чуулганы удирдагч Ажит Фернандо баг бүрдүүлэхэд тулгардаг бэрхшээлүүдийг сайн ойлгодог нэгэн юм. Тэрээр:

Магадгүй Эвангелийн чуулганд тулгарч байгаа нэг харамсалтай зүйл бол бидний шийдвэр гаргах, үйлдэх арга замыг теологи маань биш, харин мэдрэмж маань

тодорхойлох нь их түгээмэл болсон явдал. Библийн дагуух итгэгч хүн “Би энэ хүний талаар ямар ч бодолтой байсан, би түүнийг хүлээн авах болно. Учир нь Бурхан намайг ингэж хийгээсэй гэж хүсдэг. Түүнтэй эв найртай ажиллах нигүүлслийг би Бурханаас гуйх болно” гэж хэлдэг. Хэдийгээр бидний мэдрэмж өөр зүйлийг хэлж болох ч энэ хүнтэй ажиллах оролдлого амжилтанд хүрнэ гэж бидний теологи хэлдэг. Бидний теологи энэхүү харилцаанд шаргуу ажиллахад хөтөлдөг. Бид тухайн хүний төлөө болон түүнтэй харилцах харилцааныхаа төлөө залбирна. Улмаар бид тогтмол уулзаж эхэлдэг. Бид түүнд Христитгэлийн хайрыг харуулахыг эрмэлзэж, түүнд хэрэгтэй хувийн зүйлсэд нь чадах бүхнээрээ тусалдаг. Багаар дамжуулан энэ хүн юунд хүрч болох талаар бид мөрөөдлүүдээ хөгжүүлдэг.<sup>22</sup>

1 Коринт 12:12-25-д бид хүмүүст зүгээр л дургүй учраас тэднийг Христийн Бие дотор үгүйсгэх тийм эрх бидэнд байхгүй гэдгийг заасан. Хэрэв та чуулган байгуулбал танд таалагдахгүй олон гишүүд тэнд байх л болно. Христэч удирдагчийн хувьд та “Миний хувийн мэдрэмж ямар ч байсан би энэ хүнийг хүлээж авах болно. Учир нь Бурхан түүнд санаа тавиулахаар над руу явуулжээ. Түүнтэй хамтран ажиллахын тулд би Бурханаас нигүүлслийг гуйж, түүнийг ерөөн, үйлчлэлд нь хөгжин дэвжүүлэхийг гуйх болно” гэж хэлэх учиртай.

#### **Үр нөлөөтэй удирдагч бол үйлчлэгч**

Нэгэн удаа хэн нэгэн ирээдүйн пастор болох залуугаас “Чи яагаад пастор болохыг хүсдэг вэ?” гэж асууж. Залуу хариуд нь “Нисэх онгоцны буудал дээр би хэн нэгэн пасторынхаа чемоданыг барьж явахыг харсан. Хэн нэгэн бас миний чемоданыг барьж явахыг хүсэж байна!” гэжээ.

Есүсийн үзэл бодол тэс өөр байсан юм! Энэ залуу үйлчлүүлэхийг хүссэн бол харин Есүс үйлчлэхийг хүсжээ. “Учир нь Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бүс, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ гэв” (Марк 10:45). Жинхэнэ удирдлагад үйлчлэл багтдаг гэдгийг Есүс харуулсан. Есүс өөрийгөө даруу болгож, боолын дүрийг авсан (Филиппой 2:7).

► Иохан 13:1-20 эшлэлийг унших.

Сайнмэдээний олон хэсгээс бид Есүсийн үйлчлэгч-удирдлагын үлгэр дуурайлд суралцах боломжтой бөгөөд үүний хамгийн хүчирхэг жишээнүүдийн нэг нь Есүс дагалдагч нарынхаа хөлийг угаасан түүх юм. Энэ хэсэгт Есүс үйлчлэгч байх нь ямар утга учиртай болохыг харуулж байна.

Зарим чуулганууд Сүүлчийн зоог дээрх Есүсийн үйлдлийг дахин сануулах үүднээс хөл угаах ёслолыг хийдэг. Энэ нь сайхан үйлчлэл байж болох ч, Есүс тэр үед онцгой ёслол

---

<sup>22</sup> Ajith Fernando, *Jesus Driven Ministry* (Wheaton, Illinois: Crossway Books, 2002), 133

хийгээгүй гэдгийг ойлгох нь илүү чухал байж болох юм. Харин оронд нь Тэр зүгээр л хийх хэрэгтэй ажлаа л хийсэн юм.

Йерусалимын гудамжууд тоос шороо ихтэй байсан тул албан ёсны оройн зоог барих үед хөлсний зарц зочдын хөлийг угаадаг заншилтай байжээ. Энэ бол хамгийн доод албан тушаалтнуудад оногдсон даруухан үүрэг байв. Есүс дагалдагч нартайгаа Алгасал баярт оролцох үед өрөөнд нэг ч үйлчлэгч байсангүй. Дагалдагч нарын хэн нь ч энэ үүргийг сайн дураараа хийсэнгүй. Тэд Есүсийн хаанчлалд өндөр албан тушаалд хүрнэ гэж найдаж байсан болов уу. Есүс өвдөг сөгдөн хамгийн дорд боолын ажлыг хийж эхэлсэн.

Энэ хэсэг Есүсийн удирдлагын талаарх ойлголтыг харуулдаг. Хүмүүс байр суурь, эрх мэдлийн төлөө удирдлагыг хайдаг. Тэдний зорилго нь байгууллагынхаа оргилд гарах юм. Харин Есүсийн хувьд Тэр аль хэдийн оргилд гарсан байлаа. Тэр дагалдагч нарынхаа багш нь байв. Гэхдээ Тэрээр хамгийн дорд байр суурийг дуртайяа хүлээн авсан юм.

Энэ бол Христтэй адил удирдагч байхын утга учир юм. Христтэй адил удирдагч хэний ч хүсээгүй ажлыг хийдэг. Христтэй адил удирдагч бусдад тушаан зандрах боломжоороо бус, харин даруу үйлчлэлийн үлгэр дуурайлаараа бусдад урам зоригийг өгдөг.

Нэгэн хүн “Надтай зарц шиг харьцах үед би яаж хариу хандах вэ?” гэдгээр үйлчлэгчийн сэтгэлтэй хүнийг таньж болно гэж хэлсэн байдаг. Есүсийн үлгэр дуурайлыг дагадаг удирдагч түүнтэй зарц мэт харьцахад гомдохгүй. Есүс бусад дагалдагч нарын хамт Иудасын хөлийг ч угаасан гэдгийг битгий мартаарай. Чамаас урвахаар шийдсэн хүний хөлийг даруухнаар угаана гээд төсөөлж байна уу?

“Бурханы хүмүүсийн дунд удирдлагын бэлгэдэл нь тэргүүн ширээ бус, харин алчуур, угаалгын саваар солигджээ. Энэ цаг бол алчуурыг буцаан авчрах цаг юм.”  
- С. Жене Вилкес

Тэрээр дагалдагчдынхаа хөлийг угааж дуусаад, тэдгээр байр суурь горилогч эрчүүдэд хандан “Миний та нарт үйлдсэн лугаа адил та нарыг үйлд хэмээн Би ийм дуурайл өгөв” (Иохан 13:15) гэжээ. Гучин жилийн дараа Симон Петр “Бүгд бие биендээ даруу хандах байдлаар хувцасла” (1 Петр 5:5) гэж бичихдээ Есүсийн даруу байдлыг санасан байх. Есүс дагалдагч нартаа үйлчлэхийн тулд алчуураа бүсэлсэн шиг эргэн тойронд буй хүмүүстээ үйлчлэхийн тулд бид даруу байдлыг бүсэлдэг.

Христэч удирдагчдын хувьд бид үйлчлэх боломжоос илүүтэй байр суурь хайхад уруу татагдах боломжтой. Христэч удирдлага бол үйлчлэл гэдгийг Есүс харуулсан.

### **Дүгнэлт: Христэд итгэгч бусад ажилчдыг халамжлахын ач холбогдол**

Амьдралынхаа төгсгөлд таны үйлчлэлийн хамгийн том өв нь магадгүй бусад Христэд итгэгч ажилчдын халамжлагч байж нөлөөлөх явдал байж болох юм. Хэрэв та үйлчлэлийнхээ туршид зөвхөн 12 Христэд итгэгч ажилчдыг халамжилсан бол таны нөлөөлөл тэдгээр 12 хүнээр үржигдээд зогсохгүй, нэмээд тэдний халамжлах ажилчдаар ч үржигдэх боломжтой.



Харамсалтай нь ихэнх Христэч удирдагчид халамжлахын ач холбогдлыг мэддэг ч, цөөхөн удирдагчид бусдыг халамжлахад шаардагддаг цагт өөрсдийгөө зориулдаг. Яагаад бид үйлчлэлийн энэ талбарыг орхигдуулаад байна вэ?

Үүний нэг шалтгаан нь халамжлахын **өртөг** юм. Халамжлах нь үнэ цэнтэй цаг хугацааг шаарддаг. Залуу удирдагчдыг халамжлахад зориулсан цаг хугацаа нь томоохон бүлэг хүмүүст үйлчлэхэд зарцуулсан цаг хугацаанаас илүү үр дүнтэй гэж бид итгэдэг.

Өөр нэг шалтгаан нь халамжлахыг дагалддаг **урам хугаралт** юм. “Би дараа үеийн удирдагчдыг бэлтгэж байна” гэж хэлэх нь гайхалтай сонсогдож болно. Гэхдээ энэ нь бодит байдал дээр ихэнхдээ тийм ч таатай байдаггүй.

Дагалдагч нарынхаа удаашралтай ахиц үйл явцыг хараад Есүс олон удаа урам хугарч байсан байх. Есүстэй гурван жил хамт байсны дараа Филип “Эзэн, бидэнд Эцэгээ харуулаач. Энэ л бидэнд хангалттай гэв” (Иохан 14:8). Есүс 5,000 хүнийг хооллосноос хэдхэн долоо хоногийн дараа дагалдагч нар 4,000 хүнтэй нүүр тулсан. Харин тэд “Энэ зэлүүд газар эднийг хэрхэн талхаар цатгаж чадах билээ?” (Марк 8:4) хэмээн асууж байв.

Элч Паул ч мөн адил урам хугаралтыг туулж байсан. Илгээлтийн анхны аяллын үеэр Иохан Марк түүнийг орхиод явсан (Үйлс 13:13). Паул Демийг хэдэн сарын турш сургаж бэлтгэсэн ч, тэрээр шоронд ганцаардан байхдаа “Дем өнөө үеийг хайрлаж, намайг орхиод...” (2 Тимот 4:10) хэмээн бичжээ.

Халамжлах нь өртөг ихтэй бөгөөд урам хугалдаг боловч удирдагчийн ажлын чухал хэсэг юм. Өсөж төлөвшсөн Христэч удирдагч бүр ирээдүйн удирдагчдыг халамжлах хэрэгтэй. Үүний зэрэгцээ Христэч удирдагч хүн бүрд тэмцэлдэх үед нь дэмжлэг үзүүлдэг халамжлагч хэрэгтэй.

Ховард Хендрикс “Хүн бүрийн амьдралд гурван хүн хэрэгтэй байдаг” гэж хэлсэн:

1. Хүн бүрд Паул хэрэгтэй. Тасралтгүй өсөлтөд уриалж халамжлах Паул адил хүн.
2. Хүн бүрд Барнаб хэрэгтэй. Чиний сул талыг шударгаар хэлэх хэмжээнд чамайг хангалттай хайрладаг Барнаб адил найз.
3. Хүн бүрд Тимот хэрэгтэй. Үйлчлэлд халамжилж, дагалдуулах залуу хүн.

► Эдгээр асуултаар хичээлээ төгсгөө:

- “Хэн миний Паул вэ?”
- “Хэн миний Барнаб вэ?”
- “Хэн миний Тимот вэ?”

### 3-р хичээлийн даалгаврууд

(1) Доорх хүснэгтэд дагалдагч нар Есүсийн үйлчлэлийг ажиглаж байсан дөрвөн жишээ тохиолдлыг жагсаана уу. Дагалдагчид Есүсийг ажигласнаар юу сурсан талаар тэмдэглэ.

(2) Ирээдүйн үйлчлэлд нь бэлтгэж халамжлах хоёр эсвэл гурван хүний нэрийг жагсаана уу. Богино догол мөрөнд дараах хоёр асуултад хариулж бич:

- Халамжилж буй хүнээсээ ямар шалгууруудыг би харахыг хүсэж байна вэ?
- Миний халамжилж буй хүний дотор Бурхан юу хийхийг би хармаар байна вэ? (тодорхой байдлаар)

Өөрийн нэрлэсэн хүмүүсээ халамжлах алхмыг эхлүүлээрэй. Тэднийг үйлчлэлийн боломжуудад хэрхэн бэлтгэж болохыг харуулахыг Бурханаас гуй.

Үйл явдал	Бичвэр	Дагалдагч нарын сурсан хичээл
Есүс чөтгөрт эзэмдүүлсэн хүүг эдгээсэн	Матай 17:14-21	итгэлийн хүч чадал

## 4-р хичээл

### Есүстэй адил зааж сургах нь

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Есүсийг агуу багш болгосон чанаруудыг таньж мэдэх.
- (2) Багшийн ажлыг сайжруулах практик аргуудад суралцах.
- (3) Суралцагчид хичээлд бэлэн байхын тулд даалгавруудыг төлөвлөх.

#### Үйлчлэлийн зарчим

Суралцагчид маань бүрэн бэлтгэгдсэн үедээ багш шигээ болно.

#### Танилцуулга

► Энэ хичээлийн төгсгөлд даалгаврыг оруулаагүй. Харин хичээлийн туршид хийх жижиг даалгавруудыг “Сурсан зүйлээ хэрэгжүүлэх” хэсэгт багтаасан. Эдгээрийн зарим нь бичих эсвэл практик үйл ажиллагаа шаардах бол бусад нь зүгээр л бодож, ярилцах даалгаврууд юм. Хичээлийн материалтай ажиллах явцдаа даалгавар нэг бүрийг хийх ёстой.

Заах талаар хэлсэн Есүсийн хамгийн гүн гүнзгий сургаалуудын нэг нь “Шавь нь багшийнхаа дээр байдаггүй. Бүрэн суралцах аваас хэн ч багш шигээ болж болно” (Лук 6:40) юм. Есүс дагалдагч нарыг сургах үед тэд Түүний зан чанарыг тусгана гэдгийг мэдэж байлаа. Тийм ч учраас Есүс арван хоёр элчийг сургахад маш их хүч зарцуулжээ.

Зарим чуулган хүүхдийн цуглаан, Ням гарагийн сургалтдаа ямар ч туршлагагүй, бэлтгэгдэж сургагдаагүй хүмүүсийг багшаар авдаг. Шинэхэн итгэгчид болон хүүхдүүдэд заах тал дээр бага хүчин чармайлт гаргадаг.

Чуулганы удирдагчдын хувьд Есүс зааж сургахад өгч байсны адил ач холбогдлыг бид зааж сургахдаа өгөх ёстой юм. Хэрэв суралцагчид багштайгаа адил байх юм бол багшлах үүрэг нь ч маш чухалд тооцогдох болно. Бид багш нарыг бэлтгэхдээ Мастер багш Есүсийн үлгэр дуурайлыг дагахад сургах ёстой.

► Есүсийн заах арга барилын талаар мэддэг зүйлсээ бодож үзээрэй. Түүнийг агуу багш болгосон гурав эсвэл дөрвөн шинж чанаруудыг жагсаа. Одоо өөрийнхөө сурч байсан үеийн хамгийн шилдэг багшийн талаар бодож үз. Энэ хүнийг агуу багш болгосон гурав эсвэл дөрвөн шинж чанаруудыг бичээрэй. Энэ хоёр жагсаалтын аль аль шинж чанарууд нь давхцаж байна вэ?

## **Мастер багшийн зүрх сэтгэл: Зан чанар**

Есүсийн сургаалын **агуулга** нь Багшийн **зан чанарт** суурилдаг. Есүсийн зүрх сэтгэл Түүний сургаалын үндэс суурь болдог. Тэгвэл агуу багш хүний гол чанар юу вэ?

### **Мастер Багш Есүс суралцагчдынхаа хэрэгцээг ойлгож мэддэг байсан**

► Лук 4:16-21 эшлэлийг унших.

Сургуулийн багш нар өдөр бүр ангид суралцах хичээлийн төлөвлөгөө гаргадаг. Хичээлийн төлөвлөгөө нь тухайн багш анги тус бүр дээр юу хийхийг харуулдаг. Хичээлийн төлөвлөгөө нь дараах зарим зүйлсийг багтаадаг. Жишээ нь:

- Зорилго: Сурагчид бутархай тоог нэмж сурах.
- Үйл ажиллагаа: Сурагчид ангийн ажлын дэвтрийн 89-р хуудасны 1-20-р бодлогуудыг хийж гүйцэтгэнэ.

Есүс үйлчлэлдээ хичээлийн төлөвлөгөөтэй байсан ч, Түүний хичээлийн төлөвлөгөө нь ажлын дэвтэр дээр хуудасны дугаартай байсангүй. Харин Есүсийн хичээлийн төлөвлөгөө нь суралцагчдынхаа хэрэгцээнд төвлөрсөн байв. Түүнийг сонсож буй хүмүүст Есүс юуг гүйцэлдүүлэхээр илгээгдсэн талаар хэлэхдээ:

- Ядууст сайнмэдээг хүргэх.
- Олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах.
- Сохруудад хараа оруулах.
- Дарамтад байгсдыг чөлөөлөх.
- Эзэний тааламжит жилийг тунхаглах (Лук 4:18-19).

Есүсийн зорилго нь суралцагчдынхаа хэрэгцээтэй яв цав нийлж байна. Есүсийн дагалдагчид нь Йерусалим дахь Сүм дуганыг хяналтдаа байлгаж, Санхедринд улс төрийн эрх мэдлийг гартаа авсан чинээлэг садукайчууд байгаагүй. Түүний дагалдагч нар нь Ромд дарлагдаж байсан эгэл жирийн иудей хүмүүс байлаа. Тэдний зарим нь сохор эсвэл доголлон байжээ. Тэдний олонхи нь өндөр татвараас болж зовж зүдэрсэн ядуу хүмүүс байв.

Есүсийн хичээлийн төлөвлөгөө нь энгийн байсан бөгөөд суралцагчдынхаа хэрэгцээтэй тохирч байлаа. Тэр олзлогдогсдыг чөлөөлөх болно. Тэрээр сохруудад хараа оруулах болно. Иудейн хуанлийн дагуу Эзэний тааламжит жил нь баяр ёслолын үе байв. Өрийг цуцалж, газрыг анхны эзэмшигч гэр бүлд буцааж олгодог, боолууд чөлөөлөгддөг жил байв. Есүс дарлагдсан хүмүүст Эзэний тааламжит жилийг авчрахаар ирсэн гэдгээ зарласан.

Есүс дэлхий дээрх үйлчлэлийнхээ туршид суралцагч нарынхаа хэрэгцээг анхаардаг байлаа. Есүс хүмүүсийн хүссэн зүйлийг үргэлж өгч байгаагүй ч, харин тэдэнд хэрэгтэй зүйлийг нь өгдөг байсан. Самари эмэгтэй ус хүссэн. Харин түүнд золих аврал хэрэгтэй байсан (Иохан 4:7-42). Петр загас барихыг хүссэн. Харин түүнд үүрэг даалгавар

хэрэгтэй байсан (Матай 4:18-22). Эдгээр тохиолдол бүрд Есүс суралцагчдынхаа гүнзгий хэрэгцээнд нь анхаарч байна.

► Марк 10:17-22 эшлэлийг унших.

Есүстэй уулзахаар ирсэн нэгэн баян залуугийн түүхийг өгүүлэхдээ “Есүс түүнийг ширтэн харж, хайрлан” хэмээжээ. *Ширтэн харах* гэдэг үг энгийн нэг ажиглах төдий үг биш юм. Энэ нь сайтар ажиглах, тодорхой ялгах гэсэн утгатай. Есүс энэ залуугийн зүрх сэтгэлийг харсан. Бусад нь зөвхөн баян залууг л харсан байх. Есүс өлсгөлөн зүрх сэтгэлийг харжээ.

► Марк 16:1-8 эшлэлийг унших.

Есүсийг үгүйсгэснийхээ дараа Петр ямар ичгүүртэй байсныг төсөөлж үзээрэй. Тахиа донгодохыг санасан ичгүүрээсээ болж Петр Эзэнийхээ амилалд ч бүрэн гүйцэд баярлан баясч чадахгүй байв. Ийм нөхцөл байдалд тэнгэрэлч Мариад хандан “Харин явж, Түүний шавь нарт болон Петрт ‘Тэр та нараас түрүүнд Галил уруу явсан тул айлдсаных нь дагуу тэнд та нар Түүнийг харах болно’ гэж хэл гэв.” Бүх дагалдагч нараас илүү Петрт тайтгарал, баталгаа хэрэгтэй байсныг Есүс мэдэж байлаа. Бусад нь Эзэнээ үгүйсгэсэн хулчгар нэгнийг харсан бол Есүс сэргээгдэх шаардлагатай унасан дагалдагчаа харсан.

Бид суралцагчдыг ойлгохоос нааш тэдэнд зааж чадахгүй гэдгийг Есүс мэддэг. Суралцагчийн зүрх сэтгэлийг эзэмдэхийг хүсвэл суралцагчтай адил бодох хэрэгтэй. Та заадаг хүмүүсийнхээ зүрх сэтгэлийг ойлгож мэдэх учиртай. Багш хүний хувьд заах сэдвээ сайн судлах хэрэгтэй ч, үүнээс илүүтэйгээр суралцагч нараа судалж мэдэх хэрэгтэй. Та суралцагчдынхаа хэрэгцээг ойлгох ёстой.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Зааж сургаж буй хүмүүсийнхээ (албан болон албан бусаар) талаар бодож үз. Бэрхшээлтэй тулгарч байгаа оюутанд анхаарлаа хандуулаарай. Энэ оюутны хэрэгцээнд туслахын тулд хийж болох практик зүйлсийг жагсаан бич.

### **Мастер Багш Есүс тэвчээртэй байсан**

***Есүс өөрийг нь эсэргүүцсэн хүмүүст тэвчээртэй хандсан.***

► Иохан 6:41-71 эшлэлийг унших.

Энэ түүх Есүсийн үйлчлэлийн нэгэн чухал шилжилтийн мөчлөгт өрнөдөг. Өмнөх жил нь Есүс маш их нэр хүндийг олжээ. Хүмүүс Түүний гайхамшгуудыг биширч, талх, загасыг нь идэж баярлаж байлаа. Одоо Тэрээр тэдэнд хандаж “Амийн талх бол Би байгаа юм” гэжээ. Түүнчлэн сонсогчдынхоо сэтгэлийг түгшээх зүйлсийг Тэр өгүүлсэн. “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэж, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй.” Үүнээс болж Түүний дагалдагчдаас олноороо буцаж, цаашид Түүнтэй хамт явсангүй.

Есүс мянга мянган хүмүүст зааж сургаж байсан ч, олон хүн Түүний сургаалыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг мэдэж байлаа. Хэдийгээр нэг нь диавол гэдгийг мэдэж байсан ч, Тэр арван хоёрт зааж сургасан юм (Иохан 6:70). Есүс тэвчээртэй багш байжээ.

***Есүс өөрийг нь ойлгоогүй хүмүүст тэвчээртэй ханддаг байсан.***

► Марк 8:27-33 эшлэлийг унших.

Суралцахдаа удаан хүмүүст Есүс тэвчээртэй ханддаг байсан. Сайнмэдээний номуудад дагалдагч нарынх нь эргэлзсэн, харалган байдлын талаар хэдэн удаа дурдсаныг анзаарч үзээрэй. Петр “Та бол Христ...” гэж таньсан ч энэ нь юу гэсэн үг болохыг тэр үнэхээр ойлгоогүй байв. Хэдхэн эшлэлийн дараа Есүс түүний буруу бодлыг зэмлэжээ.

► Иохан 3:1-21 эшлэлийг унших.

Есүс сургаалыг нь ойлгоогүй фарисай хүнд тэвчээртэй хандсан. Никодем эргэлзэхэд Есүс гайхаж “Чи Израилийн багш атлаа үүнийг ойлгохгүй байна гэж үү?” гэж асуусан. Израил ус ба Сүнсээр төрөх өдрийн талаар Езекиел урьдаас өгүүлснийг Никодем мэдэх ёстой байжээ. Гэсэн ч Есүс бууж өгсөнгүй, тэвчээртэйгээр Никодемд заасан юм.<sup>23</sup>

Хэр зэрэг тэвчээртэй багш гэдгээ мэдэхийг хүсвэл: “Бууж өгөлгүйгээр үргэлжлүүлэн зааж сургасан тохиолдол маань хэр олон удаа вэ?” гэж асууж болно. Есүс дагалдагч нартаа тэвчээртэйгээр дахин давтан зааж сургадаг байжээ. Хэрвээ суралцагчид нь Түүний сургаалд нээлттэй байвал Есүс үргэлжлүүлэн заасаар байдаг байж. Мастер Багш Есүс тэвчээртэй байсан.

**Сурсан зүйлээ хэрэгжүүлэх нь**

► Та удаан суралцагч нараас залхаж, бууж өгөхөөр соригдож байна уу? Таныг заахад тэд хариу үйлдэхгүй таныг бухимдуулдаг уу? Та зааж сургаж буй хүмүүстээ хэрхэн Мастер Багшийн тэвчээрийг харуулж чадах вэ?

**Мастер Багш Есүс суралцагч нараа хайрласан.**

► Марк 6:30-34 эшлэлийг унших.

Есүс дагалдагч нарын хамтаар Галил нуурыг гаталж, олон хүн болон үйлчлэлийн байнгын дарамт ачааллаас түр амсхийх зэлүүд газрыг олохоор явав. Олон мянган хүмүүс Түүний явж байгааг хараад Есүстэй уулзахаар эрэг дагуу гүйлдсэн. Есүсийг эрэгт хүрэхэд 5,000 эрчүүд дээр нь эмэгтэйчүүд хүүхдүүдээс бүрдсэн олон тооны хүмүүс цугласан байлаа. Есүс олныг хараад “Тэднийг өрөвдөв. Учир нь тэд хоньчингүй хонь мэт байв. Тэр тэдэнд олон зүйлийг зааж эхлэв” (Марк 6:34) гэжээ. Мастер Багш Есүс өөрийн суралцагчдыг хайрласан учраас тэдэнд зааж сургажээ.

---

<sup>23</sup> Иохан 3:5 эшлэлд Езекиел 36:25-27 хэсгийг заасан. Езекиел Бурханы ард түмэн усаар угаагдаж (энэ нь цэвэр бусаас болон хиймэл шүтээнүүдээс цэвэрлэгдэх), шинэ Сүнснийг (энэ нь Бурханы хуулийг сахих хүсэл тэмүүллийг өгдөг) хүлээн авах тэрхүү өдрийг харжээ.

Энэ хичээлийн эхэнд бид Есүсийг дагах өртгийг төлөлгүйгээр явж одсон баян залуугийн гунигт түүхийг уншсан (Марк 10:17-22). “Есүс түүнийг ширтэн харж, хайрлан” (Марк 10:21). Хэдийгээр өөрийг нь орхиод явсан ч Мастер Багш суралцагчаа хайрласан.

Есүс олон түмнийг, хувь хүмүүсийг, тэр ч байтугай өөрөөс нь татгалздаг хүмүүсийг ч өрөвдөн хардаг байжээ. Нэгэн номлогч “Есүсийн хайрласан дагалдагч Иудас” гэсэн гарчигтай номлол хийжээ. Энэ номлогч Есүс Иудасыг ч хүртэл хайрласан гэдгийг ойлгож мэджээ. Иудасыг өөрөөс нь урвахыг мэдсэн ч Есүс дагалдагчаа эцсээ хүртэл хайрласан юм.

Хичээлдээ эрт ирдэг, даалгавраа биелүүлдэг, сурах хүсэл тэмүүлэлтэй сурагчийг хайрлахад амархан байдаг. Харин биднээс урвадаг Иудас, холдон одох баян залуу, үргэлж эргэлзэж бүтэлгүйдэг Петр шиг хүмүүсийг хайрлах нь хэцүү. Бид ийм хэцүү суралцагчдыг ч хайрлах ёстой гэдгийг Мастер Багш Есүс харуулсан юм.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Хайрлахад хэцүү суралцагчийнхаа талаар бодож үзээрэй. Магадгүй тэр таны удирдлагыг эсэргүүцдэг ажилтан чинь байж болох юм. Таныг шүүмжилдэг чуулганы тань гишүүн байж ч магадгүй. Харин та “Бурхан минь ээ, би эдгээр хүмүүсийг хайрлахад амаргүй байдгийг та мэдэх билээ. Гэхдээ Та тэдэнд хайртай гэдгийг би мэднэ. Тэднийг Таны нүдээр харахад надад туслаач. Есүс суралцагч нараа хайрласан шиг тэднийг хайрлахад надад туслаач” хэмээн залбирч эхлээрэй.

### **Мастер Багшийн гар: Арга барил**

“Мастер Багшийн зүрх сэтгэл” хэсгээс бид Есүсийн зан чанарыг харсан. Есүсийн заасан бүх зүйл Түүний зан чанарт үндэслэгдсэн байв. “Мастер Багшийн гар” хэсгээс бид Есүсийн ашигласан арга барилуудаас суралцах болно. Хэрэв бид Есүс шиг зааж сургахыг хүсвэл Түүний арга барилыг дагах ёстой.

### **Мастер Багш Есүс зорилгоо тайлбарласан.**

► Лук 5:1-11 эшлэлийг унших.

Есүс Галил нуурын эрэгт зааж байх үед олон хүн Түүнийг шахсан учраас Симон Петрийн загасчилдаг завин дээр Тэр гарчээ.<sup>24</sup> Сургаалаа дуусгаад Есүс Симонд хандан “Усны гүн уруу нь оч, загасчлахын тулд тороо доошлуул” (Лук 5:4) гэж хэлсэн.

Симон туршлагатай загасчин байсан бөгөөд шөнөжин загасчлаад хоосон иржээ. Тэр үед загасчлах талаар ямар нэг зүйл сэдэх нь дэмий гэж тэр мэдэж байсан ч, Есүсийн

---

<sup>24</sup> Лук номд “Геннесаретын нуур”, Иохан номд “Тиберийн нуур”, Матай болон Марк номд “Галил нуур” гэж тэмдэглэгдсэн, түүнчлэн Мосегийн “Хиннеретийн тэнгис” (Тооллого 34:11) гэж дурдсан бүгд Есүсийн үйлчлэлд чухал ач холбогдол бүхий томоохон нуурын нэр юм. Есүсийн хэд хэдэн дагалдагчид нь энэ нуурын загасчид байсан бөгөөд Түүний үйлчлэлийн ихэнх нь Галил нуурын эрэгт явагджээ.

тушаасны дагуу үйлджээ. Улмаар загасчид олон тооны загас барих үед Петр гайхаж хоцров. Есүс Симонд “Үүнээс хойш чи хүмүүсийг загасчлах болно” (Лук 5:10) хэмээжээ.

Есүс бусад сайн багш нарын адил дагалдагч нартаа зорилгоо тодорхой хэлж ярьж байсан. Пэнтекостын өдөр Петр Есүсийн өөрт нь бэлдсэн зорилгыг биелүүлэхэд бэлэн байгаагаа харуулжээ.

Үр нөлөөтэй багш нар зорилгоо танилцуулдаг. Тэд суралцагч нартаа “Та нар өнөөдөр үүнийг сурах болно” гэж хэлдэг. Хичээлийн төгсгөлд тэд “Та нар өнөөдөр юу сурсан бэ?” гэж асуудаг. Тэд тухайн хичээлийн зорилго биелсэн эсэхийг суралцагч нартаа бататган харуулдаг.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Дараагийн заах хичээлдээ самбар ашиглан, суралцагчдад харагдахуйц байдлаар хичээлийн зорилгоо бич. Зорилго нь ойлгомжтой, ойлгоход хялбар байгаа эсэхийг шалга. Хичээлийн эхэнд зорилгоо танилцуулаарай. Хичээлийн төгсгөлд суралцагчдаас “Бид зорилгоо биелүүлсэн үү?” гэж асууна.

### **Мастер Багш Есүс зааврын дагуу дадлага хийх боломжийг олгосон.**

Үр нөлөөтэй заах нь лекц уншихаас илүү юм. Жинхэнэ суралцах үйл явц нь дадлагыг шаарддаг.

► Лук 10:1-24 эшлэлийг унших.

Эдгээр дагалдагч нар бүрэн бэлтгэгдээгүй байсан ч, Есүс тэдэнд зааж байсан хичээлүүдийг хэрэгжүүлэхийг зөвшөөрчээ. Дагалдагчид энэ үйлчлэлийн аяллаас буцаж ирэхдээ Есүст тайлан тавьсан. Тэд сурсан зүйлээ ойлгохгүй байгааг Есүс хараад илүү зааврыг өгчээ. Тэр бас тэднийг урамшуулж “Та нарын харж буй зүйлсийг харагч нүд ерөөлтэй” (Лук 10:23) гэж хэлсэн. Есүс тэдний дадлага ажлыг зааварчилсан.

Дадлага хийх боломж олгох нь хангалтгүй. Дадлага ажлыг нь үнэлж, дараа нь залгуулаад нэмэлт сургалтуудыг хийх ёстой. “Дадлага ажил төгс болгодог” хэмээх олны ярьдаг мэргэн үг байдаг. Энэ үг бүхэлдээ үнэн биш юм. Буруу дадлага ажил нь илүү сайн гүйцэтгэлийг бий болгодоггүй. Харин үүний оронд **“зааварчилгаа бүхий дадлага”** ажил нь төгс болгодог” гэвэл илүү дээр. Үр нөлөөтэй багш суралцагчдад дадлага хийх боломж олгож, дадлага ажлыг нь суралцагчидтай хамт хянаж, улмаар суралцагчдаа урамшуулж тэдэнд заавар чиглүүлэг өгдөг.

Паул зааварчилгаа бүхий дадлага ажлын үнэ цэнийг мэддэг хүн байв. Тэрээр Тимот, Тит хоёрыг сургаж, дараа нь тэднийг үйлчлэх талбарт нь тавьжээ. Пасторуудын захидлуудад Паул Тимот, Тит хоёрт нэмэлт заавруудыг өгсөн байдаг. Тэр дагалдагч нараа түүний заасан үйлчлэлийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд нь зааварлаж чиглүүлжээ.

Өмнөд Африкийн нэгэн сургуульд сурагч бүр 1 Коринт 13-р бүлгийг цээжилж, ангидаа уншдаг байв. Нэг сурагч энэ даалгаврыг биелүүлж чадахгүй хэдэн долоо хоног болжээ.



Тэр сайн цээжилж чаддаггүй, бусдын өмнө ярихаасаа их ичдэг хүүхэд байж. Харин нэг өдөр энэ сурагч цээжилсэн бүтэн бүлгийг ангидаа уншсан юм.

Түүнийг цээжээр уншиж дуусгах хүртэл ангийнхан нь босож зогсоод, түүнийг дэмжиж байлаа. Яагаад? Энэ бүлэг нь хайрын тухай бөгөөд тэдний багш сурагчдад хайр нь бусдад урам зориг өгдөг гэдгийг заасан байжээ. Ангийнхаа хүүхдийг урамшуулж байхдаа эдгээр сурагчид 1 Коринт 13-р бүлгийн хичээлээ хэрэгжүүлжээ! Үр нөлөөтэй багш нар сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд нь суралцагчдаа урамшуулдаг.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Сурч байгаа зүйлээ хэрэгжүүлэх боломжийг суралцагч нартаа олго. Хэрэв та залуу пасторуудыг сургаж байгаа бол тэдэнд номлох, өвчтэй хүнийг эргэх эсвэл үл итгэгч хүнд сайнмэдээ хуваалцах зэрэг боломжийг олгоорой. Тэднийг хийж дууссаны дараа үйлчлэлийг нь үнэлж, сайжруулах санал хэлж, амжилттай болсон зүйлийг нь анзаарч урамшуулаарай.

### **Мастер Багш Есүс уян хатан байсан**

Есүсийн зааж сургаж байсан газрууд, нөхцөл байдлын талаар бодож үзээрэй. Есүс заахдаа:

- Далайн эрэг дээр (Лук 5-р бүлэг)
- Салхи шуургатай үед (Лук 8:22-25)
- Суралцагчид бэрхшээлтэй нүүр тулах боломжийг олгож (Матай 14:25-33)
- Зочид сургаалыг нь тасалдуулах үед (Матай 12:46-50)
- Сүмд айлчлах үедээ (Матай 24-р бүлэг)
- Зааж сургаж байхад нь хэн нэгэн байшингийнх нь дээврийг нүхлэх үед (Лук 5:18-26)

Лук 5:18-26-д өгүүлдэг гайхамшгийн дараа гэртээ буцан ирж байгаа дагалдагчдын талаар төсөөлж үзээрэй. Тэд Есүсийн хүч чадлын тухай сурсан энэ хичээлийг хэзээ ч мартаагүй нь лавтай. Лук “Тэд бүгдээрээ гайхан цочирдож, Бурханыг алдаршуулж—Бид өнөөдөр мөн ч хачин юм үзлээ гэгцгээн бүгд айдаст автсан байлаа” (Лук 5:26) хэмээн бичжээ.

Суралцагч нар нь сурахад бэлэн байх үеийг, заах тохиромжтой цаг мөчийг агуу багш мэддэг шиг Есүс уян хатан байдлыг хангалттай харуулжээ. Лук энэхүү зарчмын нэгэн жишээг дурдсан. “Нэгэн газар Түүнийг залбирч дууссаны дараа шавь нарынх нь нэг Түүнд—Эзэн... залбирахыг... бидэнд зааж өгөөч” (Лук 11:1). Есүс залбирлын талаар заахад энэ цаг мөчийг зориулжээ.

Найман настай охин Абигаил төгөлдөр хуурын хичээлээ хийхээр өрөөнд орж ирээд “Миний муур өнөө өглөө үхчихлээ!” хэмээн уйлж эхэлжээ. Абигаилд төгөлдөр хуурын дасгал, хэмжээг тоглох ямар ч сонирхол төрсөнгүй. Гэтэл багш нь түүнд “Миний дуртай

бяцхан муужгай” зохиолын хэсгийг тоглуулахаар өгчээ. Харин тэр үед Абигаил “Би үүнийг муурныхаа дурсгалд зориулж сурмаар байна!” гэж хэлжээ.

Багш нар бид суралцагчдаа сонсож, тэдний нөхцөл байдалд хариулах ёстой. Мастер Багш Есүсийн адилаар бид зааж сургахдаа уян хатан байх учиртай. Бид хичээлээ суралцагчдынхаа хэрэгцээнд тохируулж өөрчлөхөд нээлттэй байх хэрэгтэй.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Та заахдаа уян хатан байдаг уу? Хичээлээ заах дор хаяж хоёр өөр аргачлалыг төлөвлө. Хэрэв та ихэвчлэн лекц уншдаг бол лекцгүй хэлэлцүүлэг эсвэл суралцагчдыг оролцуулсан үйл ажиллагаанд үндэслэн хичээлээ төлөвлөөрэй. Хэрэв та дэлгэцээр үзүүлэх болон бусад технологийг хичээлдээ байнга ашигладаг бол цахилгаан эрчим хүч ашиглахгүйгээр заах хичээлийг төлөвлөж үзээрэй. Хэрэв та ангид хичээлээ заадаг бол гадаа, байгальтай харьцах байдлаар хичээлээ заахаар төлөвлөж болно.

### **Мастер Багш Есүс бүтээлч байдлаар тайлбарласан**

Есүс хэзээ ч сууж байгаад “Өнөөдөр бид сурах бичгийн 212-р хуудсыг унших болно. Петр, чи бидэнд эхний багц хэсгийг уншиж өгөөрэй” гэж хэлэхгүй. Харин үүний оронд Есүс бүтээлч, шинэлэг байдлаар заадаг байсан.

► Бүтээлч байдлаар заасан Есүсийн жишээ бүрийг унших:

- **Лук 6:39-42.** Сохор хүн өөр нэг сохор хүнийг замчилж байгаа егөөтэй явдлыг бодож үзээрэй. Нүдэндээ дүнзтэй хүн өөр нэг хүний нүдэн дэх үртсийг авах гэж байна гээд төсөөлөөд үз дээ.
- **Лук 18:18-30.** Бурханы хаанчлалд орохын тулд дэлхийн эд баялгийг ашиглах боломжтой юу? Тэмээг зүүний нүхээр багтаахаар шахаж байна гээд төсөөлөөд үз!
- **Лук 9:46-48.** Есүс даруу байдлын тухай сургахдаа хүүхдийг амьд үзүүлэн болгон заажээ.
- **Лук 15:1-7.** Гэртээ буцан ирж буй төөрсөн нэгэнд Бурхан хэрхэн ханддаг вэ? Есүс тариачдад хонины үнэ цэнийг сургасан.
- **Лук 15:11-32.** Туйлын эрх мэдэл нь эцэг хүнээр хэмжигддэг эцгийн эрхэт ёс давамгайлсан нийгэмд Есүс тэрслүү хүүгээ угтахаар гүйж буй эцгийн тухай сургаалт зүйрлэл ярихад хүмүүс цочирдож байсан нь лавтай.

Есүс асуултад шууд хариулах нь маш ховор байлаа. Үүний оронд Тэр түүх хүүрнэх эсвэл өөр асуулт асуух байдлаар хариулж байсан. Лук 10-р бүлэгт хуульч Есүсээс “Багш аа, мөнх амийг өвлөн авахын тул би яах ёстой вэ?” гэж асуухад Тэр сайн самари хүний түүхээр хариулжээ (Лук 10:25-37).

Есүс гайхалтай сайн асуулт асуухыг мэддэг байсан. Тэр энгийн “Тийм” эсвэл “Үгүй” гэж хариулагдах асуултуудыг бараг тавьдаггүй байв. Харин Тэрээр сонсогчийг шинэ боломжуудыг олж харахад нүдийг нь нээхүйц тийм асуултуудыг асуудаг байсан.

► Эдгээр жишээг унших:

- **Лук 7:36-50.** Өөрийг нь шүүмжилсэн фарисай хүнээс Есүс “Ихээр уучлагдсан нь уу, эсвэл багахан уучлагдсан нь уу, хэн нь хамгийн их хайрлагдах вэ?” гэж асуужээ.
- **Марк 8:36.** Өөрийг нь дагах талаар сургахдаа Есүс “Хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ?” хэмээн асуусан.
- **Лук 6:46.** Дуулгавартай байхыг хүсдэггүй хүмүүсээс Есүс “Та нар Намайг “Эзэн, Эзэн” гэж дууддаг хэрнээ юунд хэлснийг минь үйлддэггүй юм бэ?” гэж асуужээ.

Эдгээр асуултын аль нь ч амархан хариулах боломжгүй асуултууд юм. Эдгээр нь биднийг Есүсийн сургаалыг гүн гүнзгий бодож эргэцүүлэхэд хүргэдэг.

Багш нар дараах хоёр зүйлээс болж сайн асуулт тавьж чаддаггүй.

1. Бид хэтэрхий энгийн асуулт асуудаг. Хэрэв бид суралцагчдаар гүнзгий бодуулахыг хүсэж байгаа бол тийм, үгүй гэж хариулагдах эсвэл сурах бичигт бэлэн хариулт нь байгаа асуултуудыг асуух ёсгүй юм.
2. Бид хариултыг авахдаа хангалттай удаан хүлээдэггүй. Ихэнх багш нар хариулт авахаар дараагийн суралцагч руу шилжихдээ нэг секунд ч хүрэхгүй хугацааг хүлээхэд зарцуулдаг гэсэн судалгаа бий. Суралцагч асуултыг ойлгож, хариулт үүсгэж эхлэхэд ойролцоогоор гурван секунд шаардагддаг. Асуултынхаа хэрэглээг сайжруулахын тулд та дараагийн суралцагч руу шилжихээсээ өмнө үргэлж долоон секунд хүлээж байгаарай.

## Сурсан зүйлээ хэрэгжүүлэх

► Та заахдаа хэр бүтээлч вэ? Галат 6:7-8 эшлэлээр хичээл бэлтгээрэй. Суралцагчдад тарих ба хураах зарчмын талаар гүнзгий бодоход туслах асуултуудыг бэлтгэ. Та асуултуудаа бэлтгэсний дараа доорх зүүлт хэсгээс асуух боломжтой нэмэлт асуултуудыг үзнэ үү.<sup>25</sup>

---

<sup>25</sup> Галат 6:7-8 эшлэл дэх тарих ба хураах зарчмын талаарх асуултууд  
Байгальд болон нийгэмд тарих ба хураах зарчмыг харуулдаг ямар жишээнүүд байна вэ?  
Энэ зарчмыг тодруулж харуулдаг Библийн ямар дүрүүд байдаг вэ?  
Энэхүү зарчимтай холбоотой хувийн жишээ танд байна уу?  
Хувийн амьдралдаа хурааж авахыг хүсэхгүй байгаа тийм үрийг та тарьж байна уу?

## **Сайтар ажиглах нь: Сургаалт зүйрлэлүүдийг хөрвүүлэх**

Сургаалт зүйрлэл нь Есүсийн заах дуртай аргуудын нэг юм. Нэгэн хүн сургаалт зүйрлэлийг “Тэнгэрлэг сургамж бүхий ертөнцийн түүх” гэж тодорхойлсон байдаг. Есүс сургаалт зүйрлэлдээ танил хөдөө нутгийн байдал (тариачид, хоньчид болон хонин сүрэг), танил хүмүүс (самаричууд, тахилчид, татвар хураагчид болон фарисайчууд) болон танил нөхцөл байдлууд (төөрсөн хонь, алдагдсан зоос, гэрээсээ явсан хүү) зэргийг суралцагчдынхаа хүсэл сонирхолтой холбогдохын тулд ашигласан байдаг.

Shepherds Global Classroom байгууллагын *Библийн хөрвүүлгийн зарчмууд* курсэд сургаалт зүйрлэлүүдийг тайлбарлах хэсэг багтсан байдаг. Тэрхүү хичээлд заасан зарчмуудыг хураангуйлан энд оруулав. Сургаалт зүйрлэлийг судлахдаа бид дараах асуултуудыг асуух хэрэгтэй. Үүнд:

### **(1) Энэ сургаалт зүйрлэл яригдахад ямар асуулт эсвэл нөхцөл байдал нөлөөлсөн бэ?**

Сайн самари хүний тухай сургаалт зүйрлэлийг нэгэн хуульчийн “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” гэсэн асуултад хариулт болгон Есүс ярьсан бөгөөд “миний замд тааралдсан ямар ч гачигдалтай хүн миний хөрш бөгөөд миний үүрэг хариуцлага” (Лук 10:36-37) гэж хариулжээ.

Есүс төөрсөн хүүгийн тухай сургаалт зүйрлэлийг нүгэлтнүүдтэй хамт нөхөрлөж байгааг нь шүүмжилсэн шашны удирдагчдад хандан ярьжээ. “Татвар хураагчид ба нүгэлтнүүд бүгд Түүнийг сонсохоор ойртоцгооход, фарисайчууд болон хуулийн багш нар дургүйцэн дүнгэнэлдэж—Энэ хүн нүгэлтнүүдийг хүлээн авч тэдэнтэй хамт хооллодог гэхэд нь ийм сургаалт зүйрлэл тэдэнд айлдав” (Лук 15:1-3).

- Нэгэн хоньчин хонио алджээ. Тэр хонио олоод баярласан!
- Нэгэн эмэгтэй зоосоо гээж орхив. Тэр зоосоо олоод баярласан!
- Нэгэн эцэг хүүгээ алдсан. Тэр хүүгээ буцаж ирэхэд баярласан!

Есүс үүгээр “Намайг нүгэлтнүүдтэй хамт хооллоход та нар цочирдох ёсгүй. Нэг нүгэлтэн гэмшихэд тэнгэр баярладаг!” хэмээжээ.

Хэрэв бидний тайлбар нь Есүсийг түүх ярихад нөлөөлсөн нөхцөл байдал эсвэл асуултад хариулахгүй бол бид сургаалт зүйрлэлийн гол санааг орхигдуулсан гэсэн үг.

### **(2) Сургаат зүйрлэлийн үндсэн санаа (гол санаа) юу вэ?**

Сургаалт зүйрлэлд өгүүлэгдэх гол дүр болгон нэг гол санааг агуулдаг. Сургаалт зүйрлэлийн үндсэн сургамж нь сургаалт зүйрлэл ярихад нөлөөлсөн нөхцөл байдал эсвэл асуулттай шууд холбоотой байдаг. Бусад сургамжуудыг яригдсан түүхийн дүр, хүмүүсээс авдаг.

Төөрсөн хүүгийн тухай сургаалт зүйрлэлд гурван дүр гардаг. Түүхийн үндсэн сургамж нь гэмшсэн нүгэлтний төлөөх тэнгэрийн баяр баясгалан гэдгийг бид өмнө нь харсан.

Энэхүү сургамж нь Есүсийг түүх ярихад нөлөөлсөн нөхцөл байдлын хариулт юм. Сургаалт зүйрлэлд гардаг дүр болгон түүхийн үндсэн сургамжтай холбоотой үнэнийг зааж болно. Эцэгийн дүр бидний тэнгэрлэг Эцэгийн гайхалтай хайрыг заадаг. Төөрсөн хүүгийн дүр нүглийн өртөг болон гэмших боломжийн талаар аль алиныг нь заадаг. Бид сайн хүү мэт харагдаж байсан ч эцэгт хайрлагдсан боломж завшааныг алдаж болно гэдгийг том ахын дүр анхааруулдаг.

### **(3) Ахуй соёлын ямар нарийн ширийн зүйлс сургаалт зүйрлэлд чухал вэ?**

Есүсийн заасан сургаалт зүйрлэлүүд нь ихэвчлэн тухайн ахуй соёл дахь ердийн хэм хэмжээтэй зөрчилддөг. Энэ нь сургаалт зүйрлэлүүдийг мартахын аргагүй болгодог. Жишээ нь, тэрслүү хүүгээ угтахар гүйж байгаа эцэг, самари хүнийг баатар гэж харуулсан, хүчгүй бэлэвсэн эмэгтэй хүчирхэг шүүгчийг ялдаг түүх гэх мэт. Бид сургаалт зүйрлэлийн ахуй соёлын нөхцөл байдлыг сайн ойлгох тусам Есүсийн сургаалыг илүү сайн ойлгох боломжтой.

#### **Хэрэгжүүлэлт: Багшийн долоон хууль**

Др. Ховард Хендрикс<sup>26</sup> Даллас Теологийн Семинарт 60 гаруй жил багшилсан хүн юм. Багшлах хугацаандаа тэрээр 10,000 гаруй оюутнуудад хичээл заажээ. Түүний хамгийн нөлөө бүхий номуудын нэг нь “Багшийн хуулиуд” нэртэй жижиг ном юм. Эдгээр хуулиуд нь Есүсийн заах арга барилд үндэслэгджээ. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлснээр та илүү үр нөлөөтэй багш болох болно.

#### **Багшийн хууль**

*Багшийн хууль:* Өнөөдөр өсөхөө боливол, маргааш багшлахаа болино.

Др. Хендрикс “Та хуучин цөөрөм эсвэл урсгал горхины алинаас нь ус уухыг илүүд үзэх вэ?” гэж асуусан байдаг. Урсгал цэнгэг ус нь тогтоол, өмхий уснаас хавьгүй дээр юм.

Зарим багш нар заадаг хичээлтэйгээ холбоотой шинэ ном уншилгүй, шинэ санаа олж авахгүй олон жил явдаг. Тэдний зааж сургах нь яг л тогтоол, өмхий устай цөөрөм адил болж хувирдаг. Пасторууд Бурханы Үгийн талаар шинэ ойлголттой болохын тулд байнга суралцдаг шиг багш нар бид үргэлжлүүлэн суралцаар байх ёстой юм.

#### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Нэг суралцагч танаас “Багшаа, та хамгийн сүүлд Библиэс юу сурсан бэ?” гэж асуусан гэж төсөөлье. Харин таны хариулт энэ долоо хоног, энэ сар, энэ жил, эсвэл бүр эрт дээр үеэс ирэх үү? Та Бурханы Үгийн талаарх мэдлэгээ өдөр бүр нэмэгдүүлж байна уу?

---

<sup>26</sup> Энэ хэсэг дэх материалыг Howard Hendricks, *Teaching to Change Lives* (Colorado Springs: Multnomah Books, 1987) номоос ашиглав.

## Боловсролын хууль

*Боловсролын хууль:* Хүмүүсийн суралцах арга зам нь та хэрхэн заахыг тодорхойлдог.

Есүс хоньчдод хонины тухай, загасчдад “хүмүүсийг загасчлах” талаар, худгийн дэргэд уулзсан эмэгтэйд усны тухай ярьж зааж байсан. Үр нөлөөтэй багш нь суралцагч бүрийнхээ хэрэгцээнд тохируулж заадаг гэдгийг Есүс мэддэг байжээ.

Др. Хендрикс багшлахыг хөл бөмбөгийн дасгалжуулагчийн ажилтай зүйрлэн ярьдаг. Дасгалжуулагч тоглоом тоглодоггүй. Харин тэр тоглогчдыг догдлуулж, чиглүүлдэг. Үүний нэгэн адил шилдэг багш бүх ажлаа лекцийн аргаар хийдэггүй. Шилдэг багш суралцагч нэг бүрийг үр дүнтэй сурахад нь урам зоригоор тэтгэдэг.

“Зааж сургахын эцсийн шалгуур нь та юу хийдэг, хэр сайн хийдэг тухай биш, харин суралцагч юу хийдэг, хэр сайн хийдэг тухай юм.”  
- Др. Ховард Хендрикс

Мика Библийн сургуулийн оюутан байлаа. Багш бүх оюутнуудыг шалгалтанд бэлдэхийн тулд тэмдэглэлээ анхааралтай хөтлөхийг хүсжээ. Харин Мика тэмдэглэл хөтлөхийг хүссэнгүй. Үүний оронд тэр багшийг лекц унших үед дэвтэртээ зураг зурдаг байв. Багш нь Микаг хичээлээ сонсохгүй байна гэж бодов. Хэд хэдэн удаа тэр “Мика, зураг зурахаа болиод миний зааж байгаа зүйлийг бичээрэй” гэж хэлж үзэв. Мика багшийнхаа асуусныг хийх гэж оролдсон ч тэр маш их бухимдаж байлаа.

Дараа нь багш Др. Хендриксийн “Боловсролын хууль”-ийг санасан. Тэгээд тэр “Мика, туршилт хийцгээе. Хичээл дээр миний ярьсан зүйлийг харуулж чадвал чи зургаа зурж болно” гэж хэллээ. Энэхүү туршилт амжилттай болсон юм. Мика үгсийг зураг болгон хувиргаж сурчээ. “Хүмүүсийн суралцах арга зам нь та хэрхэн заахыг тодорхойлдог” учраас багш өөрийн хүлээлтээ өөрчлөхөд суралцжээ.

## Сурсан зүйлээ хэрэгжүүлэх

► Танай ангид бусад суралцагчдаас арай өөр байдлаар сурдаг хүн бий юу? Түүнийг илүү үр дүнтэй суралцахад нь та хэрхэн тусалж чадах вэ?

## Үйл ажиллагааны хууль

*Үйл ажиллагааны хууль:* Хамгийн их оролцоо нь хамгийн их суралцах боломжийг олгодог.

Өөрийнх нь зааж буй хичээлийг дагалдагчид нь хэрэгжүүлэх ёстой гэдгийг Есүс мэдэж байлаа. Тэр тэднийг үйлчлэлийн аялалд илгээх, цугласан олонд талх, загас тараахыг тушаах, залбирахын тулд эзгүй газарт аваачих зэргээр сурсан зүйлээ хэрэгжүүлэх боломжийг олгодог байсан. Үр дүн нь юу байв? Элч нар дэлхийг орвонгоор нь эргүүлсэн хүмүүс хэмээн нэрлэгджээ (Үйлс 17:6).

“Би сонсдог... тэгээд мартдаг.  
Би хардаг... тэгээд санадаг.  
Би хийдэг... тэгээд ойлгодог.”  
- Хятад зүйр үг

Сэтгэл зүйчид хэлэхдээ:

- Бид сонссон зүйлийнхээ 10 хүрэхгүй хувийг санадаг.
- Бид харж, сонссон зүйлийнхээ 50 хүрэхгүй хувийг санадаг бол
- бид **харж, сонсож, хийдэг** зүйлийнхээ 90 хүртэлх хувийг санадаг.

Идэвхтэй оролцоо нь илүү ихийг сурахад нөлөөлдөг.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Дараагийн хичээлээ бэлдэхдээ таны заах зарчмыг суралцагчид хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг бэлтгэ.

### **Харилцааны хууль**

*Харилцааны хууль:* Жинхэнээсээ зааж сургая гэвэл бид суралцагч нартайгаа холбогдох ёстой (гүүр тавих).

Багш, пасторууд бид харилцааны ажил хэрэг явуулдаг хүмүүс билээ. Бидний ажил зүгээр мэдээлэл дамжуулахаас илүү өргөн. Бид сонсогчдод үнэнийг хүргэдэг. Харилцаа холбоо нь нийтлэг ойлголцлыг шаарддаг. Бид суралцагчидтайгаа холбогдож ойлголцохын тулд гүүр тавих шаардлагатай.

Суралцагч нартайгаа гүүр тавих үлгэр жишээг Есүс өгчээ. Есүс самари эмэгтэйтэй харилцахад үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн олон саадүүдтай тулгарсан. Есүс еврей, харин эмэгтэй самари хүн байв. Есүс эрэгтэй, тэр эмэгтэй байлаа. Есүс нэр хүндтэй рабби байсан бол эмэгтэйн өнгөрсөн амьдрал ёс суртахууны асуудалтай байжээ. Есүс эдгээр саадыг даван хэрхэн гүүр тавьж чадсан бэ? Есүс нийтлэг ойлголтыг барьж авсан. Тэд хоёулаа цангаж байв. Махбодын хэрэгцээ нь амьдралыг өөрчлөх уулзалтын гүүр болжээ (Иохан 4:1-42).

Др. Хендрикс харилцаа холбоо нь гурван түвшнийг хамарсан байх ёстой хэмээн бичжээ:

- 1. Мэдлэг** – миний мэддэг зүйл. Энэ бол харилцааны хамгийн энгийн түвшин.
- 2. Хүсэл тэмүүлэл** – миний мэдэрч буй зүйл. Энэ бол илүү гүнзгий харилцааны түвшин.
- 3. Үйлдэл** – миний хийдэг зүйл. Ийм түвшний харилцаа суралцагч нарыг маань өөрчилдөг.

Жоел Африкт семинарын зохион байгуулагчийн ажил хийдэг байхдаа нэгэн чинээлэг хандивлагчтай уулзаж, алсын хараа зорилгоо танилцуулжээ. Харин тэр хандивлагч Жоелын төсөөлж байснаас их хэмжээний санхүүг санал болгосон. Хандивлагч Жоелыг гайхшруулан өгөөмөр хандсаны учир вэ? Семинарын зохион байгуулагч маань гурван түвшний харилцаа холбоог бий болгож чадсан. Үүнд:

- 1. Мэдлэг** – Тэр Африкт семинарын сургалт явуулах хэрэгцээ шаардлага байгааг мэдсэн.
- 2. Хүсэл тэмүүлэл** – Тэр Африкт чуулганы удирдагчдыг сургахыг хүсэж байв.
- 3. Үйлдэл** – Тэрээр Африкт амьдралаа өнгөрөөж, чуулганы удирдагчдыг бэлтгэхийн тулд маш их золиос зориулалт гаргажээ. Жоел Африкт юу хийж байгаагаа ойлгуулж чадсан.

Үр нөлөөтэй зааж сургахын тулд бид хичээлдээ дуртай, хүсэл тэмүүлэлтэй байх ёстой. Хүүхдийн цуглаан болон Ням гарагийн сургалтын үеэр ангид ийм яриа өрнөж байна гээд төсөөлж үзье:

Багш: “Өнөөдөр бид Иохан 6-р бүлгээс 5,000 хүнийг хооллосон талаар суралцах болно.”

Суралцагч: “Надад нэг асуулт байна. Библид зөвхөн эрчүүдийн тоог бичсэн байна. Яагаад тэр вэ?”

Багш: “Би мэдэхгүй байна. Энэ тийм ч чухал биш л дээ. Зүгээр л хичээлдээ анхаар.”

Библийн сэтгэл хөдөлгөм түүх гэнэт уйтгартай санагдаж эхэлнэ. Есүс 20,000 хүнийг цөөхөн талх, загасаар яаж хооллосныг мэдэхдээ хүүхдүүд дуртай байх болно. Бид энэ түүхийг ийм уйтгартай болгох гэж үү? Энэ багш мэдлэгийг ойлгуулж хүргэхгүй байна. Тэрхүү еврей бичээчид яагаад зөвхөн эрчүүдийг тоонд оруулж бичсэн талаар нэмэлт материалыг судалсангүй. Багш сэтгэл хөдөлгөм түүхийг мэдрэхгүй, хүсэл сонирхолгүй заажээ. Энэхүү хичээл багшийн өөрийнх нь амьдралд бага ч болтугай өөрчлөлт авчраагүй бол суралцагч нарынх нь амьдралд өөрчлөлт авчрах магадлал бага юм.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Хичээлээ бэлдэж байхдаа өөрийнхөө ертөнц болон суралцагчдынхаа ертөнц хоорондын зай ялгаатай байдлыг бодож цэгнээрэй. Суралцагч нартаа гүүр тавихад цаг гарга. Хичээлээ суралцагчдынхаа сонирхолтой холбох арга замыг хайж ол.

### **Зүрх сэтгэлийн хууль**

*Зүрх сэтгэлийн хууль:* Үр нөлөөтэй зааж сургах нь толгойноос толгойд бус, харин зүрхнээс зүрхэнд явагддаг.

Есүсийг уулан дээрх номлолоо дуусгахад олон түмэн Түүний сургаалыг биширч, Тэр хуулийн багш нар шиг бус, эрх мэдэлтэй Нэгэний хувьд тэдэнд зааж байв (Матай 7:28-29) гэв. Есүсийн сургаал Түүний зүрх сэтгэлээс гарч, сонсогчдынх нь сэтгэл зүрхэнд хүрчээ.



Сайнмэдээний номуудад Есүсийн өр нимгэн сэтгэлийг дахин давтан харуулдаг. Түүний өр нимгэн зүрх сэтгэл нь хүмүүст хүрч байв. Түүний зүрх сэтгэл тэдний зүрх сэтгэлд хүрсэн. Үр нөлөөтэй заахад туслах зүйлсийн талаар Ховард Хендрикс бичжээ.

### ***Багшийн зан чанар нь суралцагчид итгэлцлийг төрүүлдэг.***

Хэрэв суралцагч нь багшийнхаа зан чанарт итгэдэг бол түүний зааж буй зүйлд ч итгэлтэй байдаг. Пастор, багш бидний хувьд энэ итгэлцлийг хэзээ ч үгүй хийх ёсгүй. Дахин сэргээхэд хамгийн хэцүү зүйл бол итгэлцэл юм. Ухаалаг христэч удирдагчид тэднийг ёс суртахууны болон ёс зүйн уналтад хүргэж болзошгүй бүхнээс холуур явдаг. Таны зан чанар суралцагчдад итгэлцлийг төрүүлэх ёстой.

### ***Багшийн өр нимгэн сэтгэл суралцагчид урам зориг нэмдэг.***

Суралцагч багшийнхаа энэрэнгүй сэтгэлийг мэдэрвэл сурах урам зоригтой болдог. Есүс тэднийг хайрладаг гэдгийг мэдсэн учраас дагалдагчид Түүнийг дагасан. Хэрэв та суралцагч нараа хайрладаггүй бол тэдний танаас сурах хүсэл эрмэлзэл нь бага байх болно.

Др. Хендрикс хүүхдүүдэд заадаг багш нартай ярилцах үеэрээ “Хэрэв Жоанна шинэ гуталтай болсон бол та түүний шинэ гутлыг анзаарах хэрэгтэй. Эс бөгөөс тэр таны шинэ хичээлийг хэзээ ч сонсохгүй!” гэжээ. Та суралцагчдаа анхаарал хандуулсны дараа л (таны хайрын улмаас) тэд таны зааж буй хичээлийг сурахад бэлэн байх болно.

### ***Багшийн заах агуулга суралцагчид ойлголтыг авчирдаг.***

Суралцагч сурах хүсэл эрмэлзэлтэй болсны дараа л та агуулгаа заахад бэлэн болно. Тэдний итгэлийг олж авсны дараа та өөрийн зүрх сэтгэлээс тэдний зүрх сэтгэлд ярьж чадна.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Та суралцагч нартаа хайртай юу? Хамгийн чухал нь та тэдэнд хайртай гэдгийг тэд **мэддэг** үү? Бурханаас танд илгээсэн суралцагч нартайгаа сэтгэлээсээ хэрхэн илүү сайн холбогдож чадах вэ?

### **Урам зоригийн хууль**

*Урам зоригийн хууль:* Суралцагч сурах хүсэлтэй болж зөвөөр өдөөгдөх үед зааж сургах нь хамгийн үр дүнтэй явагддаг.

*Өдөөлт* (сэдэлжүүлэх) гэдэг үгийг сонсохдоо олон багш нар амттан, гэрчилгээ, дүн эсвэл суралцагчдын урмыг сэргээх бусад аргуудын талаар боддог. Эдгээр шагнал нь буруу биш бөгөөд залуу хүмүүсийн сонирхлыг татахад тусалж чадна. Гэхдээ эдгээр урамшуулал нь жинхэнэ зорилгод хамааралгүй юм. Шагнал авахын төлөө ажиллаж байгаа суралцагчийн хувьд суралцаж байгаа үнэнээрээ өөрчлөгдөх магадлал бага байдаг. Тэгэхээр багш хүн суралцагчийнхаа дотоод сэдлүүдэд хандан ярих нь илүү дээр юм.

Др. Хендрикс зарим дотоод сэдлүүдийг нэрлэжээ. Үүнд:

- **Эзэмшил.** “Энэ бол миний чуулган. Үүнийг өсгөхийн тулд би зочдыг урих болно.”
- **Хэрэгцээ.** “Сорилтыг ялан дийлэхийн тулд надад Бурханы Үг хэрэгтэй. Тиймээс би Бичвэрийг цээжлэх болно.”
- **Хүлээн зөвшөөрөл.** “Би багшдаа хайртай, түүнийг баярлуулахыг хүсэж байна. Тиймээс би хичээлээ судлах болно.”

Эдгээр сэдэл нь амттан эсвэл дүнтэй харьцуулбал хамаагүй удаан настай. Эдгээр сэдэлжүүлэх хэрэгслүүдийг ашигласнаар бид суралцагчдыг урт удаан хугацааны туршид суралцахад нь урамшуулдаг.

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Суралцагч нараа сэдэлжүүлэх зүйлсийн жагсаалт гарга. Суралцахын ашиг тусын талаар та тэднийг хэрхэн өдөөх вэ?

### **Бэлэн байдлын хууль**

*Бэлэн байдлын хууль:* Суралцагч, багш хоёулаа хангалттай бэлтгэсэн үед зааж сургах нь хамгийн үр дүнтэй байдаг.

Энэ нь танай чуулганы ердийн Ням гарагийн хичээл шиг сонсогдож байна уу?

Багш: “Өнөөдөр бид Ефес 5-р бүлгээс сурах болно. Библиэ нээцгээнэ үү.”

Суралцагчид бодохдоо: “Бид яагаад Ефес 5-р бүлгийг судлах хэрэгтэй вэ?”

Багш Ефес 5-р бүлгийг нэг цаг орчим заалаа. Тэр бол сайн багш. Хичээлийн төгсгөл хэсэг ойртож, суралцагчид Паулын сургаалаас урам зориг авч байна. Хичээл дуусч, суралцагчид гэртээ харилаа. Долоо хоногийн дараа бид дахиад дараах яриаг сонсож болох юм:

Багш: “Өнөөдөр бид Ефес 6-р бүлгээс сурах болно. Библиэ нээцгээнэ үү.”

Суралцагчид бодохдоо: “Бид яагаад Ефес 6-р бүлгийг судлах хэрэгтэй вэ?”

Суралцагчид хичээл эхлэхээс өмнө Ефес 6-р бүлгийг сурсан бол хичнээн сайн байх байв! Хичээлд ирэхдээ тэд асуултуудаа жагсаан бичээд ирсэн бол хичээл илүү үр дүнтэй байх байсан уу? Мэдээжийн хэрэг! Та үүнийг яаж гүйцэлдүүлж чадах вэ? Профессор Хендрикс суралцагч нартаа хичээлдээ бэлтгэх даалгавар өгөхийг санал болгож байна. Жишээ нь:

- Суралцагчийг дараагийн долоо хоногт судлах хичээлээ бодохуйц тийм даалгавар өг. “Ирэх Ням гарагаас өмнө Үйлс 19-р бүлгийг уншаад Паул Ефес дэх чуулганыг хэрхэн эхлүүлж байсныг мэдэж авах.”
- Хичээлтэй холбоотой нэмэлт мэдээллийг олж авахуйц даалгавар өг. “Ирэх Ням гарагаас өмнө Ефес дэх Артемисийн сүмийн талаар Библийн толь бичгээс уншиж

мэдэх. Энэ нь Паул Ефес 6:10-20-д сүнслэг тулааныг онцолсныг тайлбарлахад туслах болно.”

- Суралцагчид бие даан суралцах чадвараа хөгжүүлэхүйц даалгавар өг. “Ефес 6-р бүлгийг энэ долоо хоногт өдөр бүр нэг удаа уншина. Уншиж байхдаа энэ бүлгийн талаар асуух нэг асуулт бичээд ирээрэй. Ирэх Ням гарагт бид чиний асуултын дагуу ярилцах болно.”

### **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Заах дараагийн ангидаа тэрний дараагийн хичээлд бэлтгэх даалгавар өг. Даалгавар нь тэднийг судлах хичээлээ илүү сайн ойлгоход бэлтгэж байгаа эсэхийг нягтлаарай.

### **Дүгнэлт: Багшийн зан чанар маш чухал**

Есүс “Бүрэн суралцах аваас хэн ч багш шигээ болж болно” (Лук 6:40) гэдгийг мэддэг байсан. Түүний дагалдагч нар энэ зарчмыг харуулсан. Төгс хайрын үлгэр дуурайлаар сургагдсан тул “Аянгын хүү” гэгдэх Иохан “Хайрын элч” Иохан болжээ. Итгэлийн үлгэр дуурайлаар сургагдсан тул “Эргэлзэгч Томас” “Энэтхэгийн төлөөх элч” болжээ. Дагалдагчид бүрэн суралцахдаа тэд Багш шигээ болсон юм.

Багш хүний хийх анхны алхам бол **суралцагчдаа ямар болоосой гэж хүсдэг тэр хүн байх** явдал юм. Хэрэв Есүс тогтвортой байдлын үлгэр дуурайл байгаагүй бол тогтворгүй Петрийг “Хад” болгож чадахгүй байсан. Бид суралцагч нараа ямар байгаасай гэж хүсдэг тэр хүн байх ёстой.

Паул энэ зарчмыг ойлгодог байжээ. Тэр коринтчуудад “Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайгчид бай” (1 Коринт 11:1) гэж хэлсэн юм. Тэр ямар зоригтой хэлнэ вэ! Энэ нь Паул “Хэрэв та зөв амьдралаар амьдрахыг хүсвэл намайг хуулбарла” гэсэнтэй адил юм. Паул Христийг дагаж байсан тул коринтчуудын хувьд Паулыг дагах нь аюулгүй байжээ.

Хэрэв миний суралцагчид над шиг болвол “Суралцагчид маань надаас хуулбарлахад ичихээр тийм зан чанарыг би харуулдаг уу?” гэж асуух ёстой юм. Хэрэв би суралцагч нартаа ууртай, тэвчээргүй байдлаар хандсан бол суралцагч нар маань “бүрэн суралцахдаа” бусдад уурлаж, тэвчээргүй хандвал би гайхах ёсгүй.

Багшийн хувьд зан чанар бол гол зүйл мөн. Та өөрийн амьдралдаа хөгжүүлж хэвшүүлээгүй зан чанаруудыг суралцагч нартаа хөгжүүлж чадахгүй. Багш хүний хувьд агуу боловсролоо харуулахаас илүүтэй бурханлаг зан чанарыг харуулах нь хавьгүй илүү чухал байдаг. Бид суралцагч нараа ямар байгаасай гэж хүсдэг тэр хүн байх ёстой.

## **Сурсан зүйлээ хэрэгжүүлэх**

► Есүстэй адил зааж сургах нь гэсэн энэхүү хичээлийн төгсгөлд, суралцагч нар тань танаас хуулбарлаасай гэж хүсэхгүй тэдгээр зан чанаруудыг харуулахыг Бурханаас та хүсээрэй. Таны суралцагч нар бүрэн суралцахдаа Бурханы зан чанар тэдний амьдралд тусгагдан харагдахын тулд өөрчлөх шаардлагатай нигүүлслийг Бурханаас гуй.

### **4-р хичээлийн даалгавар**

Энэ хичээлийн даалгаврууд хичээлийн туршид өгөгдсөн. Хэрэв та хичээлийн үеэр хийх ёстой үйл ажиллагаа бүрийг гүйцэтгэсэн бол 4-р хичээлд нэмэлт даалгавар өгөгдөхгүй.

## 5-р хичээл

### Есүстэй адил номлох нь

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Есүсийг үр нөлөөтэй номлогч болгосон шинж чанаруудыг таньж мэднэ.
- (2) Үр нөлөөтэй номлолд Ариун Сүнсний оролцоо чухал болохыг үнэлнэ.
- (3) Хоньчин-пасторын хувьд итгэмжит байхад өөрийгөө зориулна.
- (4) Есүсийн номлолын жишээ загварын дагуу номлол бэлтгэнэ.

#### Үйлчлэлийн зарчим

Үр нөлөөтэй номлол нь зөвхөн хүний хүчин чармайлтын үр дүн биш, харин энэ нь Ариун Сүнсээр хүчирхэгждэг.

#### Танилцуулга

Есүсийн номлолыг сонсоод олон түмэн хэрхэн хариу үйлдсэн талаар харцгаая.

- “Тэгээд Есүсийг үгээ гүйцээмэгц ард олон... гайхаж байлаа” (Матай 7:28-29).
- “олон түмэн бүгд Түүний сургаалыг сонсоод гайхаж” (Марк 11:18).
- “Хурсан олон Түүнийг дуртайяа сонсож байв” (Марк 12:37).

Есүсийн номлол хүчирхэг байсан. Түүний номлолыг сонсохоор мянга мянган хүмүүс цуглардаг байжээ. Есүсийн номлолын хэв маяг өнөөдөр бидэнд үлгэр дуурайл болох нь гарцаагүй. Дэлхий дээр Есүс хүмүүн чанараараа үйлчилсэн гэдгийг бид санах хэрэгтэй. “Есүс Бурхан байсан учраас хүчирхэг номлогч байх нь мэдээж шүү дээ” гэж бид бодох хэрэггүй юм. Харин “Есүс хүн байсныхаа хувьд хүч, эрх мэдэлтэйгээр номлолоо хүргэдэг байв. Түүний номлол хүмүүсийг үнэн рүү хандуулж байлаа. Би илүү үр нөлөөтэй сайнмэдээний номлогч болохын тулд Есүсээс юу сурч болох вэ?”

► Та өөрийгөө НТ 30 оны үед амьдарч байсан, Есүсийн номлолыг сонссон хүн гэж төсөөлье. Та юу харж, сонсохыг хүсэх вэ?

#### Есүс эрх мэдэлтэйгээр номлосон

► 2 Коринт 4:1-6 эшлэлийг унших.

Есүсийг Капернаумд номлох үед хүмүүс Түүний сургаалд гайхаж байлаа. Учир нь Тэр эрх мэдэлтэйгээр ярьжээ (Лук 4:32). Уулан дээрх сургаалыг сонсоод “Ард олон сургаалыг нь гайхаж байлаа. Тэр хуулийн багш нар шиг бус, эрх мэдэлтэй Нэгэний хувьд тэдэнд зааж байв” (Матай 7:28-29) гэжээ. Хуулийн багш нар өөрсдийн онолд дэмжлэг болгон бусад рабби нараас эш татдаг байсан бол, харин Есүс эрх мэдэлтэйгээр номлосон.

Пасторуудын хувьд бид эрх мэдэлтэйгээр номлох ёстой. Бидний эрх мэдэл Есүсийн эрх мэдлээс ялгаатай. Түүний эрх мэдэл нь угаасаа Түүнийх байсан бол, харин бидний эрх мэдэл нь Есүс Христийг төлөөлж буйн хувьд бидэнд өгөгдсөн юм. Бидний эрх мэдэл бидний номлодог сургаалаас эхтэй.

### **Бид Есүс Христийг төлөөлж буйн хувьд эрх мэдэлтэй номлодог**

Есүс “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” хэмээжээ. Үүний дараагийн эшлэлд Тэр дагалдагч нартаа үүрэг даалгаврыг өгч томилон “Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтун.... Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:18-20) гэж хэлсэн юм. Бид Есүсийг төлөөлөхөөр томилогдсон учраас бидэнд эрх мэдэл байгаа юм.

1783 онд АНУ-ын болон Жорж III хааны төлөөлөгчид Америкийн хувьсгалт дайныг дуусгах Парисын гэрээнд гарын үсэг зурахаар цуглажээ. Жорж III хаан гэрээнд гарын үсэг зурахаар Парист очоогүй. Жорж Вашингтон ч гэрээнд гарын үсэг зураагүй. Харин хоёр талын төлөөлөгчид өөрсдийн захирагчдын нэрийн өмнөөс гэрээнд гарын үсэг зурах эрхтэй байв.

Үүнтэй адил бид Есүс Христийг төлөөлж буйн хувьд номлодог. Паул “Учир нь бид өөрсдийгөө тунхагладаггүй, харин Христ Есүсийг Эзэн гэж, өөрсдийгөө Есүсийн төлөөх та нарын боол гэж тунхагладаг юм” (2 Коринт 4:5) гэж бичсэн. Паулын эрх мэдэл нь түүнийх байгаагүй. Тэр үйлчлэгч байсан хэдий ч, Эзэн Есүс Христийн төлөөлөгч байсан юм.

### **Бидэнд өгөгдсөн сургаалын улмаас бид эрх мэдэлтэй номлодог**

Бидний эрх мэдэл бидний номлодог Бичвэр дээр суурилдаг. Паул “Заль мэх хэрэглэлгүй, Бурханы үгийг будлиулалгүй, харин үнэний илрэлээр Бурханы өмнө өөрсдийгөө хүн бүрийн мөс чанарт нотолдог” (2 Коринт 4:2) гэж бичсэн. Паул шударга бүс эсвэл Бурханы Үг сургаалыг сулруулах аливаа зүйлийг хийхээс татгалзжээ.

Зарим пасторууд Библид итгэх хэрэггүй гэж заадаг их сургуулиудад суралцсан байдаг. Тэд эрх мэдэлтэйгээр номлохоо больж, эргэлзээгээр дүүрсэн. Яагаад? Тэд Библийн эрх мэдэлд эргэлзэж, дан ганц хүний мэргэн ухаанд тулгуурладаг. Бурханы үйлчлэгчид бидний эрх мэдэл Бурханы Үгэнд суурилсан байх ёстой.

Хэрэв та Үг сургаалд итгэдэггүй бол Бурханы Үгийг номлох ямар ч шалтгаан байхгүй. Бид Бурханы Үг сургаалд итгэсэн цагт л үүнийг эрх мэдэлтэйгээр номлож чадна.

Бидний эрх мэдэл Есүсээс болон бидний номлодог сургаалаас эхтэй гэдгийг ойлгох нь пасторуудыг хоёр аюулаас зайлсхийхэд тусалдаг.

**(1) Эхний аюул нь ихэрхэл** бөгөөд “Би бол пастор. Би Босс! Хэн ч надаас асууж чадахгүй” гэж хэлдэг.

Энэхүү ихэрхэл хүмүүсийг сайнмэдээнээс холдуулдаг. Паул “Бид өөрсдийгөө тунхагладаггүй, харин Христ Есүсийг Эзэн гэж...” (2 Коринт 4:5) хэмээжээ. Бидний эрх мэдэл Есүсээс болон Бурханы Үгээс эхтэй.

Буруугаа хүлээн зөвшөөрөх даруу байдал бидэнд байх учиртай. Нэгэн пастор “Би алдаа гаргасан бол үүнийгээ чуулганд хэлдэггүй. Тэд миний эрх мэдэлд итгэл алдрах болно” гэж хэлсэн байна. Энэ пастор бидний эрх мэдэл алдаа дутагдал дээр маань суурилдаггүй гэдгийг мартжээ. Бидний эрх мэдэл Бурханы Үгэнд суурилдаг. Бид чуулганыг Бурханы Үгийн эцсийн эрх мэдэл рүү чиглүүлэх ёстой. Миний үгс чухал биш, харин Бурханы Үг туйлын чухал билээ.

**(2) Удаах аюул нь хуурамч даруу байдал** бөгөөд “Би зүгээр л пастор хүн. Надад эрх мэдэл байхгүй. Мэргэжлийн зөвлөгч нар сэтгэл судлалын талаар ихийг мэддэг, шинжлэх ухааны эрдэмтэд дэлхийн гарал үүслийн талаар ихийг мэддэг, нийгэм судлаачид хүний бэлгийн дүр хүслийн талаар ихийг мэддэг. Харин би мэргэжлийн хүн биш учраас сэтгэл зүйн хэрэгцээ, бүтээл болон ёс суртахууны талаар ярьж чадахгүй” гэж хэлдэг.

Паул “Бид үйлчлэгчид хэдий ч, Есүс Христийг төлөөлж буйн хувьд эрх мэдэлтэй” гэж хэлсэн. Үйлчлэгчийн хувьд бид даруу амьдрах ёстой. Гэхдээ Есүс Христийн төлөөлөгчийн хувьд бид итгэл төгс номлох ёстой. Бид Бурханы Үгийг үнэн зөв номлосноор орчлон ертөнцийн Хааны эрх мэдлээр үйлчилдэг.

### **Есүсийн сургаалууд тусламж хэрэгтэй хүмүүст сайнмэдээг авчирсан**

Есүс сонсогчдынхоо хэрэгцээнд яриагаа хандуулдаг байсан. Хаанчлалын сайнмэдээг тунхаглан, Галилаар аялан явахдаа Тэр олон түмэн хаягдаж, туйлдаж цөхөрсөн байгааг хараад тэднийг өрөвдсөн (Матай 9:35-36). Иудейчүүд Ромын боолчлолд байв. Ядуу хүмүүсийн хувьд ядуурлаас гарах найдвар бараг үгүй байлаа. Уяман өвчтэй хүмүүс нийгмээс гадуурхагдаж, татвар хураагчид нийгэмдээ гологдов. Эдгээр хүн бүрд Есүс найдварыг авчирсан.

Та хүмүүсийн хэрэгцээнд яриагаа хандуулахдаа тэдний анхаарлыг татдаг. Хэрэв таныг говьд амьдарч байхад “Өнөөдөр амийн усны талаар номлох болно” гэж хэлвэл та анхааралтай сонсоно! Хэрэв би настай, бие муутай хүн байгаад “Өнөөдөр бүргэд мэт хүч өгдөг Бурханы тухай номлох болно” гэхийг сонсвол би сонсох болно!

*Сайнмэдээ* гэдэг нь “сайн мэдээ” гэсэн утгатайг Есүс үргэлж санаж байсан. Тэр итгэл найдвар хэрэгтэй хүмүүст сайн мэдээг хүргэхээр ирсэн. Үр нөлөөтэй номлол нь биднийг сонсогч хүмүүст итгэл найдварыг авчрах ёстой. Есүсийн адил бид “Би хэнд номлож байна вэ? Тэдний хэрэгцээ юу вэ?” гэж асуух учиртай.

Хэн нэгэн автомашины осолд орж, цус алдаж үхэх аюулд байна гээд төсөөлье. Эмнэлэг дээр эмч түүнд автомашины ослын талаарх тоо баримт, статистик танилцууллаа. Дараа нь чагнуур үүсэж бий болсон түүхэн хөгжлийг тайлбарлав. Эцэст нь анхаарал

болгоомжгүй жолоо барих ямар аюултайг түүнд анхааруулсан гэвэл яаж сонсогдож байна.

Эмчийн хэлсэн бүхэн үнэн боловч тухайн хүний хэрэгцээг хангаж чадахгүй байна. Шархыг боож, өвчин намдаах эм өгөх хүн хэрэгтэй. Номлол өнөөгийн баримтуудаас илүү их зүйлийг хийх ёстой. Номлол маань сонсогчдынхоо хэрэгцээнд хандсан байх учиртай.

Бидний унасан ертөнц дэх муу мэдээг харж сонсох амархан байдаг. Харин сайнмэдээ илүү ихийг гүйцэтгэдэг. Энэ нь эвдэрсэн ертөнцөд итгэл найдварыг авчирдаг. Есүс сонсогчдод үргэлж найдварыг төрүүлдэг байв. Есүс хэзээ ч үнэнийг хэлэлгүй өнгөрч байгаагүйтэй адил бид хэзээ ч үнэнээс зугтаах ёсгүй юм. Зөвөөр номлогдсон үнэн итгэл найдвар авчирдаг гэдгийг Есүс мэдэж байсан. Нэгэн настай номлогч “Хүмүүсийн загатнасан газрыг маажих хэрэгтэй” гэж хэлсэн. Та хүрэхийг зорьж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээнд яриагаа хандуулах хэрэгтэй.

### **Есүсийн сургаал зэмлэж, ятгадаг**

Есүс сонсогчдынхоо хэрэгцээнд яриагаа хандуулж эхэлдэг ч, Түүний зорилго нь тэдний шарханд түр зуур боолт хийхээс ч илүү гүн гүнзгий байв. Есүсийн номлол тэдний мөс чанарыг зэмлэн ятгаж, улмаар амьдралыг нь өөрчилдөг.

Есүс сонсогчидтой нүүр тулж, тэдний нүглийн шүүлтийн талаар номлохоос айж байгаагүй. Есүс завхайрч байхдаа баригдсан эмэгтэйд “Би ч чамайг шийтгэхгүй” гэж хэлсэн боловч “Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд” (Иохан 8:11) хэмээжээ.

Иохан Бетзада цөөрөм дэх өвчтэй хүнийг эдгээсэн Есүсийн үйлчлэлийн талаар өгүүлсэн байдаг. Есүс тэр хүнийг эдгээгээд “Харагтун, чи эрүүл болжээ. Чамд илүү муу юм тохиолдохгүйн тулд дахиж нүгэл бүү үйлд гэв” (Иохан 5:14). Есүс нүглийн асуудалтай нүүр тулахаас айж байгаагүй.

Есүсийг номлох үед сонсогчид зэмлэл ятгалгыг хүлээн авдаг байсан. Орчин үеийн олон номлогчидтой адилгүй, Есүс зөв шударга амьдрах зайлшгүй шаардлагатайг номлосон. Есүс “Миний Эцэг та нараас тушаалуудыг нь сахихыг хүсэж хүлээдэггүй” гэж хаана ч хэлж байгаагүй юм. Харин Тэрээр “Та нарын зөвт байдал фарисайчууд болон хуулийн багш нарынхаас илүү гарахгүй л бол та нар тэнгэрийн хаанчлалд яавч орохгүй” (Матай 5:20) гэж хэлжээ. Есүсийн номлол нь Түүнийг сонсогчдыг зэмлэж, ятгадаг байв.

### **Есүсийн сургаал амьдралыг өөрчилдөг**

Америкийн иргэний дайны үеэр ерөнхийлөгч Абрахам Линкольн Др. Финеас Гурлигийн пасторлаж байсан чуулганд хамрагддаг байжээ. Нэг цуглааны дараа найз нь “Номлолын талаар чи юу гэж бодож байна?” гэж асуухад Линкольн “Сайн бодол санааг өгсөн, сайн толилуулга байлаа” гэж хариулжээ.

“Библи зөвхөн мэдлэгийг маань нэмэгдүүлэхийн тулд бус, харин бидний амьдралыг өөрчлөхийн тулд өгөгджээ.”

- Д. Л. Мүүди



Тэгэхэд найз нь “Чамд тэгээд таалагдав уу?” гэхэд Линкольн “Үгүй. Энэ орой пастор Гурли бүтэлгүйтсэн гэж би бодож байна” гэжээ. Найз нь гайхаад “Яагаад ингэж хэлэв?” гэхэд Линкольн “Тэр биднээс ямар нэгэн агуу зүйл хийхийг асуусангүй” гэж хариулсан байдаг. Ерөнхийлөгч Линкольн номлол нь хариу үйлдэлд уриалдаг гэж үздэг байжээ. Номлол амьдралыг өөрчилдөг гэдэгт тэр итгэдэг байв.

► Матай 18-р бүлгийг унших.

Есүс амьдралуудыг өөрчлөхийн тулд номлосон. Түүний номлол амьдралд ойр байв. Матай 18-р бүлэгт Есүсийн “Тэнгэрийн хаанчлал дахь харилцаанууд”-ын талаар заасан номлолыг тэмдэглэсэн. Есүс дараах зүйлсийг заажээ. Үүнд:

- Даруу байдлын ач холбогдол (18:2-6)
- Сорилтод хариу үйлдэх талаар (18:7-9)
- Алдагдсан хүмүүст хэрхэн хандах талаар (18:10-14)
- Таны эсрэг нүгэл үйлдсэн хүмүүст хэрхэн хандах талаар (18:15-20)
- Уучлах хэрэгцээ шаардлага (18:21-35)

Эдгээр нь өдөр тутам амьдралд тохиолддог практик асуудлууд юм. Есүс сонсогчдынхоо жинхэнэ хэрэгцээнд хандан ярьдаг байсан. Тэр амьдралуудыг өөрчлөхийн тулд номлосон.

Есүс төрөлхийн сохор хүнийг эдгээсний дараа түүний амьдралыг мөнхөд өөрчлөх сургаалыг түүнд өгчээ.

Иудейчүүд тэр хүнийг хөөн гаргасныг Есүс сонсоод, түүнийг олж—Чи Хүний Хүүд итгэж байна уу? гэхэд тэр—Эзэн минь, Тэр хэн бэ? Би Түүнд итгэе гэв. Есүс—Чи Түүнийг харсан. Одоо чамтай ярьж байгаа нь Тэр мөн гэлээ. Тэр—Эзэн, би итгэж байна гээд Түүнд мөргөв (Иохан 9:35-38).

Есүс өлссөн хүмүүст талх өгсний дараа тэдний амьдралыг мөнхөд өөрчлөх үнэнийг номлосон. “Амийн талх бол Би байгаа юм. Над уруу ирдэг нь өлсөхгүй, Надад итгэдэг нь хэзээ ч цангахгүй” (Иохан 6:35).

Амьдралыг өөрчилдөг номлолд Бурханы Үгийн үнэн болон хүмүүсийн хэрэгцээ шаардлага хамт байдаг. Үр нөлөөтэй номлол нь хүмүүсийн хэрэгцээнд хандан Бурханы үнэнийг ярьдаг.

Есүс номлохдоо сонсогчдынхоо оюун санаа, сэтгэл хөдлөл, хүсэлд хандан ярьдаг байв. Жинхэнэ өөрчлөлтөд энэ гурав хамаатай ажээ.

### **Есүс оюун санаанд нь ярьсан**

Та Матай 18-р бүлгээс харилцааны талаар урьд өмнө хэзээ ч хэлэгдэж байгаагүй Есүсийн заасан хамгийн мэргэн сургаалыг уншдаг. Хүмүүс нь бие биетэйгээ даруу байдлаар харилцдаг тийм нийгмийг төсөөлөөд үз дээ. Уучилж өршөөх нь ердийн хэм

хэмжээ байдаг тийм нийгмийг төсөөлье. Есүс сонсогчдынхоо оюун санаанд хандан мэргэн ухааныг хэлсэн.

### **Есүс сэтгэл хөдлөлд нь ярьсан**

Сайнмэдээний номуудад Есүсийг сонсохдоо хүмүүс гайхширсан, бахдан биширсэн, шагшин гайхсан тухай 34 удаа өгүүлсэн байдаг. Еммау тосгон хүрэх замд дагалдагч нар “Замд Тэр бидэнтэй ярилцаж, Бичвэрийг бидэнд тайлбарлаж байхад нь зүрх маань [бидний дотор] шатаж байсан бус уу?” (Лук 24:32) хэмээн ярьжээ. Есүсийг сонссон хүмүүс Түүний нигүүлслийн үгсэд баярлан догдолж, өөрсдийн нүгэлдээ харамсдаг байсан бөгөөд хамгийн гол нь ирээдүйд итгэх найдварыг мэдэрч байлаа.

### **Есүс хүсэлд нь ярьсан**

Есүс зөвхөн сонсогчидтой болсондоо сэтгэл хангалуун байсангүй. Харин Тэр дагалдагчдыг дуудсан юм. Есүс дан ганц гадаад өөрчлөлтөд сэтгэл хангалуун байгаагүй, харин Тэр зүрх сэтгэл, амьдралуудыг хувьсган өөрчлөхийн төлөө дуудлагыг өгсөн. Өмнө нь нүгэл үйлдсэн самари эмэгтэй эсвэл Хуулийг ягштал дагаж мөрддөг баян залуу байсан эсэхээс үл хамааран, Есүс сонсогчдоо Бурханы хүсэлд буулт хийн захирагдахыг уриалан дууддаг байв. Бид Есүстэй адил номлох үедээ сонсогчдыг амьдралын шинэ замналд уриалан дуудах болно.

### **Сайтар ажиглах нь: Та сайнмэдээг номлож байна уу?**

Нэг пастор Ром 1-р бүлгээс ижил хүйстнүүдийн нүглийн эсрэг номложээ. Тэр үнэнийг номлосон. Гэвч ямар нэг зүйл дутуу байна. Тэр цуглаанд ижил хүйстэнд татагддаг энэ асуудалтайгаа тэмцэлдэж буй нэгэн залуу сууж байв. Энэ залуу ижил хүйстэн байх нь нүгэл гэдгийг мэдэж, чөлөөлөгдөхийн төлөө залбирч эхэлсэн. Тэр залуугийн хувьд өөрийн нүглийн талаарх үнэнийг мэдсэн. Харин одоо тэр Бурхан уруу татлагыг давах ялалтыг өгч чадна гэсэн сайн мэдээг (сайнмэдээ) сонсох хэрэгтэй юм.

Нэгэн пастор Есүсийн гэр бүл салалтын эсрэг сэрэмжлүүлгээс эш татжээ. Тэрээр гэр бүл салалтыг хөнгөн авч үздэг хуулиудад харамсаж байна. Тэр үнэнийг номлосон. Гэвч ямар нэг зүйл дутуу байна. Тухайн цуглаанд залуу хос хамрагдсан бөгөөд тэд бага насны хоёр хүүхэдтэй гэр бүлийн зөрчлөө шийдвэрлэж чадаагүйн улмаас гэр бүлээ цуцлуулахаар хуульчид хандсан байж. Тэдний хувьд гэр бүл салалт нь нүгэл гэдгийг мэдсэн. Харин одоо тэд эвдэрсэн гэр бүлийг Есүс эдгээж чадна гэсэн сайн мэдээг (сайнмэдээ) сонсох хэрэгтэй юм.

Пастор индрээс “Үр хөндөлт гэмгүй хүүхдүүдийг хөнөөж буй аллага” гэж хашхирчээ. Тэр үнэнийг номлосон. Гэвч ямар нэг зүйл дутуу байна. Тэр цуглаанд дунд эргэм насны нэгэн эмэгтэй өсвөр насны охин байхдаа үр хөндөлт хийлгэхээр эмнэлэгт очсон өдрөө санан үйлжээ. Хорин жил өнгөрсөн ч Бурхан түүнийг уучилсан эсэхэд эргэлзсээр байлаа. Үр хөндөлт нь нүгэл гэдгийг тэр мэддэг байсан. Харин одоо тэр өнгөрсөн амьдралыг нь уучилдаг Бурханы сайн мэдээг (сайнмэдээ) сонсох хэрэгтэй юм.

Есүс үнэнийг хэлэлгүй өнгөрч байгаагүй, гэхдээ Тэр итгэл найдварыг авчрахаа хэзээ ч мартаж байсангүй. Есүс сайнмэдээ амьдралуудыг өөрчилдөг гэдгийг мэдэж байсан. Ижил хүйстний асуудалтай залууд хандан Есүс “Уруу татлагыг ялан дийлэхэд Миний нигүүлсэл чамд хангалттай”, гэрлэлтийн харилцаа нь эвдэрсэн хосод хандан Тэр “Би хайргүй мэт санагдсан ханийнх нь зүрх сэтгэлийг хайраар сэргээж чадна”, төрөөгүй хүүхдийнхээ эсрэг нүгэл үйлдсэн эмэгтэйд Есүс “Би бусад бүх нүглийг уучилдаг шигээ үр хөндөлтийн нүглийг ч уучлах болно. Яв, дахиж бүү нүгэл үйлд” хэмээн хэлэх байсан болов уу.

Сайнмэдээ нь нүглийн шүүлттэй холбоотой сургаалыг ч агуулдаг. Бид шүүлтийн талаар эрх мэдэлтэйгээр номлох ёстой. Гэхдээ бид Есүс шиг номлохдоо амьдралыг өөрчлөх нигүүлслийн хүчийг мартаж болохгүй. Бид эвдэрсэн ертөнцөд Бурханы нигүүлслийн сайн мэдээг хүргэх учиртай.

Сайнмэдээ нь үргэлж хоёр сайн мэдээг агуулдаг. Нэгд, сайнмэдээ нь Бурхан бидний төлөө юу хийснийг бидэнд хэлдэг. Энэ нь найдваргүй ертөнцөд итгэл найдварыг авчирдаг.

Удаах нь, сайнмэдээ Ариун Сүнсний хүчээр бид хэн болж чадахыг хэлж өгдөг. Сайнмэдээ байсан газарт маань хэзээ ч биднийг үлдээхгүй. Энэ нь биднийг Бурхантай илүү гүнзгий харилцаан дотор алхахад уриалдаг.

### **Есүсийн сургаал нь энгийн бөгөөд мартахын аргагүй байсан**

Есүс үнэнийг заахдаа хүмүүсийг хэзээ ч залхааж байгаагүй. Тэр хэрхэн энгийн бөгөөд шулуухан номлохыг мэддэг байсан. Түүнийг гүн гүнзгий үнэний талаар ярихад хамгийн боловсролгүй хүн ч анхааран сонсдог байжээ.

Үр нөлөөтэй номлогчийн зорилго нь гүн гүнзгий мэдлэгээр сонсогчдыг гайхшруулах биш юм. Харин номлогч хүний зорилго нь Бурханы Үгийг энгийн бөгөөд хүчтэйгээр дамжуулах, Бурханы Үгийн үнэнийг Ариун Сүнс сонсогчдод ятгах боломжийг олгох явдал юм.

Есүс сургаалуудаа хэрхэн энгийн бөгөөд сонирхолтой болгож байсан бэ?

### **Есүс түүх ярьдаг байжээ**

Есүсийн номлолыг сонсдог байсан хүмүүс Түүний “Би та бүхэнд нэг түүх ярьж өгье” гэхийг олонтоо сонсдог байв. Түүний ярьсан түүхүүд сонсогчдыг эзэмдэж, тэдний чихийг Түүний сургаалд нээж өгдөг байжээ.

Бидний ихэнх нь номлолын гурван гол санаанаас илүү түүхийг удаан санаж тогтоодог. Сайн түүхүүд нь номлолын гол санааг санахад бидэнд тусалдаг. Гайхалтай түүх нь номлогчийн хүргэхийг зорьж буй сургаалыг нэгтгэн дүгнэдэг.

► Номлол сонсохдоо хамгийн сүүлд сонссон түүхийнхээ талаар ярилц. Энэ нь номлогчийн сургаалыг үр нөлөөтэй хүргэж чадсан уу? Та тэрхүү түүх яагаад яригдсан

зорилгыг санаж байна уу? Түүх ярихгүйгээр номлол үр нөлөөтэй, мартахын аргагүй байх байсан болов уу?

### **Есүс энгийн үг хэллэг ашигласан**

Багш аливаа ойлголтыг хэдий чинээ сайн ойлгох тусам, суралцагчдад төдий чинээ энгийнээр тайлбарлаж чаддаг. Хэрэв багш аливаа ойлголтыг заахдаа адармаатай үг хэллэг ашиглаж байвал ихэвчлэн тухайн багш өөрөө сэдвээ ойлгоогүй бөгөөд үүнийгээ нуух гэж оролдож байна гэсэн үг. Та ямар нэг зүйлийг илүү сайн ойлгох тусам түүнийг илүү энгийнээр илэрхийлэх боломжтой.

Есүс сонсогчдынхоо ойлгодог хэл рүү заах үнэнээ хэрхэн хөрвүүлэхийг мэддэг байсан. Тэр тариаланчдад үр тарих талаар, хоньчдод хонины тухай, загасчдад загасчлах талаар номлосон. Олон хүн Есүсийн сургаалыг үгүйсгэдэг байсан ч, хэн ч Түүний номлолоос залхаж байгаагүй.

Есүсийн сургаалыг загасчид, тариачид, гэрийн эзэгтэйчүүд ойлгож чаддаг байв. Гэсэн хэдий ч Түүний сургаал эрдэмтэд, шашны удирдагчид, улс төрийн албан тушаалтай хүмүүсийн асуудлыг ч хөнддөг байжээ. Есүсийн номлол нийгмийн бүх давхаргад хүрч байсан. Энгийн гэдэг нь гүехэн гэсэн үг биш. Бидний номлол сайнмэдээний гайхалтай үнэнийг энгийн бөгөөд тодорхой байдлаар илэрхийлэх ёстой.

### **Есүс давталтыг ашигласан**

Нэгэн залуу пастор чуулгандаа сэтгэл дундуур байв. Тэр “Би хоёр жилийн өмнө энэ тухай номлож байсан, тэд үүнийг аль хэдийн мэдсэн байх учиртай” гэж хэлсэн. Харин найз нь түүнд дагалдагчдыг ойлгох хүртэл Есүс нэг ижил сургаалаа олон удаа номлож байсныг сануулжээ.

Найз нь тэрхүү пастораас “Чиний номлол Есүсийнхээс илүү гэж бодож байна уу?” гэхэд “Мэдээжийн хэрэг үгүй!” гэж хариулж.

Найз нь дахин “Танай чуулганы гишүүд дагалдагчдаас илүү ухаалаг гэж бодож байна уу?” гэхэд,

“Үгүй!” гэж тэр хариулав.

Найз нь “Тэгвэл чи Есүстэй адил үнэнийг дахин давтах хэрэгтэй юм байна” гэжээ.

Есүс нэг ижил үнэнийг дахин давтан номлодог байсан. Тэр дагалдагч нартаа үхэл болон амиллынхаа талаар дахин дахин заажээ. Тэрээр хаанчлалын тухай сургаалыг олон удаа номлосон. Есүс эдгээр үнэн амин чухал гэдгийг мэдэж байсан тул сонсогчдод хүрэх хүртэл Тэрээр сургаалыг олон удаа номлодог байв.

## Есүсийн сургаал жинхэнэ байлаа

Есүсийн номлол жинхэнэ байсан. Түүний амьдрал заасан сургаалтай нь таарч байв. Есүс зүгээр л бурханлаг амьдралын тухай номлоогүй, харин Тэр бурханлаг амьдралаар амьдарсан юм. Есүсийн амьдрал болон заасан сургаал нь зөрчилддөг гэж хэн ч хэлж чадахгүй. Есүс номлосныхоо дагуу амьдарчээ.

Та машин барьж сурмаар байна гэж төсөөлье. Та жолооны хичээл заадаг хоёр багшийг олсон. Нэг багш нь машин барьж үзээгүй ч, жолооны тухай олон ном уншжээ. Харин нөгөө багш нь олон жил жолоо барьсан, осол гаргаж байгаагүй хүн байв. Та аль багшийг нь сонгох вэ?

Одоо та христитгэлийн амьдралаар амьдрахыг хүсэж байна гэж төсөөлж үзье. Та хоёр пасторыг олсон. Нэг пастор нь нүгэлт амьдралаар амьдардаг ч, сайн номлодог хүн байж. Харин нөгөө пастор нь Бурхантай ойр дотно харилцаа бүхий амьдралтай хүн байв. Та аль пасторыг сонгох вэ?

Бидний номлол жинхэнэ байх ёстой. Бид номлодог амьдралаараа амьдрах ёстой. Олон номлогчид хэсэг хугацаанд үнэнч дүр эсгэж хуурамчаар үйлдэх боломжтой гэдгийг олж мэдсэн байдаг. Өргөлийн мөнгө хулгайлдаг хэрнээ шударга үнэнч байдлыг номлодог тийм номлогчид хүмүүс хууртагдаж болох юм. Завхайрдаг хэрнээ ёс суртахуун номлодог номлогч хүмүүсийг төөрөгдүүлж магадгүй. Эхнэрээ зоддог хэрнээ хайрыг номлодог пасторт хүмүүс хууртагдаж болох юм. Гэхдээ эцсийн эцэст үнэн ил болох л болно. Хоосон зүрх сэтгэлээс сүнслэг хүчгүй үйлчлэл л бий болно. Түүнийг бидний дотор ажиллахыг зөвшөөрөх үед Бурхан биднээр дамжуулан ажилладаг.

Номлолын сэтгэл татам байдал нүгэлт амьдралыг нуухыг хэзээ ч бүү зөвшөөр. Үр нөлөөтэй номлол нь Бурханыг таньж мэддэг зүрх сэтгэлээс эхэлдэг.

## Хэрэгжүүлэлт: Пастор бол хоньчин

► Марк 6:30-34 эшлэлийг унших.

Пастор хүний хамгийн сайн дүр төрхийн нэг нь хоньчин юм. Есүс “Үй олон хүн байхыг харж тэднийг өрөвдөв. Учир нь тэд хоньчингүй хонь мэт байв.” Есүс цугласан олон хүмүүсийг харахдаа хоньчин хэрэгтэй хонин сүргийг харав.

► Марк 6-р бүлэгт өгүүлдэг 5,000 хүний дунд хэн байх байсныг төсөөлж үзээрэй. Жагсаалт гарга.

- Таны жагсаалтад хүмүүсийг залилдаг татвар хураагчид багтсан уу? Тэд тэнд байсан л байх. Эдгээр шударга бус татвар хураагчдыг буруутгах нь амархан хэдий ч Есүс аврал хэрэгтэй хонин сүргийг олж харсан.

“Есүс хэзээ ч ‘Та тэднийг үйлчлэлийнх нь хэмжээгээр мэдэх болно’ гэж хэлээгүй. Харин ‘Та тэднийг үр жимсээр нь— Эцэгийн хүсэлд дуулгавартай байдлаар нь танина’ гэжээ.”  
- Крэйг Кеенер

- Таны жагсаалтад Есүсийг барьж авахаар урхи занга бэлдэх шүүмтгий фарисайчууд багтсан уу? Тэд тэнд байж л байсан. Есүс тэднийг олны өмнө эвгүй байдалд оруулах нь амархан байсан байх. Гэвч Тэр зөв зам хэрэгтэй зөрүүд хоньдыг олж харсан.
- Таны жагсаалтад завхайрснаасаа болоод өөрийгөө буруутгах, итгэл эвдсэн нөхөр багтсан уу? Тэр тэнд байсан л байх. Есүс залруулга болон эдгэрэл хэрэгтэй унасан хоньдыг олж харсан.
- Таны жагсаалтад орон гэрээ эсэргүүцэж, сургуулиа хаяж зугтаан нэргүй олны дунд орсон өсвөр насны хүүхдүүд багтсан уу? Тэд тэнд байж л байсан. Есүс тэнэж төөрсөн хоньдыг олж харжээ. Тэднийг цааш төөрч одохоос нь өмнө зөв зам руу эргүүлэн авчрах хэрэгтэй байв.

Та номлохдоо хэнийг хардаг вэ? Та зөвхөн чуулганыхаа алдаа дутагдлыг уу эсвэл хонин сүргийнхээ гүн гүнзгий хэрэгцээг үү? Та зөвхөн удирдах зөвлөлийн ууртай гишүүний царайг харж байна уу эсвэл бусдыг шархлуулдаг шархадсан хоньдыг харж байна уу? Та зөвхөн итгэлээ хаясан нэгнийг хардаг уу эсвэл нүглээсээ болж зовж шаналж буй хоньдыг хардаг уу? Есүс тусламж хэрэгтэй хоньдыг олж харсан.

► Иохан 10:1-18 эшлэлийг унших.

Пасторуудын хувьд бид хоньчин байхаар дуудагдсан. Хоньчин хонин сүрэгтээ хэрхэн үйлчилдэг вэ? Иохан 10-р бүлэгт тэрхүү үлгэр дуурайлыг харуулжээ.

### **Хоньчин хоньдоо хөтлөн дагуулдаг**

Хоньдоо туух шилбүүргүй хоньчныг бид харж байна. Харин хоньчин хоньдоо зөв чиглэлд хөтлөн дагуулдаг. "Хонин сүрэг дууг нь сонсдог. Тэр өөрийн хоньдыг нэрээр нь дуудаж, тэднийг дагуулж гаргана. Тэрээр өөрийнхийгөө бүгдийг гаргаж, түрүүнд нь явдаг бөгөөд хоньд дууг нь таньдаг тул түүнийг дагадаг" (Иохан 10:3-4).

Бид Сайнмэдээний номуудыг уншихдаа Есүс Петр, Иохан, Томасыг шилбүүрээр цохиод аваасай гэмээр олон тохиолдлыг хардаг! Тэд дахин дахин асуудалд орсоор л байсан. Гэвч Есүс тэднийг цохихын оронд хоньчны таягаа ашиглан эдгээр сул дорой, тэмцэлдэж буй дагалдагчдыг татан авч, зөв зам дээр гаргасан.

Хоньчин хүний хувьд Бурхан танай чуулганд тавьсан хоньдыг та хөтлөн дагуулж байна уу эсвэл зөнгөөр нь явуулж байна уу? Та хоньдыг хөтлөн дагуулдаг хоньчин уу эсвэл хоньдод дуулгавартай дагахыг тушаадаг менежер үү?

### **Хоньчин хоньдоо халамжилдаг**

Та заримдаа "Би өглөө 9:00 цагаас оройн 17:00 цаг хүртэл ажилладаг ажил хиймээр байна. Амралтын өдрүүдээр амарч, 17:00 цагаас хойш утсаар ярьдаггүй ажил" гэж боддог уу? Энэ нь их таатай сонсогдож байгаа байх. Гэхдээ энэ бол хоньчин хүний амьдрал биш.

Хоньчин хоньдоо зөвхөн ажлын цагаар бус, тусламж хэрэгтэй үед нь халамжилдаг. Хоньчин хүн гэмтсэн хургандаа “Намайг маргааш өглөө 9:00 цагт ажилдаа очих хүртэл хүлээж байгаарай” гэж хэлж чадахгүй. Хоньчин хүн хургаа аврахаар шөнө дөлөөр гарч явдаг.

Үүний нэгэн адил пастор хоньдоо тусламж хэрэгтэй үед нь халамжилдаг. Сүнслэг хоньдыг халамжлах нь номлохоос илүү зүйл юм. Номлох нь үүнд багтдаг ч зөвлөгөө өгөх, айлчлах, сонсох, залбирах, заримдаа зүгээр л өвдөж буй хургатай хамт суух ч үүнд багтдаг.

Тийм ээ пасторуудаа, та өөртөө анхаарал тавих ёстой. Хэрэв та бие махбод, сэтгэл хөдлөл, сүнслэг байдлын хувьд өөрийгөө ядрааж туйлдүүлбал үр нөлөөтэй хоньчин байж чадахгүй. Есүс ганцаараа байх цагийг гаргасан, таны хувьд ч ганцаараа байхад цаг гаргах ёстой. Гэхдээ Есүс хоньдоо халамжлахын тулд өөрийн тав тухыг золиослох ёстой цаг үе байдгийг мэдэж байсан.

Үйлчлэх ба амрах энэхүү тэнцвэрийг хадгалах нь амаргүй байж болно. Ухаалаг пастор-хоньчны хувьд та Ариун Сүнсний удирдамж зааварт болон таны эргэн тойронд буй хүмүүсийн ухаалаг зөвлөгөөнд мэдрэмжтэй байх учиртай. Ариун Сүнсний “Амарч, шинэчлэгдэхийн тулд зогсож, холдох цаг боллоо” гэж хэлэх дуу хоолойг сонс. Түүнчлэн “Чамд жаахан хугацаа хэрэгтэй байна” гэж хэлэх эхнэр эсвэл хамтран ажиллагсдынхаа дуу хоолойг ч сонсоорой. Бурханы танд даатгасан хоньдыг халамжлах шинэ хүсэл тэмүүлээр шинэчлэгдсэнийхээ дараа та буцаж ирээрэй.

### **Хоньчин хоньдоо хамгаалдаг**

Есүс аюулыг хараад зугтан оддог хөлсний хүнийг амь насаа эрсдэлд оруулан байж хоньдоо хамгаалдаг сайн хоньчинтой харьцуулсан байдаг. Хөлсний хүн хоньдын төлөө санаа тавьдаггүй, харин хоньчин хүн хоньдынхоо төлөө амиа зориулдаг (Иохан 10:13, 15).

Есүс амьдралынхаа эцсийн цаг мөч хүртэл дагалдагч нартаа санаа тавьсан. Сүүлчийн оройн зоог дээр Тэрээр удахгүй нүүр тулгарах зовлон зүдгүүрт тэднийг бэлджээ. Цэцэрлэгт Тэрбээр Петр, Иаков, Иохан нарт үргэлжлүүлэн сургасан. Загалмай дээр Тэр Мариаг Иоханы асрамжид захиж үлдээсэн. Сайн Хоньчин хоньдоо эцэс хүртлээ анхаарч халамжилсан юм.

Паул Ефесийн чуулганы ахлагчдад хоньчноор үйлчлэх үүрэг даалгаврыг өгчээ. Тэд Есүсийн цусаар худалдан авсан сүрэгт санаа тавих ёстой байв. Дараагийн эшлэлд Паул сүрэг рүү довтлох догшин чононуудын талаар сэрэмжлүүлжээ. Хоньчид сүргийг хамгаалах үүрэг хүлээсэн (Үйлс 20:28-31).

Пастор-хоньчны хувьд Бурхан танай чуулганд тавьсан хоньдыг та хамгаалдаг уу? Та тэднийг онол сургаалын алдаанаас, гэр бүл, гэрлэлтийн эсрэг дайралтаас болон бусад сүнслэг халдлагаас хамгаалдаг уу? Та хоньчин уу эсвэл хөлсний хүн үү?

Ирэх Ням гарагт номлохын өмнө хоньдынхоо хэрэгцээг харуулж өгөхийг Бурханаас гуйгаарай. Танай сүргийн шархадсан зүрх сэтгэлүүдийг харуулж өгөхийг Түүнээс асуу. Номлож байхдаа бурханлаг хоньчны хайр хэрэгтэй туйлдсан, арчаагүй хоньдыг олж хараарай.

### **Сайтар ажиглах нь: “Золгүй еэ!”**

► Матай 23:1-39 эшлэлийг унших.

Есүс өөрийг нь үгүйсгэсэн хотуудад хандан (Матай 11:21), ард олныг төөрөгдүүлсэн фарисайчууд болон хуулийн багш нарт (Матай 23:13-29), өөрөөс нь урвах Иудасын талаар ярихдаа (Марк 14:21) “золгүй еэ” гэсэн хэллэгийг ашигласан байдаг. Бид заримдаа эдгээр “золгүй еэ” хэллэгийг Есүсийн хайрыг мартсан ууртай өнгө аясаар, тэр ч байтугай Түүнээс татгалзсан хүмүүсийн дуу хоолойгоор уншдаг.

*Золгүй еэ* гэдэг үг шүүлтийн тухай ч, энэ нь мөн харууслыг ч агуулдаг. “Золгүй еэ” гэсэн хэллэг нь шүүлтэд буй хүний төлөөх “харуусал болон өрөвдөх байдал”-ыг аль алиныг нь агуулдаг. Энэ нь Есүсийн “өөрсдийн нөхцөл байдлын жинхэнэ зовлон зүдгүүрийг ухаарч чадалгүй бүтэлгүйтсэн хүмүүсийн төлөөх гуниг харууслыг илэрхийлдэг.”<sup>27</sup> “Золгүй еэ” хэллэг нь гүнзгий харуусал, сэрэмжлүүлгийг ч мөн илэрхийлдэг.

Есүс хайртай хотынхоо хувь заяаны талаар уйлан байж, тэдгээр шашны удирдагчдын дээр шүүлтийг зарлан тунхагласан юм. “Иерусалим аа, Иерусалим аа, эш үзүүлэгчдийг алж, өөрт нь илгээгдэгсдийг чулуугаар нүүлгэдэг хот оо. Тахиа дэгдээхэйнүүдээ далавчин дороо бөөгнүүлдэг шиг Би хүүхдүүдийг чинь цуглуулахыг хичнээн ч удаа хүслээ дээ. Харин та нар хүсээгүй.” Өөрийг нь удахгүй цовдлох хотын хувь заяаны төлөө Есүс уйлжээ (Матай 23:37 болон Лук 19:41).

Энэ нь шүүлтийг номлох бидний загвар байх ёстой юм. Бидний номлол нүглийн эсрэг сэрэмжлүүлэг болон гэмшихээс татгалзсан хүмүүсийн дээрх шүүлтийн үг сургаалыг агуулсан байх учиртай. Гэхдээ бидний дамжуулах үгс нүгэлтэнд уурсах биш, харин нүглийнх нь талаарх харууслыг харуулах ёстой.

Нэгэн өсвөр насны тэрслүү хүү тамын тухай номлол сонсоод гэртээ иржээ. Аав нь түүнээс “Хүү минь, чи өнөөдрийн номлолын талаар юу гэж бодож байна?” гэж асуухад тэр “Надад таалагдаагүй. Намайг уурлуулсан!” гэж хариулж. Дараагийн долоо хоногт хүү өөр нэг номлогч тамын талаар номлохыг сонсжээ. Аав нь түүнээс дахин “Чи номлолыг юу гэж бодож байна?” гэхэд хүү “Би Есүст үйлчлэх ёстой. Би хэзээ ч тийм аймшигтай газар очихыг хүсэхгүй байна!” гэж хариулжээ.

---

<sup>27</sup> Martin H. Manser, *Dictionary of Bible Themes*. (London: Martin Manser, 2009). Мөн Joel B. Green and Scot McKnight, *Dictionary of Jesus and the Gospels* -ийг үзнэ үү. (Westmont, Illinois: InterVarsity Press, 1992).



Аав нь гайхаад “Өнгөрсөн долоо хоногт тамын тухай номлол чамайг уурлуулсан. Гэтэл энэ долоо хоногт тамын талаарх номлол чамайг гэмшихэд хүргэжээ. Ялгаа нь юу байсан бэ?” гэхэд хүү “Энэ номлогч надад тамын талаар сануулахдаа уйлсан” гэж хариулжээ.

Та шүүлтийн талаар номлохдоо уйлдаг уу? Та тамын тухай номлол бэлдэж байхдаа уйлдаг уу? Та шүүлтийн талаар сэрэмжлүүлэхдээ ч хоньдоо хайрладаг хоньчин байдаг уу?

### **Дүгнэлт: Номлол дахь Ариун Сүнсний үүрэг оролцоо**

Номлогчдын хувьд бид сонсогчдыг ятгахын тулд Ариун Сүнсний хүч чадалд найдах ёстой. Хэрэв бид хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөх дан ганц хүний арга барицыг ашиглавал тэр даруй үр дүнг нь харж болох ч, сүнслэг байдлын үр дүнг харахгүй байх боломжтой. Зөвхөн Ариун Сүнс л бидний сонсогчдод удаан үргэлжлэх өөрчлөлтийг авчирч чадна.

► 1 Коринт 2:1-16 эшлэлийг унших.

Сүнслэг өөрчлөлт нь зөвхөн Ариун Сүнсний хүчээр л бий болдог гэдгийг Паул ойлгожээ. Тэрээр Афинаас хөдөлж, Арейпагийн дэргэд гүн ухаантнуудтай мэтгэлцсэний дараа Коринт хотод ирсэн (Үйлс 17:16-18:1). Коринтод тэр Есүс Христийн болон Түүний цовдлогдсон талаар номлохоос өөр ямар ч мэргэн ухааны болон цэцэрхсэн үг хэллэг ашиглахгүй хэмээн шийдсэн байдаг. Тэрээр “Сүнс ба хүчний илрэлээр” (1 Коринт 2:1-5) номлосон.

Сүнс сүнслэг үнэнийг сүнслэг хүмүүст тайлбарладаг гэдгийг Паул мэдэж байлаа (1 Коринт 2:13). Паул боловсролыг чухалчилдаг, тэр агуу эрдэмтэн хүн байв. Тэр олон нийтэд хандан үр нөлөөтэй яриа хийдэг, эртний Грек мэтгэлцэх урлагт суралцсан хүн юм. Тэрээр логик аргумент хэрхэн бүтээхийг мэддэг байсан. Ром ном бол логик бүтцийг харуулдаг шилдэг бүтээл юм. Гэхдээ хамгийн чухал нь Паул Ариун Сүнсний хүчийг үнэлдэг хүн байлаа. Жинхэнэ итгэл үнэмшил нь зөвхөн Сүнсний ажлаар дамжуулан ирдэг гэдгийг тэр мэдэж байсан.

Паул Коринт захидалдаа “Хүчний давамгайлал нь биднийх биш, харин Бурханых гэдгийг харуулахын тулд бид энэхүү эрдэнэсийг шавар савнуудад тээдэг” (2 Коринт 4:7) гэж бичсэн. Сав бол эрдэнэс биш! Үйлчлэлийн удирдагчид бид бол шавраар хийгдсэн эвдэрхий савнууд билээ. Гэхдээ бидэнд үйлчилдэг хүмүүсийнхээ төлөө сайнмэдээ болох эрдэнэсийг тээж явах гайхалтай завшаан оногджээ.

Энэ нь үйлчлэлийн удирдагч нарт хандсан хүчтэй сануулга юм. Саванд байгаа эрдэнэсийн оронд саванд анхаарлаа хандуулж төвлөрөх нь амархан байдаг. Бид дамжуулж буй сургаалаасаа илүү толилуулалтдаа анхаарах боломжтой. Бид эрдэнэсээс илүү саванд анхаарлаа хандуулдаг. Хүч чадал нь бидэнд биш, харин Бурханд харьяалагддаг гэдгийг харуулахын тулд Тэр шавар савыг зориудаар ашигладаг гэдгийг Паул бидэнд сануулжээ. Бид Бурханы хүч чадлын замд хөндөлсөх учиргүй. Зөвхөн Түүнд хамаарах алдрыг бид хүртэх ёсгүй. Бид Сүнсний хүч дотор номлох учиртай.

## 5-р хичээлийн даалгаврууд

(1) Матайн Сайнмэдээ нь таван гол сургаалыг багтаасан. Сургаал бүрийг уншиж, үүнийг үр нөлөөтэй болгож буй сургаалын нэг шинж чанарыг олж мэдээд доорх хүснэгтэд бич. Энэхүү даалгаварт зөв эсвэл буруу гэсэн хариулт байхгүй. “Есүс намайг хэрхэн залруулж, урамшуулж, Түүний сургаалыг санаж, хэрэгжүүлэхэд минь тусалдаг вэ?”

(2) Дараагийн номлолоо бэлдэж байхдаа Есүсийн сургаалаас олж мэдсэн шинж чанаруудаа эргэн харна уу. Үр нөлөөтэй дамжуулахын тулд Түүний сургаалыг жишээ загвар болгон ашиглаарай. Энэхүү номлолоо ангийнхантайгаа хуваалц. “Би номлолдоо Есүсийн үлгэр дуурайлыг шингээсэн үү?” гэсэн асуултаар сургаалаа үнэлж дүгнээрэй.

Сургаал	Шинж чанарууд
Уулан дээрх сургаал (Матай 5-7-р бүлэг)	
Элч нарыг илгээсэн (Матай 10-р бүлэг)	
Хаанчлалын сургаалт зүйрлэлүүд (Матай 13-р бүлэг)	
Хаанчлал дахь амьдрал (Матай 18-р бүлэг)	
Чидун уулан дээрх яриа (Матай 24-25-р бүлэг)	

## 6-р хичээл

### Есүс ба Бурханы хаанчлал

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Сайнмэдээний номууд дахь Бурханы хаанчлалын утга учрыг ойлгох.
- (2) Бурханы хаанчлалын өнөөгийн ба ирээдүйн шинжийг таньж мэдэх.
- (3) Уулан дээрх сургаалдаа Есүсийн заасан хаанчлалын амьдралын зарчмыг дагах.
- (4) Хаанчлалын тухай Есүсийн сургаалт зүйрлэлүүдийг зөвөөр тайлбарлах.
- (5) Дагалдагч байхын тулд Есүсийн сургасан нөхцлүүдэд захирагдах.

#### Үйлчлэлийн зарчим

Бид энэ дэлхийд Бурханы хаанчлалыг төлөөлөх элчин сайдаар үйлчилдэг.

#### Танилцуулга

Бурханы хаанчлал бол Шинэ гэрээний үндсэн сэдэв юм.<sup>28</sup> *Хаанчлал* гэх энэ нэр томъёо Матай номд 54 удаа, Марк номд 14 удаа, Лук номд 39 удаа, Иохан номд 5 удаа дурдагджээ.<sup>29</sup>

Есүсийн сургаалт зүйрлэлийн бараг тал нь Бурханы хаанчлалын талаар заадаг. Тэрээр хаанчлалын тухай номлосон. Тэрбээр хаанчлалын хүчийг харуулахын тулд хүмүүсийг эдгээж, чөтгөрүүдийг зайлуулдаг байв. Есүсийг дээш өргөгдсөний дараа анхны чуулган хаанчлалын талаар үргэлжлүүлэн номложээ (Үйлс 8:12, Үйлс 28:23).

Энэхүү хичээлээр бид Есүсийн үйлчлэл дэх Бурханы хаанчлал болон өнөөгийн үйлчлэл дэх хаанчлалын нөлөөний тухай суралцана. Энэхүү курсын төгсгөлд Бурханы хаанчлалын талаарх Нигер улсад номлогдсон нэгэн сургаалыг оруулсан. Энэ дэлхий дээрх үйлчлэлд хаанчлалын тухай мэдээ хэрхэн нөлөөлж буйг уг номлолд өгүүлэх болно.

---

<sup>28</sup> Энэ хичээлд зориулсан эх сурвалжууд:

D. Matthew Allen, "The Kingdom in Matthew." (1999). <https://bible.org/article/kingdom-matthew> вебсайтаас харах боломжтой, 2021 оны 3-р сарын 22-ны байдлаар

Darrell L. Bock, *Luke: Baker Exegetical Commentary on the New Testament*. (Grand Rapids: Baker Books, 1994-1996)

J. Dwight Pentecost, *The Words and Works of Jesus Christ*. (Grand Rapids: Zondervan, 1981)

Martyn Lloyd-Jones, *Studies in the Sermon on the Mount*. (Grand Rapids: Eerdmans, 1959)

<sup>29</sup> Матай номд ихэвчлэн "тэнгэрийн хаанчлал" гэж дурдсан бол Лук номд "Бурханы хаанчлал" гэж дурджээ. Матай номын анхны уншигчид нь иудейчүүд байсан учраас Бурханы нэрийг хэлэхээс зайлсхийж, "тэнгэрийн хаанчлал" гэх нэр томъёог ашигласан байна. Тиймээс Матай номд "Бурханы хаанчлал" гэх үгийг ихэвчлэн "тэнгэрийн хаанчлал" гэж орлуулсан юм. Энэхүү хичээлээр би Матай номоос эш татсан хэсгүүдээс бусад тохиолдолд "Бурханы хаанчлал" гэх үгийг ашиглана.

## Бурханы хаанчлал

Бурханы хаанчлалын талаар суралцахад танилцуулга болдог хоёр асуулт бий.<sup>30</sup>

1. Бурханы хаанчлал гэж юу вэ?
2. Бурханы хаанчлал хэзээ байгуулагдсан бэ?

### Бурханы хаанчлал гэж юу вэ?

► Үйлс 1:1-8 эшлэлийг унших.

Есүс амилсныхаа дараа 40 хоногийн туршид дагалдагч нартайгаа хамт байж, Бурханы хаанчлалын тухай ярьсан юм. Есүсийг дээш өргөгдөхөөс өмнөхөн дагалдагчид нь “Эзэн, энэ цагт Та Израильд хаанчлалыг сэргээх үү?” гэж асуужээ. Дагалдагчдын хүлээлт нь:

1. **Даруй бий болох хаанчлал:** “энэ цагт.” Тэд Есүсийг тэр даруй хаанчлалаа байгуулна гэж бодсон.
2. **Улс төр, газар нутгийг хамарсан хаанчлал:** “сэргээх.” Тэд Есүсийг Ромын эзэнт гүрнийг нурааж, Израилын улс төрийн эрх мэдлийг сэргээнэ гэж найдсан.
3. **Үндэсний хаанчлал:** “Израильд хаанчлалыг.” Тэд Есүсийг Хуучин гэрээний Давидын угсааны хаад шиг үндэстнээ захирна гэж найдаж байсан.<sup>31</sup>

Есүс хариуд нь “Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш. Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно” гэсэн юм.

Есүсийн хариултаас Түүний хаанчлал дараах байдлаар харагдаж байна.

1. **Цаг хугацаагүй хаанчлал:** “Эцэг... тогтоосон тэр цаг, үеийг.” Есүсийн хаанчлал хүний цагаар бус, харин Эцэг Бурханы товлосон цагаас хамаарна.
2. **Ер бусын хаанчлал:** “Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг.” Есүсийн хаанчлал улс төрийн эрх мэдэлд бус, харин Ариун Сүнсний хүчинд тулгуурлана.
3. **Даян дэлхийн хаанчлал:** “дэлхийн хязгаар хүртэл.” Есүсийн хаанчлал бүх үндэстнийг хамарна. Зөвхөн Израилаар хязгаарлагдахгүй.

Есүс дагалдагч нартаа цаг хугацааны талаар мэдэх шаардлагагүй, харин үүний оронд Ариун Сүнснийг хүлээн авах, дэлхийн төгсгөл хүртэл Түүний гэрч байх гэсэн хоёр зүйлд санаа тавих ёстой гэсэн.

---

<sup>30</sup> Scot McKnight, “What and Where is the Kingdom of God?” хэмээх Бурханы хаанчлалын тухай видео хичээлийг <http://www.seedbed.com/where-is-the-kingdom-of-god/> (Accessed March 22, 2021.)-ээс үзээрэй.

<sup>31</sup> John Stott, *The Message of Acts* (Westmont, Illinois: InterVarsity Press, 1990), 41

## Бурханы хаанчлал хэзээ байгуулагдсан бэ?

Теологичдын дунд Бурханы хаанчлалын талаар гурван үндсэн үзэл бий.

“Хаанчлал ирсэн, хаанчлал ирж байна, хаанчлал хараахан ирээгүй.”  
- Мартин Лойд-Жонс

### ***Хаанчлал ирнэ.***

Зарим теологичид эцсийн цаг үед, Есүс газар дэлхий дээрх мянган жилийн засаглалаа эхлэх үед хаанчлал байгуулагдана хэмээн үздэг. Эдгээр хүмүүс хаанчлалын улс төр, газар нутгийн шинжийг онцолсон Матай 24-25-р бүлэг зэрэг эшлэлүүдийг дурддаг.

### ***Хаанчлал ирсэн.***

Бусад теологичид нь Есүсийг газар дэлхий дээр байх үед хаанчлал байгуулагдсан гэж үздэг. Тэд “Тэнгэрийн хаанчлал айсуй” мөн “Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна” (Матай 4:17 ба Лук 11:20) зэрэг эшлэл Есүсийн хэлсэн үгийг онцолдог аж. Хаанчлалын талаарх энэхүү үзэл нь хаанчлалын сүнслэг мөн чанар болон Бурхан итгэгчдийн зүрх сэтгэлд засаглах зэрэгт анхаарал хандуулдаг.

### ***Хаанчлал аль хэдийн ирсэн ч, хараахан бүрэн гүйцэд болоогүй байна.***

Хаанчлал нь одоогийн ба ирээдүйн шинж чанарыг агуулдаг гэж олон теологичид үздэг. Энэ үзлээр бол Есүсийг газар дэлхийд байх үед хаанчлал эхэлсэн бөгөөд чуулганы үйл ажиллагаагаар дамжуулан үргэлжилж, улмаар Христ бүхнийг захирахаар ирэх үед бүрэн гүйцэлдэх юм.<sup>32</sup> Христ эргэн ирээд бүх засаглал, бүх эрх мэдэл, хүчийг устгасны дараа хаанчлалыг Бурхан Эцэгт шилжүүлнэ (1 Коринт 15:24). Үүгээр Бурханы хаанчлал бүрэн гүйцэд байгуулагдах аж.

► Хаанчлалын талаарх эдгээр үзлийн алийг нь та баримталдаг вэ? Эдгээр нь тус бүрдээ үйлчлэлд ямар бодит нөлөө үзүүлэх вэ?

Энэ хичээлээр бид хаанчлалын биелсэн болон хараахан биелж гүйцээгүй шинж чанаруудыг авч үзнэ. Хаанчлал нь дараах шинж чанаруудыг агуулдаг.

- **Хаан:** Есүсийг төрөх үед мэргэд ирснээс эхлэн, загалмай дээр цовдлогдох хүртлээ Тэр хаан байсан юм.
- **Эрх мэдэл:** Есүс гайхамшиг, мөн үхлийг ялсан ялалтаараа эрх мэдлээ харуулсан.
- **Хууль:** Есүс уулан дээрх сургаалаараа хаанчлалынхаа хуулийг хураангуйлж айлдсан.
- **Нутаг дэвсгэр:** Түүний хаанчлал даян дэлхийн өнцөг буланг хүртэл үргэлжлэх бөгөөд бүх ард түмэн, бүх үндэстний хүмүүсийг хамарна хэмээн Есүс заасан.

---

<sup>32</sup> Тайлбарлагчид Есүсийн газар дэлхий дээрх үйлчлэлийн үеэр хаанчлал эхэлснийг тооцон “Хаанчлалын эхэн” гэх нэр томъёог хэрэглэдэг. Харин “Хаанчлалын төгсгөл” гэх нэр томъёогоор Христийн эргэн ирэлтээр хаанчлал гүйцэлдэхийг илэрхийлдэг.

- **Ард түмэн:** Хаан Есүсийн авралд багтаж, Түүнд захирагддаг хүмүүс Есүсийн хаанчлалын иргэд юм.

### **Хаанчлалын талаарх амлалт**

► Матай 3:1-12 эшлэлийг унших.

Шинэ гэрээнд Бурханы хаанчлалын тухай хамгийн анх баптисч Иоханы номлолд дурдагдсан байдаг. Хуучин гэрээний хамгийн сүүлийн эш үзүүлэгчийн хувьд Иохан Израилын удирдагчдын хоёр нүүрт байдлыг буруушааж байлаа. Харин Шинэ гэрээний эхний элчийн хувьд тэрээр “Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал айсуй” (Матай 3:2) хэмээн Хааны замыг бэлтгэсэн юм. Энд буй “айсуй” гэх үг хаанчлал тун ойрхон ирснийг зааж байна. Хараахан ирээгүй, гэхдээ тун ойр гэсэн үг. Иохан айсуй хаанчлалыг эхлүүлэх Мессиагийн ирэлтэд Израилыг бэлтгэсэн юм.

Удалгүй Иохан баривчлагдаж, харин Есүс үйлчлэлээ эхэлжээ. Тэрээр Галил даяар явж тэнгэрийн хаанчлалын сайнмэдээг тунхаглаж байв (Матай 4:23). Баптисч Иоханы адилаар Есүс ч “Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал айсуй” (Матай 4:17) хэмээн тунхагласан юм.

► Матай 10:5-42 эшлэлийг унших.

Есүс хаанчлалын талаарх сургаалыг Израилын гэрийн төөрсөн хоньдод номлуулахаар арван хоёр дагалдагчаа илгээв. Баптисч Иохан, Есүс хоёрын адилаар тэд ч “Тэнгэрийн хаанчлал айсуй” (Матай 10:5-7) хэмээн номлосон.

Дагалдагчдын үйлчлэл Багшийнхаа үйлчлэлтэй адил байлаа. Тэд Есүсийн нэгэн адил хаанчлалыг тунхаглаж, хүмүүсийн бодит хэрэгцээг хангах ёстой байв. Тэд Есүсийн адилаар өвчтэйг нь эдгээж, чөтгөрүүдийг хөөсөн нь Бурханы хаанчлал Сатаны ноёрхлыг нураасныг харуулах тэмдэг байсан юм. Есүс өвчтэй хүмүүсийг эдгээж, үхэгсдийг амилуулан, уяман өвчтөнүүдийг цэвэрлэж, чөтгөрүүдийг хөөхөөр төлөөний хүмүүсээ илгээсэн (Матай 10:8).

### **Хаанчлалын эхэн**

► Матай 12:22-32 эшлэлийг унших.

Хаанчлалын амлалт шинэ зүйл биш. Хуучин гэрээний эш үзүүлэгчид ирээдүйн хаанчлалыг амлаж байв. Гэхдээ Есүс тэрхүү хаанчлалыг ирээдүйн найдвар биш, харин даруй ирэх бодит байдал хэмээн тунхагласан билээ. Өөрөөр хэлбэл, Есүс тэрхүү хаанчлалын эхлэлийг тунхагласан хэрэг. Есүс хаана байна, Бурханы хаанчлал тэнд байлаа.

Есүс чөтгөрүүдээс дээгүүрх хүч чадлаараа Сатаны хаанчлалыг ялан дийлэх Хааны эрх мэдлээ харуулсан юм. Чөтгөрт эзэмдүүлсэн хүнийг чөлөөлөх үед фарисайчууд Есүсийг чөтгөрийн ханхүү Беелзебулийн хүчээр чөтгөрүүдийг зайлуулж байна гэжээ. Харин Есүс Бурханы хүчээр Сатаны хаанчлалыг эзэлж байгаа гэдгээ илэрхийлэн “Би Бурханы

Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймд Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна” (Матай 12:28) хэмээн хариулжээ. Есүс Сатаны хаанчлал руу халдан довтолсон юм.

► Матай 11:1-24 эшлэлийг унших.

Есүсийн үйлдсэн гайхамшгууд нь хаанчлалын эхэн үеийн шинж тэмдэг байв. Есүсийн гайхамшгуудыг Иохан номд *тэмдэг* гэх нэр томъёогоор илэрхийлжээ. Гайхамшгууд нь Есүсийг Бурхан гэдгийг болон шинэ хаанчлалыг илэрхийлсэн тэмдэг байсан юм.

Баптисч Иохан “Тэнгэрийн хаанчлал айсуй” гэж тунхагласан. Тэрээр Израилд авралыг авчрах улс төрийн хаанчлалыг хүлээж байв. Гэтэл Иохан шоронд орж, үхэлтэй тулгарчээ. Тиймээс дагалдагч нараа явуулж “Та ирэх ёстой Нэгэн мөн үү эсвэл бид өөр нэгнийг хүлээх үү?” (Матай 11:3) гэж асуулгасан байна. Есүсийн үйлчлэл нь газар дэлхийн хаанчлалыг байгуулах улс төрийн Мессиаг хүлээж байсан Иоханы горьдлоготой нийцэхгүй байлаа.

Харин Есүс авралын үйл хэргийнхээ талаар ийн хариулжээ:

Явж, үзсэн дуулснаа Иоханд хэл. Сохор нь хараа орж, суунги нь алхаж, уямантай нь цэвэршиж, дүлий нь сонсож, үхэгсэд нь амилж, ядууст сайнмэдээ тунхаглагдаж байна. Надаас болж үл бүдрэгч нь ерөөлтэй (Матай 11:4-6) гэв.

Есүс Мессиагийн талаарх урьдаас өгүүлсэн тэмдгүүд гүйцэлдэж байгааг Иоханд сануулсан. Хэдийгээр Есүс Иоханы хүч чадал, эр зоригийг магтсан ч, тэнгэрийн хаанчлалд хамгийн бага нь Иоханаас агуу гэж хэлжээ. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл Есүс хаанчлалын давуу эрх бүхий шинэ гэрээг байгуулахаар ирсэн юм. Шинэ гэрээний хамгийн өчүүхэн итгэгч хүртэл Хуучин гэрээний агуу хүмүүсийн хэзээ ч харж байгаагүй давуу эрхийг эзэмшсэн. Шинэ гэрээний итгэгчид Хуучин гэрээний амлалтууд биелж байгааг үзсэн юм. Амлагдсан хаанчлал тийнхүү эхэлжээ.

### **Хаанчлал дахь амьдрал: Уулан дээрх сургаал**

Сайнмэдээний номуудад буй Есүсийн хамгийн урт сургаал нь Уулан дээрх сургаал юм. Энэхүү номлолын сэдэв бүхэлдээ Бурханы хаанчлал байв. Үүнийг хэд хэдэн эшлэлээс харж болно.

- Хамгийн эхний “ерөөлтэй еэ” нь Тэнгэрийн хаанчлал бол сүнсэндээ ядуу хүмүүсийнх юм (Матай 5:3). Хамгийн сүүлчийн “ерөөлтэй еэ” нь Тэнгэрийн хаанчлал бол зөвт байдлын төлөө хавчигдах (Матай 5:10) хэмээн өгүүлсэн. Энэ хоёр санаа бусад “ерөөлтэй еэ” сэдвүүдийг зангидаж, энэ сургаалын гол сэдэв нь тэнгэрийн хаанчлал юм гэдгийг харуулдаг.
- Есүс хуулийг тайлбарлах эрх мэдлээ илэрхийлсэн (Матай 5:21-48). Энэ бол хаанчлалын хуулийг тайлбарлаж, батлах Хааны эрх мэдлийг харуулсан үйлдэл юм.

- Есүс дагалдагч нартаа “Таны хаанчлал иртүгэй. Таны таалал тэнгэрт шигээ газарт бас биелтүгэй” (Матай 6:9-13) хэмээн залбирахыг заасан. Бид Бурханы хаанчлалыг дэлхий дээр улам дэлгэрүүлэхийн төлөө залбирахаар дуудагдсан юм. Бурханы хүмүүс Уулан дээрх сургаалын дагуу амьдрах үед хаанчлал тэлж, Бурханы эрх мэдэл хаанчлалын шинэ иргэдэд хүрдэг.
- Номлолын төгсгөлд Есүс тэнгэрийн хаанчлалд ороход хүчит үйл дангаараа хангалтгүй, харин Эцэг Бурханы хүслийг биелүүлдэг хүмүүс л тийш орно (Матай 7:21) хэмээн заасан.

## **Уулан дээрх сургаалыг унших зарчим**

Бид Уулан дээрх сургаалыг уншихдаа гурван зарчмыг санах ёстой.

### **(1) Уулан дээрх сургаалын тушаалуудыг дагалаа гээд тэнгэрийн хаанчлалын иргэн болно гэсэн үг биш.**

Бид “Ингэж амьдарвал Христэд итгэгч болно” гэж бодох ёсгүй. Харин “Христэд итгэгч учраас ингэж амьдрах учиртай” хэмээн хаанчлалын иргэний амьдралын удирдамж болгож, энэ сургаалыг унших ёстой. Бид зөвхөн нигүүлслээр аврагдсан. Бурханы хаанчлалын иргэн болсны хувьд бид Түүний тушаалуудыг дагах ёстой.

### **(2) Уулан дээрх сургаал нь үл итгэгчдэд бус, дагалдагчдад зориулагдсан.**

Энэ бол Бурхангүй улс нийгмийн үндсэн хууль биш. Таны үл итгэгч хөршүүд эдгээр зарчмаар амьдрахаас татгалзаж байгаад та гайхах хэрэггүй. Учир нь энэ сургаал хүний хаанчлал дахь амьдралыг биш, харин Бурханы хаанчлал дахь амьдралыг тодорхойлдог.

### **(3) Уулан дээрх сургаал итгэгч хүн бүрд зориулагдсан.**

Олон хүн Уулан дээрх сургаалын шаардлагуудаас зайлсхийхийг оролдож, үүнийг жирийн итгэгчдэд хамаагүй гэж хэлдэг. Зарим нь “Энэ хууль ирээдүйн мянган жилийн хаанчлалынханд зориулагдсан” гэдэг. Өөр зарим нь “Энэ бол цөөн хэдэн гэгээнтнүүдэд зориулагдсан, ихэнх итгэгчид энэ тушаалуудыг дагаж чадахгүй” гэж хэлдэг. Харин зарим нь “Энэхүү сургаал нь Бурханы тушаалыг бид хэзээ ч гүйцэлдүүлж чадахгүй гэдгийг харуулж байна. Бид Бурханы шаардлагуудыг хэзээ ч биелүүлж чадахгүй гэдгээ ойлгож байгаа учир зөвхөн нигүүлсэлд найдахаас өөр аргагүй” гэх нь ч бий.

Гэхдээ анхны чуулганыхан Уулан дээрх сургаалыг итгэгч бүрийн удирдамж болгож байлаа. Иаков ба 1 Петр захидлуудад энэхүү сургаалын олон тушаалыг давтан өгүүлсэн байна. Есүс ч Бурханы ариун чанарын хэм хэмжээг бууруулахыг хүссэнгүй. Харин фарисайчуудын доогуур жишгийн оронд илүү өндөр жишгийг дагалдагч нар нь баримтлаасай хэмээн хүсэж “та нарын зөвт байдал фарисайчууд болон хуулийн багш нарынхаас илүү гарахгүй л бол та нар тэнгэрийн хаанчлалд яавч орохгүй” (Матай 5:20) гэжээ.



## **Бурханы хаанчлал дахь амьдрал**

► Матай 5-7-р бүлгийг унших.

Хэрэв Есүс газар дээрх үйлчлэлийнхээ үеэр Бурханы хаанчлалыг эхлүүлсэн бол, бид одоо Бурханы хаанчлалд амьдарч байгаа гэсэн үг. Уулан дээрх сургаалд тэнгэрийн хаанчлалын иргэний зан чанарыг дүрсэлсэн. Одоо уг сургаалын сэдвүүдийн тоймыг энд товчлон оруулъя.

### **(1) Бурханы хаанчлалын үнэт зүйлс нь энэ дэлхийн үнэт зүйлстэй зөрчилддөг.**

Энэ дэлхийн ямар ч удирдагч ядуу байх, гашуудах, эрхээсээ татгалзахыг ерөөлтэй зүйл гэж үзэхгүй. Ерөөлтэй еэ гэгдсэн тэдгээр зүйл нь Есүсийн үеийн Ромын эзэнт гүрний болон өнөөгийн бидний дэлхий ертөнцийн үнэ цэнийн эсрэг зүйлс юм. Бурханы хаанчлал хүний хаанчлалаас өөр.

### **(2) Бурханы хаанчлалын иргэд энэ дэлхийд нөлөөлөх ёстой.**

Есүсийн үеийн эссенчүүд зөвт хүмүүс нийгмээс холдож, тусгаар байж, Бурханы хаанчлалыг байгуулах ёстой гэж үздэг байв. Харин Есүс “Үгүй ээ, та нар дэлхийд амт оруулах давс байх ёстой, тэнгэр дэх Эцэгт алдрыг авчрах гэрэл байх ёстой” гэсэн юм. Бурханы хаанчлал нь үндсэндээ сүнслэг хэдий ч, хаанчлалын иргэдийн ач тусыг манай дэлхийн улс төр, эдийн засаг, нийгэм хүртэх учиртай.

Бид Бурхангүй нийгэмд гэрэл давс болж яваа олон итгэгчийн жишээг дурдаж болно. Их Британи дахь боолын худалдааг халахын тулд Вильям Вилберфорс парламентыг удирдсан. Методист сэргэлт нь Английн нийгмийн бүх давхаргад шинэчлэл авчирсан, Вильям Кейри Энэтхэгт нялх хүүхдийг хөнөөх болон бэлэвсэн эхнэрийг шатаах сати гэх зан үйлийн эсрэг тэмцсэн. Христэд итгэгчид олон оронд бичиг үсэг сургах, эмнэлэг, асрамжийн газруудыг байгуулах, ядууст туслах зэрэг үйл ажиллагааг явуулсаар иржээ.

“Зүрхэндээ цэвэр ариун хүн Бурханыг харахаас гадна, Бурханыг нийгэмдээ харуулах бичиг үсэг нь болдог.”  
- Леон Хинсон

### **(3) Бурханы хаанчлалын иргэд Эцэгийн хайрыг харуулахын тулд Хуулийн наад захын шаардлагуудыг давуулан үйлддэг.**

Есүс хуулийг хүчингүй болгох гэж бус, харин гүйцэлдүүлэх гэж иржээ. “Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн юм” (Матай 5:17). Аливаа зүйлийг гүйцэлдүүлнэ гэдэг нь бүрэн гүйцэд болгох эсвэл дуусгах гэсэн утгатай. Есүс хуулийг хүчингүй болгох гэж бус, харин хуулийн цаадах сүнслэг утгыг илчлэх гэж ирсэн. Дараах зургаан жишээгээр хаанчлалын иргэдийн зөвт байдал нь хуулийн багш ба фарисайчуудынхаас давж гарах ёстой гэдгийг Есүс харуулсан юм.

Хууль	Хаанчлалын иргэд
Хууль хүн хөнөөхийг хориглосон.	Хаанчлалын иргэд уур хилэн хэмээх үндсэн сэдлийг авч үздэг.
Хууль завхайрлыг хориглосон.	Хаанчлалын иргэд эмэгтэй хүнийг тачаалын сэдлээр харж болохгүй.
Хууль “цуцлалтын бичиг” өгөхийг шаардсан.	Хаанчлалын иргэд салах шалтаг хайх бус, харин гэрлэлтээ хадгалах арга замыг эрэлхийлдэг.
Хууль хуурамч тангарагийг хориглодог.	Хаанчлалын иргэдийн хувьд “За эсвэл үгүй” байх нь хангалттай.
Хууль өс хонзонгийн хязгаарыг заасан. (“нүдийг нүдээр”)	Хаанчлалын иргэд өс хонзонгоор бус, хайраар үйлддэг.
Хууль хөршөө хайрлахыг шаарддаг.	Хаанчлалын иргэд дайснаа хүртэл хайрлах ёстой. <sup>33</sup> Тэд тэнгэрлэг Эцэгийн хайр, өршөөлийг тусган харуулдаг (Лук 6:36).

**(4) Хаанчлалын иргэд бусдыг баярлуулахаас илүүгээр Бурханыг баярлуулахад анхаардаг.**

Фарисайчууд хүмүүст өгөөмөр харагдахыг хүсдэг байв. Харин хаанчлалынхан нууцаар өгдөг. Хоёр нүүртнүүд сэтгэл хөдөлгөм залбирлыг нь сонсоосой гэж хүсдэг бол, хаанчлалын иргэд энгийнээр, чин сэтгэлээсээ залбирдаг. Фарисайчууд удаан мацаг барьсныхаа төлөө бусдын хүндлэлийг хүсдэг байсан бол, хаанчлалын иргэд Эцэгийн өгөх шагналын төлөө мацаг барьдаг.

**(5) Хаанчлалын иргэд эд баялагт найддаггүй, хэрэгцээндээ санаа зовнидоггүй.**

Үүний оронд тэд Эцэгийн хангамжинд найддаг.

**(6) Хаанчлалын иргэд бусдыг шүүдэггүй.**

Гэхдээ хуурамч багш нарыг муу үр жимсээр нь ялгахын тулд болгоомжтой байдаг.

**(7) Хаанчлалын иргэд итгэлтэй залбирдаг.**

Тэнгэрт байгаа Эцэг Өөрөөс нь гуйсан бүгдэд сайн зүйлсийг өгнө гэдэгт итгэдэг учраас хаанчлалын иргэд итгэлтэй залбирдаг! (Матай 7:11)

---

<sup>33</sup> Израилчуудад Хуучин гэрээ “дайснаа үзэн яд” гэж тушаагаагүй. Хуучин гэрээний талаарх буруу ойлголтуудын нэг нь энэ юм.

## **(8) Хаанчлалын иргэд хоёр л зам бий гэдгийг ойлгодог.**

Өргөн ба нарийн хаалга бий. Мөн сайн ба муу мод гэж байдаг. Мэргэн бас мунхаг барилгачин гэж бий. Хаанчлалын иргэд эдгээрийг ялгадаг.

### **Хаанчлалын зарчмаар амьдрах нь**

Бид Уулан дээрх сургаалын зарчмаар хэрхэн амьдрах вэ? Гол түлхүүр нь Матай 5:48 юм. Хаанчлалын иргэд тэнгэрлэг Эцэг шигээ байхаар дуудагдсан бөгөөд Есүсийн сургаал энгийн боловч хэцүү юм. Есүсийн сургаалаар амьдрахад зөвхөн Бурханы нигүүлсэл л биднийг хүчирхэгжүүлдэг. Бид өөрсдийн хүчээр энэ сургаалын шаардлагыг биелүүлж амьдрах боломжгүй. Зөвхөн Сүнс л хаанчлалын амьдралыг боломжтой болгодог.

“Уулан дээрх сургаал нь биднийг болзолтой хайрлах, хонжоо хайж хайрлах, жинхэнэ зөвт байх дуудлагыг үл ойшоохоос сэрэмжлүүлдэг. Харин энэ сургаал нь Бурхан шиг өршөөл, өгөөмөр сэтгэл, талархал, халуун хайрыг харуулах уриалга юм.”  
- Даррел Бок

Уулан дээрх сургаалыг номлохдоо бид энэ зарчмыг ойлгох учиртай. Хэрэв бид үүнийг зөвхөн хууль гэдэг талаас нь номлох юм бол хүмүүсийг бухимдуулж, урмыг нь хугалах болно. Бид үүнийг Бурханы нигүүлслээр хангагдсан, Хүүгийн золиосоор худалдан авагдсан, Ариун Сүнсээр хүчирхэгжсэн хаанчлалын амьдралын жишээ загвар болгон номлох үед л Уулан дээрх сургаал үнэхээр сайнмэдээ, “сайн мэдээ” болдог.

► Уулан дээрх сургаалыг уншсаны дараа дараах асуултуудын дагуу ярилцаарай.

- Номлолын аль сургаал нь танай нийгмийн итгэгчдийн хувьд хамгийн хэцүү вэ?
- Христэд удирдагчийн хувьд энэ номлолын аль сургаал нь танд хамгийн хэцүү вэ?

### **Хаанчлалын нууц: Хаанчлалын талаарх сургаалт зүйрлэлүүд**

Номлол сургаалын мэдэгдлүүдээс илүүтэй түүхүүдийг хүн санаж тогтоодог гэдгийг еврей багш нар мэддэг байжээ. Тиймээс еврей багш нар сургаалт зүйрлэлийг түгээмэл ашигладаг байв. Есүс ч Бурханы хаанчлалын гүн гүнзгий үнэнийг ярихын тулд сургаалт зүйрлэлийг ашиглажээ.

Үйлчлэлийнхээ эхэн үед Есүс сургаалт зүйрлэл ашигласнаар өрсөлдөгчидтэйгөө шууд зөрчилдөхөөс зайлсхийж, дагалдагч нартаа номлож байв. Хожим нь Есүс Йерусалим дахь шашны удирдагч нартай шууд нүүр тулсан ч, үйлчлэлийнхээ эхний жилүүдэд гол анхаарлаа дагалдагчдыг сургах ажилд хандуулсан юм.

Олон хүн сургаалт зүйрлэлийг сонсдог ч, тэд ойлгодоггүй байв. Тэд сонсовч ойлгохгүй, харавч ер ухаарахгүй байжээ (Матай 13:14). Яагаад тэр вэ? Яагаад гэвэл тэдний зүрх сэтгэл хатуурсан байлаа. Тиймээс эш үзүүлэгч Исаиа:

... энэ ард түмний зүрх нь хатуурч, чих нь дүлийрэн хатуурч, нүдээ аньжээ. Эс бөгөөс тэд нүдээрээ харж, чихээрээ сонсож, зүрхээрээ ухаарч, эргэнэ. Би тэднийг эдгээх байсан” гэсэн байдаг (Исаиа 6:9-ийг Матай 13:15-д эш татсан).

Тиймээс Есүс чих нь нээлттэй хүмүүст зориулан сургаалт зүйрлэлээр зааж байсан юм.

Матай 13-р бүлэгт хаанчлалын нууцуудын тухай цуврал сургаалт зүйрлэл бий (Матай 13:11). Эдгээр сургаалт зүйрлэл нь Бурханы хаанчлалын мөн чанарыг Есүсийн дагалдагчдад илчлэхийн зэрэгцээ, сургаалын ихэнхийг үл итгэгч удирдагчдаас нууцалсан байв.

► Цааш үргэлжлүүлэхийн өмнө Матай 13:1-52 болон Лук 19:11-27 эшлэлийг уншаарай. Сургаалт зүйрлэл бүрийг судлах явцдаа дараах хүснэгт дээр тэдгээрийг нэг юм уу, хоёр өгүүлбэрээр дүгнээрэй. Сургаалт зүйрлэл бүр дээр өнөөгийн үйлчлэлд хэрэгжүүлж болох нэг санааг олоорой. Эхний сургаалт зүйрлэлийг жишээ болгон бөглөсөн байгаа.

<b>Хаанчлалын талаарх сургаалт зүйрлэл</b>		
<b>Сургаалт зүйрлэл</b>	<b>Сэдэв</b>	<b>Өнөөгийн үйлчлэлд зориулсан сургамж</b>
<b>Тариачин</b>	“Үрийг” сонссон хүний хариу үйлдэл үр дүнг тодорхойлно.	Би номлож, зааж байхдаа үр дүнг нь Бурханд даатгах ёстой. Би ургацыг хариуцахгүй, харин үрийг итгэмжтэйгээр тарих үүрэгтэй.
<b>Үрийн сүүл</b>		
<b>Гичийн үр</b>		
<b>Хөрөнгө</b>		
<b>Нуусан эрдэнэс</b>		
<b>Үнэт сувд</b>		
<b>Загасны тор</b>		
<b>Гэрийн эзэн</b>		
<b>Арван маанэ</b>		

### **Тариачны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:3-9, 18-23; Лук 8:5-18)**

Цуврал сураалт зүйрлэлийн эхнийх нь болох энэхүү зүйрлэл нь “үрэнд” хариулах бидний хариу үйлдэл ургацын үр дүнг тодорхойлно гэдгийг заадаг. Тэнгэрийн хаанчлалд зарим нь итгэж, үр жимсээ гаргах бол зарим нь итгэхээс татгалзаж, зарим нь эхэндээ хариу үйлдэл хийх боловч унах болно.

Энэхүү сургаалт зүйрлэлийг хөрсний тухай сургаалт зүйрлэл ч гэж хэлж болно. Учир нь энд өөр өөр тариачдын тухай биш, харин өөр өөр хөрсний тухай өгүүлдэг. Жишээ бүрд үр ч, тариачин ч адилхан, харин хөрс ялгаатай байна. Биднийг хаанчлалын тухай мэдээг тунхаглах үед зарим хүн хүлээж авахдаа муу байж болно. Бид үүнд гайхах, эсвэл сэтгэлээр унах ёсгүй. Зарим сонсогч нь үржил шимтэй хөрс байх бол, зарим нь Үгийн эсрэг сэтгэлээ хатууруулна гэж Есүс хэлсэн.

Лук ном дахь Тариачны сургаалт зүйрлэлийн дүгнэлтэд “Иймд та нар сонссон зүйлээ нягтлагтун. Хэнд байна, түүнд ихээр өгөгдөнө. Хэнд байхгүй байна, түүнээс байгаа гэж санагдсан нь хүртэл авагдана гэв” (Лук 8:18) гэсэн нь энэхүү зүйрлэл үнэнийг хэрхэн сонсох тухай өгүүлснийг харуулж байна. Хүн үнэнд эерэгээр хариулах үед илүү их үнэнийг хүлээн авдаг. Есүс номлолдоо бусад сургаалт зүйрлэлүүдийг ярихаас өмнө хэрхэн үр шимтэй хөрс мэт сонсох талаар сонсогчдодоо заажээ.

### **Үрийн сүүлийн тухай сургаалт зүйрлэл (Матай 13:24-30, 36-43)**

Иудейчүүд Бурханы хаанчлалыг хорон муу хүмүүс дээр даруйхан шүүлт буулгах хаанчлал гэж бодож байв. Харин Есүс итгэгч ба үл итгэгчид энэ дэлхийд хамтдаа амьдрах тэр үеийн төлөө дагалдагчдыг бэлтгэж байсан. Энэхүү түүхэнд дэлхийг тариан талбайгаар зүйрлэжээ (Матай 13:38). Зөвхөн үеийн төгсгөл болоход л тэнгэрэлч нар үрийн сүүлийг зулгааж шатаана (Матай 13:40). Бурханы хаанчлал хүний цагаар бус, Бурханы цаг хугацааны дагуу өсөж хөгжих болно.

### **Гичийн үрийн тухай сургаалт зүйрлэл (Матай 13:31-32)**

Есүсийн газар дээрх үйлчлэлийг харсан хэн ч дэлхий даяар чуулган байгуулагдана гэж төсөөлөөгүй. Дагалдагч нар нь боловсролгүй, ядуу, дээр нь айдастай байв. Тэдэнд харизм, нийгмийн байр суурь, улс төрийн эрх мэдэл аль нь ч байсангүй. Тэд яг л өчүүхэн гичийн үр мэт байлаа. Гэвч өчүүхэн гичийн үр том мод болж ургахтай адил, Бурханы хаанчлал дэлхий даяар түгсэн юм.

Есүсийг сонсогчид Бурханы хаанчлалыг гичийн үртэй адилтгаж байгааг нь гайхаж байв. Иудей рабби нар Бурханы хаанчлалыг хүч чадал, алдар суутай ирнэ гэж найдаж байсан. Тэд нүгэлтнүүд шүүгдэхийг үзнэ, мөн Ромын эсрэг цэргийн бослого гарна хэмээн хүлээж байлаа. Иудейчүүдийн шинэ хаанчлал байгуулагдахад түлхэц болох нийгмийн өөрчлөлтийг тэд хүлээж байв. Гэтэл Есүс хаанчлалын эхлэлийг тавихдаа хэний ч нүдэнд үл анзаарагдам байдлаар дагалдагч нараа бэлтгэж байсан.

Шинэ гэрээг унших үедээ бид 1-р зууны үеийн Иудей нь өчүүхэн, ямар ч нөлөөгүй байсныг мартаж болох юм. Иудей нь Шинэ гэрээний гол сэдэвт багтдаг ч, 1-р зууны дэлхий ертөнцийн төв байгаагүй. Та улсынхаа нийслэлийн тухай бод доо. Иудей ийм нийслэл байгаагүй, харин Ром л нийслэл байсан юм. Томоохон их сургуулиуд бүхий боловсролын системийг бодож үзээрэй. Иудейд тийм зүйл байсангүй, харин Афин, Александр хотууд тийм байжээ.

Дэлхийн бусад улсуудтай харьцуулахад Иудей нь улс төрийн хувьд ч, эдийн засгийн хувьд ч чухал биш, нийгмийн талаасаа ч ач холбогдолгүй байжээ. Монгол улсынхаа хамгийн ач холбогдол багатай бүс нутгийн нэгийг бодоод үзээрэй. Иудей нь Ромын эзэнт гүрэн дэх тийм л газар байсан юм.

Гичийн үрийн тухай сургаалт зүйрлэл нь Бурханы хаанчлалыг Ромын эзэнт гүрний буланд байгаа өчүүхэн газрын, цөөн хүний жижиг бүлгээс бүх үндэстнийг хамарсан мод мэт болно гэдгийг харуулдаг.<sup>34</sup> Иудей рабби нар Бурханы хаанчлалыг иудейчүүдээр хязгаарлан төсөөлж байсан бол, Есүс Бурханы хаанчлалыг дэлхийн хязгаарт хүрнэ хэмээн номложээ.

### **Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл (Матай 13:33)**

Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл нь хаанчлалын ер бусын өсөлтийг бас харуулдаг. Есүс хөрөнгийг хаанчлал хэрхэн тархах бэлгэдэл болгожээ. Гурван хэмжүүр гурилаар 100 хүний талхыг хийж болно. Эхлэл нь өчүүхэн байвч, хаанчлал агуу хүчтэй болж өснө.

Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл нь хаанчлалын тогтвортой өсөлтийг харуулж байна. Хөрөнгө гэдэг онцгой, бөмбөг шиг тэсэрдэг зүйл биш. Харин алгуурхнаар талхыг исгэдэг зүйл. Иудей рабби нар Бурханы хаанчлал нь дэлхий дахиныг хамарсан тэмдгээр танигдаж гарч ирнэ гэж зааж байсан бол, харин Есүс Бурханы хаанчлалыг дэлхий даяар тархах хүртлээ алгуур байдлаар өснө хэмээн сургасан юм.

### **Нуусан эрдэнэс ба үнэт сувдны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:44-46)**

Эдгээр сургаалт зүйрлэл нь хаанчлалын баяр хөөрийн тухай заадаг. Аль алинд нь нэгэн хүн асар үнэтэй зүйл олоод, байгаа бүхнээ худалдаж, түүнийг авдаг талаар өгүүлсэн. Эдгээр сургаалт зүйрлэлийн гол санаа нь золиос гаргах тухай биш, харин үнэ цэнтэй зүйлийг олж авсан баяр хөөрийн тухай юм. Баярласандаа тэр хүн явж хамаг юмаа зардаг шүү дээ. Жинхэнэ дагалдагчид Христийг дагахын төлөө бүхнээ зориулахдаа баяртай байдаг.

Эдгээр сургаалт зүйрлэлээс хаанчлалын ер бусын үнэ цэн харагдаж байна. Бурханы хаанчлал нь амьдралд хандах бүхий л хандлагад нөлөөлдөг. “Нүд чинь чамайг

---

<sup>34</sup> Даниел 4:12 ба Езекиел 31:6-д шувууд үүрээ засдаг модоор олон үндэстнийг хамарсан агуу хаанчлалыг төлөөлүүлсэн байдаг.

бүдрүүлвээс ухаж хая. Хоёр нүдтэйгээ тамд хаягдсанаас өрөөсөн нүдтэйгээр Бурханы хаанчлалд орох нь чамд дээр” (Марк 9:47). Бурханы хаанчлалд орох нь дэлхийн юмсыг золиослохуйц үнэ цэнтэй.

### **Загасны торны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:47-50)**

Галил нууранд загас агнуурын завинууд том том тор чирж, хүнсэнд хэрэглэх ба хэрэглэхгүй загаснуудыг барьдаг байжээ. Тиймээс загасчид эрэг дээр гарч ирээд загасаа сайн муугаар нь ялгадаг байв.

Үрийн сүүлийн тухай сургаалт зүйрлэлтэй адил, энэхүү сургаалт зүйрлэл нь үеийн төгсгөл ирэхэд шүүлт болно гэдгийг дагалдагчдад сануулжээ. Тэд даруйхан ирэх шүүлтийг хүлээхийн оронд Бурхан товлосон цагтаа зөвт ба хорон муу хүмүүсийг шүүнэ гэдгийг мэдэж, хаанчлалыг номлох ёстой байв. Сайн мууг тусгаарлах эцсийн шүүлт бий. Гэхдээ хэзээ болох нь Бурханд хамаатай асуудал юм.

### **Гэрийн эзний тухай сургаалт зүйрлэл (Матай 13:51-52)**

Есүс дагалдагч нартаа үржил шимтэй хөрс байх ёстой тухай цуврал хэдэн сургаалт зүйрлэлийг заасан байдаг. Тэрээр энэхүү цувралаа хаанчлалыг бусадтай хуваалцах үүрэг хариуцлагын талаар зааснаар төгсгөжээ. Сайтар сургагдсан гүүш хүн мэдлэгийнхээ сан хөмрөгөөс бусдад заах ямар нэг зүйл гаргах ёстой. Бид зөвхөн өөрийнхөө төлөө юм сурдаггүй. Дагалдагчид бусад дагалдагчдыг сургах чадвартай болохын тулд суралцдаг.

### **Арван маанэгийн тухай сургаалт зүйрлэл<sup>35</sup> (Лук 19:11-27)**

► Лук 19:11-27 эшлэлийг унших.

Энэхүү сургаалт зүйрлэлийг Лук номд өгүүлсэн. Гэхдээ Есүс Чидун уулан дээр үүнтэй төстэй сургаал ярьсныг Матай номд тэмдэглэсэн байдаг. Хүмүүс Бурханы хаанчлал даруй бий болно гэж бодож байсан учраас Есүс Йерусалимын ойролцоо арван маанэгийн тухай сургаалт зүйрлэлийг өгүүлжээ (Лук 19:11).

Есүсийг Йерусалимд ойртоход хүмүүс улс төрийн Аврагчийг хүсэмжлэн, улам баярлан зоригжиж байв. Харин Есүс хаанчлалыг хүлээх зуураа итгэмжтэй байхыг сануулахын тулд энэхүү сургаалт зүйрлэлийг ярьжээ. Тэд Багшийнхаа заасан зүйлийг болгоомжлон нуух бус, харин хаанчлалын өсөлт хөгжлийн төлөө нөөц боломжоо ашиглах ёстой юм.

### **Хаанчлал бүрэн байгуулагдах нь**

► Матай 24-25-р бүлгийг унших.

Есүсийн эхний сургаалууд голчлон хаанчлалын эхлэлийн тухай байлаа. Түүний газар дээрх үйлчлэлийн төгсгөл ойртох тусам Тэрээр ирээдүйд хаанчлал бүрэн байгуулагдах

---

<sup>35</sup> Маанэ бол мөнгөний нэгж. Тухайн үеийн ажилчны гурван сарын цалинтай тэнцэх мөнгө байв.




талаар илүү ихийг өгүүлсэн. Матай 24-25-р бүлэгт Есүс Чидун уулын ойролцоо байхдаа ирээдүйд биелэгдэх хаанчлалын талаарх амлалтыг олонтоо өгүүлжээ.

### Сайтар ажиглах нь: Херодын сүм

НТӨ 19-р зуунд Агуу Херод Йерусалимын Сүмийн их засварыг эхлүүлжээ.<sup>36</sup> Энэ Сүмийг НТӨ 516 онд Зерубабел барьсан бөгөөд Соломоны барьсан анхны Сүмээс жижиг бөгөөд энгийн байв. Херод Йерусалимын Сүмийн анхны үзэсгэлэнтэй төрхийг сэргээхээр төлөвлөж, 80 гаруй жил үргэлжилсэн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Херод барилгын ажилд 10,000 чадварлаг ажилчин томилж, мөн Сүмийн зөвхөн тахилч нар орж болох хэсгүүдэд ажиллуулахаар 1,000 леви хүнийг сургажээ.

Херод дэлхийн хамгийн агуу Сүмийг барьсан хүн гэдгээр дурсагдана гэж найдаж байв. Есүсийг үйлчлэлээ хийж байх үед уг Сүмийн ажил 46 дахь жилдээ үргэлжилж байлаа (Иохан 2:20). Сүмийн ажил НТ

63 онд бүхэлдээ дууссан боловч, үүнээс хойш ердөө долоон жилийн дараа НТ 70 онд Ромын жанжин Титус Йерусалим хотыг бүслэн, улмаар тус Сүм сүйджээ.



<sup>36</sup> "Temple Comparison" Ricardo Gandelman гэрэл зураг (CC BY 2.0) болон EB Vol. IV ба Gal m.-ийн Сүмийн план зургаас авч бүтээсэн бөгөөд <https://www.flickr.com/photos/sgc-library/52345523784>, public domain (CC0)-с үз.

Херодын Сүм нь Соломоны Сүмээс хоёр дахин том, баярын үеэр Йерусалимд ирсэн мянга мянган иудейн мөргөлчид багтахаар том зайтай байжээ. Энэ Сүм Ромын эзэнт гүрний гайхамшгуудын нэг байв.

### **Хаанчлал бүрэн байгуулагдах нь (Үргэлжлэл)**

Йерусалимд байх сүүлийн долоо хоногийн үеэр дагалдагчид нь Есүст Сүмийн барилгыг үзүүлэхээр иржээ. Сүмийг барих ажил үргэлжилсээр байсан учраас магадгүй өмнө ирснээс хойш өөрчлөгдсөн зүйлийг үзэхээр ирсэн болов уу.

Харин Есүс энэ Сүмийн сүйрлийн талаарх эш үзүүллэгийн үгсээр “Та нар энэ бүгдийг харахгүй байна уу? Үнэнээр Би та нарт хэлье. Энд нэг ч чулуу нөгөө дээрээ үлдэхгүй бүгд нурах болно” хариулжээ. Дагалдагчид ч “Энэ нь хэзээ болох вэ? Таны залрал болон үеийн төгсгөлийн тэмдэг юу байх вэ? Бидэнд хэлээч” (Матай 24:2, 3) гэж асуув.

Дагалдагч нарын асуулт хоёр хэсэгтэй, Есүсийн хариулт ч хоёр хэсэгтэй байв. Хуучин гэрээний эш үзүүлэгчид ойр тохиолдох болон алс ирээдүйд тохиолдох зүйлийг эш үзүүллэгтээ оруулдаг байсны адил Есүс ч бас удахгүй болох үйл явдал болон үеийн төгсгөлд болох зарим үйл явдлыг эш үзүүлжээ.

- Дагалдагчид “Энэ нь хэзээ болох вэ?” гэж асуусан. “Энэ” явдал (Сүмийн нэг чулуу нөгөө дээрээ давхарлаж үлдэхгүй сүйрэх) нь НТ 70 онд болсон.
- Дагалдагчид “Таны залрал болон үеийн төгсгөлийн тэмдэг юу байх вэ?” гэж асуусан. Есүс ирээдүйд буцан ирэх тухайгаа “Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дунд аугаа сүр хүч, цог жавхлантайгаар залрахыг харна” гэж хэлсэн (Матай 24:30).

Хаанчлалд иудей, харь гэлтгүй бүх үндэстний хүмүүс багтана гэж Есүс илэрхийлжээ. Харь үндэстнүүд Бурханы хаанчлалд орох нь Бурханы төлөвлөгөө байсан гэдгийг “Ертөнцийн сууриас” (Матай 25:34) хэмээн илэрхийлсэн. Бурханы хаанчлал бол ард түмэндээ зориулсан Бурханы мөнхийн төлөвлөгөө юм.

Хаанчлалыг хүлээж байх зуураа бид итгэмжтэй байх ёстой гэдгийг Чидун уулнаа ярьсан хоёр сургаалт зүйрлэлээр зааж байна. Таван мунхаг бүсгүй хүлээж байсан ч, зохих ёсоор бэлтгээгүй байв. Нэг таланттай зарц бас хүлээж байсан ч, итгэмжтэйгээр зохицуулсангүй. Хаанчлалын иргэдийн хувьд бид Хаанд үйлчлэхдээ итгэмжтэй, тууштай байхаар дуудагдсан.

Эцсийн шүүлт дээр сайн мууг тусгаарлана гэж Матай 13-р бүлэгт амлажээ. Сургаалын гол санаа нь энэ шүүлт хэзээ, хэрхэн болох тухай биш, харин хаанчлалын иргэд эцсийн шүүлтэд бэлтгэлтэй байхын тулд өнөөдөр хэрхэн амьдрах тухай юм. Тэр өдөр Хаан “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар энэ ах дүүсийн минь дорд нэгэнд ийн үйлдсэн бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40) гэж хэлнэ. Бид Хааныг эргэн иртэл байнгын бэлэн байдалд амьдрах ёстой. Түүнийг буцаж иртэл бид итгэмжтэй байх ёстой.

## Хэрэгжүүлэлт: Дагалдагч байхын өртөг

► Лук 9:21-27 эшлэлийг унших.

Зөвхөн нигүүлслээр л Бурханы хаанчлалын иргэн болно. Бид сайн үйлсээрээ хаанчлалын иргэн болохгүй. Гэхдээ энэ нь дагалдагч байхад өртөг төлөхгүй гэсэн үг биш. Лук 9-р бүлэгт Есүс дагалдагч нартаа дагалдагч байхын өртөг зориулалтын тухай заасан.

Даллас Виллард “Нигүүлсэл нь хүчин чармайлтын эсрэг зүйл биш, харин олж авахын эсрэг зүйл юм”<sup>37</sup> гэж хэлсэн. Дагалдагчийн хувьд гаргаж буй хүчин чармайлт маань нигүүлслийг үгүйсгэж байгаа юм биш. Үнэн хэрэгтээ дагалдагч байх хүчийг олж авах цорын ганц арга зам нь Бурханы нигүүлсэл билээ.

Есүсийн сургаалын төлөв байдлыг ажиглаарай: **загалмай, тэгээд алдар.**

- Есүс үхэл, амиллынхаа талаар эш үзүүлсэн (Лук 9:21-22). Үүгээр Есүс биднийг хаанчлалын иргэд болгох төлөөсийг төлсөн юм.
- Дагалдагч байхын өртөг юу болох талаар Есүс дагалдагч нартаа (Лук 9:23-25) “Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр нь өдөр бүр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага” гэж хэлжээ. Есүс хаанчлалыг байгуулахын тулд загалмай дээр зовж шаналсан. Тиймд хэрэв бид хаанчлалд амьдрахыг хүсэж байгаа бол загалмайг үүрэх ёстой.
- Есүс Бурханы хаанчлалын талаар “Хэн Надаас болон Миний үгсээс ичнэ, Хүний Хүү Өөрийн болон Эцэгийн мөн ариун тэнгэрэлч нарын цог жавхлан дотор ирэхдээ түүнээс ичих болно” (Лук 9:26-27) гэж хэлсэн.

Бид загалмайг үүрэлцэхгүйгээр хаанчлалын алдрыг хуваалцаж чадахгүй. Есүс “үхэлд, загалмайн үхэлд хүртэл дуулгавартай байв. Тиймээс ч Бурхан үлэмжийн дээдээр Түүнийг өргөмжилсөн...” (Филиппой 2:8-9) билээ.

Бурханы хүүхдүүдийн хувьд бид ч үүнийг мөн дуурайх ёстой. “Христ дотор та нарыг Өөрийн **мөнх алдарт** дуудсан, бүх нигүүлслийн Бурхан Өөрөө, түр зуур **зовсны** чинь дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно” (1 Петр 5:10). Энэ бол хаанчлалын амьдралын хэв маяг юм. Христ өргөмжлөгдөхөөсөө өмнө загалмай дээр зовсон. Есүсийн дагалдагчид мөнхийн алдар сууг эдлэхээсээ өмнө загалмайг үүрэх ёстой.

Есүс үнэнч дагалдагчдыг хайж байв. Тэрээр дагалдагчдыгаа хурц оюун ухаантай байхыг шаардаагүй, харин үнэнч зүрх сэтгэлтэй байхыг шаардсан юм. Тэгвэл дагалдагч

---

<sup>37</sup> Dallas Willard, *The Great Omission: Reclaiming Jesus's Essential Teachings on Discipleship*. (New York: HarperOne, 2006)

байхын өртөг юу вэ? “Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага” (Матай 16:24).

1. **Дагалдагч хүн өөрийгөө үгүйсгэх ёстой.** Өөртөө “Үгүй” гэж хэлэх нь хүнд хэцүү зүйл юм.
2. **Дагалдагч хүн загалмайгаа үүрэх ёстой.** Есүсийн дагалдагчид загалмай гэдэг нь үхэл гэсэн утгатайг ойлгосон бөгөөд загалмай нь зовлон зүдгүүр, ичгүүрийг илэрхийлж байв. Анхны Христэд итгэгчид дагалдагч байхын тулд загалмай шаардагдана гэдгийг мэддэг байжээ. Игнатус итгэлийнхээ төлөө амиа зориулахаар Ром руу явахдаа “Би дагалдагч болж эхэлж байна” гэж хэлсэн байдаг. Дагалдагч байхад загалмай шаардлагатай.
3. **Дагалдагч хүн зан чанар, биеэ авч явах байдлаараа Есүсийг дуурайсаар байх ёстой.** Дагах гэсэн үйл үг одоо цаг дээр байна.

Дагалдагч байх нь ямар үнэ цэнтэй вэ? Есүс дагалдагч байх гурван шалтгааныг хэлсэн. Хачирхалтай нь олон хүн эдгээр шалтгаанаас болж дагалдагч байхаас зайлсхийдэг аж. Ер нь бид яагаад дагалдагч байхад өртөг төлөх ёстой вэ?

1. **Аюулгүй байдал.** Загалмайнаас зайлсхийж, амиа аврахыг оролдсон хүн мөхөх болно (Лук 9:24).
2. **Жинхэнэ баялаг.** Христтэй адил болохоос татгалзсан хүн бүхнээ алдах болно (Лук 9:25).
3. **Шагнал.** Христийг дагасан хүмүүс л хаанчлалд орох болно (Лук 9:26-27).

► Лук 14:25-33 эшлэлийг унших.

Есүс дагалдагч байх талаарх сургаалаа улам өргөжүүлжээ. Түүний зааврыг гурван хэсэгт хувааж болно.

1. Дагалдагч байхын өртөг (Лук 14:26-27)
2. Өртгийг тооцоолохгүйгээр дагах мунхаглал (Лук 14:28-32)
3. Дагалдагч байхын өртгийг сануулах нь (Лук 14:33)

Машин авахаар очих үед зарим борлуулагч эцсийн өртгийг нуух гэж оролддог. Тиймээс “Сайхан машин байгаа биз, ямар хүчирхэг гэж бодно!” гэх мэтийн юм ярина. Тэгээд тухайн хүн машиныг бүрэн шохоорхон, ихэд татагдсан хойно л уг машины үнийг хэлдэг.

Харин Есүс дагалдагч нартаа хэзээ ч хаанчлалд хүрэх хялбар замыг санал болгож байгаагүй юм. Тэрээр үнийн шошгоо эхлээд харуулж,

Хэрэв хэн нэг нь Над дээр ирж, өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үл ойшоохгүй бол тэр Миний шавь байж чадахгүй. Загалмайгаа үүрэлгүй Намайг дагагч нь Миний шавь байж чадахгүй (Лук 14:26-27) гэж хэлсэн юм.

Эдгээр эшлэлд аливаа зүйлийг үзэн ядаж байгаа бол үүнийг өөр нэг зүйлээс бага хайрлаж байгаа гэсэн утгатай болохыг хэлжээ. Есүс "Чи намайг аав, ээж, эхнэр, үр хүүхэд, ах, эгч нараасаа, бүр өөрийнхөө амьдралаас ч илүү хайрлахгүй бол миний дагалдагч байж чадахгүй!" гэжээ.

Дагалдагч байхын өртөг тэгэхээр юу вэ? Бүх зүйл! Христийн дагалдагч байх нь Мессиагийн амлалтуудын баяр хөөрийг хуваалцахаас илүү зүйл юм. Энэ нь загалмайт үүрэлцэхийг шаарддаг.

► Иоханы Сайнмэдээнд дагалдагч байх гурван нэмэлт нөхцлийг дурдсан байна. Иохан 8:31, Иохан 13:35, Иохан 15:8 эшлэлийг унших. Лук, Иохан номд заасан дагалдагч байх нөхцлийн дагуу, та үйлчлэлдээ дагалдагч бэлтгэж байна уу?

### **Дүгнэлт: Бурханы хаанчлал гэж юу вэ?**

Христ эргэн иртэл бид хаанчлалынх нь тухай сургаалын бүх нарийн ширийн зүйлсийг ойлгохгүй. Гэсэн ч Сайнмэдээний номуудад Бурханы хаанчлалын олон шинж чанарыг харуулсан байдаг.

- Бурханы хаанчлал бол сүнслэг хаанчлал юм. "Бурханы хаанчлал бол идэх болон уух явдал бус, харин Ариун Сүнс дорх зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгалан нь юм" (Ром 14:17). Шинэ итгэгчид Сатаны хүчнээс салж, Бурханы хаанчлалын нэгэн хэсэг болдог.
- Бурханы хаанчлал нь эцсийн цаг үед бодит, улс төрийн засаглал байх болно.
- Бурханы хаанчлал Иудей үндэстнээр зогсохгүй, бүх дэлхийн үндэстнүүдийг хамарна.
- Бурханы хаанчлал нь Бурханы хүч дэлхий дээр ажиллахыг хэлдэг. Хаанчлал нь бодит засаглал биш юм. Арван маанэгийн тухай сургаалт зүйрлэлд хаанчлалыг газарзүйн байрлал бус, харин захирах эрх мэдэл гэж хэлсэн (Лук 19:11-12).
- Бурханы хаанчлал ер бусын юм. Хүн хаанчлалын үрийг тарьдаг ч, ургуулж чадахгүй. Бурханы хаанчлал Бурханы хүчээр өсдөг.
- Бурханы хаанчлал ирээдүйн бүрхэг найдвар бус, харин яаралтай хариу нэхдэг өнөөгийн бодит байдал юм.
- Бурханы хаанчлал Есүсийн үйлчлэлээр эхэлсэн. Чөтгөрүүдээс дээгүүрх Түүний эрх мэдэл нь Бурханы хаанчлал Сатаны хаанчлалыг ялан дийлснийг харуулдаг.
- Бурханы хаанчлал чуулганаар дамжуулан урагшилсаар байна. Өнөө үеийн итгэгчид хэрхэн амьдрахаар дуудагдсаныг Уулан дээрх номлол харуулдаг.
- Бурханы хаанчлал Христийг сүр жавхлантайгаар хаанчлахаар ирэх үед бүрэн гүйцэлдэнэ. Сатаны хүч нурж, Бурхан үүрд засаглана.

► Энэ курсын төгсгөлд “Хаанчлалын сайнмэдээ” гэсэн номлол бий. 7-р хичээлийг эхлэхээс өмнө уншаарай.

#### **6-р хичээлийн даалгавар**

Есүсийн Уулан дээрх сургаалд тулгуурлан гурван цуврал номлол бэлтгэ. Номлолын сэдэв нь “Бурханы хаанчлал дахь амьдрал”. Бид Бурханы хаанчлалын иргэдийн хувьд хэрхэн амьдрах ёстойг зааж сургаарай. Сургаалаа сайн мэдээ болгон номлож буй эсэхээ нягтал. Бурханы хаанчлалын иргэдийн хувьд Бурханы нигүүлсэл бидэнд амьдрах хүчийг өгдөг гэдгийг харуулаарай.

## 7-р хичээл

### Есүстэй адил хайрлах нь

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Есүсийн амьдрал, үйлчлэл хайранд төвлөрч байсныг ойлгоно.
- (2) Бурханыг хайрлах хайранд Бурхантай харилцах харилцаа, Бурханы Үгийн мэдлэг, Бурханы хүсэлд итгэж найдах зэрэг нь багтдагийг ойлгоно.
- (3) Үйлчлэхдээ хүмүүсийн төлөө байдаг Есүсийн хайрыг дуурайна.
- (4) Бурханд байнга буулт хийхийн чухлыг ойлгоно.
- (5) Өдөр бүрийн амьдралдаа Есүсийн зан чанарыг харуулах.

#### Үйлчлэлийн зарчим

Христийн адил хайрлах нь Христийн адил үйлчлэх өдөөлт болдог.

#### Танилцуулга

Есүсийн бүхий л амьдрал, үйлчлэл хайраар хөтлөгдсөн байлаа. Бурханыг болон бусдыг хайрлах нь Түүний амьдрал, үйлчлэлийн гол зүйл гэдгийг Тэрээр олонтоо харуулсан юм. Хэрэв бид Есүсийн үлгэр дуурайлыг дагавал бидний амьдрал, үйлчлэлийн төвд хайр байна. Үүнийг сайн самари хүний тухай сургаалт зүйрлэл хамгийн тодорхой харуулдаг.

► Лук 10:25-37 эшлэлийг унших.

Есүс энэ сургаалт зүйрлэлийг ярихын өмнө “Бурхан эдгээрийг ухаантан мэргэдээс нууцалж, балчир хүүхдүүдэд илчилжээ” (Лук 10:21) хэмээн сүнслэг ойлголтын талаарх чухал хичээлийг заасан. Сүнслэг үнэнийг ойлгоход оюуны сургалтаас илүү их зүйл шаардагддаг. Үүнд сүнслэг илчлэлт шаардлагатай. Бурханы Сүнсний тусламжтайгаар ойлгох хүүхдийн хувьд Бурханы үнэн их энгийн хэдий ч, дан ганц оюуны чадвараар ойлгох эрдэмтэн мэргэдийн хувьд энэ нь маш гүн гүнзгий ойлголт юм.

Яаж ийм зүйл байж болох вэ? Бурхан үнэнийг үүнийг хүсэмжилж буй хүмүүсээс нуудаг гэж үү? Хариулт нь хоёр зарчмыг агуулдаг.

- 1. Сүнслэг үнэн зөвхөн Ариун Сүнсээр илчлэгддэг.** Паул “Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч эс мэднэ” гэсэн байдаг. Иймээс бид “Сүнсний сургасан үгээр, сүнслэг зүйлсийг сүнслэг хүнд тайлбарладаг юм” (1 Коринт 2:11, 13).

## **2. Сүнслэг үнэн нь зөвхөн хүлээн авахад нээлттэй сонсогчдод л илчлэгддэг.**

Паул цааш нь “төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Ийм хүнд эдгээр нь мунхаглал бөгөөд сүнслэгээр цэгнэгдэх учиртай эл зүйлсийг тэр мэдэж чаддаггүй” (1 Коринт 2:14) гэсэн байна.

Сонсогчийн хандлага нь үрийн үржил шимийг тодорхойлдог гэдгийг Тариачны сургаалт зүйрлэлд харуулдаг (Матай 13:1-23). Үнэнийг хүлээн авахад нээлттэй хүмүүс л сонссон үнэнээ ойлгоно.<sup>38</sup>

Лук 10:25-д гарч буй хуульч бол хоёр дахь зарчмын бодит амьдрал дээрх жишээ юм. Хуульч үнэнээр цангасандаа асуусан бус, харин Есүсийг урхинд оруулах хүсэлтэй учраас тэгж асуужээ. Тэр Есүсийг сорьж шалгахыг хүссэн. Есүсийн хариултыг сонсоод хуулчийн хэлж байгаа хариу нь үржил шимтэй хөрс биш гэдгийг харуулж байна. Тэр хүн өөрийгөө зөвтгөх өөр асуулт асуусан юм (Лук 10:29).

Есүс түүний “мөнх амийг өвлөн авахын тул би яах ёстой вэ?” гэсэн асуултын хариуд “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла” (Лук 10:27) хэмээн Хуульд бичигдсэн гэж хариулжээ.

Энэ бол бидний үлгэр дуурайл болох Есүсийн зүрх сэтгэл юм. Есүстэй адил амьдарч, үйлчлэхийн тулд бид Бурханыг болон хөршөө Есүсийн адилаар хайрлах ёстой. Христийн адил хайрлахгүй бол энэ курсын бусад аль ч хичээлүүд нь ач холбогдолгүй байх болно. Хайрлахгүй л бол залбирал, удирдлага, зааж сургах, номлол зэрэг нь бүгд ач холбогдолгүй байх болно.

Магадгүй энэ нь хэтэрхий энгийн санагдаж болох юм. Та “Мэдээж бид Бурханыг хайрлаж, хүмүүсийг хайрлах ёстой. Би үүнийг аль хэдийн мэддэг шүү дээ!” гэж хэлж болох юм. Гэвч бид өдөр тутмын үйлчлэлийн ачааллаас болоод хайрлах сэтгэлээ алдаж болно. Чуулганы гишүүдээ хайрлахгүйгээр тэдэнд үйлчлэх боломжтой. Гэр бүлээ хайрлахгүйгээр үйлчлэх боломжтой. Бурханыг хайрлахгүйгээр Христийн үйлчлэлийг хийх боломжтой. Тиймээс л Христийн адил хайрлах нь христэч үйлчлэлийн маань өдөөлт байх учиртай.

### **Бурханыг Есүсийн адил хайрлах нь**

Хүн төрөлхтөнд үйлчлэх Есүсийн үйлчлэл нь Бурхан Эцэгийг хайрлах хайраас эхтэй. Үйлчлэлдээ бухимдаж, цөхөрч туйлдахгүйн тулд хүмүүсийн төлөөх үйлчлэл маань Бурханы төлөөх хайраар өдөөгдөх ёстой. Бурханы төлөөх хайргүй үйлчлэл нь төд удалгүй хоосон, үр жимсгүй болдог.

---

<sup>38</sup> Ялангуяа Матай 13:12-г анзаар. Үнэнийг хүлээж авсан хүн илүү их үнэнийг хүлээн авдаг “хэнд байна, түүнд ихээр өгөгдөнө.” Харин аль хэдийн сонссон үнэнээ ч үгүйсгэх хүний хувьд “хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс авагдана.”



Бидэнд үлгэрлэж буй, Эцэг Бурханы төлөөх Есүсийн хайранд гурван шинж бий. Эдгээр нь: харилцаа, мэдлэг, итгэж найдах нь юм.

### **Есүс Эцэгтэйгээ дотно харилцаатай байсан**

Есүсийг Эцэгтэй дотно харилцаатай байсныг Сайнмэдээний номууд ахин дахин өгүүлдэг. Үүнийг дараах эшлэлүүдээс харж болно.

- Есүс гэрийнхэндээ “Эцэгийнхээ гэрт байх ёстойг минь мэдсэнгүй гэж үү?” (Лук 2:49) гэж хэлсэн байдаг.
- Иохан 17-р бүлэг Есүсийн дотно залбирлыг өгүүлсэн.
- Есүс загалмай дээр шаналан “Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?” (Матай 27:46) хэмээн хашхирчээ.

Гэтсемани цэцэрлэгт байхдаа Есүс гэр бүлийн хүмүүс хэрэглэдэг дотно үгээр “Ааба, Аав аа” (Марк 14:36) хэмээн Бурханыг дууджээ. Энэ бол Эцэгтэйгээ бат харилцаатай хүүгийн хэрэглэдэг үг юм.

Иудейчүүдийн уламжлалт залбиралд Бурханыг Абрахам, Исаак, Иаковын Бурхан; Бидний эцэг өвгөдийн Бурхан; Ерөөлт Нэгэн, Төгс Хүчит Нэгэн; Израилын Аврагч гэх мэт олон нэрээр дууддаг. Харин Есүс Ааба хэмээн дотночлон дууджээ. Есүс Бурхан Эцэгтэйгээ дотно харилцаатай амьдарсан юм.

Кеннет Е. Бэйли Ойрхи Дорнодод олон жил багшилсан хүн бөгөөд Ааба бол Ойрхи Дорнодын хүүхдүүд хэлд орохдоо хэлж сурдаг анхны үг гэж бичсэн байдаг. Ааба нь хүүхэд аавыгаа дууддаг нэр юм.

Бид Бурханы хүүхдүүд тул Түүнд хандан “Ааба! Аав аа!” гэж дуудах эрхтэй (Ром 8:15, Галат 4:6) хэмээн Паул хэлжээ. Бид алс хол байдаг Бурханыг хүндэтгэн мөргөдөггүй. Харин Есүсийн адилаар Эцэгийнхээ хайранд аюулгүй, тав тухтай амьдардаг.

Пасторууд бидний хувьд өөрсдийгөө үйлчлэлийн амжилтаараа хэмжиж, соригддог байж болох юм. Хэрэв бид чуулганы хэмжээ, чуулгандаа хүлээн зөвшөөрөгдсөн байх эсвэл үеийнхэн дундаа танигдах зэргийг үнэ цэнээ болговол, амжилтанд хүрэхийн төлөө үнэнч байдлаа золиослох сорилтод унах болно. Хичээл зүтгэл маань амжилтгүй болбол бид шантарна. Харин бидний амжилтаас үл хамааран Ааба маань биднийг хайрладаг гэдэгт итгэлтэй байвал үр дүнг нь Түүнд үлдээж болно. Түүний хайр бидний гүйцэтгэлээс хамаардаггүй.

### **Есүс Эцэгийнхээ хүслийг мэддэг байсан**

Газар дээрх үйлчлэлийнхээ төгсгөлд Есүс “Хий гэж Надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би” (Иохан 17:4) хэмээн гэрчилсэн юм. Эцэг нь юу хийлгэхээр өөрийг нь илгээснийг Есүс мэддэг байсан, тиймээс тэрхүү зорилгыг биелүүлэхийн тулд амьдралаа зориулжээ.

Есүс хүнийхээ хувьд Эцэгийн хүслийг залбирал болон Үгээр дамжуулан мэдэж авсан юм. Есүс залбирлаар дамжуулан Эцэгийн хүслийг мэдсэн.

Эцэгийн хүслийг Есүс мөн Үгээр дамжуулан мэдсэн. Есүс Капернаумд байхдаа Исаагийн эш үзүүлэгийг биелүүлэх нь Түүний үүрэг даалгавар хэмээн дүгнэн хэлжээ (Лук 4:18-19). Есүс Баптисч Иоханы элч нарт авралын үйлчлэлийнхээ нотолгоо болгон Исаиа номын үгээр (Матай 11:4-5) хариу илгээсэн байдаг. Есүс Үгийг мэддэг байв.

Христэд итгэгчид бэрхшээлтэй үедээ үргэлж Бичвэр рүү хандаж байсныг бид Шинэ гэрээнээс олонтоо хардаг. Стефан итгэлийнхээ төлөө амиа өргөх үеийн сүүлчийн номлолдоо Хуучин гэрээний бичвэрүүд Есүс Христээр биеллээ олсон гэдгийг (Үйлс 7:1-53) багтаан өгүүлжээ. Иудей удирдагчид итгэгчдийг дахиж Есүсийн сайнмэдээг тунхаглахыг хориглох үед чуулганыхан хамтдаа цугларч залбирч байлаа. Тэдний залбиралд Дуулал 2-оос урт хэсгийг эш татсан байдаг (Үйлс 4:24-30, Дуулал 2:1-2). Анхны итгэгчид Бичвэрийг мэддэг байсан бөгөөд энэ нь тэдний залбирал, номлолын үндсэн хэл яриа нь байжээ.

Чуулганы түүхийн туршид дэлхийг өөрчилсөн номлогчид Үгийн хүмүүс байсаар иржээ. Мартин Лютер Вормстын уулзалтын үеэр "Би Бичвэрт хүлэгдсэн бөгөөд миний оюун ухаан Бурханы Үгэнд олзлогддог" хэмээн гэрчилжээ. Жон Весли өөрийгөө "Нэгэн Номын хүн" гэж тодорхойлсон бол, Чарльз Спержион "Библийн мөн чанар чамаас урсан гарах хүртэл" номлогч хүн Үгээр хооллох ёстой гэжээ. Хадсон Тэйлор Үгэнд маш их цаг зарцуулдаг байсан тул нэгэн зохиолч "Тэйлор Библиэр амьсгалж амьдардаг байсан" гэж бичжээ. Эдгээр хүмүүс Үгийг эрх мэдэлтэйгээр номлосон учраас өөрсдийн ертөнцийг өөрчилсөн билээ.

Хэрэв Есүс шиг, анхны итгэгчид шиг мөн түүхэн агуу номлогчид шиг үйлчлэх хүсэлтэй бол бид ч хандлага, бодлоо Үгээр хэлбэржүүлэх ёстой. Паулын үйлчлэлд Бичвэр онцгой эрх мэдэлтэй байсан (2 Тимот 3:16-17). Есүс дагалдагч нарыгаа ариусгагдаж, үйлчлэлд тусгаарлагдаасай хэмээн залбирсан бөгөөд энэ нь "Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг үнэн мөн" гэх үгээр гүйцэлджээ (Иохан 17:17). Үг дагалдагчдын үйлчлэлийг үр нөлөөтэй болгосон шиг, энэ нь бидний үйлчлэлийг ч үр нөлөөтэй болгодог.

"Ямар ч сайн номыг  
Библиэр бүү орлуул.  
Харин булгаасаа ундаал!"  
- Эми Кармайл

Ажит Фернандо бүх амьдралаа Шри Ланкад үйлчлэхэд зориулжээ. Тэрээр Бичвэрт үндэслэхгүйгээр хэзээ ч том мэдэгдэл санааг дамжуулахгүй байх дадлага хийсэн талаараа бичсэн байдаг. Энэ нь Үгэнд суурилсан номлолоо хадгалахад түүнд тусалжээ. Итгэгч бидний хувьд Бурханыг Үгээр дамжуулан мэддэг. Үйлчлэгчдийн хувьд бид Бурханы Үгэнд суурилсан үйлчлэлээр дамжуулан хүчирхэг чуулганыг байгуулдаг.

## **Есүс Эцэгтээ итгэж найдсан**

Есүс дэлхий дээрх үйлчлэлийнхээ үеэр Эцэгтэйгээ ямар харилцаатай байсныг “Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог гэж” (Матай 26:39) Гетсемани цэцэрлэгт залбирсан үгээр нь дүгнэж болно. Энэ бол бүрэн төгс итгэлцэл ба дуулгавартай байдлын илэрхийлэл юм.

Итгэж чадахгүй хүнийхээ хүсэлд бүрэн бууж өгөх нь хэцүү. Тиймээс бид гаднаа бууж өгөхөөс өөр аргагүйд хүрдэг ч, зүрх сэтгэл маань ийм хүнд захирагдахыг эсэргүүцдэг. Есүс Эцэгийн хайр, сайн сайханд бүрэн итгэж найдсан учраас Эцэгийнхээ хүсэлд бууж өгсөн юм.

► Иохан 5:1-47 эшлэлийг унших.

Есүсийн бүх үйлчлэл Эцэгт туйлын найдсан хандлагыг харуулдаг. Амралтын өдөр доголлон хүнийг эдгээсний төлөө Иудейн удирдагчид Есүсийг эсэргүүцэхэд Тэр:

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг.... Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд шүүлт минь шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг (Иохан 5:19, 30) гэж хариулсан юм.

Есүс Бурхан гэдгээ аль хэдийн мэдэгдэж: “Эцэг минь одоо болтол ажилласаар байна. Би ч ажиллаж байна” (Иохан 5:17) гэжээ. Тэрээр бүрэн дүүрэн Бурхан байсан ч, газар дэлхий дээр гүйцэтгэх туслах чанарын үүрэг даалгаварт хүсэлтэйгээр захирагдсан юм. Тэрбээр Эцэгтэйгээ эн тэнцүү боловч, Эцэгийн хүсэлд захирагджээ.

Хэдэн сарын дараа хуулийн багш нар болон фарисайчууд Есүсийг эсэргүүцэх үед Тэр мөн л Эцэгийн эрх мэдлийг заан, өөрийнхөө үйлдлийг хамгаалж “Би юуг ч Өөрөөсөө хийдэггүй, харин Эцэгийн Надад зааснаар Би эдгээрийг ярьдаг” (Иохан 8:28) гэж өгүүлсэн. Тэрбээр Эцэгт бүрэн итгэж найдсан учраас Эцэгийн хүсэлд дуртайяа бууж өгчээ.

Чуулганы удирдагч хүнд тэнцвэртэй байдал шаардагдана. Удирдах чадвар сайтай чуулганы удирдагч, пасторууд маш олон бий. Удирдагчдын хувьд тэд хүчирхэг үзэл бодол, зан чанартай байдаг. Энэ нь удирдагч хүний давуу тал, хүч нь байж болно. Гэсэн ч энэ хүч Бурханд хүсэлтэйгээр захирагдах байдалтай харьцуулахад тэнцвэртэй байх ёстой. Бид Бурханд итгэж найдан бууж өгөхгүй л бол, Бурханы арга замыг дагахын оронд өөрсдийнхөө арга замыг хүчээр тулгах хандлагатай болдог.

Магадгүй Мосе үүний хамгийн сайн жишээ байх. Мосе ... газрын хөрсөн дээрх хэнээс ч илүүгээр маш даруу нэгэн байлаа (Тооллого 12:3). Мосе хүчирхэг боловч, номхон даруу хүн байв. Тэр Египетийн хамгийн хүчирхэг хүн Фараонтой нүүр тулсан. Тэрээр зөрүүд израилчуудыг цөлд удирджээ. Мосе хүчирхэг удирдагч, бас Бурханд дуулгавартай хүн байлаа. Чуулганыг үр нөлөөтэй удирдахын тулд бид төрөлх хүчээ Бурханд даатгах

ёстой. Энэ нь Бурханд итгэж найдсан амьдрал дотор Бурхантай хамт алхаснаар л боломжтой болдог.

► Эцэгийн хайрын талаарх энэ гурван шинж чанарын (харилцаа, Үгийг мэдэх мэдлэг, итгэж найддаг дуулгавартай байдал) аль нь таны хувьд бэрхшээлтэй зүйл болдог вэ?

### **Сайтар ажиглах нь: Есүс өөрийгөө Бурхан гэж хэлсэн үү?**

Мормон, Ёховагийн гэрчүүд гэх мэт хуурамч тэрс үзэл, мөн Ислам гэх мэт Христийг үгүйсгэдэг шашнууд Есүсийг үнэхээр Бурхан байсан гэдгийг үгүйсгэдэг. Тэд Есүсийг агуу багш, эсвэл эш үзүүлэгч, анхны бүтээл, тэр ч байтугай Мессиа гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ Түүнийг жинхэнэ Бурхан байсан гэдгийг үгүйсгэдэг.<sup>39</sup>

Эдгээр шашны дагалдагчид “Есүс хэзээ ч Бурхан байгаагүй. Бид Бурханы хүүхдүүд гэдэг шиг тийм утгаар л Тэр Өөрийгөө Бурхан гэж хэлсэн” гэдэг.

Есүс өөрийгөө Бурхан гэж хэлсэн үү? Тийм. Түүнийг сонссон хүмүүс энэ мэдэгдлийг нь ойлгосон. Есүс Бурханыг “Эцэг минь” гэсэн тул иудей удирдагчид Түүнийг алахыг оролдсон юм. Яагаад тэр вэ? “Үүнээс болж иудейчүүд Түүнийг алахыг улам санаархах болжээ. Учир нь Есүс Амралтын өдрийг зөрчсөн төдийгүй мөн Бурханыг Эцэгээ хэмээн Өөрийгөө Бурхантай адилтгасан юм” (Иохан 5:18).

Өөрийгөө Бурхан гэж хэлсэн Есүсийн хамгийн тодорхой мэдэгдлийн нэг нь иудей удирдагчдад хандаж “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Абрахамаас өмнө ч Би байгаа гэж айлдав” (Иохан 8:58) хэмээн хэлсэн үг юм. Эдгээр үг бол Бурхан өөрийгөө Мосед шатаж буй бутан дундаас илчлэхдээ хэлсэн үг буюу “Израилийн хөвгүүдэд чи “«Би байгаа» намайг та нар уруу илгээв” гэж хэл” гэсэн үгс байв (Гэтлэл 3:14). Эдгээр үгээр Есүс өөрийгөө Мосед харагдсан Бурхан гэдгийг илэрхийлжээ. Есүс яг юу гэж байгааг иудей удирдагчид ойлгосон учраас хариуд нь Түүнийг хөнөөхөөр чулуу шүүрч авсан юм. Чулуугаар нүүлгэх нь өөрийгөө Бурхан гэж худлаа хэлсэн хүний шийтгэл байв (Леви 24:16).

Есүсийг шүүх үедээ Кайаф “Чи Магтаалт Нэгэний Хүү, Христ мөн юм уу?” гэж асуухад Есүс маш тодорхойгоор “Би мөн. Та нар Хүний Хүүг Хүчит Нэгэний баруун талд заларч, тэнгэрийн үүлсээр ирэхийг харах болно” гэжээ. Энэ хариултаараа Есүс өөрийгөө Бурханы баруун талд суудаг, дэлхийг шүүхээр ирэх Хүний Хүү гэж Даниелын эш үзүүлсэн тэр Нэгэн гэдгээ мэдэгджээ (Дуулал 110:1 болон Даниел 7:13-14). Түүнийг өөрийгөө Бурхан гэж хэлнэ гэдгийг Кайаф мэдэж байсан бөгөөд тэрээр хувцсаа урж, “Бурханыг доромжлохыг нь та нар сонслоо” гэсэн юм (Марк 14:61-64).

Та Есүсийн хэлсэн үгэнд итгэхээс татгалзаж болох ч, Есүс өөрийгөө Бурханы Хүү гэж мэдэгдсэн гэдгийг хүлээн зөвшөөрөхгүйгээр Сайнмэдээний номуудыг нягтлан унших

---

<sup>39</sup> Эдгээр хуурамч шашны сургаалын талаар судалъя гэвэл Shepherds Global Classroom курсын *Дэлхийн итгэл үнэмшлийн уламжлал* хичээлийг үзээрэй.

боломжгүй. Түүнийг сонсогчид энэ мэдэгдлийг нь сонсоод, нэг бол Есүсийг Бурхан гэж хүлээн зөвшөөрөх эсвэл Түүнийг хуурамч эш үзүүлэгч, Бурханыг доромжлогч гэж хөнөөхөөс өөр замгүй болжээ.

### **Хөршөө Есүсийн адил хайрлах нь**

Есүс сургаал заахдаа татвар хураагчид болон нүгэлтнүүдийг олонтоо цуглуулдаг байв. Тэрээр тэдэнд заагаад зогсохгүй, хамт хооллодог байжээ. Фарисайчууд Есүсийг дуртайяа тэдэнтэй хооллож байгааг хараад шүүмжилж эхэлсэн. Харин Есүс гурван сургаалт зүйрлэлээр хариу барьсан юм. Та эдгээр түүхийг уншиж байхдаа хоёр чухал нөхцөл байдлыг ойлгох хэрэгтэй.

1. Есүсийн цаг үед хүнтэй хооллох нь нөхөрлөлийн харилцаа тогтоож байна гэсэн үг байв.<sup>40</sup> Тэр нүгэлтнүүдтэй хооллож байсан нь зориуд тэдэнтэй хамт байсныг илтгэдэг. Энэ нь Бурхан хүмүүсийг өөрсдөө хүрээд ирэхийг хүлээж суудаггүй, харин төөрсөн хүмүүсийг идэвхтэй хайдаг гэдгийг харуулдаг.
2. Есүсийн үед иудейчүүд зөвт хүнийг нүгэлтнүүдтэй холбогдохыг цээрлэдэг байжээ. Рабби нар Мессиаг ирэх үедээ хорон муу хүмүүстэй харилцахаас зайлсхийж, зөвхөн зөвт хүмүүстэй хооллоно гэж сургадаг байжээ.

► Лук 15:1-32 эшлэлийг унших.

Энэ бол алдагдсан хонь, алдагдсан зоос, алдагдсан хүү гэсэн гурван хэсгээс бүрдэх том сургаалт зүйрлэл юм. Аль ч тохиолдолд сургаалт зүйрлэлийн сэдэв нь алдагдсан зүйлээ олсон хүний баяр баясгаланг өгүүлнэ. Нүгэлтнийг гэмших үед тэнгэрт баяр баясгалан болдгийг Есүс харуулжээ.

Рабби нарт “Нүгэлт хүн Бурханы өмнө сүйрэхэд тэнгэрт баяр хөөр болдог” гэх мэргэн үг байжээ. Есүс үүнийг орвонгоор нь эргүүлж: “гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно” гэсэн юм. Есүс ба рабби нарын хооронд ямар ялгаа байна вэ? Энэ бол Хайр. Хайрын зүрх сэтгэлээс үйлчлэх нь ямар утга учиртай болохыг Есүс харуулсан.

Хайргүйгээр үйлчлэх аваас байр суурь, зэрэг дэв маань хүмүүсээс илүү чухал болно. Харин бид хайраар үйлчилбэл, алдагдсан хүмүүсийн төлөө золиос гаргах хүсэлтэй байдаг. Есүс хайр хэрэгтэй хүмүүст хайраа харуулахын төлөө шашны удирдагч нарын шүүмжлэлд өртөж, зовлон амсахад бэлэн байжээ.

“Эдгээр сургаалт зүйрлэлүүд сайнмэдээ нь бүх зүйл нь зөв хүмүүст зориулагдаагүй гэдгийг харуулдаг. Сайнмэдээ нь бүх юм нь зөв бус байгааг мэддэг хүмүүст зориулагдсан юм.”  
- Самуел Ламерсон

<sup>40</sup> Энэ дүрслэл Сургаалт үгс номд бий. Бүсгүйн мэргэн ухаан “гэнэн” хүнийг хамт хооллохыг урьсан тухай (Сургаалт үгс 9:1-6) өгүүлдэг. Бүсгүйн мэргэн ухаантай нөхөрлөснөөр гэнэн хүн ухаантай болно.

► Хэрэв “Та төөрсөн хүүг хайрлах уу?” гэж асуувал бид цөм л “Тийм” гэж хариулна. Үүний оронд “Миний замд хамгийн сүүлд тааралдсан төөрсөн хүү хэн байв? Би тэр хүнийг хэрхэн хайрлав?” гэж асуугаарай.

### **Есүс шаналж байгаа хүмүүсийг хайрлах хайраа өрөвдөх сэтгэлээрээ харуулсан**

Сайнмэдээний номуудыг унших үедээ нүгэлтнүүд шашны удирдагч нараас *зугтааж*, Есүс рүү очиж байгааг анзаарсан уу? Юу нөлөөлсөн болоод нүгэлтнүүд Есүсийг хайсан бэ?

Есүс тэдний нүглийг үл тоосон гэсэн үг биш. Харин ч Есүс фарисайчуудаас ч илүү зөвт байх өндөр хэм хэмжээг шаарддаг байсан (Матай 5:20). Есүс хүнийг өрөвддөг байсан учраас нүгэлтнүүд Есүс рүү очдог байв. Тэр нүглийг зөвшөөрсөн хэрэг биш, харин нүгэлд эзлэгдсэн хүнийг өрөвдөж байсан хэрэг.

Бид үүнийг завхайрч байгаад баригдсан эмэгтэйд хандан хэлсэн Есүсийн үгээс харж болно. Буруутгагчид явсны дараа Есүс түүнд “Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд” (Иохан 8:11) гэсэн билээ. Есүс нүглийг зүгээр өнгөрүүлээгүй, харин нүгэлт амьдралаа орхихыг тэр эмэгтэйдээс шаардсан. Гэхдээ Есүс яллахаас илүүгээр өрөвдөж энэрсэн сэтгэлээ харуулсан юм.

Лукийн Сайнмэдээнд өгүүлэх Есүсийн өрөвдөж энэрэх сэтгэл анхаарал их татдаг. Шашны удирдагчдын зэвүүцдэг татвар хураагч Закхайн тухай түүх Лук номд бий. Харин Есүс тэнд байсан хүмүүсийг цочирдуулж, нүгэлт хүний гэрт зочлохыг хүсжээ (Лук 19:7).

► Лук 5:12-16 эшлэлийг унших.

Лук энэхүү эдгэрлийн талаар өгүүлэхдээ олныг гайхшируулсан нарийн мэдээллийг өгчээ. Есүс гараа сунган тэр хүнд хүрсэн. Тэр үед уяман өвчтэй хүнд хэн ч хүрч байгаагүй. Халдвар авах аюултай байв. Харин иудейчүүдийн хувьд уяман өвчтэй хүнд хүрэх нь ёс заншлын хувьд бузарт тооцогддог байсан.

Тэгвэл Есүс яагаад тэр уяман өвчтэй хүнд хүрэв? Есүс түүнийг өрөвдсөн учраас “Тэр өрөвдөн гараа сунгаж түүнд хүрээд” (Марк 1:41) гэжээ. Тэр хүнд биеийн эдгэрэл хэрэгтэй байсан шиг сэтгэл санааны эдгэрэл ч бас хэрэгтэй байсан. Уяман өвчтэй хүн бусдаас дөлж явах ёстой бөгөөд ийм хүнтэй харилцсан хүн өөр бусад хүнд хүрч болдоггүй байжээ. Есүс түүнд хүрэлгүйгээр эдгээж чадах л байсан, гэхдээ уяман өвчтэй хүнд өөр нэгний хүрэлт хэрэгтэй гэдгийг Тэр мэдэж байсан. Есүс өрөвдөн энэрчээ.

“Хүмүүст санаа тавих  
хүртэл чиний хэр их  
мэддэг чинь тэдэнд  
хамаагүй.”  
—Теодор Рузвельт

Хэрэв бид Есүсийн адил үйлчлэхийг хүсвэл, Есүс адил өрөвдөх сэтгэлтэй байх ёстой. Нүгэлтнүүд Есүсийн нүд рүү хараад хайр энэрлийг олж харсан. Нүгэлтнүүд чиний нүд рүү хараад юу олж хардаг вэ?

## **Есүс зовж зүдэрсэн хүмүүст үйлчилснээрээ хайраа харуулсан**

“Би энэ хүнийг өрөвдөж байна” гэж хэлэх нь амархан боловч зовж зүдэрсэн хүмүүст үйлчлэх нь амаргүй. Есүс эргэн тойрондоо байсан тэдгээр хүмүүст үйлчлэхдээ хайраа харуулсан юм. Есүсийн бүхий л үйлчлэл нь нэг л үйлчлэл байсан. Паул Есүсийг боолын дүрийг авч, өөрийгөө хоосолсон хэмээн бичсэн байдаг (Филиппой 2:7). Есүс дагалдагч нартаа “Учир нь Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ гэв” (Марк 10:45) гэсэн юм.

Есүсийн гайхамшгууд нь Түүний бусдад үйлчлэх үйлчлэлийг харуулдаг. Гайхамшгууд нь Мессиа гэдгийг харуулах тэмдэг байсан ч, хүний хэрэгцээг хангах хэрэгсэл байв. Заримдаа цөөн хүмүүсийн төлөө ч Тэр гайхамшгуудыг хийдэг байсан. Заримдаа гайхамшгууд нь ямар ч эрх мэдэл, нөлөөгүй хүмүүст ашиг тустай байв. Заримдаа (Амралтын өдөр үйлдсэн) гайхамшгуудаас нь болж хүмүүс Түүнийг үгүйсгэж, дургүйцэж байсан.

Есүс хүчирхэг хүмүүсийг татахын тулд биш, харин тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэхийн тулд гайхамшгуудыг үйлдсэн. Бичвэрт хоёр удаа Есүс гайхамшиг үйлдэхээс татгалзсан тухай өгүүлдэг. Фарисайчууд “Түүнийг сорихын тулд тэнгэрээс тэмдэг үзүүлэхийг шаардаж эхлэв” (Марк 8:11). Есүс тэмдэг үзүүлэхээс татгалзсан юм. Түүнчлэн Есүсийг шүүх үедээ Херод ямар нэг тэмдэг үзнэ гэж найдаж байсан (Лук 23:8). Тиймээс л Есүс Херодод хариу хэлэхээс татгалзсан юм. Тэрээр хүсэлтээр, эсвэл олныг гайхшируулахын тулд гайхамшиг үйлдэж байгаагүй.

Хэдийгээр Есүс Херод Антипаст гайхамшгаа үзүүлэхээс татгалзсан ч, загасчны хадам эх, уяман өвчтөн, хараагүй гуйлгачид гэхчлэн Түүнд хариу төлж чадахгүй хүмүүсийн төлөө гайхамшгаа үзүүлсэн. Тэрээр талархах сэтгэлгүй, өөрийг нь нь орхисон 5,000 хүнийг хооллож, өөрийг нь баривчлахаар ирсэн тэргүүн тахилчийн зарцыг эдгээж байсан. Есүс гайхамшгуудаараа дамжуулан тусламж хэрэгтэй хүмүүст үйлчилсэн юм.

Пастор ба чуулганы удирдагчдын хувьд бидэнд хариу барьж чадах хүмүүст туслах нь их амархан шийдвэр байж болно. Бид ядуусаас илүү баян чинээлэг хүмүүстэй цаг өнгөрөөхдөө “Бизнес эрхлэгчид чуулганы маань үйлчлэлийг дэмжиж чадна” хэмээн боддог. Бид нөлөө бүхий албаны хүнтэй уулзахын тулд бэлэвсэн эмэгтэйтэй уулзахаа хойшлуулах үедээ “Албаны хүний нөлөө Бурханы ажилд тус болно” гэж шалтаглаж ч болох юм. Есүс харин хэзээ ч тэгж байсангүй. Хэрэв бид Есүсийн адил үйлчлэхийг хүсвэл бид Есүс адил үйлчлэгч болох ёстой. Бид яг Түүнтэй адил үйлчлүүлэх гэж бус, харин үйлчлэхийг эрэлхийлэх ёстой (Матай 20:28). Паул “Учир нь бид өөрсдийгөө тунхагладаггүй, харин Христ Есүсийг Эзэн гэж, өөрсдийгөө Есүсийн төлөөх та нарын боол гэж тунхагладаг юм” (2 Коринт 4:5) гэсэн байдаг.

Зарим пасторууд “Би өндөр боловсролтой хүн. Би чуулганыхаа тариачин эрийн зарц биш!” гэж хэлж болох юм. Паул хэзээ ч тийм байгаагүй. Тэр хамгийн өндөр боловсролтой байсан ч, Есүсийн төлөө коринтчуудын зарц болсон юм. Паул “Миний боловсролыг хар даа. Би Иудейн утга зохиол, Грекийн гүн ухаан, Христитгэлийн

теологийг эзэмшсэн. Би Иудейн санхедрин, Грекийн арейпаг, Ромын сенатад ярьж чадна” гэж хэлж болох байсан. Харин оронд нь тэрээр “Би Эзэн Есүсийнхээ төлөө Коринтын хамгийн боловсролгүй хүмүүсийн зарц болсон” гэж хэлсэн юм.

Хэрэв бид Есүсийн адил үйлчлэхийг хүсвэл зарц шиг амьдрах даруу зантай байх ёстой. Үйлчлэгчид бидний амьдралын хэв маяг бол захирагчийн амьдралын хэв маяг биш юм. Хэрэв бид Есүсийн адил хайрлахыг хүсвэл даруухан зарц байх учиртай.

### **Есүс дайснуудаа өршөөснөөр хайраа харуулсан**

► Матай 5:43-48 эшлэлийг унших.

Есүс дагалдагч нартаа тэнгэрлэг Эцэг адил төгс бай хэмээн заасан нь, тэнгэрлэг Эцэг адил хайрлах ёстой гэсэн утгатай юм. Энэ нь дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир гэсэн үг. Хэрэв та нарыг тийм хайрыг харуулбал энэ дэлхий таныг тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд гэдгийг мэдэх юм.

Есүсийг Уулан дээрх сургаалаа номлохоос 200 орчим жилийн өмнө Сирах хэмээх нэгэн иудей гүүш сургаалын цоморлиг бичжээ. Тэрээр тусламж үзүүлэх шаардлагагүй хүмүүстэй яаж харьцахыг дагалдагч нартаа хэрхэн сургасныг харна уу.<sup>41</sup>

- Сайн үйл хийхдээ хэнд ашигтайг мэд. Тэгвэл хүч чинь дэмий үрэгдэхгүй.
- Даруу хүмүүст сайныг хий, харин сүсэггүй хүмүүст юу ч бүү өг.
- Сүсэггүйчүүдэд хоол битгий өг. Тийм хүмүүсийн төлөө хийсэн бүхэн чинь чамд хоёр дахин их гай авчирна.
- Дээдийн Дээд нь нүгэлтнүүдийг үзэн яддаг тул тийм хүмүүсийг шийтгэх болно.
- Сайн хүмүүст харин өг, нүгэлтнүүдэд бүү тусал.

Есүсийн цаг үед Бен Сирахын бүтээлийг иудейчүүд бичвэр хэмээн үздэг байжээ. Тиймээс Есүс “Хөршөө хайрла, дайснаа үзэн яд” гэж хэлснийг та нар сонссон” (Матай 5:43) гэсэн нь Сирахын бичсэн “Сайн хүмүүст л сайныг хий, муу хүмүүст сайн үйлсээ дэмий бүү зарцуул” гэсэн хэсгийг хэлсэн болов уу.

► Матай 5:43-48 эшлэлийг дахин унш. Есүсийн сургаал хүмүүсийг цочирдуулж байгааг харж байна уу?

Хуучин гэрээнд Бурхан ард түмэндээ дайснуудаа хайрла хэмээн заасан учраас энэ нь шинэ сургаал биш байв. Энд нэгэн профессорын оюутнуудаасаа асуусан Хуучин гэрээний хичээлийн сорилын асуултыг оруулъя.

*Таны хөрш бол чуулганы дайсан. Таныг өнгөрөн явахад араас чинь хараадаг. Таныг хуурч, малыг чинь хүртэл хулгайлахыг санаархдаг хүн. Нэг өдөр ширүүн бороо ороход*

---

<sup>41</sup> Сирах 12:1-7, *Good News Translation*



*хөршийн чинь үхэр алдууран одохыг та харжээ. Та хөршийнхөө өмнө ямар хариуцлага хүлээх вэ?*

*1. Та үхрийг нь гуядаад цааш хөөх үү?*

Энэ зөв хариулт биш гэдгийг оюутнууд мэднэ!

*2. Та зүгээр тоохгүй орхиж "Энэ миний асуудал биш" гэх үү?*

Олон оюутнууд энэ сонголтыг сонгодог. Тэд "Энэ миний үхэр биш, хөршийнх. Би өөрийнхөө хэрэгт л санаа тавина. Түүнээс гадна хөрш надад дургүй, тэр миний тусламжийг үнэлэхгүй" гэдэг.

*3. Та Гэтлэл 23:4 эшлэлийг биелүүлэх үү? "Хэрэв дайсныхаа алдуул үхэр, илжигтэй тааралдвал түүнийг заавал эзэнд нь буцаан аваачиж өг."*

Хуучин гэрээнд ч Бурхан дайснуудаа хайрлахыг ард түмэндээ уриалжээ. Харин Есүсийн цаг үед хүмүүс Хуучин гэрээний Гэтлэл 23-р бүлгээс илүү *Сирахын* бүтээлийг эш татдаг байсан бололтой. Тэд хөршөө хайрлаж, дайснаа үзэн ядах сургаалд дуртай байж. Есүс харин "Таны тэнгэрлэг Эцэг сайн болон муу хүний аль алиныг хайрладаг учраас та дайснаа хайрлах ёстой" гэсэн. Бодит амьдрал дээр энэ нь ямархуу байдаг вэ? Дараах үйл явдлыг та үйлчлэлдээ тохиолдсон гэж төсөөлөөд үзээрэй.

*Таны итгэл үнэмшлийг байнга олны дунд ярьж, эсэргүүцдэг бүлэг хүмүүс цуглажээ. Тэд таныг урхинд оруулах асуулт тавьж, танай цуглааны гишүүдэд таныг хуурамч сургаал заадаг гэж хэлэхээс гадна, таныг дагалдагчидтайгаа ямар нэг асуудалд орох хэрэг тарина гэж найдан хүлээсээр. Та тэдэнд яаж хандах вэ?*

*1. Тэднийг хөөж явуулаад дахин эргэж ирэхийг хориглох уу?*

*2. Тэдний харьцаж байгаа шиг харилцах уу?*

*3. Тэдний алдаанд шударга байх ч, тэдэнд хайраар хандах уу?*

Фарисайчууд Есүсийг эсэргүүцэх бүх арга замыг туршсан. Есүс тэдний алдааны тухайд шударга байж, тэдэнд үнэнийг заахыг оролдож байсан. Гэхдээ Есүс тэдэнд үргэлж хайраар хандаж байсан юм.

Хэрэв бид Есүсийн адил үйлчлэхийг хүсвэл дайснуудаа хайрлах ёстой. Энэ бол Есүсийн хамгийн ихээр биелүүлэхийг шаарддаг сургаал юм. Биднээс урвасан хүмүүс, бидний мэдээнээс татгалзсан хүмүүс, биднийг хавчин гадуурхсан хүмүүст бид Есүсийн болзолгүй хайрыг харуулах ёстой.

### **Хэрэгжүүлэлт: Христэд итгэгчийн амьдрал дахь Есүсийн зан чанар**

Бурханыг болон хөршөө хайрлах тухай бичих амархан. Харин өдөр бүрийн амьдралдаа хайрыг харуулах нь амаргүй. Бид Есүсийн зан чанарыг амьдралдаа хөгжүүлснээр л Есүсийг дэлхийд таниулахад бэлтгэгдэж чадна.

Тэгвэл Есүс шиг зан чанартай болох боломжтой юу? Бичвэрт Бурхан ард түмнээ өөр шигээ боддог болгож чадна гэж заасан. Тэрээр ард түмэндээ шинэ сүнсийг өгөхийг хүсдэг бөгөөд тэрхүү сүнсээр бид Бурханы хүссэн зүйлийг хүсэж, Бурханы дуудсан амьдралаар амьдардаг (Езекиел 36:26-27). Бурхан биднийг Хүүгийнхээ зан чанараар төлөвшүүлэхийг хүсдэг.

Өдөр тутмын үйлчлэлдээ итгэмжит байх тухайд Освальд Чамберс юу хэлснийг үзэцгээе.

Бурханаас ямар ч хараа ирэхгүй, амьдралд чинь ямар ч урам байхгүй, хэн ч чамайг харахгүй, урамшуулахгүй байх үед Бурханд зориулалт гаргах дараагийн алхмыг хийхийн тулд Төгс Хүчит Нэгэний нигүүлсэл хэрэгтэй. Дараагийн алхмыг хийхэд сайнмэдээ номлохоос хамаагүй их нигүүлсэл, Түүнийг илүү их таних ухаарал шаардагдана.

Бурханыг гэрчлэх, Бурханы хүмүүсийн төлөө удаан хугацаанд явах нь бусдад харагдахгүй ч, их тэвчээр шаарддаг. Түүнчлэн ялж амьдрах цорын ганц зам бол Бурханыг үргэлж хайх явдал юм. Сүнсний чинь мэлмий амилсан Христийг үргэлж ширтсээр байхыг хүсэн залбираарай.<sup>42</sup>

Бид үйлчлэлдээ энэхүү итгэмжит байдлыг яаж хадгалах вэ? Бид долоо хоногоос долоо хоногт, жилээс жилд Бурханыг болон хөршөө яаж хайрласаар байх вэ? Есүсийн зан чанарыг өдөр бүрийнхээ амьдралд хөгжүүлснээр чадна. Ингэхийн тулд бидэнд Христийн оюун ухаан хэрэгтэй.

### **Христийн оюун ухааны тодорхойлолт**

► Филиппой 2:1-16 эшлэлийг унших.

Паулаас Филиппой чуулганд өгсөн заавар бол Христийн адил зан чанар гэж юу болохыг заасан хүчирхэг удирдамж юм. Хувь хүмүүсийн зөрчлөөс болж хуваагдсан чуулганд хандан Паул, “Юуг ч аминч санаархал эсвэл ихэрхэг зангаар бүү хий. Харин даруугаар бие биенээ өөрөөсөө дээр гэж үзэж, хүн бүр өөрийн ашиг сонирхлыг бус, харин бусдын ашиг сонирхлыг хар” (Филиппой 2:3-4) гэж бичжээ.

Тэд үүнийг яаж хийж чадах байв? Зөвхөн Паулын өгсөн “Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай” гэх зааврыг дагаснаар чадах байв (Филиппой 2:5).

Паул Христэд итгэгчийн амьдралд байх ёсгүй дөрвөн зан чанарыг жагсаажээ.<sup>43</sup> Эдгээр зан чанар Христийг гэрчлэхэд хохирол учруулж, христитгэлийн үйлчлэлийг сүйтгэдэг. Энэ нь:

---

<sup>42</sup> Oswald Chambers, *My Utmost for His Highest* (3 сарын 6-ны бичлэг). <https://utmost.org/taking-the-next-step/> 2021 оны 3 сарын 22-нд хандсан.

<sup>43</sup> Энэ хэсгийг Dennis F. Kinlaw, *The Mind of Christ* (Anderson, Indiana: Warner Press, 1988), 101-107-оос авсан.

### **(1) Юуг ч аминч санаархал ... бүү хий (Филиппой 2:3).**

Хувиа хичээсэн зан "Надад ямар хэрэгтэй юм бэ? Би үүнээс ямар ашиг хүртэх вэ?" гэдэг. Харин Есүс уяман өвчтэй хүнийг эдгээхдээ эсвэл загалмайтай тулгарах үедээ "Надад ямар ашигтай вэ?" гэж хэлсэн гээд төсөөлж чадах уу? Мэдээж үгүй!

Паул "Хэрэв бидэнд Христийн оюун ухаан байгаа бол, хэрэв бид Христтэй адил боддог бол, бид юуг ч хувиа хичээсэн сэдлээр хийхгүй" гэсэн. Бидэнд зарцын хандлага байх ёстой бөгөөд "Би яаж үйлчлүүлэх вэ?" биш, харин "Би яаж үйлчлэх вэ?" гэсэн хандлагатай байх ёстой.

### **(2) Юуг ч ... ихэрхэг зангаар бүү хий (Филиппой 2:3).**

Ихэрхүү зан "Энэ намайг ямар харагдуулах бол? Хүмүүст ямар сэтгэгдэл төрүүлэх бол?" гэдэг. Дахиад төсөөлөөд үз. Есүс самари эмэгтэйтэй худгийн дэргэд уулзахаасаа өмнө "Хүмүүст ямар сэтгэгдэл төрүүлэх бол? гэж бодсон уу? Мэдээж үгүй!

Паул "Хэрэв бидэнд Христийн оюун ухаан байгаа бол, хэрэв бид Христтэй адил боддог бол, бардам зангаар юу ч хийхгүй." Бид байр сууриа олж авах боломжийг биш, харин Христийг харуулах боломжийг эрэлхийлнэ" гэж хэлсэн.

### **(3) Бүхнийг гомдол ... үгүйгээр хийцгээ (Филиппой 2:14).**

Гомдол нь "Би үүнээс илүүг хүртэх эрхтэй!" гэдэг. Есүсийг "Би дагалдагчдын хөлийг угаахгүй. Би багш. Би илүүг хүртэнэ" гэж хэлсэн гээд төсөөлж чадах уу? Мэдээж үгүй!

Паул "Хэрэв бидэнд Христийн оюун ухаан байгаа бол, хэрэв бид Христтэй адил боддог бол бид хамгийн хүнд үед ч гомдоллохгүйгээр үйлчилж чадна" гэж хэлсэн юм. Бид илүү юу ч хүртэх албагүй гэдгээ ухаарах болно. Байгаа бүхэн маань Бурханы ивээл гэдгийг санах аваас үйлчлэлийнхээ талаарх үзэл бодол маань өөрчлөгдөнө.

Хелен Рөүзвир бол 20-р зууны гайхалтай илгээлтийн эздийн нэг байлаа. Кембрижийн Их сургуулийн анагаахын доктор байсан тэр эмэгтэй Заир улсад эмч-илгээлтийн эзнээр ажиллаж байхдаа эмнэлэг барихыг хүсжээ. Гэхдээ тэнд барилгын материал байхгүй учраас хамгийн эхлээд тоосго шатаах ёстой байв. Ингээд Доктор Рөүзвир африк ажилчидтай мөр зэрэгцэн тоосго цохих болжээ. Тоосго цохих үед нь түүний зөөлөн гараас цус урсаж эхлэв. Тэгээд гомдоллож "Бурхан минь, би Африкт тоосго цохихоор биш, мэс засал хийх гэж ирсэн! Ийм дорд ажлыг хийх өөр хүмүүс гарцаагүй байгаа" гэжээ.

Хэдэн долоо хоногийн дараа африк ажилчдын нэг нь түүнд "Эмч ээ, та мэс заслын өрөөнд байхдаа эмчийнхээ хувьд биднийг айлгадаг. Гэхдээ та тоосгон дээр ажиллаж, бидэн шиг хуруунаасаа цус дуслуулж байгаа бидний эгч шүү. Бид танд хайртай" гэжээ. Доктор Рөүзвир гэнэт "Бурхан намайг Африк руу зөвхөн мэс засалч болгох гэж илгээгээгүй, Тэр намайг Христийн хайрыг харуулахын тулд илгээсэн" гэдгийг ухаарчээ.

#### **(4) Бүхнийг ... маргаан үгүйгээр хийцгээ (Филиппой 2:14).**

Маргаан нь “Тийм ээ, Эзэн, гэхдээ... Би дуулгавартай баймаар байна, гэвч...” гэдэг. Та дахиад Есүсийг “Эцэг минь, Би Танд үйлчлэхээр ирсэн. Та яагаад үүнийг ийм хэцүү болгоод байна?” гэж хэлсэн гээд төсөөлөөд үзээрэй. Мэдээжийн хэрэг, бид Есүсийг Эцэгтэйгээ маргалдаж байна гэж төсөөлж чадахгүй.

Паул “Хэрэв бидэнд Христийн оюун ухаан байгаа бол, хэрэв бид Христтэй адил боддог бол, маргалдаж, амар хялбар замыг эрэлхийлэхгүй” гэсэн. Бид илүү амар хялбар замыг наймаалцах замаар Бурханы хүслийг амьдралдаа зөрчихгүй. Харин хариулт маань “Тийм ээ, Эзэн” байх болно. Бидэнд Христийн оюун ухаан бий.

Паул Филиппой чуулганыхныг Христийн оюун ухаантай гэж хэлсэн нь ингэх боломжтой гэж үзсэнийх. Тэрээр тэднийг Есүсийн амьдралыг харуулсан даруу, дуулгавартай сэтгэлтэй байж чадна гэдгийг мэдэж байсан. Тэгвэл бид энэхүү Христийн оюун ухааныг хэрхэн олох вэ?

#### **Бидний оюун ухаан Бичвэрээр дамжин хувьсан өөрчлөгддөг**

Энэ хичээлийн эхэнд Бичвэр бидэнд Бурханы хүслийг хэрхэн заадаг тухай үзсэн. Есүс Бурханы Үгийг мэддэг байсан. Элч нар ч Бурханы Үгийг мэддэг байсан. Чуулганы түүхэн дэх удаан үргэлжилсэн сэргэлт Бурханы Үгийг судлахаас эхэлсэн байдаг.

Паул филиппойчуудыг амийн үгээс чанга зуур хэмээн уриалсан (Филиппой 2:16). Тэдний итгэл, сайнмэдээний төлөөх зүтгэл нь тэднийг тэдний ертөнцийн гэрэл болгоно.

Бурханы Үгийг сайтар судалснаар бид Есүстэй адил сэтгэж, Христийн оюун ухаантай болж эхэлнэ. Энэ бол Бичвэрийг ойлгохын тулд та грек, еврей хэл мэдэх ёстой гэсэн үг биш. Энэ бол Библийн тайлбаруудтай том номын сантай байх ёстой ч гэсэн үг биш. Энэ бол зүгээр л та Бурханы Үгэнд цаг зарцуулах ёстой гэсэн үг. Үгийг судлах нь таны амьдралын өдөр тутмын нэг хэсэг байх ёстой.

Христэд итгэгчдийн хувьд Бурханы Үг өдөр тутмын хоол байх ёстой. Энэ нь үүрэг биш, харин баяр баясгалан байх учиртай. Хэн ч эрүүл хүнд “Чи өнөөдөр идэх ёстой! Хэрэв идэхгүй бол бие чинь муудна” гэж хэлэхгүй. Харин эрүүл хүн бол сайхан хоол бэлтгээд идэхийг хүсдэг. Бурханы Үг өлссөн Христэд итгэгч бүрийн хоол байх ёстой.

Бурханы Үгээр хооллосноор бидний оюун ухаан Христийнхтэй адил болж өөрчлөгддөг. Олон итгэгчид дахин төрсөн хэдий ч, үл итгэгч байсан үе шигээ бодож сэтгэдэг хэвээр байдаг. Тэдний оюун ухаан Христийн оюун ухаан болж өөрчлөгдөөгүй гэсэн үг. Яагаад?

Шинэ итгэгчдийн хувьд бид оюун санаагаа Христийнхтэй адил болгож програмчлах ёстой. Итгэгч болохоос өмнө та хамгийн түрүүнд хэрэгцээнийхээ тухай боддог байсан. Ядуу хүнийг хараад та “Надад өөрт минь мөнгө хэрэгтэй. Тэр хүнд юм өгч чадахгүй нь” гэж боддог байсан байх. Харин итгэгч болоод “Ядууст өгдөг хүн хэзээ ч, юугаар ч үл дутагдана” (Сургаалт үгс 28:27) мөн, Есүсийн “Өгөгтүн, тэгвэл та нарт өгөгдөх болно. Тэгэхдээ шахагдсан, чигжсэн мөн бялхсан сайн хэмжээгээр өвөр дээр чинь асгарах

болно. Өөрсдийнхөө хэмжсэн хэмжээсээр та нар хариуд нь хэмжигдэх болно гэлээ” (Лук 6:38) гэж хэлснийг уншдаг болсон. Та мөнгөний тухайд Христтэй адил боддог болсон. Та Бурханы Үгээр дамжуулан Христтэй адил бодол санаатай болж байна.

Бид Христэд итгэгч болохоосоо өмнө биднийг гомдоосон хүмүүсийг гомдоохыг оролддог байсан. Хэн нэг нь бидэнд ширүүн хандах үед бид уурлаж хилэгнэдэг байсан. Харин итгэгч болоод бид “өрөвч зүрхийг өмс” (Колоссай 3:12) хэмээн уншдаг. Бид мөн “Ерөөлийг өвлөхөөр дуудагдсан тул та нар мууг муугаар, эсвэл доромжлолыг доромжлолоор хариулахын оронд ерөөгтүн” (1 Петр 3:9) гэж уншдаг. Биднийг гомдоосон хүмүүст бид Христтэй адил хариу үйлдэл үзүүлж эхэлнэ. Ийнхүү бид Бурханы Үгээр дамжуулан Христийн оюун ухааныг олж авч байна.

### **Өдөр бүр буулт хийснээр бидний оюун ухаан хувьсан өөрчлөгддөг**

Паул филиппойчуудад Христ Есүст байсны адил бодол санаатай бай хэмээн хэлсэн. Тэрээр Христийн бодол санаа гэж юу болохыг тодорхойлж, улмаар үүнийг амьдралдаа хэрхэн бий болгох тухай хэлж өгчээ. Тэрээр филиппойчуудыг *авралыг олж авахын тулд биш*, харин итгэмжит дуулгавартай байдлаараа авралаа үргэлжлүүлэн ажил хэрэг болгох ёстой гэжээ. Учир нь Бурхан аль хэдийн “хүсэл ба сайн тааллынхаа төлөө ажиллаж” байгаа юм (Филиппой 2:12-13). Хэрэв даруухнаар Бурханд бууж өгвөл Бурхан тэдэнд бурханлаг амьдралаар амьдрах хүсэл ("хүсэх") болон хүчийг ("ажиллах") өгөх болно.

Бурханд бууж өгсөн амьдралаар амьдрах үед Ариун Сүнс бидний дотор Есүсийн амьдрал үйлчлэлд байсан зан чанаруудыг хөгжүүлдэг. Бид өөрсдийнхөө хүч зүтгэлээр Христийн оюун ухаантай болохгүй, харин бууж өгснөөр Христийн оюун ухаантай болно.

Энэ бол өдөр бүр буулт хийнэ гэсэн үг. Паул бидэнд “өөрсдийн биеийг... амьд... тахил болгож өргө (Ром 12:1) гэсэн юм. Амьд тахил бол үхсэн биш, харин үргэлжлүүлэн амьдрах тахил гэсэн үг. Бурханы өмнө хүслээсээ татгалзаж, бүрэн **бууж өгөх** юм. Мөн өдөр бүрийнхээ амьдралыг Түүний хүсэлд нийцүүлэн **олонтоо бууж өгөх** тухай юм.

Нэнси Лэй ДеМосс бууж өгдөг амьдралыг ийнхүү дүрсэлжээ.<sup>44</sup> Та энэ дүрслэлийг унших үедээ “Би эдгээр талбар дээр өдөр бүр бууж өгч амьдарч байна уу? Би эдгээр тал дээр Христийн оюун ухааныг харуулж байна уу?” хэмээн өөрөөсөө асуугаарай.

- Махбод чинь шүүмжилсэн үгийг давтан хэлэхийг хүснэ. Сүнс “Хэнд ч муу үг бүү хэл” гэнэ (Тит 3:2). Бууж өгдөг хүний сэтгэл “За” гэдэг.
- Махбод чинь хэцүү нөхцөл байдлын талаар гомдоллохыг хүснэ. Сүнс “Бүх зүйлд талархалаа өргө” гэнэ (1 Тесалоник 5:18). Бууж өгдөг хүний сэтгэл “За” гэдэг.

---

<sup>44</sup> Nancy Leigh DeMoss, *Surrender*-с эш татав. (Chicago: Moody Press, 2008), 223-224.

- Махбод чинь бодлогогүй даргыгаа эсэргүүцэхийг хүснэ. Сүнс “Эзэний төлөө өөрсдийгөө... захируул” гэнэ (1 Петр 2:13). Бууж өгдөг хүний сэтгэл “За” гэдэг.

Биднийг бууж өгөх үед Христийн дотор амьдарч байсан Сүнс бидний дотор амьдарч эхэлдэг. Бид өөрсдийнхөө сайн сэдлээр биш, харин Сүнсээр хүчирхэгжсэнээр өдөр тутмын бухимдал, урам хугаралт, уруу татлагад Христийн адил хариу үйлдэл үзүүлэн, Сатаны сорилтыг эсэргүүцдэг.

► Махбодын хүсэл чинь Бурханы хүсэлтэй зөрчилдсөн саяхны үйл явдлын талаар хуваалцаарай. Сорилттой тулгарсан ч, өдөр бүр бууж өгөх амьдралыг хэрхэн хэрэгжүүлсэн бэ? Бурханы хүсэлд дахин бууж өгөх ёстой болсон саяхны сорилт юу байв? Эдгээр асуудлын талаар ангид бие биеийнхээ төлөө залбираарай.

“Ариун амьдралын нууц нь Христийг дуурайхад бус, харин миний амьдралаар Өөрийгөө харуулахыг Есүс Христэд зөвшөөрөхөд оршино... Ариусгал бол ариун байх хүчийг Есүсээс авах биш, харин Есүст байсан ариун чанарыг Есүсээс авахыг хэлж байгаа юм.”

- Освальд Чемберс-

### **Дүгнэлт: Христийн адил хайраар дамжуулан Бурхан ажилладаг**

Бид зовлонтой дэлхийд амьдардаг. Энэ хичээлийг уншиж байгаа олон хүн засгийн газар, хуурамч шашин, нийгмийн дарамтууд чуулганыг заналхийлж буй газар оронд амьдарч байгаа. Бид дайснаа хайрласнаар дэлхийгээ үнэхээр өөрчилж чадна гэж бодох нь ухаалаг зүйл үү? Дайсан биднийг алах гэж байхад бид яаж дайснаа хайрлах юм бэ?

Багдад хотод амьдардаг Христэд итгэгч нэгэн ирак хүнтэй сурвалжлагч ярилцжээ.<sup>45</sup> Сурвалжлагчийг энэ хүнтэй ярилцаж байх зуур ISIS-ийн цэргүүд гэрээс нь 40 минутын зайтай байсан аж. Сурвалжлагч “Танай цуглаан хүндэтгэл мөргөл өргөсөн хэвээрээ юу?” гэхэд тэр итгэгч “Тийм ээ, бид чуулгандаа залбирлын хоёр шинэ бүлэг эхлүүлсэн. Нэг нь умардад байгаа хавчигдаж буй ахан дүүсийнхээ төлөө, нөгөө нь дайснуудынхаа төлөө залбирч байна” гэжээ.

Багдад дахь Гэгээн Жоржийн сүмийн гишүүд дайснуудынхаа төлөө залбирдаг. Тэд исламын шашинт бэлэвсэн эмэгтэйчүүдэд хүнсний багц тараадаг. Мөн тэд Есүсийн үлгэр дуурайлыг дагахаар дуудагдсан гэдэгт итгэдэг учраас дайснаа хайрладаг.

Энэ нийтлэл чуулганы түүхэнд байсаар ирсэн үнэнийг бидэнд сануулж байна. Бурханы ажиллах арга зам үргэлж хүний арга замтай зөрчилддөг. Хүний арга зам нь Дундад зууны исламын шашинт улсуудын эсрэг аян дайн явуулсан бол, Бурханы арга зам нь исламын ертөнц рүү сайнмэдээний сүүлийн аянаа хийж, 82 насандаа нас барсан Рэймонд Луллаар дамжуулан ажилласан юм. Хятадын гүнд хүмүүс цэргийн хүчээр ажилласан бол, Бурхан сайнмэдээ тараахын төлөө амьдралаа зориулсан Хадсон

<sup>45</sup> Mindy Belz, “How Does the Church Move the World?” *World Magazine*, May 27, 2017

Тэйлороор дамжуулан ажилласан. Хүн хүчээр хийдэг, Бурхан сул доройгоор дамжуулан ажилладаг.

Бурханы арга хэзээ ч хүний арга зам байдаггүйгээс гадна, эцэстээ Бурханы арга зам л ялдаг. Христэд итгэгчид Есүстэй адил хайрладаг учраас л манай дэлхий өнө мөнхийн төлөө өөрчлөгдөж байна. Энэ өөрчлөлт удаан, өвдөлт ихтэй ч, уналтад орсон бидний дэлхийд ажиллах Бурханы арга зам ийм ажээ.

Есүстэй адил үйлчлэе гэвэл Есүстэй адил хайрлах ёстой. Сайнмэдээг тараагч нэгэн настай хүн үйлчлэлийнхээ нууцыг хуваалцахдаа “Бурхан өөрсдөд нь хэр их хайртай гэдгийг мэдэх цорын ганц зам бол **та** тэднийг хэр хайрлаж байгаагаа харуулах явдал юм” гэжээ. Энэ хүн Христийн хайр биднээр дамжуулан хэдий чинээ гэрэлтэнэ, төдий чинээ дэлхийн хүмүүс Бурхан руу ойртоно гэдгийг ойлгожээ. Үүнийг Есүсийн адил хайрлах гэнэ.

**7-р хичээлийн даалгавар**

Есүс хэрхэн хайрлаж байсныг бид энэ хичээлээр үзлээ. Энэ даалгавар танд Есүсийн адил арга замаар хөршөө хайрлахыг даалгаж байна. Даалгаврыг хийхэд их хугацаа орохгүй боловч, үүнийг хэрэгжүүлэхэд их хугацаа шаардагдана. Хэрэгжүүлэхгүй байж болохгүй шүү. Бид Есүсийн адил хайрлахаар дуудагдсан.

Есүс хүмүүсийг хэрхэн хайрлаж байгаа гурван жишээг Сайнмэдээний номуудаас ол. Тэгээд амьдралдаа хэрэгжүүлэх гурван тодорхой хэрэгжүүлэлт гарга. Та Есүсийн үлгэр дуурайлыг хэрхэн дагах вэ? Энэ даалгавар танд зориулагдсан учраас аль болох тодорхой байгаарай.

<b>Есүсийн үлгэр дуурайл</b>	<b>Миний хэрэгжүүлэлт</b>





## 8-р хичээл

### Загалмай ба Амилал

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Зовлонгийн долоо хоногийн үеэр Есүсийн үйлчлэлд өгсөн ялгаатай хариу үйлдлүүдийг ойлгох.
- (2) Инжрийн модыг хараасан нь амьд сургаалт зүйрлэл байсныг ойлгох.
- (3) Петрийг бүтэлгүйтэхэд хүргэсэн сул талыг ойлгох.
- (4) Загалмай ба амилал нь Христэд итгэгчийн амьдрал, үйлчлэлийн суурь гэдгийг үнэлж цэгнэх.

#### Үйлчлэлийн зарчим

Үр нөлөөтэй бүхий л үйлчлэл загалмай ба амиллын хүчээр хийгдсэн байдаг.

#### Танилцуулга

Зовлонгийн долоо хоног бол Сайнмэдээний номуудын оргил үйл явдал юм. Сайнмэдээний номуудын 89 бүлгээс 30-д нь Есүс Йерусалим руу сүр жавхлантай орсноос амилал хүртэлх долоо хоногийн талаар өгүүлжээ. Иохан номын бараг хагас нь энэ долоо хоногийн тухай өгүүлдэг. Энэ бол Есүсийн бүхий л амьдрал үйлчлэлийн оргил үе юм. Энэ хичээлээр Есүсийн газар дээрх сүүлийн долоо хоногийн үйлчлэлээс бид амьдрал үйлчлэлдээ хэрэгжүүлэхийн тулд суралцана.

► Хичээлийг цааш үргэлжлүүлэхийн өмнө хоёр асуултыг хэлэлц.

- Загалмайн үйл явдал нь теологи болон хувь хүний талаас надад ямар утгатай вэ?
- Амилал нь теологийн болон хувь хүний талаас надад ямар утгатай вэ?

#### Есүст үзүүлсэн хариу үйлдлүүд: Есүсийн олонд үйлчилсэн сүүлийн 7 хоног.

Сайнмэдээг тунхаглагчдын онцлон анхаардаг зүйлсийн нэг бол Есүстэй тааралдсан хүмүүсийн хариу үйлдэл юм. Жишээ нь Есүсийг төрсний дараа мэргэд Түүнийг хүндлэн мөргөж байсныг, өрсөлдөгчөө хөнөөхийг завдсан Херодын хариу үйлдэлтэй Матай номд харьцуулсан байдаг. Иохан номд рабби Никодемын хэрхэн асууж хариулж байгааг худгийн дэргэдэх боловсролгүй самари эмэгтэйтэй харьцуулсан байдаг.

► Матай 10:32-39 эшлэлийг унших.

Есүсийн өгүүлсэн сургаалын тухайд хэн ч төвийг сахих боломжгүй. Бид нэг бол зөвшөөрнө, эсвэл Түүнийг үгүйсгэнэ. Есүсийн үйлчлэл хүмүүсийг хоёр бүлэгт хуваах

илд мэт хэмээн дүрслэгдсэн байдаг. Есүст өгсөн хариу үйлдлээрээ гэр бүлүүд ч хуваагдсан бөгөөд Есүсийн өөрийнх нь гэр бүл ч сорилттой учирч байсан юм (Иохан 7:5, Марк 3:21). Тиймээс хэн ч төвийг сахин үлдэж чадахгүй.

Есүст өгсөн эсрэг тэсрэг хариунууд Түүний нийтэд үйлчлэх сүүлийн долоо хоногт улам бүр хурц болжээ. Энэ ялгаатай байдал нь загалмай хүртэл үргэлжилсэн бөгөөд хоёр дээрэмчин ч Есүст хоёр өөр байдлаар хариу өгчээ.

### **Лазарын амилалд өгсөн хариу үйлдэл**

► Иохан 11:1-57 эшлэлийг унших.

Лазарыг амилахаас ч өмнө шашны удирдагчид Есүсийг эсэргүүцэж байсан юм. Сүмийг ариусгасны баяраар Есүсийг Йерусалимын сүмд очих үеэр иудейн удирдагчид Түүнийг буруутгаж, чулуу нүүлгэхийг завдаж байсан. Гэхдээ тахил золиос болох цаг нь болоогүй байсан учраас Есүс зайлан явж, Йерусалим дахь шашны төвөөс хол Йордан голыг гатлан одсон ажээ (Иохан 10:22-42).

Лазарыг үхсэн тухай мэдээ ирэх үед дагалдагч нар нь Есүсийг Иудей руу буцах аюултай боллоо гэж мэджээ. Уншигчид үргэлж Томасын эргэлзээ, гутранги үзлийг элэглэдэг. Гэхдээ тэр Багшдаа үнэнч хүн байсан юм. Тэрээр Есүсийг Иудейд алагдана гэдгийг (зөв) тааварлаж байсан ч үнэнч үлджээ. Тиймээс Есүсийг Иудей рүү буцах гэж зүтгэхэд Томас бусад дагалдагч нарт “Цөмөөрөө бас явцгаая. Тэгээд Түүнтэй хамт үхье гэж хэлэв” гэж хэлж байсан юм (Иохан 11:16). Хожим нь эргэлзсэн удаа байсан ч, энэ айдастай дагалдагч үнэнч хэвээрээ үлдсэнийг бид мартаж болохгүй. Томас Энэтхэг рүү сайнмэдээ тарааж яваад амиа алдсанд гайхах зүйлгүй биш үү?

Бетан шиг жижигхэн тосгонд Лазарыг амилуулсныг нуух аргагүй. Шашны удирдагчдад ч ийм хурц үйл явдлыг нуух боломжгүй байв. Энэ гайхамшигт үйл явдлын тухайд хүмүүс янз бүрийн хариу үзүүлж байсныг Иохан номд дурдсан байдаг.

### **Олон түмний хариу үйлдэл**

Лазарыг амилуулсан тухай мэдээ тархахад ард олон Есүсийг Йерусалимд Ромын ноёрхлыг унагааж, Давидын сэнтийг байгуулна гэж итгэжээ. Тэд Есүсийг амлагдсан Мессиа гэж итгэж байв. “Мариагийнд ирсэн иудейчүүд дундаас олон хүн Есүсийн үйлдсэнийг хараад Түүнд итгэжээ” (Иохан 11:45 and 12:11). Есүсийг асар олон хүн дагаж байсан учраас фарисайчууд “Харцгаа, Түүний араас ертөнц даяараа дагалаа” гэж хэлж байсан (Иохан 12:19). Үүнээс болоод Есүсийг илжиг унан Йерусалимд орж ирэхэд цугласан олон маш их урам зоригтой байжээ.

### **Шашны удирдагчдын хариу үйлдэл**

Лазарын амиллаас болоод шашны удирдагчдын хувьд өөрийгөө Мессиа гэж мэдэгдсэн Есүсийн үгийг үл тоомсорлох боломжгүй болжээ. Олон түмэн Есүс рүү ханарах үед шашны удирдагчдад хоёр л сонголт байв.

- 1. Есүс өөрийгөө хэн гэж байгааг хүлээн зөвшөөрөх.** Гэхдээ ингэвэл тэд эрх мэдлийн төлөөх хүслээ орхих шаардлагатай. Есүс тэдний хоёр нүүрт байдлыг аль хэдийн буруушаасан учраас хэрэв тэд Есүсийг Мессиа гэж хүлээн зөвшөөрвөл иудейчүүдийг удирдах шашны эрхээ алдах байв.
- 2. Есүсийг барьж, хөнөөх.** Хэрэв тэд Есүсийг Мессиа гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан бол Түүнийг хөнөөх ёстой.

Шашны удирдагчид Есүсийг хөнөөх шийдвэрээ үндэстнийхээ төлөө гэж зөвтгөж байлаа. Түүхэнд байсан сул дорой удирдагчид шиг тэд шийдвэртээ “Юу хийх вэ? Энэ хүн олон тэмдэг үйлдэж байна. Хэрэв бид Түүнийг ингээд орхивол бүх хүн Түүнд итгэнэ. Тэгвэл ромчууд ирж, манай газар болон үндэстнийг маань сүйтгэнэ” хэмээн шалтаглажээ (Иохан 11:47-48). Тэд Есүсийг Ромын эсрэг хувьсгал хийнэ хэмээн айж байв. Түүний хаанчлал сүнслэг гэдгийг тэд ойлгоогүй юм.

“Манай газар” гэсэн нь Йерусалимын сүм, “үндэстнийг маань” гэсэн нь Ромоос иудейчүүдэд олгосон эрх чөлөөг хэлсэн бололтой (Үйлс 6:13, Үйлс 21:28-г үз). Хэдийгээр Иудей Ромын мэдэлд байсан ч иудейчүүд сүмдээ мөргөл үйлдэх, шашны хуулийг дагаж мөрдөх, мөн Санхедринаараа дамжуулан зарим иргэний хэргийг шийдвэрлэх засаглалтай байхыг зөвшөөрдөг байв. Хэрэв Ром бослогыг дарвал энэ бүхэн алга болно.

Түүнчлэн Каиаф Санхедрин зөвлөлд бүх үндэстнээрээ зовсноос нэг хүн үхэх нь дээр хэмээн итгүүлсэн юм (Иохан 11:49-50). Егөөтэй нь, Есүсийг хөнөөсний дараа Санхедрины айдас биелжээ. Есүсийн үхлээс 40 жилийн дараа ромчууд иудейн шашны сүмийг сүйтгэж, иудейчүүдийн эрхийг булаан авснаар Каиафын сэргийлэх гэж оролдсон бүхнийг бодит болгожээ.

Тэд Есүсийн үйлдсэн гайхамшгуудын нотолгоог нууж чадахгүй учраас Санхедрин зөвлөл үндэстнээ хамгаалахын төлөө Есүс Лазар хоёрыг хөнөөхөөр шийдсэн байна (Иохан 11:53, Иохан 12:10). Гайхамшгаар үл итгэгчдийг итгүүлэх албагүй. Бид ихэвчлэн “Хэрэв Бурхан өөрийгөө гайхамшгаар баталсан бол бүгд итгэх байсан” гэж боддог. Гэхдээ гайхамшиг нь эргэлздэг хүмүүсийг үл итгэх байдалд нь хатууруулж болно.

Баян эр Лазар хоёрын тухай (амилсан Лазар биш) түүхэнд баян эр Абрахамаас Лазарыг өөр рүү нь явуулахыг гуйхад Абрахам “Хэрэв тэд Мосе ба Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ” (Лук 16:31) гэж хариулсан байдаг. Бичвэр өөрөө үнэнийг хангалттай гэрчилдэг. Хэрэв бид Бичвэрээс татгалзвал бусад нотолгоо биднийг итгүүлж чадахгүй.

## **Есүст үзүүлсэн хариу үйлдэл: Мариа**

► Матай 26:6-13 ба Иохан 12:1-11 эшлэлийг унших.

Есүсийг газар дээрх үйлчлэлийнх нь туршид дагалдсан хайртай дагалдагчдын нэг нь Лазар, Марта хоёрын дүү Мариа байв. Өмнө нь Мариаг Есүсийн хөлд суугаад сургаал сонсож байхад Марта зочлох ажлаасаа болж гомдоллосон удаатай. Тэгэхэд Есүс “Өөрөөс нь булаагдашгүй сайныг сонгон авчээ” хэмээн Мариаг магтсан юм (Лук 10:42).

Үхэхээсээ долоо хүрэхгүй хоногийн өмнө Есүс дагалдагч нартайгаа уяман өвчтэй байсан Симоны гэрт очжээ. Лазар ба дүү охид нь энэ бүлэгт уригджээ. Хоолны үеэр Мариа Есүсийн толгой, хөл дээр үнэтэй тос асгав. Энэ тос нь гурван зуун денар буюу нэг жилийн цалинтай тэнцэх үнэтэй эд байв. Банк гэж байхгүй цаг үед тэр нь Мариагийн хадгаламж байсан болов уу.

Дагалдагчид мөнгө дэмий үрлээ хэмээн Мариад уурласан боловч (Матай 26:8, Марк 14:5), Мариа зөвхөн Есүсийн санаа бодлыг л анхаарч байлаа. Мариа бусдын санаа бодлыг үл хайхран, хайраар ийн үйлджээ. Түүнд тос ямар үнэтэй, хүмүүс юу гэж бодох нь хамаагүй байв. Тэрээр Эзэнийгээ мөргөн хүндэтгэж байсан бөгөөд юу ч хамаагүй байлаа.

Дагалдагчид Мариагийн үйлдлийг эсэргүүцэхэд, Есүс тэднийг зэмлэж, “Түүнийг орхи ... Энэ эмэгтэй Надад сайныг үйлдэв” (Марк 14:6) гэжээ. Загалмай үхэл хэдхэн хоногийн дараа байгааг мэдэж байсан Есүс Мариагийн энэ үйлдлийг бэлгэдэл хэмээн үзэж, “Энэ эмэгтэй... Намайг оршуулгад минь бэлтгэв” (Матай 26:12) гэсэн юм. Тэрээр өөрийгөө умартан хамгийн сайнаа өргөж, хүндэтгэн мөргөж буй тэр эмэгтэйг хүндэлжээ.

Мариа ийнхүү Есүсийг тосолсон тухай бид уншихдаа “Би Есүст хэр их хайртай вэ? Би Түүнийг илүү анхаардаг уу, хажуугийн хүмүүсийн санаа бодлыг илүү анхаардаг уу?” хэмээн өөрсдөөсөө асуух учиртай. Мариа Есүст үнэхээр хайртай байсан.

## **Есүст үзүүлсэн хариу үйлдэл: Сүр жавхлантай ирэлт**

► Матай 21:1-11 ба Иохан 12:12-19 эшлэлийг унших.

Ням гарагт Есүс илжиг унасаар Йерусалим хотод орж иржээ. Энгийн өдөр бол үүнд ямар нэг онцгой зүйл байхгүй. Галилын нэг багш цөөн хэдэн дагалдагчаа дагуулаад Йерусалим хотод Алгасал баяр тэмдэглэхээр орж ирж байгаа төдий. Гэвч энэ удаагийн ирэлт ердийн бус байв. Лазарыг амилуулсан үйл явдал нь тухайн Алгасал баярын мөргөлийг шашин, улс төрийн мэдэгдэл болгон өөрчилсөн хэрэг.

Матай номд Есүсийн ийнхүү Йерусалимд орж ирсэн үйл явдлыг шашны талаас онцлон харуулсан. Матай үүгээр Есүсийн сүр жавхлантай ирэлт нь Зехариагийн эш үзүүллэгийн биелэл хэмээн харуулжээ. Хурсан олны үг нь Дуулал 118, Алгасал баярын Дуулалаас авсан бөгөөд Йерусалимд сүр жавхлантай орж ирж буй тухай дүрсэлсэн байдаг (Матай 21:4-11, Зехариа 9:9, Дуулал 118:26).

Энэхүү цуваа улс төрийн далд утгаар дүүрэн байв.

- Хаанд захирагдахаа илэрхийлэн олон түмэн зам дээр хувцсаа дэлгэн тавьжээ (Матай 21:8, 2 Хаад 9:13).
- Маккабигийн үеэс дал модны мөчир нь дайснаа ялахын бэлгэдэл болж байв (Иохан 12:13, 1 Маккаби 13:51).
- “Хосанна!” нь “биднийг авраач” хэмээн аврал гүйсан үг юм.
- “Давидын Хүүд” хаан удмын Мессиаг дуудах нэр өргөмжлөл байжээ.

Хүмүүс Есүсийг Ромын дарлалыг устгаж, хаанчлалаа байгуулахаар Йерусалимд орж ирлээ гэж итгэж байв. Давидын удмын хааныг хүлээсэн удаан хугацааны хүлээлт дууслаа. Эш үзүүлэгчдийн амласан амлалтууд удахгүй биелэхээр болов.

Эдгээр хашхирч байсан хүмүүсийн дундаас олон хүн хэдхэн хоногийн дараа “Түүнийг цовдол!” хэмээн хашхирсан юм. Яагаад? Яагаад гэвэл тэд Есүсийг буруу шалтгаанаар дэмжиж байсан хэрэг. Тэд Есүсийг Ромыг түлхэн унагана гэж итгэж байсан, гэтэл Түүнд цэргийн бослого удирдах бодол байсангүй. Хүмүүс улс төрийн хаанчлалыг хүсэж байхад, харин Есүс сүнслэг хаанчлалыг авчирчээ. Урам нь хугарсан олон түмэн тун удалгүй Есүсийн эсрэг эргэсэн юм.

Улс төрийн хувьд хүчирхэг, нийгмийн элит гишүүдээс бүрдсэн Санхедрин зөвлөлийнхөн Есүсийг хөнөөхөөр хэдийн шийдсэн байв. Хүчгүйчүүд ч тун удалгүй Түүний эсрэг эргэх болно. Өмнө нь юу хүлээж байгааг мэдэж байсан тул Есүс өөрийг нь үгүйсгэх тэр хотын хувь заяаны төлөө уйлсан юм (Лук 19:41-44). Есүс сүр жавхлантайгаар Йерусалимд орж ирсэн нь улмаар загалмай руу хөтөлнө гэдгийг мэдэж байсан. Хурсан олон Дуулал 118:26-г эш татан “ЭЗЭНий нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ!” гэж хашхирч байсан ч Есүс тэрхүү дууллын дараах мөр болох “Тахилын ширээний эврэнд тахилыг уяагаар холбогтун” гэсэн байдгийг мэдэж байлаа (Дуулал 118:27). Есүс удалгүй тахилын ширээнд холбогдож, Ромын загалмай дээр тахил золиос болохоор Йерусалим хотод орж иржээ.

### **Сайтар ажиглах нь: Есүс инжрийн модыг хараасан нь**

► Марк 11:12-25 эшлэлийг унших.

Синоптик Сайнмэдээний номууд тус бүрд Есүс олон түмэнд үйлчлэх сүүлийн долоо хоногтоо үржил шимгүй инжрийн модыг харааж байсан түүхийг багтаасан байдаг. Есүс Бетанд хоносны дараа Даваа гарагт Йерусалим руу ирж явахдаа тэр инжрийн модыг хараасан юм. Ердөө 24 цагийн дотор мод хатсан байхыг Мягмар гарагт дагалдагчид харжээ.

Хэдийгээр инжрийн цаг болоогүй (Марк 11:13) байсан ч, навч байгаа л бол ногоон инжир байх ёстой гэсэн үг. Инжрийн модны жимс нь навч гарсны дараа богино

хугацаанд ургадаг. Тиймээс инжрийн модонд эрт ургацын инжир гараагүй бол тэр мод тэр жилдээ үр жимсээ өгдөггүй байжээ.

Энэ түүх бол үр жимс ургуулах Израилын тухай амьд сургаалт зүйрлэл юм.<sup>46</sup> Израил бол Бурханы ерөөхөөр сонгосон үндэстэн (Эхлэл 12:3).

Гэтэл Израил ИАВЭгийн нэрд ичгүүр авчирчээ. Йерусалимын сүм бол бүх үндэстний залбирлын гэр болох ёстой байв (Исаиа 56:7). Гэтэл энэ сүмд хүчирхэг тахилчид ядуу хүмүүсийг хуурч мөлждөг дээрэмчдийн үүр болжээ. Инжрийн мод үр жимсгүй, Израил ч бас үр жимсгүй болжээ. Инжрийн мод гологдсон, Израил ч удалгүй гологдох болно.

Есүс олны дунд үйлчлэх сүүлийн долоо хоногийнхоо үеэр шүүлтийн тухай ярьсан цуврал сургаалын нэг нь харагдсан инжрийн мод юм.

1. Жимсгүй инжрийн модны тухай сургаалт зүйрлэл (Марк 11:12-14, 20-25).
2. Сүмийг цэвэрлэсэн нь (Марк 11:15-19).
3. Итгэмжгүй түрээслэгчдийн тухай сургаалт зүйрлэл (Марк 12:1-12).
4. Шашны удирдагчидтай маргалдсан нь (Марк 12:13-40).
5. Есүс сүмийн сүйрлийг зөгнөсөн нь (Марк 13:1-37).

**Есүст үзүүлсэн хариу: Есүсийн олонд үйлчилсэн сүүлийн долоо хоног (Үргэлжлэл)**

**Есүст үзүүлсэн хариу: Шашны удирдагчид**

► Матай 21:23-22:46 эшлэлийг унших.

Лазарыг амилуулсны дараа шашны удирдагчид Есүсийг алахаар шийдсэн. Гэхдээ Есүс энгийн ардуудын дунд нэр хүндтэй учраас үүнийг хийх хэцүү байв. Тэд олны нүдэн дээр Есүсийг гутаах ямар нэг арга хайж байлаа. Тэгээд Есүсийг Йерусалимд сүр жавхлантай ирсэн өдөр шашны удирдагчид сүмд хэд хэдэн сөргөлдөөн зохион байгуулжээ. Тэд Есүсийг урхинд оруулах гэж оролдсон хэдий ч, дахин дахин бүтэлгүйтсээр байв. Харин Есүс мэргэн ухаанаараа олны өмнө шашны удирдагчдыг ичгүүрт оруулж байсан.

Эхлээд ахлах тахилчид ба ахлагчид Есүсээс сүмийг цэвэрлэж, тэнд сургаал заах ямар эрхтэйг шалгаажээ. Есүс тэднийг баптисч Иоханы тухай асуултаар таг болгов.

Есүс тэгээд шашны удирдагчдыг буруушаасан гурван сургаалт зүйрлэл ярьсан. Хоёр хүүгийн тухай сургаалт зүйрлэл нь шүтлэг биш, дуулгавартай байдал л Бурханы хаанчлалын харилцааг баталгаажуулна гэдгийг харуулдаг. Харин хорон муу түрээслэгчдийн тухай сургаалт зүйрлэл нь Есүсийн Мессиа гэдгийг үгүйсгэх нь ямар үр дагавартай болохыг харуулдаг. Сүүлийнх нь найранд уригдсан шашны удирдагчид

---

<sup>46</sup> Хуучин гэрээнд инжрийн модоор Израилыг төлөөлүүлдэг (жишээ нь: Иеремиа 8:13, Хосеа 9:10, Иоел 1:7).

гологдож, оронд нь найрын урилгад хариу өгсөн дорд хүмүүс таалал хүртэх тухай өгүүлсэн найрын тухай сургаалт зүйрлэл.

Есүсийг гутаахаар шийдсэн шашны удирдагчид Түүнийг урхинд оруулах гэж хэд хэдэн асуулт асуужээ. Тэд үнэнийг суралцах зорилгогүй, харин Есүсийг сүйрүүлэх л зорилготой байв. Тэдний үнэнийг хүсдэггүй байдлыг Есүс мэдэж байсан учраас асуултад нь шууд хариулаагүй юм.

Есүсийг үгээр нь унагах гээд чадаагүй тул шашны удирдагчид бууж өгөв. Матай энэ хэсэгт тэднийг ялагдлыг “Хэн ч хариуд нь Түүнд үг хэлж чадаагүй бөгөөд тэр өдрөөс хойш нэг ч хүн Түүнээс юм асууж зүрхэлсэнгүй” хэмээн илэрхийлсэн байна (Матай 22:46). Марк эдгээр сөргөлдөөнийг харсан энгийн хүмүүсийн баяр хөөрийг дурдаж, “Хурсан олон Түүнийг дуртайяа сонсож байв” гэсэн байдаг (Марк 12:37).

► Пастор эсвэл Христэд итгэгч удирдагчийн хувьд та хэцүү асуултуудтай байнга тулгарах болно. Та чин сэтгэлийн асуулт болон таныг урхинд оруулах асуулт хоёрыг яаж ялгах вэ? Ийм хоёр янзын асуултад өгөх хариу чинь юугаараа ялгаатай байх вэ? (Ийм ялгаа бүхий жишээг Сургаалт үгс 26:4-5-с үз)

## **Шүүлт ба цовдлол**

► 1 Коринт 15:1-8 эшлэлийг унших.

Есүсийг дээш өргөгдсөнөөс хойш 20 жилийн дараа Паул Коринт хотод чуулган тарьжээ. Энэ чуулган янз бүрийн нөхцлөөс итгэсэн хүмүүсээс бүрдсэн байв. Энэ чуулганд иудей Бичвэрийг мэддэг иудейчүүд болон Бурханы тухай юу ч мэдэхгүй харь үндэстнүүд ч нэгдсэн байлаа.

Коринт чуулган хагаралд автаж, бас хуурамч сургаалын заналхийлэлд орж байсан. Эдгээр асуудалд Паул хариулахдаа анх номлосон сургаалаа сануулсан юм. Харь шүтлэг өргөн тархсан хотод хандсан Паулын анхны сургаал нь дөрвөн түүхэн үйл явдал дээр төвлөрч байсан.

- Христ бидний нүглийн учир үхсэн,
- оршуулагдан,
- гурав дахь өдөртөө амилуулагдсан.
- Тэр олны өмнө эхлээд Кеф, 12 дагалдагч нарт, улмаар 500 ахан дүүст нэг мөчид үзэгдсэн бол Иаков, бүх элч нарт, эцэст нь Паулд үзэгджээ.

Коринтчуудад бичсэн Паулын эхний үг нь загалмайн тухай “Христ бидний нүглийн учир үхсэн” гэсэн үг байв. Загалмайн тухай мэдээ бол Христэд итгэл үнэмшлийн гол цөм юм.

Хуучин гэрээнд тахилын хонь авчирсан хүн гараа хонины толгой дээр тавьж, тахилын малын үхэлтэй холбогддог байжээ. Мөргөн хүндлэгч нь тахилын толгой дээр гараа тавьснаар “Энэ мал миний өмнөөс үхэж байна. Би нүглийнхээ оронд үхэх ёстой байсан” гэсэн утгыг илтгэдэг байж. Үүний нэгэн адилаар бид нүглийнхээ төлөөсөнд үхэх ёстой

байсан ч, Христ бидний оронд үхсэн юм. Бид үхвэл зохих байсан ч, Тэр үхсэн учраас бид амьд үлдэх болсон.

### **Христ зовсон шалтгаан**

Тэр ташуурдуулсан уу?

Тэр ташуурын ормоор биднийг эдгээхийн тулд тэгсэн юм.

Тэр буруугүй атлаа буруутгагдсан уу?

Гэм буруутай биднийг цагаатгахын тулд тэгсэн юм.

Тэр өргөст титэм өмссөн үү?

Бидэнд алдрын титэм өмсгөхийн тулд тэгсэн юм.

Тэр хувцсаа тайлсан уу?

Биднийг мөнхийн зөвт байдлын хувцсаар хувцаслахын тулд тэгсэн юм.

Тэр шоолуулж, доромжлуулсан уу?

Биднийг хүндэтгэж, ерөөхийн тулд тэгсэн юм.

Тэр хэрэгтэн мэт тооцогдож, гэмтнүүдийн дунд тоологдсон уу?

Биднийг гэмгүйд тооцож, хамаг нүглээс маань хэлтрүүлэхийн тулд тэгсэн юм.

Тэр өөрийгөө аврах боломжгүй гэж зарласан уу?

Тэр эцэстээ бусдыг аврахын тулд тэгсэн юм.

Тэр эцэстээ хамгийн шаналантай, гутамшигтай үхлээр үхсэн үү?

Эцэстээ биднийг мөнх амьдруулж, өндөрт өргөмжлөхийн тулд тэгсэн юм.”

- Жон Чарльз Райл<sup>47</sup>

### **Шүүлт ба цовдлол (үргэлжлэл)**

#### **Баривчилгаа**

► Матай 26:1-5, 14-56 эшлэлийг унших.

Зовлонгийн долоо хоногийн Лхагва гарагт Есүс хоёр өдрийн дараа үхнэ гэдгээ эш үзүүлжээ. Санхедрин зөвлөлийнхөн Алгасал баярын дараа хүмүүс хотыг орхин явсан хойгуур Есүсийг баривчлахаар төлөвлөсөн нь энэ эш үзүүллэгээс даруй 9 хоногийн өмнө байв. Гэхдээ Иудас Эзэнээсээ урвахыг зөвшөөрсөн тул тэд Есүсийг дагалдагчдын нэгийнх нь тусламжтайгаар баривчлахаар болсон юм.

---

<sup>47</sup> J.C. Ryle, *Expository Thoughts on the Gospel of Matthew: A Commentary*, Updated ed. (Abbotsford, WI: Aneko Press, 2020), 331



Ахлах тахилчдад яагаад Иудас хэрэг болов? Тэд Есүсийг олон түмнээс хол байхад нь баривчлах хэрэгтэй байсан. Есүс олны дунд нэр хүндтэй байсан учраас хэрэв Түүнийг олны өмнө баривчилбал үймээн гарах нь тодорхой байв.

“Есүс хүмүүний зовлонгоосоо ангижрахын тулд бурхан чанараа ашиглаагүй, харин залбирч хүч чадлыг олж байсан.”

- Т.В Килпатрикаас авав.

Есүс дагалдагч нартайгаа Алгасал баярын зоог барьсны дараа залбирахаар Гетсемани цэцэрлэг рүү явсан. Загалмай дээр тарчлах биеийн зовлон, Эцэг Бурханаас тусгаарлагдах сүнслэг шаналантай тулгарсан Есүс “Эцэг минь, болж өгвөл Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог гэж залбирлаа” (Матай 26:39). Есүс ийм туйлын хүнд сорилтын өмнө ч Эцэгийн хүсэлд захирагдсан юм.

Тэр үдэш Иудас бөөн хүн дагуулан Есүсийг баривчлахаар ирэв.<sup>48</sup> Тэрээр Есүсийг үнсэлтээрээ зааж өгөхөд Есүс цэргүүдэд хандан ингэж хэлжээ. “Есүсийг тэдэнд “Тэр чинь Би байгаа юм” гэхэд тэд ухарч газар унацгаав” (Иохан 18:6). Энэ бүлэг цэрэг үхлийн хүчийг атгасан хүнээс айж байлаа. Дайснууд нь биш, харин Есүс нөхцөл байдлыг удирджээ. 19-р зууны номлогч Октав Винслов “Есүсийг хэн үхэлд тушаасан бэ? Мөнгөнд шунасан Иудас биш, айдаст хөтлөгдсөн Пилат биш, атаархсан иудейчүүд ч биш. Харин хайрынхаа төлөө Эцэг Бурхан тушаасан!”<sup>49</sup> гэсэн байдаг.

## ШҮҮЛТ

► Матай 26:57-27:26, Лук 22:54-23:25, Иохан 18:12-19:16 эшлэлийг унших.

Есүсийг шүүх хэрэг явдалд Иудейн шүүх болон Ромын шүүх хоёулаа оролцжээ. Иудейн хууль нь эртний эрх зүйн тогтолцооны дундах хамгийн хүмүүнлэг хууль байсан. Иудейн хууль амийг хамгаалахын төлөө боломжтой бүхнийг хийдэг хууль байв. Ромын хууль харин чанд хатуу, цогц байдлаараа алдартай байлаа. Эдгээр хуулиуд эрт үеийн дэлхийн хамгийн шилдэг хууль эрх зүйн тогтолцоо байсан боловч, нүгэлтнүүд Бурханы Хүүг хөнөөх явдлаас хамгаалж чадаагүй юм.

Есүсийг баривчилснаас хойших хэдэн цагийн туршид зургаан удаа шүүхийн сонсгол хийжээ. Үүнд иудейн шашны шүүх, Ромын шүүх багтаж байв. Иудейн хуулийн дагуу бол Есүсийг шүүсэн иудейчүүдийн шүүх нь хууль бус байсан гэж түүхчид үздэг. Есүсийг буруутгах гэж яарсандаа Санхедрин зөвлөлийнхөн дараах алхмуудыг хийсэн.

- Шөнө шүүх ажиллагаа явуулсан (хууль бус)
- Есүсийг баривчлахаас өмнө албан ёсоор буруутгаагүй (хууль бус)
- Есүсийг өмгөөлөх гэрч нарыг дуудаагүй (хууль бус)
- Иудейн хуулинд зааснаас илүү хурдан яаралтай шүүх хурал хийсэн (хууль бус)

<sup>48</sup> Иохан 18:3 энэ хэсэг цэргийг “баг” буюу “бүлэг” цэрэг гэж тодорхойлжээ. Ромын цэргийн бүлэг ихэвчлэн 600 хүнээс бүрддэг байв.

<sup>49</sup> John Stott, *The Message of Romans* (Westmont, Illinois: InterVarsity Press, 1994), 255-с эш татав.

Егөөтэй нь, тэд Алгасал баяраас өмнө Есүсийг цовдолж, баяраас өмнө биеийг нь зайлуулахын тулд энэ бүхэн тохиолдсон юм. Тэд Алгасан баярын хургыг зохих ёсоор нь идэх гээд Бурханы Хургыг алжээ!

### ***Шүүх ажиллагааны явц***

#### **(1) Аннасын өмнөх иудейн шүүх хурал (Иохан 18:12-14, 19-23)**

Аннас насан туршдаа тэргүүн тахилч байжээ. Ромчууд Аннасыг хүргэн Кайафаар нь сольсны дараа ч ихэнх иудейчүүд Аннасыг “тэргүүн тахилч” гэх цолоор нь дууддаг байв. Тиймээс Аннасын өмнөх сонсгол нь албан бус бөгөөд ямар нэг ял тулгаагүй, гэрч оролцоогүй юм.

#### **(2) Санхедрин зөвлөлийн өмнөх иудейн шүүх хурал (Матай 26:57-68)**

Санхедрин зөвлөлийн бүрэн бүрэлдэхүүний өмнөх анхны шүүх хурал өглөөний 02:00 цагт болсон бололтой. Тэд албан ёсны шүүх хурлыг нар мандахаас өмнө хийж чадахгүй байсан хэдий ч, иудейн удирдагчид илүү хурдан явуулахыг хүсэж байв. Шөнийн шүүх хурал албан бус байсан ч, Санхедрин зөвлөлийнхөн албан бус шүүх сонсгол явуулж, Бурханыг доромжилсон хэргээр Есүсийг яллаж, үхэх ял оногдуулах ёстой хэмээн үзсэн байна.

#### **(3) Санхедрин зөвлөлийн өмнөх албан ёсны шүүх хурал (Лук 22:66-71)**

Өглөө болоход зөвлөлийнхөн албан ёсны шүүх хурал хийв. Энэ хурал дээр тэд Есүсийг Бурханыг доромжилсон хэмээн албан ёсоор буруутгажээ.

#### **(4) Пилатын өмнөх Ромын эхний шүүх хурал (Лук 23:1-5, Иохан 18:28-38)**

Ромчууд Санхедрин зөвлөлд гэмт хэрэгтнүүдийг цаазаар авах эрх олгодоггүй байв (Иохан 18:31). Тэд цаазын ялыг Пилатаар гаргуулах гэсэндээ Бурханыг доромжилсон хэмээн Есүсийг буруутгаж байснаа, улс төрийн бослогын ял болгон өөрчилжээ. Тиймээс Есүсийг “манай үндэстнийг төөрөгдүүлэн, Цезарьт татвар төлөхийг хорьж, Өөрийгөө Христ, Хаан гэж байхыг нь бид харсан гэсэнд” (Лук 23:2) хэмээн буруутгасан юм.

Алгасал баярын өдрүүдэд иудейчүүд бузартвал баярын зоогийг идэж чадахгүй болдог учраас үүнээс зайлсхийж, Ромын ямар нэг байшинд ордоггүй байжээ. Тэд ордонд орохгүй учраас Пилат ордны хаалганы гадаа зам дээр шүүхийн сонсголыг явуулсан юм.

#### **(5) Херод Антипасын өмнөх Ромын шүүх хурал (Лук 23:6-12)**

Есүсийг гэмгүй гэдгийг Пилат мэдэж байв. Гэхдээ иудей удирдагчдын уурыг хүргэхийг хүссэнгүй. Пилат Есүсийн тухайд “Галилаас эхлэн энэ газрыг хүртэл, Иудейн бүх нутгаар сургаалаа заан ард олныг өдөөн хатгаж байна гэж шаардангуй” хэлэхийг сонсоод (Лук 23:5) энэхүү хүнд байдлаас зайлсхийхээр шийджээ. Алгасал баярын

долоо хоногийн үеэр Галилын захирагч Херод Антипас Йерусалимд ирсэн байв.<sup>50</sup> Есүс Галилаас гаралтай тул Пилат энэ хэргийг Херодоор шүүлгэхийг хүсжээ. Тэгээд Пилат Есүсийг Херод руу явуулсан боловч Херод энэ хэрэгт оролцохыг хүссэнгүй.

### **(6) Пилатын өмнөх сүүлчийн шүүх хурал (Матай 27:15-26, Лук 23:13-25, Иохан 18:39-19:16)**

Есүсийг буцаагаад авчрах үед Пилат өөр шийдэл хайж байлаа. Тэрээр Есүсийг гэмгүй гэдгийг мэдэж байсан тул “та нарын өмнө Түүнийг байцаагаад, Түүний эсрэг та нарын мэдүүлээд байгаа гэм бурууг энэ хүнээс би ер олсонгүй” гэжээ (Лук 23:14). Пилат гэмгүй Есүсийг яллахыг хүсээгүй юм.

Иудейн удирдагчид Пилатыг үнэнч бус байсан гэж Цезарьт мэдэгдэнэ хэмээн заналхийлсэн учраас Пилат тэдний шаардлагад бууж өгөв. Пилат сул дорой удирдагч байсан. Өмнө нь Пилат цэргүүдэд эзэн хааны дүрсийг бариулан Йерусалим руу оруулж, үүнээс болоод үймээн гарахад хүрч байв. Иудейчүүд Пилатын ордны гадаа 5 хоног хуран цуглаж эсэргүүцэл илэрхийлжээ. Пилат жагсагчдыг ална гэж заналхийлэхэд жагсагчид ариун хотод Цезарийн дүрсийг залснаас үхсэн дээр хэмээн зарласан аж. Тиймээс Пилат ухрахаас өөр аргагүй болж байжээ.

Ийм явдал тохиолдож байсан учраас Пилат иудейчүүдээс айж байлаа. Ялангуяа Ром дахь дээд захирагч Сежанус нь Иудейг захирах Пилатын чадварт итгэхгүй байв. Тиймээс хэрэв Есүсийг суллавал Цезарьт гомдол гаргана гэсэн иудейн удирдагчдын заналхийллээс болоод Пилат тэдэнд Түүнийг цовдлуулахаар өгчээ (Иохан 19:16). Пилат Есүсийг гэмтэй гэдэгт итгэсэндээ үхэх ял оноогоогүй, харин өөрийнхөө сул дорой байдлаас болж ийнхүү зөвшөөрчээ.

### ***Шүүх хурал болох зуур Петр Есүсийг үгүйсгэв.***

Алгасал баярын зоогийн үеэр Есүс Петрт “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Тахиа донгодохоос өмнө чи Намайг гурвантаа үгүйсгэх болно” гэж хэлж байсан (Иохан 13:38). Ингээд Есүсийг шүүгдэж байх үед Петр Есүсээс гурвантаа урважээ.

Петрийн ичгүүртэй уналтын тухай уншиж байхдаа бид Петрийг тэр шөнө урвасан цорын ганц хүн биш гэдгийг санах хэрэгтэй. Зөвхөн Петр Иохан хоёр л шүүх хурлын дэргэд байсан. Харин бусад дагалдагчид айсандаа зугтаасан шүү дээ.

Петр Есүст хайртай байсан нь тодорхой. Тэгвэл Петр яагаад унав? Бид өмнөх бүлгээр Есүсийн сорилтын талаар болон сорилтын үед яах ёстой талаар суралцсан. Харин Петрийн уналтаас сорилт тулгарах үед бидэнд тус болох сэрэмжлүүлгийг харж болно. Петрийн уналтад нөлөөлсөн багадаа хоёр шинж байсныг харж болно.

---

<sup>50</sup> Алгасалын долоо хоногийн үеэр Ромын эрх баригчид бослого гарахад бэлэн байх үүднээс Палестинд ирдэг байжээ.

## **(1) Хэт өөртөө итгэлтэй байх**

Сатаны дайралтыг Есүс сэрэмжлүүлэх үед Петр “Би Тантай хамт үхэх ёстой болсон ч Таныг үгүйсгэхгүй” гэж бардамнажээ (Матай 26:35). Бид өөртөө хэт итгэлтэй байх үедээ унаж бүдэрдэг. Бид зөвхөн Сүнсний хүчээр л ялалттай итгэгчийн амьдралаар амьдардаг. Хэт их итгэлтэй байх нь сүнслэг уналтын эхний алхам юм.

## **(2) Залбиралгүй байх**

Гетсемани цэцэрлэгт байхдаа Есүс дагалдагч нартаа “Та нар уруу татагдахгүйн тулд залбирцгаа” гэж сануулсан (Лук 22:40). Айсуй сорилттой тулгарах хүч чадлын төлөө залбирахын оронд Петр унтаж байсан.

Залбиралгүй байх нь сүнслэг талаар уналтад ороход нөлөөлдөг. Идэвхитэй залбиралгүйгээр ялалттай итгэгчийн амьдралаар амьдрах боломжгүй. Сатан Христэд итгэгч ажилчдыг залбирах цаггүй болтол нь олон үйл ажиллагаанд татан оролцуулахыг оролддог. Хэрэв бид залбирах завгүй явах юм бол тун удахгүй унах болно гэдгийг Тэр мэднэ.

► Өөрийнхөө христитгэлийн амьдрал, үйлчлэлийг эргээд хараарай. Сорилтод орж байсан талбар, унахад ойрхон очсон үеэ бодоорой. Уналтад ороход ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ? Хэт итгэлтэй болоход хүргэсэн үйлчлэлийн ямар нэг амжилт танд байсан уу? Залбиралд хангалттай цаг зарцуулаагүйгээс уналтад хүргэсэн тун завгүй үе танд байсан уу? Ирээдүйд анхааруулга болох өөр хүчин зүйлс байв уу?

## ***Шүүлтийн үеэр Иудас амиа хорлов.***

Матай Петрийн үгүйсгэлийн тухай өгүүлээд залгуулаад Иудасын амиа хорлолтын тухай хэлдэг. Иудас урвалтаа хараад бодлоо өөрчилж, 30 мөнгөн зоосыг ахлах тахилч, ахлагчдад аваачиж өгөөд “Би гэм зэмгүй цуснаас урваснаараа нүгэл үйлдлээ” (Матай 27:3-4) гэсэн. Иудас урвасныхаа хөлсөнд авсан мөнгөө шидээд, явж өөрийгөө дүүжилжээ (Матай 27:5). Иудас насан туршдаа гэм буруу үүрч явснаас амиа хорлохыг илүүд үзсэн аж.

Матай номд Петрийн гэмшил, Иудасын харуусал хоёрыг зэрэгцүүлэн харуулсан байдаг. Петр Иудас хоёр хоёулаа хийсэн зүйлдээ гэмшиж байсан. Гэхдээ Матай Иудасын тухай өгүүлэхдээ гэмшлийг илэрхийлдэг жирийн үг биш, харин бодлоо өөрчилснийг илэрхийлдэг үгийг ашигласан байна. Энэ ялгаа нь хүмүүс нүглийн буруутгалд ямар хариу үзүүлдгийг ойлгоход тустай.

Паул ч (нүглийн үр дүнд) үүссэн харуусал, гэмшил хоёрын ялгааг (нүгэлдээ харамсаж, чиглэлээ өөрчлөх) бичсэн байна. Элч маань захидалдаа “Бурханы дагуух гашуудал нь авралд хүргэдэг гэмшлийг бий болгодог. Харин ертөнцийн гашуудал үхлийг бий болгодог” (2 Коринт 7:10) гэжээ.

Бурханлаг гашуудал нь жинхэнэ гэмшлийг авчирч аврал, амь руу хөтөлнө. Дэлхийн уй гашуу нь зөвхөн буруутгал, үхэл рүү хөтөлнө. Петр, Иудас хоёр хоёулаа харамссан хэдий ч, зөвхөн Петр л гэмшжээ.

Иудас урвалтынхаа үр дагаврыг хараад ичгүүр, буруутгалыг биш үхлийг сонгосон. Тэрээр гашуудаж байсан ч гэмшээгүй юм. Харин Петр уналтынхаа үр дүнг хараад жинхэнэ гэмшлийг сонгосон. Иудасын гашуудал үхэлд, Петрийн гашуудал гэмшил ба насан туршийн үр нөлөөтэй үйлчлэлд хүргэжээ.

► Та нүглээсээ болоод харуусаж байгаа боловч жинхэнээсээ гэмшээгүй хүнийг харсан уу? Үр дүн нь ямар байсан бэ? Бид номлолоороо дамжуулан хүмүүсийг яаж жинхэнэ гэмшил рүү хөтлөх вэ?

### **Загалмай**

► Матай 27:27-54 эшлэлийг унших.

Иудей нь Ромын цэргүүдийн хувьд аймшигтай цэг байв. Хүмүүс нь Ромын цэргүүдийг үзэн яддаг, zealot бүлгийнхэн нь цэргүүдийг хороохоор төлөвлөдөг тийм газар байсан аж. Алгасал баярын үеэр бослогоос сэрэмжилж цэргүүд бэлэн байдалд байна. Цэргүүдийн хувьд үүнээс муу даалгавар гэж байгаагүй байх. Тиймээс иудей хоригдлыг цаазаар аваачих үедээ цэргүүд уг хэрэгтэнд үзэн ядалтаа гаргадаг байв.

Үүрэг даалгавраа үзэн ядаж хатуурсан, тэрхүү ард түмнийг үзэн яддаг цэргүүдийн харгислал, Есүст хандсан хандлагаас нь харагддаг. Өөрөөр хэлбэл, буцаагаад хариу өгч чадахгүй хүнийг цохиж, доромжилж, өргөст титэм өмсгөж, үүндээ баясаж байснаас нь харагддаг. Есүс энэ бүгдээс болж тарчилж байсан ч, тэр цэргүүдийн өөдөөс уурласан нэг ч үг хэлээгүй юм.

Загалмайн түүхийг судалж байсан олон эрдэмтэн Есүсийн загалмай дээр хэлсэн 7 үгийг анхаардаг. Хүний сүүлчийн үг тухайн хүнд юу чухал байсныг илэрхийлдэг. Есүс үхэлтэй тулгарах үедээ юу хэлсэн бэ?

### **Уучлалын үгс**

Цэргүүд Есүсийг загалмай дээр хадаж байх үед Тэрээр “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” гэсэн (Лук 23:34). Эцэслэхийн өмнө ч Есүс хайр, уучлалаа харуулсан билээ.

Үхвэл зохих дээрэмчинд Есүс “Үнэнээр Би чамд хэлье. Өнөөдөр чи Надтай хамт Диваажинд байх болно” гэж амласан юм (Лук 23:43).

### **Энэрлийн үгс**

Есүс ээжийгээ Иоханд хариуцуулж “Эмэгтэй, хараач, хүү чинь” гэж хэлээд Иоханд “Хараач, эх чинь” гэсэн (Иохан 19:26-27). Урьд нь Есүс гэр бүлийн хамгийн гүн хэлхээ холбоо нь сүнслэг байдал юм хэмээн зааж сургасан “Харагтун, Миний эх ба ахан дүүс

энд байна. Тэнгэр дэх Эцэгийн минь хүслийг биелүүлэгч хэн боловч Миний эх, ах эгч, дүүс мөн гэж айлдав” (Матай 12:49-50).

Есүсийг үхэх үед дүү нар нь итгэгч биш байсан тул Түүний сүнслэг гэр бүлийн нэг хэсэг байгаагүй юм. Тиймээс Есүс ээжийгээ сүнслэг дүү хайрт Иоханыхаа асрамжинд үлдээжээ.

### ***Биеийн тарчлалын үгс***

Бурханы Хүү байлаа гээд Есүс загалмай дээрх махбодын тарчлалаас ангид байсангүй. Тэрээр гэмт хэрэгтэн мэт бүхий л биеэрээ тарчлан зовсон юм. Аймшигтай халуунд усгүй хэдэн цаг болсны дараа Есүс “Би цангаж байна” гэж хэлсэн (Иохан 19:28).

### ***Сүнслэг шаналлын үгс***

Есүсийн загалмай дээр хэлсэн зүрх зүсэм үгсийг Матай болон Марк тэмдэглэжээ: “Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?” (Матай 27:46 ба Марк 15:34, Дуулал 22:1-ээс эш татсан).

Есүс хүмүүн чанарынхаа хувьд Давидын мэдэрсэнтэй адил орхигдох мэдрэмжийг амссан. Хүмүүс Давидыг шоолж, түүн рүү толгой сэгсэрч байсан шиг (Дуулал 22:7), тэд Есүсийг шоолж толгой сэгсэрч байлаа (Матай 27:39). “Тэр цаг мөчид Бурханд хаягдсанаа Давид сэтгэл санаагаараа мэдэрсэн шиг Есүс, “Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?” хэмээн хашхирчээ.

Гэсэн хэдий ч Бурхан өөрийг нь орхиогүйг Давид олж мэдсэн. Тэр энэ талаар хожим нь Дуулалд гэрчилсэн байдаг. “Учир нь, Тэр зовогсдын зовлонг жигшээ ч үгүй, үзэн ядаа ч үгүй. Тэр нүүрээ нуугаа ч үгүй. Харин тусламж гуйн түүнийг хашхирахад Тэр сонссон юм” (Дуулал 22:24).

Үүнтэй адилаар Бурхан өөрийг нь орхиогүйг Есүс мэдэж байлаа. Есүсийн загалмай дээр хэлсэн дараагийн үг нь Эцэгтээ хандсан хашхираан байв. Эцэг нь Түүнийг орхиогүйг мэдээд Есүс “Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая” (Лук 23:46) хэмээн залбирсан.

Есүс хүмүүн чанарынхаа хувьд бидний адил Бурхан залбирлыг сонсохгүй байгаа мэт санагдах хоосон мэдрэмжийг амссан юм. Гэвч бидний тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ хэзээ ч орхидоггүй тэрхүү бодит байдлыг Есүс бас амсаж туулсан. Бид Түүний оршихуйг мэдрэхгүй байсан ч Тэр биднийг сонсдог гэдгийг мэдэж, Түүнд хандан хашхирч чадна.

### ***Дуулгавартай байдлын үгс***

“Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая” (Лук 23:46) Есүс амьдралынхаа туршид Эцэгтээ итгэмжтэй амьдарсан. Тэгээд загалмайтай тулгарах үедээ Тэрээр “харин Таныхаар болог гэж” (Матай 26:39) хэлсэн. Тэрбээр Эцэгийн хүсэлд дуулгавартай байж, эцсийн үгээ ийнхүү хэлсэн юм.

## **Ялалтын үгс**

“Гүйцэлдлээ” (Иохан 19:30). Есүс өөрийг нь илгээсэн Эцэгийнхээ даалгаврыг гүйцэтгэсэн гэдгээ энэ үгээр тунхагласан юм. Нүглийн шийтгэл төлөгдөж, Сатан ялагдсан. Исаиа 53-р бүлэгт буй Хуучин гэрээний хургаар эш үзүүлсэн цагаатгал ийнхүү биелж, амлалт гүйцэлджээ.

Бурхан загалмай дээр нүглийг үл мэдэгч Түүнийг нүгэл болгосон учир бид Түүний дотор Бурханы зөвт байдал болох юм (2 Коринт 5:21). Исаиа 53-р бүлэгт бидний нүглийг үүрэх зовлонт Зарцын талаар эш үзүүлэгч ярьжээ (Исаиа 53:4-12). Энэхүү орлуулах эвлэрүүлэл нь загалмай дээр хийгдсэн гэдгийг Паул харуулдаг.

Түүний дотор бид Бурханы зөвт байдал болохын тулд Есүс бидний төлөө нүгэл болжээ (2 Коринт 5:21). Бид нүглийн боолчлолд амьдрахаа нэгэнт больсон. Христийн үхлээр бид зөвт болгогдсон юм. Бид зөвхөн Түүний дотор зөвт байхаар дуудагдсан гэж Паул хэлээгүй. Харин оронд нь бид Түүний дотор Бурханы зөвт байдал болно гэжээ. Загалмай дээрх Христийн ажлаар дамжуулан жинхэнэ хувьсан өөрчлөлт бий болдог. Биднийг зөвт болгохын тулд Христ нүгэл болсон юм.

### **Өө тэнгэрлэг хайр минь, өршөөж биднийг хэлтрүүлсэн гэж үү!**

Өө тэнгэрлэг хайр минь, өршөөж биднийг хэлтрүүлсэн гэж үү!

Өнө мөнхийн Бурхан миний төлөө үхсэн гэж үү!

Өрлөг Эцэгийн мөнхийн Хүү

Өрөвдөлт миний бүх нүглийг модон дээр үүрчээ.

Өнө мөнхийн Бурхан миний төлөө үхжээ:

Өө миний Эзэн, миний Хайр цовдлогдсон юм!

Өрийг нь өвтгөж эсэргүүцсэн биднийг Бурханд буцаахаар

Өргөст миний болон чиний төлөө цовдлогджээ.

Өө итгэгтүн, итгэгтүн

Өр нимгэн Есүсийн цус бүгдийг нь худалдан авсанд

Өөрийн зүгээс бүгдийг уучилсан гэдэг үнэнд

Өө миний Эзэн, миний Хайр цовдлогдсон юм!

Өнгөрөн одож холдолгүй

Өөдөө Түүнийг хараарай,

Өршөөлт Ханхүү

Өөрийн цусаа урсган байж амь ба амар тайвныг өгсөн юм!

Өө ирэгтүн, харагтун

Өршөөн Аврагчийн үхлийг,

Өө хэлэгтүн, зарлагтун

Өөр илүү гасланг Түүн шиг тээсэн нь үгүй

Өө ирэгтүн, мэдрэгтүн

Өр зүрхэнд цутгагдах Түүний цусыг

Өө миний Эзэн, миний Хайр цовдлогдсон юм!

- Чарльз Весли

## **Шүүлт ба цовдлол (үргэлжлэл)**

### **Оршуулга**

► Матай 27:57-61 эшлэлийг унших.

Паул Коринт захидалдаа Есүс бидний нүглийн төлөө үхэж, оршуулагдсан хэмээн тунхагласан байдаг (1 Коринт 15:3-4). Паул болон анхны чуулганыхны хувьд оршуулга маш чухал байлаа.

Зовлонгийн долоо хоногийн олон зан үйлийг орчин үед Ивээлт Баасан гарагаас Амилсны баярын Ням гараг хүртэл сахидаг болжээ. Гэхдээ чуулганы түүхэнд ихэвчлэн “Ариун Бямба гараг” нь Амиллын баярын чухал хэсэг гэж тооцогдож ирсэн. Тэгвэл Есүсийн оршуулга ямар ач холбогдолтой вэ?<sup>51</sup>

### ***Түүхэн ач холбогдол***

Есүс үнэхээр үхсэн гэдгийг оршуулга нь харуулдаг. Түүнийг дараа нь сэрсэн гэж үздэг исламын шашныхны мэдэгдлийн эсрэг зүйл юм. Энэ нь Тэр үнэхээр үхсэн учраас оршуулагдсан гэдгийг харуулдаг. Ромчууд ял авсан хэрэгтнийг яаж хөнөөхөө сайн мэддэг байсан. Тэр үед хүнийг үхэхээс нь өмнө загалмайнаас авах ямар ч боломж байдаггүй байв.

Цаашилбал хүнд чулуу, харуулууд гээд хэн ч булшнаас зугтах аргагүй нь баталгаатай байна. Тэр ч бүү хэл Ромын цэргүүд Есүсийг үхэхээс нь өмнө андуураад оршуулсан гэж бодлоо гэхэд загалмай дээр олон цаг шаналсан хүн биеийг нь ороосон боолтыг ураад, хүнд чулууг түлхэж зайлуулаад, мэргэшсэн харуулуудыг дийлээд гарч явна гэдэг төсөөлшгүй зүйл шүү дээ. Оршуулга болсон нь Назарын Есүс үхсэн гэдэг түүхэн үнэнийг баталж байна.

### ***Эш үзүүлэгийн ач холбогдол***

Алагдахаар яваа хурганы тухай эш үзүүлэгч Исаиа “Булшийг нь буруутуудын хамт товлосон ч үхэлд Тэрээр баян хүнтэй хамт байв” хэмээн эш үзүүлсэн байдаг (Исаиа 53:9). Есүсийн оршуулга нь авралын эш үзүүлэгийг биелүүлсэн юм.

Есүсийг үхсэний дараа Ариматын Иосеф Түүний биеийг Пилатаас авахаар очжээ. Иосеф Санхедрины гишүүн байсан боловч, Есүсийг яллахыг зөвшөөрөөгүй юм. Иудейн удирдагчдын ихэнх нь Есүсийг эсэргүүцэж байсан ч, зарим нь Бурханы хаанчлалыг хайж байлаа. Иосеф бол эдгээр нууц дагалдагчдын нэг юм. Тэрээр Никодемийн хамт

---

<sup>51</sup> James Boice, “The Burial of Jesus”—с авав. <http://www.alliancenet.org/tab/the-burial-of-jesus-christ-part-one>, 2021 оны 3 сарын 22-нд хандсан.



Есүсийн цогцсыг Иосефын булшинд оршуулжээ (Матай 27:57-60, Марк 15:42-46, Лук 23:50-54, Иохан 19:38-42).

Үүнд ямар их зориг шаардагдаж байсныг бодоод үзээрэй. Дагалдагч нар нь хүртэл Есүсийг орхин явсан байхад Иосеф яллагдсан гэмт хэрэгтний төлөө алхам хийсэн. Олны өмнө хийсэн энэхүү алхам нь Иосефын зөвлөл дээрх, мөн нийгэм дэх байр суурийг нь эрсдэлд оруулсан. Цаашлаад Иосеф Пилатын уур хилэнд өртөх ч боломжтой байв. Ромын албан тушаалтнууд цовдлогдсон ялтны цогцсыг найз нөхөд, хамаатнуудад нь өгөхийг бараг зөвшөөрдөггүй байжээ. Хэрэгтний цогцсыг олны өмнө үзүүлж, бусдад сануулга болгодог байсан хэрэг. Харин тэрээр Пилатаас зөвшөөрөл авч чадсан нь Есүсийг ямар нэг гэмт хэрэгт буруугүй гэдгийг мэдсэний бас нэг нотолгоо болдог.

### **Теологийн ач холбогдол**

Паул бидний баптисмыг Есүсийн оршуулгатай ийнхүү адилгасан байна.

Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд бид үхэл уруу баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм (Ром 6:3-4).

Оршуулга бол Есүсийн үхлийн олон нийтийн өмнөх баталгаа юм. Үүнчлэн баптисм ч бас Есүсийн үхлийг олон нийтийн өмнө гэрчилж байгаа явдал юм. Баптисмаар бид хуучин амьдралаасаа салж үхсэн гэдгийг тунхагладаг.

Оршуулга бол хэн нэгний үхлийг мэдэх сүүлчийн алхам юм. Баруунд гашуудагчид “баяртай” хэмээн энэ дэлхий дээрх эцсийн мөчийг илэрхийлэн авс руу шороо шиддэг. Паул биднийг нүгэлд үхэж эцэслэсэн гэдгийг онцолсон бөгөөд Христ үхсэн шиг бид ч бас нүгэлд үхсэн юм. Христтэй хамт үхсэн атлаа нүгэлдээ буцах нь үхсэн цогцсыг ухаад гаргаж буйтай адил.<sup>52</sup> Бид Христтэй хамт оршуулагдсан, тиймээс бид нүглийн хувьд амьд биш.

### **Амилал**

Паул загалмайн тухай, Христ бидний нүглийн улмаас үхэж, оршуулагдсан хэмээн коринтынхонд номлосон. Тэгээд Паул амиллын тухай бас номлож, Христ гурав дахь өдөртөө амилан, олон гэрч нарт үзэгдсэн гэжээ (1 Коринт 15:3-8). Амилал бол христитгэлийн цөм юм.

► Матай 27:62-28:15 эшлэлийг унших.

Шашны удирдагчид Пилатаас загалмай дээр бичсэн үгсийг өөрчлөхийг хүсэхэд тэр татгалзсан. Тэрээр Есүсийг “Назарын Есүс, Иудейчүүдийн Хаан” гэж бичсэн самбарын

---

<sup>52</sup> James Boice, “The Burial of Jesus.”-аас авсан. <http://www.alliancenet.org/tab/the-burial-of-jesus-christ-part-one-д> 2021 оны 3 сарын 22-нд хандсан.

доор цовдолсон юм (Иохан 19:19). Энэ цолыг шийтгүүлж байгаа хэрэгтэнд ашигласнаараа Пилат дургүйг нь хүргэдэг иудейчүүдийг шоолж байсан хэрэг.

Есүсийг цовдолсны дараа шашны удирдагчид Пилат руу дахин ирж, булшийг мануулах Ромын харуулуудыг гаргаж өгөхийг гуйжээ.

Эрхэм ээ, тэр мэхлэгч амьд байхдаа “Би гурав хоногийн дараа амилна” гэж хэлж байсныг бид санаж байна. Тиймээс шавь нар нь ирж, Түүнийг хулгайлаад, ард олонд “Тэр үхэгсдээс амилав” гэж хэлүүлэхгүйн тул гурав дахь өдөр нь хүртэл булшийг хамгаалахыг тушаагаач. Эс бөгөөс сүүлчийн мэхлэл нь эхнийхээсээ ч дор муу юм болно гэцгээлээ (Матай 27:63-64).

Ингээд Пилатын зөвшөөрлөөр тэд булшийг лацдаж, цэцэрлэгт Есүсийг баривчилсан хүмүүсээс харуулд гаргажээ. Гэнэт:

маш хүчтэй газар хөдлөлт болов. Учир нь Эзэний тэнгэрэлч тэнгэрээс буун ирж, чулууг зайлуулаад дээр нь суужээ. Түүний үзэгдэх төрх аянга лугаа адил, хувцас нь цас мэт цагаан байв. Харуулууд түүнээс айн чичирч, үхдэл мэт болжээ (Матай 28:2-4).

Есүс амилжээ!

► Иохан 20:1-29 эшлэлийг унших.

Сайнмэдээний номуудад Есүс амиллынхаа дараа хэд хэдэн удаа үзэгдсэн талаар тэмдэглэсэн байдаг. Тэрээр олон хүнд янз бүрийн орчинд харагдсан юм.

Үл итгэгчид заримдаа “Булшин дээр очсон эмэгтэйчүүд хий юм харсан. Тэд хармаар байгаагаа л харсан хэрэг” гэдэг. Гэхдээ тэдгээр гэрч эмэгтэйчүүд Есүсийг үхсэн гэдгийг мэдэж байсан учраас Түүнийг амьдаар нь харна гэж бодоогүй. Тэд амиллын тухай эш үзүүллэгийг хараахан ойлгоогүй байсан (Иохан 20:9). Тэр ч байтугай Есүсийг харсан эхний гэрч нарын үгэнд ч дагалдагчид эргэлзэж байсан шүү дээ (Марк 16:13). Тэд Есүсийг үхлээс амилна гэж бодоогүй байсан.

Тэр Магдалын Мариад харагдсан, (Иохан 20:11-18), хоёр дагалдагчтай цуг Еммау тосгон руу алхсан (Лук 24:13-32), арван нэгэн элч (Иохан 20:19-31), тэгээд 500 хүнд зэрэг харагдсан (1 Коринт 15:6) бөгөөд ийнхүү Есүсийн дагалдагчид Түүнийг үнэхээр амилсан болохыг аажмаар ойлгожээ. Ингээд анхны чуулганыхан “Тэр амилсан, Тэр үнэхээр амилсан” гэж хүндэтгэн мөргөдөг болжээ.

### **Хэрэгжүүлэлт: Загалмай ба амиллын хүчээр үйлчлэх нь**

Олон либерал теологичид амиллыг домог мэтээр тайлбарлахыг оролдсон юм. Гэсэн хэдий ч элч нарын итгэл Есүсийн амьдралын мөнхийн нөлөөний тухай сайхан түүх дээр биш, харин Түүний үхэл, амиллын баттай баримтууд дээр үндэслэжээ. Элч нар Есүсийг үхээд амилсан гэдгийг мэдсэн билээ. Энэ нь тэднийг хавчлага, бүр үхлийн өмнө ч итгэл зоригтой байлгасан юм. Есүсийн үхэл амилал өнөөдрийн үйлчлэлд яаж нөлөөлөх вэ?

## **Загалмайн хүчээр үйлчлэх нь**

► 1 Коринт 1:17-2:5 эшлэлийг унших.

Сайнмэдээний хоёр дахь аяндаа Паул Коринт хотоос Афиныг зорьж, тэндээ Арейпагт номложээ. Афинд үйлчилсэн Паулын үйлчлэл үр дүн багатай байсан гэж харагддаг (Үйлс 17:16-34). Тэрээр Афинд чуулган тариагүй бөгөөд тэндхийн гүн ухаантнууд амиллын тухай мэдээг шоолж байлаа. Ингээд Паул Афинаас явж, тэндээс 75 км зайд байх, Ахай мужийн хамгийн нөлөө бүхий хот Коринт руу очжээ.

Паул дараалсан гурван хот болох Тесалоник, Берой, Афинд эсэргүүцэл амссаныхаа дараа Коринтод ирсэн. Магадгүй үүнээс болоод тэрээр “Мөхөсдөл, айдас, үлэмж чичрэл дор би та нартай хамт байсан” (1 Коринт 2:3) гэж бичсэн байх. Хэдийгээр грек сонсогчид уран яруу хэллэг, ухаалаг цэцэн байдлыг хүсэж байсан ч, Паул зөвхөн загалмайн тухай номлохоор шийдсэн байна. Түүний номлолын хүч уран яруу үгээс биш, харин загалмайнаас өөрөөс нь гарсан юм. Паул “Христийн загалмайг дэмий хоосон зүйл болгохгүйн тулд, үгийн мэргэн цэцнийг хэрэглэлгүй” номложээ (1 Коринт 1:17).

Коринт хотод Паул “та нарын дунд би Есүс Христ буюу цовдлогдсон Түүнээс өөр юу ч мэдэхгүй байхаар шийдсэн юм” гэсэн бөгөөд (1 Коринт 2:2) тэрхүү номлол олон хүний дургүйг хүргэнэ гэж Паул мэдэж байлаа.

Учир нь иудейчүүд нь тэмдэг шаардаж, грекүүд нь мэргэн ухааныг хайдаг. Бид харин цовдлогдсон Христийг тунхагладаг. Энэ нь иудейчүүдэд бүдрүүлэх саад, харийнханд мунхаглал болдог агаад... (1 Коринт 1:22-23).

Энэ мэдээ иудейчүүдийн хувьд бүдрүүлэх чулуу, бөөн шуугиан болсон юм. Тэд Мессиагийн тэмдэг гайхамшгийг хайж байсан хүмүүс. Тэдний бодлоор бол цовдлогдсон хүн нь сонгогдсон Мессиа байна гэдэг нь утгагүй зүйл байжээ. Иудейн хуулинд “Модон дээр өлгөгдсөн хүн бүр Бурханы хараал болой” (Дэд хууль 21:23) гэсэн байдаг. Тиймээс цовдлогдсон Есүсийг Мессиа гэж тунхаглах нь иудейн сонсогчдын хувьд дуулиантай асуудал юм.

Загалмайн тухай үг нь харь үндэстнүүдийн хувьд мунхаглал байв. Грекчүүд амиа зориулагчийн нэр төртэй үхлийг хүндэтгэдэг байжээ. Хэрэв Есүс Ромын өөдөөс тулалдаж байгаад үхсэн бол грек сэтгэгчдийн хувьд эр зоригийг нь хүндэтгэх зүйл байлаа. Гэвч загалмай дээр үхэх нь тухайн хүнийг хүндлэлгүй болгодог учраас нэр төртэй үхэлд тооцогдохгүй. Загалмай дээр үхсэн хүнийг ердийн ёсоор оршуулахаас татгалздаг байсан. Тийм хүний цогцсоор шувуу, харх хооллож, ясыг нь хогийн нүх рүү шиддэг байжээ. Тиймээс цовдлогдсон иудей тариачинг “Эзэн” гэж тунхаглах нь өөр үндэстний хүмүүст хачин утгагүй зүйл байв.

Загалмай нь иудейчүүдийн хувьд дуулиан, харь үндэстнүүдийн хувьд мунхаглал байсан ч, Паул загалмайн тухай мэдээг эргэлзэлгүйгээр тунхагласан. Паулын жишээ бидэнд үлгэр дуурайл болж байна. Өнөөдөр ч загалмай нь 1-р зууны үеийн адилаар зарим

хүмүүсийн дургүйг хүргэж, заримд нь тэнэг санагдаж болох ч, бид энэ мэдээг тунхаглах ёстой.

Үйлчлэгч, чуулганы удирдагчдын хувьд бидний итгэлтэй байдал чадвараас маань ирээгүй, харин бидний итгэл загалмайн мэдээн дээр суурилдаг. Паул гайхалтай боловсролтой, хурц ухаантай, тухайн үеийнхээ хамгийн оюунлаг хүмүүстэй маргаж чаддаг хүн байв. Гэхдээ түүний туйлын итгэлтэй байдал нь загалмайн мэдээнд суурилсантай холбоотой. Бид хүмүүсийг ятгаж чадлаа гэвэл, тэдний итгэл хүний мэргэн ухаанд түшиглэнэ. Харин бид тэдэнд загалмайн тухай ойлгуулбал, тэдний итгэл Бурханы хүчинд суурилна (1 Коринт 2:5).

### **Амиллын хүчээр үйлчлэх нь**

► Үйлс 2:22-36 эшлэлийг унших.

Амилал нь анхны христитгэлийн номлолын гол сэдэв байсныг Үйлс ном харуулж байна. Пентекостын баяраар Петр Есүсийн амиллыг эш үзүүлэгчдийн амласан амлалтуудын биелэл байсан гэдгийг нотолсон байдаг.

Паул өөрийгөө Агрипп хааны өмнө өмгөөлөхдөө “Би энд Бурханаас манай өвөг дээдэст өгч, манай 12 овгийн хүртэхийг найддаг тэрхүү амлалтын найдвараас болж шүүгдэж байна” гэсэн байна. Тэгвэл тэр амлалт нь юу вэ? Амилал. “Хэрэв Бурхан үхэгсдийг амилуулдаг бол энэ нь яагаад та нарын дунд үнэмшмээргүй хэмээгдэнэ вэ?” (Үйлс 26:6-8).

► 1 Коринт 15:12-34 эшлэлийг унших.

1 Коринт номд Паул үйлчлэлээ зөвхөн загалмайн хүч дээр төдийгүй, бас амиллын хүч дээр үндэслэсэн гэж хэлсэн байдаг. Тэрээр амилал байхгүй бол үйлчлэл нь утгагүй гэдгийг “Христ амилуулагдаагүй бол бидний тунхаглал хоосон, та нарын итгэл ч хоосон болно” гэж илэрхийлжээ. (1 Коринт 15:14). Амилалгүйгээр Есүс ч бас нэг хуурамч Мессиа л болох байсан. Амилалгүйгээр Есүс зүгээр нэг эмгэнэлт амиа өргөгч болохоос биш, амлагдсан Мессиа байж таарахгүй.

Амилал бол христитгэлийн суурь юм. “Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хоосон агаад та нар ч нүгэлдээ байсаар байна” (1 Коринт 15:17). Загалмай дээр бидний нүглийн төлөөсийг Христ төлсөн бол, амилал нь Христийг үхэл ба нүглээс илүү хүчтэй гэдгийг батлан харуулдаг. Хэрэв амилал байхгүй бол Паулын хэлдгээр таны итгэл хоосон бөгөөд та нүглийнхээ боолчлолд байсаар байна гэсэн үг.

Амилал бол бидний итгэлийн суурь юм. “Учир нь үхэл нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилал мөн нэг хүнээр иржээ. Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно” (1 Коринт 15:21-22). Христ үхлээс амилсан учраас тэдэнд амиллын найдвар бий гэж Паул коринтчуудад батлан хэлжээ.

2-р зууны грекийн зохиолч Лусиан Христэд итгэгчдийг дахин амилалд итгэдэг гэж шоолж “Хөөрхийс, мөнх амьдарна гэж итгэдэг. Тийм учраас үхлийг үл тоомсорлож,

итгэлийнхээ төлөө амиа өгөхөд бэлэн байдаг” гэсэн байдаг. Хэдийгээр Лусиан итгэгчдийг шоолж хэлсэн ч, тэрээр үнэн байдлыг хэлжээ. Үнэхээр Лусианы хэлснээр 2-р зууны итгэгчид үнэхээр мөнх амьдарна гэдэгтээ итгэдэг байсан. Тэрхүү итгэлээсээ болж, тэд итгэлийнхээ төлөө үхэхэд бэлэн байсан юм.

Энэ үнэн өнөөгийн бидний хувьд ч хэвээрээ байх ёстой. Хэрэв бид Христийг үхлээс амилсан гэдэгт үнэхээр итгэдэг бол, энэ итгэл маань биднийг хавчлага, бүр үхлийн өмнө ч бат итгэлтэй байлгаж чадна. Амилал бол бидний итгэлийн суурь юм.

Амилал бол бидний христитгэлт амьдралын суурь юм. Паул амиллын тухай онол сургаалыг бодитоор хэрэгжүүлэн “Хэрэв үхэгсэд амилуулагдахгүй л юм бол ‘Маргааш бид үхэх юм чинь идэж ууцгаая!’ ...Та нар зөв ухааралд ир. Нүгэл үйлдэхээ боль” гэсэн байдаг (1 Коринт 15:32, 34). Паулын хэлснээр амилал нь бидэнд бурханлаг амьдралаар амьдрах шалтгааныг өгдөг. Хэрэв амилал гэж байхгүй бол, бид магадгүй Епикурын хэлсэн шиг “Удахгүй үхэх юм чинь идэж ууцгаая” хэмээн амьдарч болох юм. Хэрэв амилал гэж байхгүй бол мөнх амьдрах шалтгаан гэж байхгүй. Гэхдээ Паулын үргэлжлүүлэн хэлснээр нэгэнт амилал гэж байгаа тул, бид сэрж, нүглээс ангид амьдрах ёстой. Амилалд баттай итгэх нь нүглийг ялсан бидний ялалтыг зоригжуулж байдаг.

Үйлчлэлд бэрхшээл тулгарах үед амиллын тухай түүх бидний итгэл багатайг зэмлэдэг. Залбиралд маань хариу ирэхгүй байна гэж бид хичнээн удаа бодсон бол? Яагаад вэ? Яагаад гэвэл бид амиллын хүчийг мартсан байна. Бид ялна гэсэн итгэл багатайгаар хэр олон сорилттой тулгардаг бол? Яагаад тэр вэ? Яагаад гэвэл бид Паулын хэлсэн амилалтыг мартдаг. Тэрээр “Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжин үхлийн биест чинь амь өгнө” гэсэн юм (Ром 8:11).

Хэрэв Христ бидний дотор амьдарч байгаа бол, бид махбодоороо амьдрахаа болино. Бид нүглийн хоригдол байхаа болино. Энэ бол амиллын хүч доторх амьдрал юм. Есүсийг булшнаас амилуулсан тэр хүч бидэнд нүглийг ялах өдөр бүрийн ялалтыг өгдөг. Үүнийг амиллын хүчээр амьдарч, үйлчлэх гэнэ.

### **Дүгнэлт: Христэй адил амьдрал ба үйлчлэлийн шинж тэмдэг**

#### **Таны үйлчлэл Христийнх адил байна уу?**

“Дагалдагчдыг Антиохт анх удаагаа Христитгэгчид гэж нэрлэх болов” гэж Лук бичжээ (Үйлс 11:26). Хүмүүс Антиохын итгэгчдийг ажиглаж байгаад “Эдгээр хүмүүс Христэй адил үйлдэж байна. Тэднийг Христэд итгэгчид гэж нэрлэе” хэмээн ярьж эхэлсэн байна. Та энэ эшлэлийг унших үедээ “Манай хөршүүд миний зан ааш, үг, хандлагыг хараад “итгэгч” гэдгийг минь мэдэх болов уу? Би Христэй адил харагдаж байгаа болов уу?” гэж өөрөөсөө асуугаарай. Антиохын итгэгчдийн амьдрал олон талаар Христийг тусган харуулж байв. Тэд жинхэнэ итгэгчид байлаа.

Олон жилийн туршид пастороор үйлчилсэн Др. Х. Б. Лондон одоо залуу пасторуудад зөвлөгчөөр үйлчилдэг. Тэрээр пасторуудад тулгарч буй сүнслэг аюулын талаар

анхааруулан “Хүн ариун байхгүйгээр ариун зүйлсийн дэргэд байж болно. Өршөөлийн тухай номлосон ч өөрөө уучлахгүй байх боломжтой. Үйлчлэгч нар үйлчлэлдээ маш их чармайлт гаргах атлаа өөрсдийнхөө сүнсний эрүүл мэндийг хайхрахгүй байх нь ч бий” гэж хэлжээ.<sup>53</sup> Бусдад номлосон ч өөрөө тэнцэхгүй байх боломжтой юм (1 Коринт 9:27).

Др. Лондон пасторуудад бусдыг удирдан чиглүүлэхийн зэрэгцээ сүнслэг тал дээр бүтэлгүйтэхээс зайлсхийхэд туслах хэдэн практик зөвлөгөөг санал болгожээ. Эдгээр нь Христтэй адил амьдралаа хадгалахад туслах хэдэн арга юм. Тэрээр ингэж бичжээ.

- **Номлосон шигээ амьдар.** Өөрөө амьдралдаа хэрэгжүүлээгүй зүйлээ бусдад бүү номло.
- **Өөрийнхөө сүнслэг байдлыг анхаар.** Зарим эмч нар эрүүл биш байдаг. Тэд бусдыг анхаарах атлаа өөрийнхөө эрүүл мэндийг үл хайхарна. Зарим пасторууд сүнслэг талаараа эрүүл бус байдаг. Пасторын хувьд тэд сүнслэг эрүүл мэнддээ ч анхаарах ёстой.
- **Өөрийгөө даруусга.** Пастор бол банкны ерөнхийлөгч биш, хоньчин гэдгийг сана. Үйлчлэгч бай.
- **Урам хугарч сур.** Та үйлчлээд сэтгэл дундуур байх болно. Таны зөвлөсөн хүн төөрч будилна. Дотны найз чинь таны эсрэг болно. Чуулганы гишүүд танаас татгалзана. Гэхдээ урам хугаралт таны итгэл найдварыг алдагдуулж болохгүй. Иудас Есүсээс урвасан. Дем Паулаас урвасан. Нулимсаа урсган өөрөө өсөж, сүргээ сайн хариул.

### **Таны үйлчлэл Христийнх адил байна уу?**

Есүсийн амьдрал, үйлчлэлийн тухай эдгээр хичээлээс бид Түүний үйлчлэлийн олон шинж чанарыг олж харсан. Эдгээр шинж чанар таны үйлчлэлээс харагдаж байна уу?

Үйлчлэлээ үнэлж дүгнэх зарим асуултыг энд орууллаа.

- Нүгэлтнүүд аврагдаж байна уу? Есүсийг номлох үед хүмүүс шинэ амьдралыг хүлээн авдаг байсан. Та хүмүүсийг шинэ амьдралд хөтөлж байна уу?
- Итгэгчид сүнсээр дүүрч байна уу? Есүс хүүхдүүддээ Сүнсийг илгээнэ гэж амласан. Энэ амлалт таны үйлчилж байгаа хүмүүсийн дунд биелж байна уу?
- Сатан ялагдаж байна уу? Сатаны бэхлэлтүүд нурж байна уу? Есүсийн үйлчлэл сүнслэг эрх мэдлээрээр ялгарч байсан юм.
- Шархалсан хүмүүс эдгэж байна уу? Хагаралдсан гэр бүл эвлэрч байна уу? Тасарсан харилцаа сэргэж байна уу? Есүс биеэр, сэтгэлээр, сүнсээр, сэтгэл хөдлөлөөр, сүнсээр шархалсан хүмүүсийг эдгээж байсан.

---

<sup>53</sup> H. B. London, *They Call Me Pastor*. (Grand Rapids: Baker Books, 2000), 145

- Хүмүүс нигүүлсэл ба үнэнийг харж байна уу? Та хүмүүсийг Есүс рүү татаж байна уу эсвэл Есүсээс холдуулж байна уу? Есүс үнэнийг итгэлтэйгээр, нигүүлсэл дүүрэн номлодог байсан.

► Та нар эдгээр асуултыг хэлэлцэх зуураа өөрийнхөө үйлчлэлийг Христийнхтэй адил өсгөх талбаруудыг олоорой. Үйлчлэгч бүрд өсөх орон зай бий гэдгийг санаж, энэ жагсаалтыг өөрийгөө буруутгах бус, харин өсөлтөд хүргэх сорил гэж хараарай.

### **8-р хичээлийн даалгаврууд**

(1) “Загалмай дээрх долоон үгийн тухай” номлол эсвэл Библийн хичээл бэлтгэ. Есүсийн үгээс өнөөгийн итгэгчдэд зориулсан санааг тодруулан онцол.

(2) Амиллын утга учрын тухай өнөөгийн Христэд итгэгчдийн амьдралд зориулсан номлол эсвэл Библийн хичээл бэлтгэ. 1 Коринт 15:15-17 дахь амиллын тухай сайнмэдээ болон Паулын үгийг аль алиныг ашиглаж бэлтгээрэй.





## 9-р хичээл

### Өв үлдээх нь

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч:

- (1) Дагалдагчид ба чуулганд Есүсийн өгсөн сүүлчийн өвийн талаар ойлгох.
- (2) Есүсийн үлдээсэн өв, үүрэг даалгаврын чухлыг үнэлэх.
- (3) Үйлс ном дахь дагалдагчдаар дамжуулан Есүсийн үйлчлэл үр нөлөөтэй үргэлжилсэн гэдгийг ойлгох.
- (4) Түүний үйлчлэлийн өвийг үлдээх бодит алхмуудыг хөгжүүлэх.

#### Үйлчлэлийн зарчим

Биднийг байхгүй болоход ард үлдэх зүйл маань бидний үйлчлэлийн шалгуур болно.

#### Танилцуулга

Тимот олон жил нэр хүндтэй пастороор ажиллаад, тэтгэвэртээ гарах дөхөж байлаа. Нэг хүн түүнээс "Та тэтгэвэрт гарахдаа чуулганаа хэрхэн бэлтгэж байна вэ? Танай чуулганы ойрын 10 жилийн алсын хараа юу вэ?" гэхэд Тим "Би энд байхгүй учраас намайг явсны дараа яах нь надад хамаагүй" гэжээ. Энэ пастор үйлчлэлийн чухал зарчмыг ойлгоогүй хүн байна. Биднийг явсны дараа чуулганд юу болох нь бидний үйлчлэлийг хэмждэг эцсийн шалгуур юм.

Энэ пасторыг Натантай харьцуулъя. Натан 25 жил үйлчлээд гэнэт нас баржээ. Натан эдгээр он жилүүдэд нутгийн чуулгандаа хэд хэдэн үйлчлэлийг хариуцаж байв. Тэрээр орон гэргүй хүмүүст зориулсан үйлчлэл, мансуурч донтогсдод нөхөн сэргээх хөтөлбөрийг бий болгож, бизнесийн удирдагчдад хүрч ажиллах ажлыг зохион байгуулжээ. Натаны оршуулга дээр мансуурагсдад зориулсан нөхөн сэргээх үйлчлэлийн ахлагч "Өнгөрсөн сард Натан бид хоёр уулзаад, ирэх жилийн төсвөө хэлэлцсэн" гэж ярихад, орон гэргүй хүмүүсийн үйлчлэлийн ахлагч, гэр бүлүүдийг түр сууцаар хангах шинэ барилгынхаа хар зургийн талаар ч мөн ярьжээ. Натан үйлчлэлийнхээ ирээдүйг сайтар төлөвлөсөн байв. Тэр ардаа өв үлдээжээ.

Энэхүү сүүлийн хичээлээр бид дагалдагч нартаа зориулсан Есүсийн сүүлчийн сургаал, дагалдагч нарт өгсөн Түүний сүүлчийн даалгавар болон Түүнийг дээш өргөгдсөний дараа дагалдагчдын гүйцэтгэсэн үйлчлэлийн талаар судална. Бид ардаа өв үлдээх тухай суралцана.

► Хэрэв та өнөөдөр энэ хорвоог орхивол ямар өв үлдэх бол?

- Гэр бүлдээ үлдээх өв чинь юу вэ?
- Нийгэмдээ үлдээх өв чинь юу вэ?
- Үйлчлэлдээ үлдээх өв чинь юу вэ?

### Есүсийн дээш одохын өмнөх захиас

Иохан 13-16-р бүлгийг Хуучин гэрээний Иаков, Мосе, Иошуа, Давид нарын сүүлчийн захиастай харьцуулж болно.<sup>54</sup> Есүсийн “Салан одохын өмнөх захиас” нь Түүний хамгийн гүн гүнзгий утгатай, дотночилсон сургаал байсан юм.

Иохан 13:1 дээр энэхүү сүүлчийн сургаалын хэсгийг “Энэ ертөнцөөс салж, Эцэг өөдөө очих цаг нь... Есүс мэдээд” хэмээн эхлүүлжээ. Хэрэв та 48 цагийн дотор үхнэ гэдгээ мэдсэн гэвэл үйлчлэлийг чинь үргэлжлүүлэх хүмүүст юу захиж хэлэх вэ? Эдгээр үгс нь таны дагалдагчдын хувьд хамгийн чухал зүйл байх болно.

Сүүлчийн зоог дээр Есүс дагалдагч нараа бүрэн хайрлах хайраа үг ба үйлдлээрээ (тэдний хөлийг угаах) харуулсан юм. Есүс “дэлхийд байсан Өөрийнхнийгөө хайрлаж байсан тул тэднийг эцсээ хүртэл хайрлав” (Иохан 13:1) гэжээ. “Эцсээ хүртэл” гэдэгт хоёр санаа агуулагдаж байна.

1. Энэ бол Есүс тэдэнтэй хамт байх эцсийн мөч хүртэл тэднийг хайрласан гэсэн үг.
2. Энэ бол Есүс тэднийг туйлын ихээр хайрласан гэсэн үг. Есүс бүрэн хайрласан.

► Иохан 13:31-14:31 эшлэлийг унших.

### Есүсийн захиас дахь тушаал ба амлалт

**Тушаал: Бие биенээ хайрла (Иохан 13:34).**

“Бие биенээ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун гэсэн шинэ тушаалыг Би та нарт өгч байна” Хайрлахаас илүүгээр хэрүүл тэмцлээрээ танигдсан тэдгээр дагалдагчдын хувьд энэ нь хэцүү тушаал байлаа.

Гэхдээ энэ яагаад шинэ тушаал гэж? Хуучин гэрээнд хүртэл Бурханы ард түмэнд “хөршөө... хайрла” гэж хэлсэн биш үү. Тэгэхээр хайрын тухай Есүсийн сургаалд хоёр шинэ зүйл байна.<sup>55</sup>

Эхнийх нь, Есүс хайрлах тушаалыг хэрхэн гүйцэтгэх **үлгэр дуурайлыг** өөрөө үзүүлсэн юм. Тэд Есүсийн адил хайрлах ёстой байв. Тэдний хөлийг даруугаар угаасны дараа Есүс “Би та нарыг яаж хайрласны адилаар та нар бие биенээ хайрла” гэсэн юм. Тэрбээр даруу сэтгэлээр үйлчилдэг хайрыг бодит болгож харуулсан. Дагалдагчид тэр үед ч, одоо ч Есүсийн адил хайрлах ёстой. Энэ хайр бол үйлчлэхээр алчуур аваад босдог хайр. Энэ хайр бол урвагчийг ч хайрладаг хайр. Энэ хайр үхэх хүртлээ хайрладаг хайр юм.

<sup>54</sup> Эхлэл 49, Дэд хууль 32-33, Иошуа 23-24, 1 Шастир 28-29

<sup>55</sup> Darrell L. Bock, *Jesus According to Scripture* (Grand Rapids: Baker Book House, 2002), 498

Хоёр дахь нь, Христэд итгэгчдийн дундах хайр бол Есүсийн сургаал үнэн гэдгийг харуулах ер бусын **гэрчлэл** юм. “Бие биендээ хайртай байваас та нарыг Миний шавь гэдгийг үүгээр чинь бүгд мэдэх болно гэлээ” (Иохан 13:35). Дараа нь Есүс “тэд төгс нэг болж, ингэснээр Та Намайг илгээсэн гэдгийг дэлхий мэдэх болно” гэсэн юм (Иохан 17:23). Чуулганы хайр ба эв нэгдэл бол Есүсийн сургаалыг гэрчлэх гэрч билээ.

Олон итгэгчийн хувьд итгэдэггүй хөршөө хайрлах нь алдаа дутагдлаар дүүрэн итгэгч ах дүүгээ хайрлахаас хамаагүй хялбар байдгийг мэдсэн байдаг. Гэхдээ Христэд итгэгчид бидэнд бие биенээ хайрлах тушаал өгөгдсөн. Элч Иохан 50 жилийн дараа чуулганд энэ тушаалыг сануулсан юм.

Хэн нэгэн нь “Би Бурханыг хайрладаг” гэж хэлчихээд, ах дүүгээ үзэн яддаг бол тэр худалч. Учир нь харсаар атлаа ах дүүгээ хайрладаггүй нь, хараагүй Бурханыг хайрлаж чадахгүй шүү дээ. Бурханыг хайрладаг нь ах дүүгээ мөн хайрлах ёстой. Бид энэ тушаалыг Түүнээс авсан билээ (1 Иохан 4:20-21).

Есүс сүүлчийн сургаалдаа бие биенээ хайрлах тушаалыг өгчээ. Энэ тушаал бол Түүний тунхагласан энэхүү сургаал дахь бүх зүйлийн үндэс суурь юм.

### ***Тушаал: Зүрхээ бүү шаналга, итгэ (Иохан 14:1).***

Петр сурсан зангаараа Есүсийн яриаг тасалж “Эээн, Та хаашаа явах юм бэ?” гэж асуухад Есүс түүний үгүйсгэлийг урьдаас өгүүлжээ. Тэгээд Тэр Петрт, бусад дагалдагчдад, мөн өнөөгийн бидэнд хандан “Зүрхээ бүү шаналга” гэсэн юм.

Иохан 13:38 эшлэлээр бүлэг төгсдөг учраас бид ихэвчлэн Иохан 14:1 эшлэлийг шинэ агуулга эхэлж байгаа мэт уншдаг. Гэхдээ Иохан 14:1 бол Петрт өгсөн хариултын нэг хэсэг юм. Үүнийг ингэж уншаарай.

Петр ээ, чи намайг гурван удаа үгүйсгэнэ. Чи бодож байгаагаасаа илүү сул дорой. Гэхдээ бүү цөхөр. Петр ээ, удалгүй Намайг баривчлагдах үед айсандаа зугтаж одох чамд болон та нарт зориулсан найдварын үг Надад байна. Зүрхээ бүү шаналга. Бурханд итгэ, бас Надад итгэ.

Петрийн бүтэлгүйтлээс үл хамааран, түүнд зориулсан найдварын мэдээ Есүст байгааг Петр мэдэх хэрэгтэй байлаа. Дагалдагчдын айдсаас үл хамааран, тэдэнд зориулсан найдварын мэдээ Есүст байгааг тэд мэдэх хэрэгтэй байлаа. “Зүрхээ бүү шаналга” гэх энэ үг одоо цаг дээр байна. Есүсийн сэрэмжлүүлэг болон шашны удирдагчдын эсэргүүцлээс болоод дагалдагчид айдастай байсан. Тиймээс Есүс “Зүрхээ шаналгааа боль. Бурханд итгэ... бас Надад итгэ” гэж хэлсэн юм.

Үйлчлэлийн дарамтаас болж шаналж зовохоос зайлсхийх цорын ганц зам нь итгэх юм. Дэлхий даяар урам нь хугарсан пасторууд Даваа гарагтай золгодог. Урьд өдөр нь таныг итгэмжтэй номлоход, чуулганы хэн нэг нь уурлаж байсан байх. Таныг гэмшлийн тухай номлоход хэн ч хариу үзүүлээгүй. Та үл итгэгчдийг урьсан, гэвч хэн ч ирсэнгүй.

Зарим улсад чуулганууд засгийн газрын эсэргүүцэл дор байна. Зарим улс оронд Исламын дайчид чуулганд заналхийлдэг. Түүнчлэн зарим улсад хэн ч анхаарал хандуулдаггүй нийгмийн ялгаатай байдал чуулганыг заналхийлж байна. Гэхдээ Есүс “Зүрхээ бүү шаналга, Бурханд итгэ, бас Надад итгэ” гэж хэлсэн юм.

**Амлалт: Би бол зам (Иохан 14:6).**

Есүс дагалдагч нартаа орон байр бэлдэхээр явна хэмээн тэднийг урамшуулсан. Тэгтэл Томас яриаг нь нь тасалж “Эзэн, Таны хаашаа явахыг бид мэдэхгүй. Бид тэр замыг яаж мэдэх вэ?” гэв.

Есүсийн хариулт нь христэч амьдралын чухал зарчмыг заадаг. Тэрээр “Би тийшээ явах гэж байна” гэж хэлээгүй, харин “Би бол зам” гэж хэлсэн юм. Есүс ямар нэг чиглэл заагаагүй, харин Өөртөө хандуулсан юм. Эцэг рүү хүрэх зам Христээр дамжина гэдгийг Бичвэр үүнээс илүү тодорхой яаж хэлэх билээ. Либерал теологичдын хэлдгээс тэс өөрөөр, Бурханд хүрэх цорын ганц зам бол Тэр өөрөө гэдгийг Есүс тодорхой мэдэгдсэн.

**Амлалт: Та нар агуу үйлсийг хийнэ (Иохан 14:12-14).**

Есүс “Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Учир нь Би Эцэгтээ очно” гэж амласан. Эдгээр үйлс нь үнэхээр гайхалтай учраас биш, харин өргөн цар хүрээтэй учраас агуу байгаа юм. Есүсийн газар дээрх үйлчлэл тодорхой бүс нутгийн хүрээнд хязгаарлагдаж байсан бол, одоо Есүсийн илгээсэн Сүнсний тусламжтайгаар чуулган дэлхий даяар агуу үйлсийг хийж байна.

Есүс цааш нь “Та нар нэрээр минь юу ч гуйсан, Эцэг Хүүгээр алдаршуулагдахын тулд Би түүнийг үйлдэнэ” гэсэн. Энэ амлалтад хоёр нөхцөл тавигдаж байна.

**(1) “Миний нэрээр гүй.”**

Энэ бол залбирлын төгсгөлд “Есүсийн нэрээр” гэж хэлэхээс илүү зүйл. Энэ бол Есүс бидний хүслийг биелүүлж өгөх тухай шидэт хэллэг ч биш. Харин Библийн туршид Бурханы нэр нь Бурханы зан чанарыг төлөөлдөг. Тиймээс “Есүсийн нэрээр залбирах” гэдэг бол Есүсийн зан чанар болон хүсэлд нийцүүлэн залбирах гэсэн үг.

Есүсийн нэрээр залбирах нь Хүүгийн эрх мэдлээр Эцэгт очно гэсэн үг юм. Мосе ЭЗЭНий нэрээр ярихаар Фараон дээр очихдоо (Гэтлэл 5:23) өөрийг нь илгээсэн Бурханы эрх мэдлээр очсон. Тиймээс Есүсийн нэрээр залбирна гэдэг нь Есүсийн зөвшөөрөл, эрх мэдлээр залбирна гэсэн үг. Бид Эцэг Бурхан руу бидний төлөө “зуучлан залбирахын тулд үргэлж амьд” байдаг Хүүгийн зуучлалаар очдог (Еврей 7:25).

**(2) “... Эцэг Хүүгээр алдаршуулагдахын тулд.”**

Бидний залбирал Бурханы алдрын төлөө байх ёстой. Иаков зарим нэг “гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулъя хэмээн буруугаар гуйдаг” хүмүүст анхааруулга өгчээ (Иаков 4:3). Есүсийн амлалтыг дурдах үедээ бид

өөрсдийнхөө зорилгын төлөө биш, харин Бурханы алдрын төлөө залбирч байгаа эсэхээ сайн мэдэж байх ёстой.

**Тушаал: Тушаалуудыг минь сахь (Иохан 14:15).**

Есүсийг хайрлах хайраа хэмжиж болох жишгийг Есүс бидэнд өгчээ. Тэр нь “Та нар Намайг хайрладаг бол тушаалуудыг минь сахь” гэсэн үг билээ. Иохан энэ тушаалыг санаж, эхний захидалдаа “Түүний үгийг сахидаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ” гэсэн байдаг (1 Иохан 2:5). Өнөөгийн зарим номлогчдын хэлдэг шиг тушаалыг нь зөрчин амьдарч болно гэж Есүс дагалдагч нартаа хэзээ ч зааж байгаагүй. Хайр бол дуулгавартай дагах хүслээс харагддаг.

**Амлалт: Тэр та нарт Туслагчийг илгээнэ (Иохан 14:16).**

Иохан 14:16 эшлэлд буй “Туслагчийг” хэмээн орчуулж байгаа үг бол хэн нэгнийг өмгөөлөхөөр ирж байгаа өмгөөлөгч гэсэн утгатай. Энэ бол бэрхшээлтэй хүнд үед тайтгаруулахаар ирэгч туслагч, тайтгаруулагчийг зааж байгаа үг юм.

Есүс Эцэг “... та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна” гэж хэлсэн. Энэ нь Ариун Сүнсний үйлчлэл Есүсийн үйлчлэлтэй адил гэдгийг зааж байна. Сүнс бол эзэн биегүй хүч биш, харин Есүс адил бодгаль нэгэн юм.

Туслагч бол “та нартай хамт... бөгөөд та нарын дотор” оршдог үнэний Ариун Сүнс юм. (Иохан 14:17). Тэрээр “та нарт хэлсэн бүгдийг минь сануулах болно” (Иохан 14:26) гэсэн. Түүний үйлчлэл бол Есүсийн хэлсэнчлэн маш хүчирхэг бөгөөд “Миний явах нь та нарт дээр. Би явахгүй бол Туслагч та нар дээр ирэхгүй” хэмээн Тэр батламжлан өгүүлсэн (Иохан 16:7).

Есүс явах нь дагалдагч нарт ямар ашиг тустай байв? Үүнийг Роберт Коулмэн ийнхүү тайлбарлажээ.

Есүс бие махбодын хэлбэрээр тэдэнтэй хамт байхад Сүнсэнд найдах хэрэгцээ бага байна гэж харсан [дагалдагчид]. Тиймээс ч дагалдагчид Есүсийн амьдралын бодит байдлыг гүн гүнзгий дотноор мэдэж чадахгүй байв. Харин Түүнийг явсны дараа тэдэнд нүдэнд харагдах дэмжлэг байхгүй болсон. Ингээд тогтож үлдэхийн тулд тэд Есүсийн Эцэгтэйгээ холбоотой дотно харилцааны нууцад суралцах ёстой болжээ. Хэрэгцээнээсээ болоод тэд өмнө нь хэзээ ч байгаагүй тийм дотно нөхөрлөлөөр Христтэй холбогдсон юм.<sup>56</sup>

**Усан үзмийн модтой холбогдох амьдрал**

► Иохан 15:1-16:37 эшлэлийг унших.

Есүс хамгийн хүчирхэг дүрслэлийнхээ нэг болох “Би бол усан үзмийн жинхэнэ мод, Эцэг минь усан үзэм тариалагч билээ” хэмээх үгээ энд хэлжээ. Хуучин гэрээнд Израилыг

---

<sup>56</sup> Robert Coleman, *The Mind of the Master* (Colorado Springs: WaterBrook Press, 2000), 29

байнга л усан үзмийн модтой зүйрлэдэг.<sup>57</sup> Гэхдээ Израил үндэстэн нүглээсээ болоод энэхүү үзмийн модыг тариалсан Бурханы зорилгыг биелүүлж чадаагүй юм. Харин Израил материаллаг талаараа хөгжин дэвжих тусмаа хуурамч бурхдад тахилын ширээ босгосон юм (Хосеа 10:2). Израил бусад үндэстнийг ерөөх үр жимс ургуулахын оронд зэрлэг усан үзэм ургуулжээ<sup>58</sup> (Исаиа 5:2). Израил маш их нүгэл үйлдсэн тул Бурхан энэ усан үзмийн модыг түлш болгон шатаахаас өөр юу ч хийж чадахгүй болсон байв (Езекиел 15:1-6).

Есүс жинхэнэ усан үзмийн мод адил ирсэн. Тэрээр Израил үндэстний хийж чадаагүй зүйлийг гүйцэлдүүлэхээр иржээ. Тэр үндэстнүүдэд ерөөл болох Израилын дуудлагыг биелүүлэхээр ирсэн юм.

Есүс дагалдагч нартаа өөрийгөө усан үзмийн мод, тэд бол мөчир гэдгийг хэлсэн бөгөөд Есүсийн захиас тодорхой байв. Үр жимстэй байх нь Түүний дотор байх бидний хүсэл эрмэлзлээс бүрэн шалтгаална.

Би бол усан үзмийн мод, та нар мөчрүүд. Хэн Миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр их жимс гаргана. Учир нь Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй (Иохан 15:5).

Усан үзмийн модноос салангид байвал дагалдагчид юу ч хийж чадахгүй. Бид ч бас тэр модноос салангид байснаар юу ч хийж чадахгүй. Хэрэв бид үйлчлэлээ өөрсдийнхөө хүч чадлаар хийх гэж зүтгэвэл урам хугаралт, хүчгүй байдлыг амсаж сүйрэхээс өөр гарцгүй. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл бид хэзээ ч өөрсдөөсөө үр жимс ургуулж чадахгүй.

Үзмийн модтой тасралтгүй харилцаатай байхаас бидний сүнслэг амьдрал хамааралтай. Хэрэв хэн нэг нь үзмийн модтой холбоотой байж чадахгүй “байваас мөчир мэт хаягдаж, хувхайрна. Тэдгээр мөчрийг түүж, галд хаяж шатаана” (Иохан 15:6). Энэ эшлэл сэрэмжүүлэг мэт боловч басхүү гайхалтай урам зориг ч бас мөн. Бид үзмийн моднос салангид байвал хэрэггүй, үнэ цэнгүй. Хэрэв бид усан үзмийн модтой тасралтгүй холбоотой байвал бидэнд амь ба үр жимс бий болно. Бидний сүнслэг амьдрал бидний хүч чадалд түшиглэдэггүй. Бид “Усан үзмийн модонд” амьдардаг.

Энэ сэдвийг Еврей номд мөн өгүүлдэг. Бидний агуу тэргүүн тахилч Есүс, Бурханд ойртон очигсдын төлөө “зуучлан залбирахын тулд үргэлж амьд” байдаг (Еврей 7:25). Тусгаарлагдсан мэт мэдрэмжтэй, зүдэрч байгаа пасторуудыг Ховард Хендрикс ийнхүү урамшуулжээ. “Хэрэв чиний төлөө залбирах хэн ч байхгүй бол, Христ чиний төлөө залбирч байгааг хэзээ ч бүү март. Тэр бидний зуучлагч, бидний сүнслэг амьдралын эх сурвалж юм.”

---

<sup>57</sup> Дуулал 80:8-9, Исаиа 5:1-7, Исаиа 27:2-6, Хосеа 10:1-2

<sup>58</sup> “Зэрлэг” гэдэг үг нь арчилж ургуулсан, таримал усан үзмийн амтлаг чанарын оронд “гашуун” амттай гэсэн санааг агуулдаг.

Есүс дагалдагч нартаа хандан усан үзмийн модтой холбогдож амьдрах ёстой гэдгийг сануулсан. Пастор, чуулганы ахлагчийн үйлчлэлийг та өөрийнхөө хүчээр хийдэггүй. Та усан үзмийн модны хүч дотор, хүч чадалгүй үед чинь таны төлөө зуучлан залбирдаг агуу Тэргүүн Тахилчийн хүч дотор амьдардаг.

Есүс сүүлчийн захиас сургаалынхаа үлдсэн хэсэгт дагалдагч нартаа дахин бие биенээ хайрлахыг заасан юм. Тэрээр тэднийг энэ дэлхийн үзэн ядалттай тулгарахад нь бэлтгэжээ. Дэлхий Есүсийг үзэн ядсан, дэлхий Есүсийн дагалдагчдыг ч үзэн ядах болно гэдгийг Тэр мэдэж байв.

Дараа нь Есүс Ариун Сүнсний ажлын талаар илүү ихийг тайлбарлажээ. Энэ ярианы эхэнд Тэрээр Ариун сүнснийг илгээнэ гэж амласан. Тиймээс энэ хэсэгт Ариун Сүнсний ажлын талаар илүү ихийг заажээ. Сүнс дэлхийг буруутгаж, харин дагалдагч нарыг бүх үнэн рүү хөтлөх болно. Тэрээр Хүүг алдаршуулах болно гэжээ.

Ингээд Есүс тун удахгүй явах тухайгаа тэдэнд тайлбарлав. Бэрхшээл дунд амар тайван байх талаар Тэр дахин ярьжээ. Энэ ярианы эхэнд “Зүрхээ бүү шаналга, Бурханд итгэ, мөн Надад итгэ” гэж тушааж байсан (Иохан 14:1). Тэрээр энэхүү яриагаа “Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан гэж айлдлаа” гэх урам зоригийн үгээр төгсгөсөн (Иохан 16:33).

Аль ч тохиолдолд бидний найдвар бол зөвхөн Христ гэдгийг анхаараарай. Бид Христэд итгэдэг бол санаа зовох хэрэггүй юм. Харин Христ дэлхийг ялсан учраас бид зүрх зоригтой байх болно. Усан үзмийн мод доторх амьдрал бол итгэж болох газар юм. Бидний итгэл найдвар нь энэ ертөнцийн нөхцөл байдалд тулгуурладаггүй. Харин энэ нь ертөнцийг ялан дийлсэн Христ дээр суурилдаг.

### **Сайтар ажиглах нь: Сүүлчийн зоог**

*Мишна* бол эртний иудейн уламжлалт бичвэр юм. *Мишнагийн* нэг хэсэгт иудейчүүд хэрхэн Алгасал баярын зоогийг сахиж байсныг тэмдэглэсэн байдаг.<sup>59</sup> Сүүлчийн зоогийн үеэр Есүс болон дагалдагч нар нь 2,000 жилийн турш мөрдөгдсөөр ирсэн энэ уламжлалыг дагасан бололтой.

Эхлээд устай хольсон дарс аягална. Энэ аягыг барих ерөөлийн залбиралд Гэтлэлийн үед өгөгдсөн “Би та нарыг гаргасан” гэх ерөөл багтана.

Хоёр дахь аяга нь мөн устай хольсон дарс боловч хараахан аягалахгүй. Тэгээд хамгийн залуу хүн нь “Энэ шөнө яагаад бусад шөнөөс ялгаатай байгаа юм бэ?” гэж асуудаг. Эцэг нь энэ үед израилчууд Египетээс гарсан түүхийг ярьж өгнө.

---

<sup>59</sup> Мессиад итгэдэг еврейчүүдийн Алгасал баярын зоогийн тухай видеог та <https://www.youtube.com/watch?v=bVolBDIWloQ>, линкээр үзээрэй. 2021 оны 3 сарын 22-нд нээлттэй байсан. Илүү дэлгэрэнгүйг <http://www.crivoice.org/haggadah.html>-с үзээрэй. Мөн 2021 оны 3 сарын 22-нд нээлттэй байсан.

Ингээд түүхийг ярьсны дараа гэр бүлээрээ *Алгасал баярын Халлел* буюу Дуулал 113-114-ийг аялгуулан уншина. Дараа нь “Би та нарыг тэдний боолчлолоос аварсан” гэх амлалтай цуг хоёр дахь аягыг ууна.

Ерөөлийн залбирлын дараа хоол авчирна. Баярын зоогт гашуун ногоо, исгээгүй гамбир, хурганы мах, халуун ногоо, цагаан цуу бүхий амтлагчуудаар хийсэн сүмс зэрэг багтана. Гэрийн эзэн гараа угаагаад гамбираа хугалж, хэсэг гамбирыг гашуун ногоотой сүмсэнд дүрээд иднэ. Тэгээд талархал өргөж, хурганы махнаас хэсгийг иднэ. Тэгээд гэр бүлийн гишүүн бүр ийнхүү иднэ.

Гурав дахь аяга дарсыг барихдаа Алгасалын амлалт болох “Би та нарыг аварна” гэх амлалтаар ерөөнө.

Дөрөв дэх аяга дарсыг барихдаа Алгасалын амлалт болох “Би та нарыг үндэстэн болгоно” гэх амлалтаар ерөөнө.

Ингээд гэр бүлээрээ Алгасалын Халлел дуу буюу Дуулал 115-118-г аялгуулан уншина.<sup>60</sup>

Алгасалын зоогийн үеэр еврейчүүд Бурхан хэрхэн Израилыг боолчлолоос аварсныг санан дурсдаг. Гэхдээ хамгийн чухал нь Мессиа тэднийг бүрмөсөн чөлөөлнө гэсэн Бурханы амлалт биелэхийг ихэд хүлээж байгаа хүлээлт юм.

Сүүлчийн зоог барьсны дараах өдөр нь Есүс Алгасалын төгс хурга болж, цовдлогдсон билээ. Загалмай дээр авралын амлалт бүрмөсөн биелэгджээ.

### **Тэргүүн тахилчийн залбирал**

► Иохан 17-р бүлгийг унших.

Есүсийн дагалдагчидтайгаа залбирсан сүүлчийн залбирал нь дагалдагчид болон өнөөгийн чуулганд үлдээсэн Түүний өвийг ойлгоход тун чухал ач холбогдолтой залбирал юм. Энэ залбирлыг “Есүсийн ариунаас ариун залбирал” гэж нэрлэдэг. Энэ бол Есүсийн хамгийн гүнзгий дотно залбирал байв.

### **Есүсийн өөрийнхөө төлөө залбирсан (Иохан 17:1-5)**

Эцэгтээ хандаж Есүс, “Хүү нь Таныг алдаршуулахын тулд Хүүгээ алдаршуулаач” гэж залбирсан. Дагалдагчид энэ залбирлыг тухайн үед ойлгоогүй боловч, тун удалгүй Ромын загалмай дээр энэ залбирлын хариу болох цочирдом үнэнтэй тулгарсан билээ.

Зовлонгийн долоо хоногийн Даваа гарагт Есүс, “Би газраас өргөгдвөл бүх хүнийг Өөртөө татна” гэж хэлж байсан. Үүнийг Иохан “Тэр ямар үхлээр үхэхээ илэрхийлэн үүнийг хэлжээ” гэж тайлбарласан байдаг (Иохан 12:32-33). Есүс ялалтаар

---

<sup>60</sup> Энэ хамгийн сүүлийн Дуулал бөгөөд Есүс дагалдагч нартайгаа Гетсемани цэцэрлэг рүү явахын өмнө үүнийг дуулжээ (Матай 26:30).



алдаршуулагдаагүй, харин ялагдлаар алдаршуулагдсан юм. Тэрээр загалмайгаар алдаршуулагдсан билээ.

### **Есүс дагалдагчдынхаа төлөө залбирсан (Иохан 17:6-19)**

Есүс дагалдагч нарынхаа төлөө гурван зүйлийг залбирсан. Эцэг тэднийг өөрийнх нь нэрээр хамгаалахын төлөө, бас дагалдагчид ёр муугаас хамгаалагдахын төлөө, мөн Эцэг үнэнээр тэднийг ариусгахын төлөө залбирсан юм.

### **Есүс бүх итгэгчдийн төлөө залбирсан (Иохан 17:20-26)**

Есүс ирээдүйд өөрт нь итгэх хүмүүсийн төлөө залбирсан. Тэрээр итгэгчдийг нэг байхын төлөө залбирсан бөгөөд энэхүү нэгдэл нь дэлхийд гэрчлэл болно гэдгийг илэрхийлж, “Та Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ” гэж хэлжээ.

Есүс ертөнцийн төлөө залбираагүй. Харин “Би ертөнцийн төлөө бус харин Таны Надад өгсөн хүмүүсийн төлөө гуйж байна” гэсэн юм (Иохан 17:9). Есүс өөрт нь итгэдэг хүмүүсийн төлөө залбирсан. Тэрбээр биднийг нэгдмэл байдал болон үр жимстэй байдлаараа энэ дэлхийд гэрчлэл болохын төлөө залбирчээ.

Зорилгыг нь энэ дэлхийд гүйцэлдүүлэх хэсэг бүлэг итгэгчид бол Есүсийн өв юм. Хуучин гэрээнд Бурхан Израилыг бүх үндэстэнд ерөөлийг нь хүргэх хэрэгсэл байлгахын тулд ерөөсөн юм (Эхлэл 12:1-3). Харин Шинэ гэрээнд Бурхан чуулганыг бүх ард түмэнд ерөөлийг нь хүргэх хэрэгсэл байлгахын тулд ерөөжээ. Бүх үндэстэнд ерөөл болох үүргээ биднийг биелүүлээсэй хэмээн Есүс бидний төлөө залбирсан.

### **Есүсийн дагалдагч нартаа өгсөн сүүлчийн захирамж**

► Матай 28:16-20, Марк 16:15, Лук 24:44-49, Үйлс 1:6-11 эшлэлийг унших.

Удирдагч хүний алсын хараагаа хэрхэн хуваалцах чадвараас түүний удаан үргэлжлэх нөлөө их хамаарна. Есүс бол тууштай бөгөөд дагалдагч нартаа урам зориг өгөхөөр алсын хараагаа хуваалцдаг удирдагчийн үлгэр дуурайл юм. Түүний алсын харааны ачаар дагалдагчид нь Ромын эзэнт гүрэн даяар Бурханы хаанчлалын мэдээг түгээхэд бүх амьдралаа зориулжээ.

Сайнмэдээний номууд Есүсийн захирамжид гурван даалгавар багтсан талаар өгүүлдэг. Даалгавар бүр агуу захирамжийн өөр өөр талыг онцолсон байна. Матай агуу захирамжид шаардлагатай эрх мэдлийг чухалчилсан бол Марк уг захирамжийг “хамаг бүтээлд” тунхаглахын чухлыг онцолжээ. Харин Лук элч нарын номлох сургаалын агуулгыг нэгтгэн дүгнэсэн байдаг.

Есүсийн өгсөн сүүлчийн захирамж буюу агуу захирамж бүтнээрээ Матай 28:18-20-д бий.

Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтун, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм

хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.

Агуу захирамжийн гол тушаал нь “дагалдуулагтун” юм. Энэхүү тушаалыг биелүүлэхийн тулд бид явж, шинэхэн итгэгчдэд баптисм хүртээж, залуу итгэгчдэд заах шаардлагатай. Эдгээр үйл ажиллагаа нь “дагалдуулагтун” гэх гол тушаалыг дэмждэг. Сайнмэдээ тараах, нийгэмд үйлчлэх, боловсрол болон үйлчлэлийн бусад бүх талбар нь “дагалдагч бэлтгэх” бидний тэргүүн зорилгоор хөтлөгддөг. Бид дагалдагч бэлтгэх захирамжийг хүлээн авсан хүмүүс.

### **Хоньчлох зорилго**

Америкийн пастор Эд Марккуарт олон жил коммунист шоронд хоригдож байсан Румыны пастор Ричард Вурмбрандтай оройн хоол иджээ. Хоолны үеэр Вурмбранд Марккуартын чуулганы нэг гишүүнээс “Танай пастор сайн пастор мөн үү?” гэж асуув. Өнөөх гишүүн “Тиймээ” гэв. Вурмбранд “Тэр яагаад сайн пастор вэ?” гэж асуухад нөгөө хүн “Сайн номлодог болохоор” гэжээ. Вурмбранд “Дагалдагч бэлтгэх тал дээр тэр юу хийдэг вэ?” гэж асуужээ. Энэ асуулт пастор Марккуартын бүхэл үйлчлэлийн чиглэлийг өөрчилсөн гэдэг. Тэрээр:

“Бүх пасторуудад зориулсан Бурханы зорилго бол Есүс Христийг хайрладаг, Есүс Христийг дагадаг, Есүс Христийг Эзэн гэж нэрлэдэг хүмүүсийг Есүс Христийн дагалдагч болгох ажил юм. Бид хүмүүсийг Христ Есүсийн дагалдагч болгох гэж л дуудагдсан. Тэрнээс биш чуулганы гишүүд болгох гэж биш, цуглааны сургалтад хамруулах гэж биш, чуулганы барилгын төлөө биш, харин хүмүүсийг Христ Есүсийн дагалдагч болгохоор бид дуудагдсан. Үүнд л хамаг учир байгаа юм”<sup>61</sup> гэж хэлсэн юм.

### **Сайтар ажиглах нь: Есүсийн өгсөн үүрэг даалгавар**

Есүсийн үйлчлэлийн сүүлийн долоо хоногт болсон үйл явдал нь бүх үндэстэн, угсаатан, бүх ард түмнээс бүрдсэн хаанчлалыг бий болгох эрхэм зорилгыг харуулж байна. Түүний сүүлийн долоо хоногийн үйл явдлууд нь Түүний бүх үндэстэнд хандсан захирамжийг илэрхийлдэг.

- Есүс хот руу илжиг унаад орсон. Матай, Иохан номуудад Зехариагийн эш үзүүллэгээс эш татаж, “Харагтун, танай хаан даруухнаар илжиг унаад ирж явна” гэсэн байна. Зехариа энэ хааны хаанчлалыг “Тэр **үндэстнүүдэд** амар тайвныг тунхаглаж, Түүний ноёрхол тэнгисээс тэнгис” хүрнэ хэмээн дүрсэлсэн байдаг (Матай 21:5, Зехариа 9:9-10).

---

<sup>61</sup> Edward Markquart “Pentecost: Go, Go, Go, Go, Go”, номлолоос. Дараах хаягаар үзээрэй.  
[https://www.sermonsfromseattle.com/pentecost\\_go\\_go\\_go\\_go\\_go.htm](https://www.sermonsfromseattle.com/pentecost_go_go_go_go_go.htm), 2022 оны 11 сарын 7-нд хандсан.

- Есүс Сүмийн харь үндэстнүүдийн талбайг цэвэрлэх үедээ Исаиа номоос эш татаж, “Миний гэр **бүх үндэстний** залбирлын гэр гэж нэрлэгдэх болно” гэж бичигдсэн бус уу?” (Марк 11:17, Исаиа 56:7-аас эш татсан) гэсэн юм. Иудейн удирдагчид иудейн шашинд дагаар орсон харь үндэстнүүдийн цуглаж залбирдаг хэсгийг мөнгө солигчид болон тагтаа зарагчдын наймааны зах болгосон байв.
- Дагалдагч нар Мариаг үнэт тос дэмий үрсэн хэмээн зэмлэх үед Есүс “Үнэнээр Би та нарт хэлье. Сайнмэдээ **бүх ертөнцийн** хаа ч тунхаглагдсан, энэ эмэгтэйг дурсаж, үйлс нь яригдах болно” гэж хэлсэн (Марк 14:9).
- Чидун уулан дээрх сургаалдаа Есүс “Хаанчлалын... сайнмэдээ дэлхий даяар тунхаглагдаж, **бүх үндэстэнд** гэрчлэл болно. Тэгэхэд л төгсгөл ирнэ” хэмээн эш үзүүлсэн байдаг (Матай 24:14). Хаанчлалыг зөвхөн сонгогдсон ард түмэнд зориулагдсан гэж бодсон эдгээр иудей дагалдагч нарт Есүс сайнмэдээ бүх дэлхийд тунхаглагдана гэж хэлсэн юм.

Хуучин гэрээний эш үзүүлэгчид ч Мессиаг бүх үндэстний төлөө ирнэ хэмээн харуулсан байдаг. Есүс олны өмнөх үйлчлэлийн сүүлийн долоо хоногтоо Бурханы хаанчлалд бүх үндэстний хүмүүс багтана гэдгийг зааж сургажээ. Энэ амлалт чуулганаар дамжин биелэгдэх ёстой байв.

### Есүсийн үлдээсэн өв: Үйлс ном дахь чуулган

Христийн амьдралын тухай олон ном Түүний дээш өргөгдсөн үйл явдлаар төгсдөг. Харин Есүсийн үйлчлэл зөвхөн загалмай юм уу, хоосон булш руу хөтөлдөггүй. Түүний үйлчлэл мөн Пентекост руу дагуулдаг. Дагалдагч нартаа хамт байх өөр нэг Туслагчийг илгээнэ хэмээн Есүс амласан юм (Иохан 14:16). Энэхүү амлалт Үйлс номд биелжээ. Үйлс номд гардаг хоёр үйл явдал Есүсийн өв биеллээ олсныг харуулдаг.

### Пентекостын өдөр чуулган мэндлэв

► Үйлс 1:4-11, Үйлс 2:1-41 эшлэлийг унших.

Түүнийг өргөгдөхийн өмнөхөн дагалдагчид “Эзэн, энэ цагт Та Израильд хаанчлалыг сэргээх үү?” гэж асуужээ. Тэд Есүсийг газар дэлхийн буюу улс төрийн хаанчлал байгуулна хэмээн найдаж байв. Тэдний бодлоор амилал нь газар дэлхийн хаанчлалыг бий болгох боломжийг улам бэхжүүлсэн хэрэг байв. Ромчуудыг түлхэн унагаахын тулд хүчээ ашиглах нь Есүсийн хийх ёстой бүх зүйл хэмээн тэд боджээ. Харин Есүс,

Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш. Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно гэв (Үйлс 1:7-8) гэсэн.

“Хаанчлалын цаг хугацаа та нарын хэрэг биш” гэж Есүс хариулаад, “Харин та нар Миний өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ёстой. Дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч

болж үйлчил. Гэхдээ явахаасаа өмнө жаахан хүлээж бай” гэсэн юм. Лук номд Есүс “Харин та нар дээрээс ирэх хүчийг өмстлөө энэ хотдоо үлд” гэж хэлжээ (Лук 24:49).

Алгасал баяраас хойш 50 хоногийн дараа дээд өрөөнд цугласан 120 дагалдагч дээр Ариун Сүнс бууж, амлалт биелэв. Тэд иудейн Пентекост баярт оролцохоор цугласан олон үндэстний хүмүүсийн хэлээр ярьжээ (Үйлс 2:4, 6-11). Энэ үйл явдал Христийн чуулган бүх үндэстнээс бүрэлдэх төлөвлөгөө биелснийг бэлгэддэг.

Үйлс 2-р бүлэгт дурдсан үндэстнүүдийн жагсаалт нь бидэнд Эхлэл 10-р бүлэгт дурдсан жагсаалтыг санагдуулдаг. Бурхан Эхлэл 11-р бүлэгт даян дэлхийн нэгдсэн хаанчлалыг Бабелд байгуулах гэсэн хүний оролдлогыг зогсоож, хэлийг нь хутгалдуулсан тухай өгүүлдэг. Харин Үйлс 2-р бүлэгт Бурхан хэлний будлианыг өөрчлөх байдлаар хаанчлалаа байгуулж эхэлжээ.

Пентекост бол Есүсийн амласан “эдгээрээс агуу ажлуудын” эхлэл байв (Иохан 14:12). Есүсийн өвийн биелэлт дөнгөж эхэлж, улмаар элч нарын үйлчлэл дээр амлагдсан Ариун Сүнс ажиллаж эхэлжээ. Энэ цаг үеэс чуулган Бурханы хаанчлалыг байгуулах Бурханы агуу зорилгыг биелүүлж эхэлсэн юм. Петрийн номлолд тодорхой дурдсанаар Хуучин гэрээний амлалтууд чуулганаар дамжин биелэгдэж эхэлжээ.

Жон Стотт Пентекостын өдрийн дөрвөн онцлогийг ийнхүү тайлбарлажээ.<sup>62</sup>

- Пентекостын өдөр бол Есүсийн газар дэлхий дээрх авралын үйлчлэлийн сүүлчийн үйл хэрэг байсан.
- Пентекостын өдөр элч нарыг агуу захирамжид бэлтгэсэн.
- Пентекостын өдөр Сүнсний шинэ эрин үе эхэлсэн. Хуучин гэрээний туршид Ариун Сүнс Бурханы үйлчлэгчдийг үйлчлэлийн онцгой үед хүчирхэгжүүлдэг байсан. Харин Пентекостын дараа бүх газар оронд байгаа болон бүх цаг үеийн итгэгчид Сүнсний үйлчлэлээс ашиг тус хүртэх боломжтой болсон.
- Анхны христитгэлийн сэргэлт Пентекостын өдөр эхэлсэн юм.

Пентекостын нөлөөг Үйлс номын бусад хэсгээс мөн харж болно. Пентекост баярын тэмдгүүд онцгой байв. Баяр хөөр, итгэгчдийн нөхөрлөл, мөргөл хүндэтгэлийн эрх чөлөө, гэрчлэх зориг, үйлчлэлийн хүч зэрэг нь Ариун Сүнсний хүч доторх үйлчлэлийн ердийн нотолгоо болсон юм.

### **Анхны чуулган дахь өдөр тутмын амьдрал**

► Үйлс 2:42-47 эшлэлийг унших.

Есүсийн өв биелснийг харуулсан хоёр дахь үйл явдал Үйлс 2-р бүлгийн төгсгөлд гарч байна. Энэ хэсэг анхны чуулганы итгэгчдийн өдөр тутмын амьдралыг харуулдаг.

---

<sup>62</sup> John W. Stott, *The Message of Acts* (Westmont, Illinois: InterVarsity Press, 1990), 60-61

Тэргүүн тахилчийн залбиралдаа Есүс дагалдагчдынхаа эв нэгдлийн төлөө залбирч байсан. Тэр “Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд” гэсэн юм (Иохан 17:22). Энэ залбирлын хариулт Үйлс 2-р бүлгээс харагддаг. “Итгэсэн бүгд хамтаараа байцгаан” тэд бүгд “нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж,” Бурхан “аврагдагсдыг тэдэн дээр өдрөөс өдөрт” нэмж байв.

Үйлс номд буй “нэг сэтгэлээр” гэх үг нь анхны чуулганы эв нэгдлийг илэрхийлнэ. Иудей ба харь үндэстний хүмүүсийг нэгтгэсэн чуулганыг байгуулах хэцүү боловч, иудейн удирдагчдын хавчлага, элч нарын дундах хувийн зөрчилдөөн дунд чуулган нэгдмэл байдлаа хадгалж үлдсэн. Бүхий л бэрхшээлийн эсрэг Есүсийн “... тэднийг нэг байлгахын тулд” гэсэн залбирал биеллээ олсон юм.

► Үйлс 2:42-47 дахь зураглал танай чуулгантай адил харагдаж байна уу? Та Ариун Сүнсний хүч дотор үйлчилж байна уу? Хэрэв үгүй бол, Ариун Сүнс таны үйлчлэлд болон танаар дамжуулан ажиллахад саад болох зүйл юу байна вэ? Дуулгаваргүй байдал уу? Эв нэгдэлгүй байдал уу? Итгэл дутагдаж байна уу? Та үйлчлэлдээ Сүнсний шинэ цутгалтыг хэрхэн харж болох вэ?

### **Хэрэгжүүлэлт: Өв үлдээх нь**

Тэтгэвэрт гарсан удирдагчид үйлчлэлдээ өв үлдээх, удирдлагаа орхих бэлтгэл болон шилжилтийн үеийн сургамжийнхаа талаар дараах зүйлсийг хуваалцсан юм.<sup>63</sup>

#### **(1) Ирээдүйн төлөвлөгөөг өв болгон үлдээдэг удирдагчид**

Барилгачин хүнээс “Та юу барьж байна вэ?” гэж асуусан гээд төсөөлье. Барилгачин “Одоохондоо мэдэхгүй байна. Би юу болохыг харахыг хүлээж байна” гэвэл та гайхан цочирдох биз.

Барилгачин хүн барилгаа барихаас өмнө эцсийн бүтээгдэхүүнээ төлөвлөдөг. Үүнчлэн өв үлдээдэг удирдагчид ардаа юу үлдээхийг хүсэж байгаагаа мэддэг юм.

Сайн төгсгөдөг удирдагчид ардаа юу үлдээхээ сайн мэддэг. Тэд үйлчлэлээ сохроор явуулдаггүй бөгөөд “Бурхан намайг миний үйлчилж байгаа энэ газар, үүнийг хийлгэхээр дуудсан” гэж итгэдэг хүмүүс юм.

---

<sup>63</sup> Энэ хэсгийн ярилцлагыг дараах удирдагчид өгсөн.

Dr. Michael Avery, God’s Bible School and College, Cincinnati, OH ерөнхийлөгч асан.

Rev. Paul Pierpoint, Hobe Sound Bible Church пастор, FEA Missions, Hobe Sound, FL, ерөнхийлөгч асан.

Rev. Leonard Sankey, тэтгэвэрт гарсан пастор, хэд хэдэн илгээлтийн байгууллагуудын удирдагч асан

Dr. Sidney Grant, FEA Missions, Hobe Sound, FL, ерөнхийлөгч асан.

Есүсийн өв бол чуулганыг удирдах хэсэг дагалдагчид байв. Үйлчлэлийнхээ эхнээс л Есүс тэдгээр эрчүүдийг өөрийнхөө өв болгон бэлтгэхийн тулд хангалттай цаг, хүч зарцуулдаг байсан.

Хэрэв та өв үлдээхийг хүсэж байгаа бол, та ирээдүйгээ төлөвлөх хэрэгтэй. Харамсалтай нь, олон хүн зорилгодоо анхаарал хандуулалгүйгээр амьдралаа бүтээдэг. Хэрэв та тэдний 30, 50, бүр 70 насанд нь “Та ямар амьдралыг бүтээж байна вэ?” гэж асуувал тэд “Би мэдэхгүй байна. Би юу болохыг харахаар хүлээж байна” гэж хариулах болов уу.

“Та өөрийнхөө өвийг амьдралынхаа төгсгөлд биш, харин өдөр бүр барьж байгуулдаг.”  
- Алан Вейс

## **(2) Өв үлдээдэг удирдагчид шилжилтэд хянуур бэлтгэдэг**

Дуусах шатандаа яваа томоохон барилгын төслийн ажилтантай та уулзсан гэж төсөөлье. Хана нь боссон, дээвэр дууссан, ашиглалтад орох ойрхон байна. Тэгээд та “Барилга дуусахад ямар ямар ажил үлдсэн бэ?” гэж асуулаа гэж бодъё.

Хэрэв та “Би мэдэхгүй, би хамаг цагаа сүүлчийн алхмуудыг бодож өнгөрүүлдэггүй” гэсэн хариулт сонсвол шууд цочирдон гайхна. Мэдээж тэгэхгүй! Барилгачин хүн өөрөөс нь илүү урт наслах зүйл хийж үлдээдэг. Тэрээр алхам бүрээ хянамгай төлөвлөдөг. Тиймээс “Энэ өдөр бид барилгыг дуусгана. Тэгээд эзэн нь нүүж ирнэ” гэж хэлж чаддаг. Шилжилтийн үеийн бүх зүйл төлөвлөгдсөн байдаг.

Өв үлдээдэг удирдагчид шилжилтэд хянамгай бэлтгэдэг юм. Боломжтой бол хэзээ үйлчлэлээ шилжүүлэхээ урьдчилан төлөвлөж, байгууллагынхаа залгамжлагчийг сонгон, залгамжлагчийгаа шинэ үүрэг хариуцлагад бэлтгэх боломжийг олгодог. Зарим тохиолдолд өмнөх удирдагч нь зөвлөгөө заавар өгөх боломжтой байх үед шинэ удирдагчийг бие даан шийдвэр гаргаж эхлэх хүртэл явж байгаа болон ирж байгаа удирдагчид түр хугацаанд үүргийг нь хуваалцаж болно.

Өв үлдээдэг удирдагчид үйлчлэлээ шилжүүлэх үйл явцад бэлтгэдэг. Явж байгаа үр нөлөөтэй удирдагчид Бурхан ирээдүйд хангана гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсээр байдаг ба, тэд хүмүүсийг дараагийн удирдагчийн дор сайн ажиллахад нь бэлтгэдэг. Тэд тухайн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс аюулгүй байдлыг мэдэрч байгаа эсэхийг анхаардаг. Нэгэн удирдагч “Ажиллагсад намайг явсныг мэдрэхгүй байхаар тийм жигд үйл ажиллагаатай болгох нь миний зорилго байсан” гэж бичжээ.

## **(3) Өв үлдээдэг удирдагчид хэзээ явахаа мэддэг.**

Удирдагчид үүргээ залгамжлагч нартаа шилжүүлээд, харамсахгүй явахад бэлэн байх ёстой. Хуучин удирдагчид зөвлөгөө өгөхөд бэлэн байх ёстой ч, залгамжлагч нь асуусан үед л үүнийг хийх хэрэгтэй.

Энэ курсээр Есүс чуулганыг удирдуулахаар дагалдагчдыг хэрхэн бэлтгэж байсныг бид үзлээ. Есүс бүр анхнаас нь тэднийг хянамгай сургаж байсан юм. Дараа нь тэднийг үйлчлэлд явуулж, эргээд үнэлж дүгнэхээр буцаан цуглуулж байсан. Сүүлчийн зоогийн

үеэр Есүс тэдэнд үйлчлэлийн талаарх сүүлчийн заавраа өгчээ. Дээш өргөгдөхийн өмнө Есүс тэдэнд сүүлчийн агуу захирамж бүхий сүүлчийн санамжаа өгсөн юм. Есүс шилжилтийн үеийн төлөө хянамгай бэлтгэжээ.

Харамсалтай нь шилжилтийн асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй христэд удирдагчид олон байдаг. Тэд “Би солигдох хүртлээ ажлаа хийнэ. Дараа нь юу болох нь өөр хүний асуудал” гэдэг. Мэдээж, гэнэтийн өвчин, үхэл, эсвэл үйлчлэлийн томоохон өөрчлөлт зэрэг нөхцөл үүсэх үед шилжилтэд хангалттай бэлтгэх боломжгүй байж болно. Гэхдээ боломжтой бол, бид ажил үүргээ дараагийн удирдагчид шилжүүлэх ажилд хянамгай бэлтгэх ёстой. Энэ бол ирээдүйдээ өв үлдээхийн төлөө авч хэрэгжүүлэх чухал алхмуудын нэг юм.

## **9-р хичээлийн даалгаврууд**

Эдгээр зааврыг ашиглан 3-5 хуудас эссээ бичнэ.

(1) Таны христитгэлийн амьдрал, үйлчлэлд нөлөөлөхүйц өв үлдээсэн үйлчлэлийн удирдагч, эсвэл гэр бүлийн гишүүнийхээ талаар бодоорой. Таны амьдралд үзүүлсэн тэдний нөлөөг дүгнэсэн нэг хуудас бичээрэй. Дараах хоёр асуултад хариул.

- Тэд таны амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?
- Тэд ийм нөлөө үзүүлэх юу хийсэн, эсвэл хэлсэн бэ?

(2) Та энэ хорвоог орхихдоо ямар өв үлдээмээр байна вэ? Хариултаа тодорхой илэрхийлээрэй. Энэ талаар 1-2 хуудас бич.

- Та гэр бүлдээ ямар өв үлдээмээр байна вэ?
- Та нийгэмдээ ямар өв үлдээмээр байна вэ?
- Та үйлчлэлдээ ямар өв үлдээмээр байна вэ?

(3) Даалгавар 2-т байгаа гурван асуултын хувьд та ардаа өв болгон үлдээхийн тулд одоо дагаж мөрдөхийг хүсэж байгаа үйл ажлаа тодорхойл. Хариулт 1-2 хуудас байна.

Бичсэн хуудсаа хадгалаад, дараагийн 6 сарын туршид долоо хоног бүр дахин уншиж байгаарай. Тэгээд хойч үедээ үлдээх өвөө төлөвлөхдөө үүнийгээ ашиглаарай.





# Хаанчлалын сайнмэдээ (номлол)

Профессор Данни Маккайн (Жос Их Сургууль, Нигери улс)

Хэдэн жилийн өмнө, Гамби улсын Эмир намайг урьсан юм. Хэдэн сарын дараа би ордонд нь очлоо. Албаны хүн Эмиртэй уулзахдаа дагаж мөрдөх ёстой дүрмийг надад тайлбарлаж, "Та ордонд орохдоо гутлаа тайлах ёстой. Эмир жирийн хүмүүстэй гар барьдаггүй тул та түүнтэй гар барьж болохгүй. Та Эмиртэй нэг түвшинд сууж болохгүй. Та хааныг "Эрхэм дээдэс" эсвэл "Сүр жавхлант эзэн" гэж дуудах ёстой" гэлээ.

Хаант улс бүр өөрийн гэсэн онцлог, дүрэм журам, захирагч удирдагчтай байдаг. Хэрэв та аливаа нэг хаант улсад харьяалагддаг бол тэр улсынхаа дүрэм журмыг ойлгох ёстой. Би энэ номлолыг Бичвэрийн хоёр эшлэл дээр үндэслэн заах болно. Эдгээрийг уншаад эхэлье.

Матай 6:9-10:

Тэнгэр дэх, бидний Аав аа, Таны алдар ариунаар дуurstугай. Таны хаанчлал иртүгэй. Таны таалал тэнгэрт шигээ газарт бас биелтүгэй.

Лук 9:1-2:

Есүс арван хоёроо цугт нь дуудаад, өвчнийг эдгээх болон бүх чөтгөрөөс дээгүүрх хүч, эрх мэдлийг тэдэнд өгчээ. Бурханы хаанчлалыг тунхаглуулан мөн өвчтэйг эдгээлгэхээр Тэр тэднийг илгээв.

Энэхүү номлолоороо би Бурханы хаанчлалын тухай том зураглалыг өгч, энэхүү үнэн бидний амьдралд хэрхэн хэрэгжиж болох талаар ярихыг хүсэж байна.

## Бурханы хаанчлал: Том зураглал

Би хүүхэд байхдаа "Бурханы хаанчлал" бол **Бурханы үүрд орших гэр буюу тэнгэр** гэж боддог байлаа. Хаанчлалын тухай олон эшлэлд үүнийг бидний мөнхийн гэр орон гэсэн байдаг. "Намайг 'Эзэн минь, Эзэн минь' гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч нь л орно" (Матай 7:21).

Би судлах тусмаа хаанчлал бол Бурханы мөнхийн гэр орон гэдгээс илүү утгатай зүйл гэдгийг ойлгож эхэлсэн юм. Хэсэг хугацаанд би хаанчлалыг **чуулгантай** адил, ерөнхийдөө нэг зүйл гэж итгэдэг байлаа. Харин торонд орсон загас мэтийн сургаалт зүйрлэлүүдээс хаанчлалын тухай зарим эшлэл нь тэнгэрийн улсын тухай биш гэдгийг харсан юм.

Мөн тэнгэрийн хаанчлал нь төрөл бүрийн загас барихаар тэнгист хаясан том тортой адил юм. Тор дүүрмэгц тэд түүнийг эрэг дээр татаж гаргаад, сайныг нь саванд хийн, харин мууг нь хаяна. Үеийн төгсгөл ч мөн ийм байх болно. Тэнгэрэлч

нар ирж, зөвтийн дундаас ёрын мууг ялгаж, тэднийг галтай зууханд хаяна. Тэнд уйлаан, шүд хавирах нь буй (Матай 13:47-50).

Энэ хэсэг чуулганд хамаарах ёстой. Манай чуулгануудад жинхэнэ итгэгч, хоёр нүүртнүүд аль аль нь байдаг шүү дээ. Гэхдээ Бурхан тэднийг чуулганы эрин үеийн төгсгөлд ялган ангилна. “Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч нь л орно” (Матай 7:21).

Тэгээд би судлах тусмаа Бурханы хаанчлал нь **чуулганаас илүү өргөн хүрээтэй** гэдгийг заасан эшлэлүүдийг олж мэдсэн. Есүс “Гэвч Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймд Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна” гэсэн байдаг (Матай 12:28). Хэрэв чуулган Пентекостын өдөр мэндэлсэн бол, хаанчлал үүнээс өмнө аль хэдийн ирчихсэн бөгөөд чуулган ба хаанчлал хоёр нэг ижил зүйл биш гэсэн үг.

Эдгээр бодол намайг хаанчлалын талаар бүхэлд нь, ерөнхий байдлаар харахад хүргэсэн юм. Үүнийг би одоо хиймээр байна.

### **Еден цэцэрлэг дэх Бурханы хаанчлал**

Бүтээлийн үед Бурхан “Бид дүр төрхийнхөө дагуу бидэнтэй адилхан хүнийг буй болгоё. Тэгээд тэднээр далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхдөг мөлхөгч бүгдийгд захируулъя гэж айлдав” гэжээ (Эхлэл 1:26). Бурхан хүмүүнийг бүтээхдээ өөртэйгөө ямар нэг байдлаар адилхан бүтээсэн байна.

Бурханы өөрийнх нь амьдардаг газрын хамгийн чухал шинж чанаруудыг агуулсан тийм газарт Бурхан хүмүүнийг амьдруулахаар бий болгосон гэдэг санаа үндэслэлтэй санагдаж байна. Тэгэхээр Еден цэцэрлэг ямар газар байсан бэ?

- Гэм нүгэл, ёс суртахууны доголдол байхгүй, яг тэнгэрийн улс адил байсан.
- Өвчин, үхэл байхгүй, яг тэнгэрийн улс адил байсан.
- Тэнд ямар ч таагүй зүйл байхгүй. Төгс төгөлдөр тэнгэрийн улс адил байсан.
- Эмх замбараагүй зүйл байхгүй, бүх юм ямар байхаар бүтээгдсэн тэр ёсоороо байдаг, тэнгэрийн улс адил байсан.

Еден цэцэрлэг бол тухайн үеийн газар дээрх Бурханы хаанчлал байлаа. “Өөрийнх нь буй болгосон бүгд нэн сайн болсныг Бурхан харлаа” (Эхлэл 1:31). Тэр цэцэрлэг бол газар дээрх Бурханы хаанчлалын талаарх анхны дүрслэл байв. Аливаа зүйл сайн байвал бүх зүйл өөрийн гэсэн байрандаа, зөв дараалалтай байдаг. Дэлхий дээрх бүх зүйл Бурханы хүссэнээр байсан. Тэр цэцэрлэг бол тэнгэр дэх Бурханы орон гэрийг тодорхойлж болох эмх цэгц, гоо үзэсгэлэн, төгс байдлын тусгал байсан юм.

### **Еден цэцэрлэг дэх Бурханы хаанчлал алдагдсан нь**

Бурхан газар дээрх Түүний хаанчлалыг хадгалах, хамгаалах арга замыг хүнд нарийвчлан зааварлаж өгчээ. Харамсалтай нь хүн Бурханы ариун итгэлийг хөсөрдүүлж,

Бурханы эсрэг нүгэл үйлдсэн юм. Үүний үр дүнд хоёр ноцтой нөхцөл байдал бий болжээ.

Нэгдүгээрт, нүгэл дэлхийд нэвтрэн орж, хүний доторх Бурханы дүр төрхийг гажуудуулахад хүргэжээ. Хоёрдугаарт, хүн Бурханы дүр төрхөө хэсэгчлэн алдсан учраас төгс газарт амьдрах чадваргүй болсон. Еден цэцэрлэгт хүн амьдрах аргагүй болжээ.

Тиймээс Бурхан тэднийг Еденээс зайлуулж, газар дэлхийг ч бас эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хараасан шигээ хараасан. Бурхан газрыг хараасан учраас өргөс, шарилж ургах болсон юм. Дэлхий гоо үзэсгэлэн, тав тух, үр бүтээл, аюулгүй байдлаа алдсан. Хүмүүс өмнө байсан өөрийнхөө ариун бодгалийнхаа сүүдэр төдий болж, газар дэлхий ч анх Бурханы бүтээсэн тэр байдлынхаа сүүдэр нь болжээ. Үүнийг энэ сургаалын үүднээс тайлбарлавал, үнэндээ дэлхий дээрх Бурханы хаанчлал нуран унасан юм.

- Бурханы бүтээсэн юмс муудсан.
- Бурханы сайхан болгосон юмс муухай болсон.
- Бурханы тав тухтай байхаар бүтээсэн зүйл хөндүүртэй зүйл болсон.
- Бурханы ариун байлгахаар төлөвлөсөн зүйл нүгэлтэй, гажуудсан зүйл болсон.
- Хүн төрөлхтөн ба газар дэлхийд хийхээр Бурханы төлөвлөсөн зүйл биелэхгүй болжээ.

Гэхдээ Бурхан бүтэлгүй биш. Тэр хэзээ ч ялагдахгүй. “ЭЗЭНийг сөрөн чадах мэргэн ухаан, бодрол ухаан, зөвлөгөө ч гэж ер үгүй” билээ (Сургаалт үгс 21:30). Сатан оролдож үзсэн, гэхдээ тэр хэзээ ч Бурханыг дийлэхгүй.

- Бурханы хийснийг хэн буцааж чадах вэ?
- Бурханы тийм гэснийг хэн үгүй болгож чадах вэ?
- Бурханы бүтээснийг хэн сүйрүүлж чадах вэ?

Бурхан ялагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Харин Бурхан буруутсан юмсыг буцааж, эргүүлэн сэргээх чадвартай. Бурхан бол Эзэн, чөлөөлөгч юм.

Бурхан газар дэлхий дээрх хаанчлалаа сэргээх төлөвлөгөө гаргасан.

Давидын сэнтий дээр Түүний хаанчлал дээгүүр засаглал хийгээд амар тайван нь тэлэхүйд эцэс үгүй. Шударга ёс, үнэн зөвөөр үүнийг өдгөөгөөс өнө мөнхөд тогтоон тулна. Түг түмдийн ЭЗЭНий зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно (Исаиа 9:7).

Адам Ева хоёр нүгэлд унахаас бүр өмнө, Бурхан хаанчлалаа газар дэлхий дээр сэргээж, дахин байгуулах төлөвлөгөөтэй байсан. Бурханы хамгийн чухал зорилгын нэг нь Бурханы хаанчлалыг тэнгэр дэх шигээ газар дэлхий дээр сэргээх тухай дүрслэл юм. Сэргээх ажил одоо ч үргэлжилж байна. Бид энэ үйл явцын эхлэлийг Эхлэл 12:1-3 эшлэлээс харж болно.

## Бурханы хаанчлал ба Абрахам

Абрахам Халдейн Ур хотод байхдаа энэ үгийг хүлээн авчээ:

Чи эх нутгаасаа, төрлүүдээсээ мөн эцгийнхээ гэрээс гарч чамд Миний харуулах нутаг уруу явагтун. Чамаас Би **агуу үндэстнийг гаргаж**, чамайг бас Би ерөөн, чиний алдрыг Би агуу болгоно. Чи тэгээд ерөөл болтугай! Чамайг ерөөгчдийг Би ерөөж, чамайг хараагчийг Би хараана. Газар **дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно** гэв (Эхлэл 12:1-3, онцлон тэмдэглэв).

Энд **хаанчлал** гэдэг үгийг ашиглаагүй боловч, энэ эшлэлд дурдсан хоёр амлалтын улмаас Бурхан дэлхий дээрх хаанчлалаа сэргээж эхэлсэн гэдэгт бид итгэдэг.

### Бурхан агуу үндэстэн Израилыг байгуулахаа амласан

Хуучин гэрээний гуравны нэгд энэ үндэстний байгуулагдсан тухай өгүүлдэг нь сонирхолтой.

Энэ үндэстнийг байгуулах өөрийнхөө төсөлд Бурхан хоёр зарчмыг ашиглаж байгаа юм шиг харагддаг.

1. Бурхан газар дэлхийд ажиллахдаа үргэлж хүнээр дамжуулан ажилладаг. Бурхан энэ дэлхий дээр хүссэн ажлаа хийлгэхдээ ерөнхийдөө тэнгэрэлч нарыг ашигладаггүй.
2. Бурхан энэ дэлхий дээр ажиллахдаа хатуу, удаан, хүнд хэцүү, үйл явцтай замаар буюу бидний аливааг хийдэг арга барилаас эсрэг байдлаар ажилладаг. Энэ үндэстнийг байгуулах зам саад бэрхшээлээр дүүрэн байсан. Гэсэн ч эцэстээ биелсэн юм.

Энэ үндэстнийг байгуулснаар Бурханы газар дээрх хаанчлалаа сэргээх ажил бүрэн биелсэн гэж би бодохгүй байна. Гэхдээ энэ чиглэлд хийсэн алхам мөн байсан. Бурхан газар дээрх ард түмнээ захирч болдог гэдэг нь энэ хаанчлалаас харагддаг. Харамсалтай нь, хүний хүчин зүйлээс болоод үүний хэсэгхэн нь амжилт олсон юм.

### Абрахамын үр удмаар дамжуулан газар дээрх бүх үндэстэн ерөөгдөнө гэж Бурхан амласан.

“... Газар дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно гэв” (Эхлэл 12:3). Есүс ирснээр энэ амлалт биелэгдсэн юм.

## Бурханы хаанчлал ба Есүс

Лук номд өгүүлснээр Есүсийн баптисм, сорилтын дараах эхний үйл явдал нь Түүний Назар хотын синагогт очсон тухай түүх юм. Есүс уугуул хотынхоо синагогт очиж, сайн дураар Бичвэрээс уншжээ. Тэр өдрийн уншлага нь Исаиа 61-р бүлэг байв.

“Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах, сохруудад хараа оруулах, дарамтад байгсдыг чөлөөлөхийн сацуу, Эзэний тааламжит жилийг тунхаглахын тулд болой гэж уншаад, номоо хуйлж харгалзагчид эргүүлэн өгөөд, суув. Синагогт байсан бүгдийн нүд Түүнийг ширтэн байлаа. Тэр тэдэнд—Энэхүү Бичвэр өнөөдөр сонсголд тань биеллээ гэж айлдав” (Лук 4:18-21).

Үйлчлэлийнхээ эхэн үед Есүс, Бурханы хэдэн зуун жилийн туршид хийж ирсэн шинэчлэн сэргээх ажлыг үргэлжлүүлэхээр тэнд очсон гэдгээ хүчтэй илэрхийлсэн байдаг.

- Нүглийн үр дагавраас болоод дэлхий сүнслэг болон материаллаг талаараа ядуурсан. Гэсэн ч Есүс “ядууст сайнмэдээг хүргэхийн” тулд тослогдсон гэдгээ тунхагласан билээ.
- Уналтаас болоод хүн төрөлхтөн нүглийн хоригдол болсон. Гэсэн ч Есүс “олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах” гэж ирсэн гэдгээ хэлжээ.
- Уналтаас болоод хүн төрөлхтөн сүнсний хувьд сохорсон учраас хүмүүс үнэнийг ойлгож чадахгүй болсон. Зарим хүмүүс бие махбодын хувьд ч сохор болсон. Гэсэн ч Есүс “сохруудад хараа оруулах” гэж иржээ.
- Уналтаас болоод чөтгөр болон түүний гар хөл бологчид хүмүүсийг олон талаар дарамталдаг болсон. Гэсэн ч Есүс “дарамтад байгсдыг чөлөөлөхийн” тулд ирсэн гэж хэлсэн юм.

Нүглээс болоод газар дэлхий дээр буусан олон хараалыг арилгах нь өөрийнх нь зорилго юм гэдгийг Есүс хэлсэн. Өөрөөр хэлбэл, дэлхий дээр Бурханы хаанчлалыг байгуулах үйл явцыг үргэлжлүүлэхийн тулд Есүс дэлхий дээр ирсэн юм. Бүр цаашилбал, Абрахамд өгсөн хоёр дахь амлалт буюу газар дээрх бүх үндэстэнд ерөөл болохоор Есүс энэ дэлхийд иржээ. “Тэр цаг биелэлээ оллоо. Бурханы хаанчлал айсуу. Гэмшиж, сайнмэдээнд итгэгтүн гэж байлаа” (Марк 1:14-15). Тиймээс Есүсийн үйлчлэлийн туршид Түүний номлол сургаалын гол цөм нь хаанчлал байсан юм.

### **Бурханы хаанчлал ба чуулган**

Хуучин гэрээний үед Бурханы ажиллаж байсан суваг нь Израил үндэстэн байв. Шинэ гэрээнд Бурханы ажиллах суваг нь чуулган болов. Чуулган хэд хэдэн шалтгаанаар Хуучин гэрээнээс давуу юм.

- Чуулганд зөвхөн иудейчүүд биш, харин дэлхийн бүх үндэстэн багтсан.
- Чуулган хүн бүрд Ариун Сүнснийг авах боломжийг олгодог бол Хуучин гэрээний үед зөвхөн сүнслэг агуу хүмүүс л Сүнснийг хүлээн авдаг байв.
- Чуулган хувь хүний Бурхантай харилцах шинэ харилцаанд ач холбогдол өгдөг.

- Чуулган нь амьтнаар тахил өргөх хатуу ёслолоор биш, харин **сүнсээрээ, үнэнээр** хүндэтгэн мөргөхөд ач холбогдол өгдөг.

### **Бурханы хаанчлалын талаарх Есүсийн сургамж**

Есүсийн амьдрал, номлолоос хаанчлалын талаар сурч болох зарим хичээл бий.

**(1) Бурханы хаанчлалд газар зүйн хил хязгаар байхгүй ч, Хаан хаана байна, тэнд хаанчлал оршдог.**

- Есүс хуримд зочлон очихдоо дарсаар хангаж өгсөн. Учир нь Түүний оршихуйн улмаас хаанчлал нь тэр газарт тархаж байв.
- Есүс өвчтэй хүмүүстэй уулзахдаа эдгээж өгдөг байсан. Яагаад гэвэл Түүний хаанчлалд өвчтэй, зовлонтой хүмүүс ч багтах болсон.
- Есүс өлсгөлөн хүмүүстэй уулзахдаа хооллож ундалдаг байсан. Яагаад гэвэл Түүний хаанчлал хүмүүсийн үндсэн хэрэгцээг анхаардаг.

Есүс дагалдагчдынхаа очсон газар бүрийг хамруулан хаанчлалаа тэлэхийг хүсэж байна. Хааны хүмүүс хаана байна, тэр газар Түүний хаанчлалын нэг хэсэг болдог. Хааны гэр бүлийн нэг хэсэг болсон бидний хувьд энэ бол бидний үүрэг хариуцлага мөн. Дэлхий дээрх бидний нөлөөллийн бүс нутагт буюу бидний хамаарч байгаа газарт Есүсийн засаглал байгаа эсэхэд бид анхаарал тавих ёстой.

- Бид гэр бүл дээрээ Бурханы хаанчлалыг байгуулах ёстой.
- Бид нийгэмдээ Бурханы хаанчлалыг байгуулах ёстой.
- Бид ажлын байрандаа Бурханы хаанчлалыг байгуулах ёстой.
- Бид орон нутгийн болон үндэсний засаг захиргаан дээрээ Бурханы хаанчлалыг байгуулах ёстой.
- Бид чуулган, христэч байгууллагууд дээрээ Бурханы хаанчлалыг байгуулах ёстой.

Хааны харьяат хүн хаана байна, тэнд хаанчлал байгуулагдах ёстой. Тийнхүү бидний гэр орон, албан газар Бурханы хаанчлалыг төлөөлдөг. Хамт ажиллагсадтайгаа харилцах харилцаа маань Бурханы хаанчлалыг харуулна. Элч Петр ийнхүү бичжээ.

Хайртууд аа, сэтгэлийн чинь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэхийг ирмэл агаад түр суурьшигч та нараас би гуйя. Харийнхан дунд биеэ зөв авч яв. Ингэснээр тэд та нарыг муу муухайг үйлдэгчид хэмээн гүтгэвч, сайн үйлсийг чинь хараад Түүний харгалзлын өдөр Бурханыг алдаршуулах болно (1 Петр 2:11-12).

Бидний дотор буй хаанчлалыг хаанчлалын иргэд болоогүй хүмүүс олж хараасай гэж Бурхан хүсдэг. Бид зөвхөн хаанчлалын зарчмын дагуу амьдрах үед л тэд амьдралаас

маань хаанчлалыг олж харж чадна. Хүмүүс таны дотроос Бурханы хаанчлалыг олж харж байна уу?

**(2) Бурханы хаанчлал тодорхой бүлэг хүмүүст бус, харин Түүнийг дагадаг бүх хүнд зориулагдсан.**

Есүс Ромын (харь үндэстэн) цэргийн даргын зарцыг эдгээхдээ,

Би та нарт хэлье. Дорноос хийгээд өрнөөс олноороо ирцгээж, **тэнгэрийн хаанчлалд** Абрахам, Исаак, Иаковтай хамт ширээнд тухлах болно (Матай 8:11, онцлон тэмдэглэв) гэж хэлжээ.

Бурханы хаанчлалд угсаа гарал, хэл, яс үндэс хамаарахгүйгээр бүх ард түмний хүмүүс багтана. Есүс янз бүрийн гаралтай хүмүүсийг сонгосон учраас бид Есүсийн дагалдагч болох янз бүрийн гарал угсаатай хүмүүсийг хүлээн авах ёстой. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, бүлэглэх нь Бурханы хаанчлалын нэг хэсэг биш юм.

**(3) Бурханы хаанчлал бол үнэтэй ордон, чамин хувцас биш, нийгмийн үнэт зүйлстэй холбоотой.**

Хаанчлалын талаар бодоход бид ихэвчлэн хааны өргөө буюу ордны тухай боддог. Харин Есүс “Үнэгэнд нүх, тэнгэрийн шувуудад үүр байдаг ч Хүний Хүүд толгой хоргодох газар ч үгүй” гэсэн юм (Матай 8:20). Есүсийн хаанчлал нь эд баялаг, гоёмсог барилга байгууламж, гоёмсог хувцас, чамин гоёл чимэглэлээр тодорхойлогдохгүй. Есүсийн хаанчлал бол ийм гадаад зүйлсээр бус, харин эерэг үнэт зүйлсээр тодорхойлогддог.

**(4) Бурханы хаанчлал бол хорон санаа, заль мэхээр биш, зөвт байдал, үнэнээр тодорхойлогддог.**

Есүс “та нарын зөвт байдал фарисайчууд болон хуулийн багш нарынхаас илүү гарахгүй л бол та нар тэнгэрийн хаанчлалд яавч орохгүй” гэж заасан (Матай 5:20). Энд дурдсан зөвт байдал бол теологийн ойлголт биш, харин практик сайн сайхан байдал юм. Фарисайчууд хүмүүсийг гайхшируулж, хүндлүүлэх гэсэндээ гаднаа зөвт харагддаг байсан. Гэхдээ жинхэнэ зөвт байдал эдгээрээс илүүтэй шударга ёс, сайн сайхан байдал юм. Есүсийн хаанчлал зөв зүйлийг хийдэг хүмүүсээр тодорхойлогдоно. Бурханы хаанчлал элбэг дэлбэг газарт ч, дутмаг хоосон газарт ч өрнөн дэлгэрэх боломжтой. Бурханы хаанчлал бол биет, материаллаг хаанчлал биш, харин ариун журам, үнэт зүйлсийн хаанчлал учраас энэ нь үнэн билээ.

**(5) Бурханы хаанчлал бол бардамнал, ёс жаягаар тодорхойлогдохгүй, харин даруу зан, үйлчлэх сэтгэлээр тодорхойлогддог.**

Есүс “Сүнсэндээ ядуус ерөөлтэй еэ! Тэнгэрийн хаанчлал тэднийх юм” гэсэн (Матай 5:3). Тиймээс даруу байдлыг илэрхийлсэн “Сүнсэндээ ядуус” гэсэн хэллэг байгаа юм. Даруу байдал нь энэ дэлхийн улс төрийн удирдагчдад ихэвчлэн байдаггүй. Яагаад гэвэл улс төрчид өрсөлдөгчдөөсөө илүү гэдгээ бусдад хэлэх ёстой. Харин Есүсийн хаанчлал нь даруу байдал, өөрийгөө зориулах, бусдыг өргөх байдлаар тодорхойлогддог.

Хаад ноёдыг хүмүүс ихээр магтаж, зусарддаг учраас тэд бардам болж, өөрсдийгөө хамгийн чухал гэж боддог. Тэдний хандлага ихэмсэг байдаг. Харин Есүс “Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин **үйлчлэхийн тулд** мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ” гэсэн юм (Матай 20:28, онцлон тэмдэглэв). Хаан эдгээр хүмүүсийг хаашаа ч явсан дагуулан явж, мэддэг зүйлээ зааж өгдөг байв. Энэ хаан дагалдагч нарынхаа хөлийг ч угаахад бэлэн байжээ. Бид энэ хаанчлалын мөн чанарыг ганган чамин зүйлээр бус даруу, энгийн байдлаар харуулдаг.

### **(6) Бурханы хаанчлал энгийн төрөлтөөр биш, харин Есүсийн дагалдагчдын үйл ажиллагаагаар өсдөг.**

Есүс “Би чамд **тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг** өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно” гэсэн (Матай 16:19, онцлон тэмдэглэв). Бурханы бүтээсэн хаанчлал нүгэл, харанхуй, цөхрөлд унах үед Бурхан дэлхийг сэргээх ёстой болжээ. Бурхан хүн төрөлхтөнд хүмүүсийг Бурханы хаанчлал руу аваачих болон нийгмийн бүх хэсэгт Түүний хаанчлалыг барьж байгуулах үүрэг хариуцлагыг өгсөн. Тэрээр хаанчлалаа байгуулах ажилд тэнгэрэлч нарыг илгээхгүй. Харин та биднийг энэ ажилдаа ашиглана. Бурханы хаанчлалын хэсэг болсон хүмүүс:

- Хүмүүсийг хаанчлал руу авчрах,
- Хаа байгаа газартаа хаанчлалыг байгуулах,
- Нийгмийн бүх хэсэгт хаанчлалын зарчмыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагатай.

Энэ бол бидний хариуцлага, онцгой эрх юм. Хүмүүсийг Бурханы хаанчлалд оруулахад идэвхитэй байцгаая.

### **Бурханы хаанчлалын сайнмэдээг Үйлс номд өгүүлсний адил хэрэгжүүлэх нь**

Газар дээр тэнгэр дэх шиг хаанчлал байгуулагдсаныг харахын төлөө залбирсан Есүсийн залбирлыг анхны чуулганыхан хэрхэн биелүүлэхийг хичээж байсныг бид одоо үзнэ. Эдгээр жишээг анхаарна уу.

#### **Тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэх**

Бурхан үргэлж гачигдагсдад, тэр дундаа бэлэвсэн эхнэрүүд, өнчин хүүхдүүд, ядуучуудад үргэлж анхаарал халамж тавьж ирсэн. Тиймээс Есүсийн дагалдагчид газар дээр Бурханы хаанчлалыг байгуулах бодит үйл ажилд оролцож байсанд гайхах зүйлгүй.

Үйлс 6-р бүлэгт анхны итгэгчид бэлэвсэн эхнэрүүдэд санаа тавьж байгаа тухай өгүүлдэг. Доркас гэдэг нэгэн итгэгч эмэгтэй “сайн үйл, өглөгөөр дүүрэн” байсан (Үйлс 9:36). Паул Барнаб хоёр ган гачгаас болж зовж зүдэрч байгаа Йерусалимын итгэгчдэд туслах мөнгөн тусламжийг хүргэсэн (Үйлс 11:29). Мөн Үйлс номын сүүлийн хэсэгт Македон ба Ахайн чуулгануудаас Паул өргөл цуглуулж, Йерусалимд байгаа ядууст аваачиж өгсөн (Үйлс 24:17) талаар өгүүлдэг.



Бидний хэрэгцээний тухайд Бурханы хаанчлалын зарчим ямар байх учиртайг Паул 2 Коринт 8:13-15-д ийнхүү хэлжээ.

Бусдын хувьд хөнгөн болж, та нарт зовлон болоосой гэсэндээ бус, харин тэгш байхын үүднээс ингэв. Өнөө цагт та нарын элбэг дэлбэг байдал тэдний хэрэгцээг хангаснаар тэдний элбэг дэлбэг байдал бас та нарыг хангах болно. Тэгэхлээр тэгш байх болно. Энэ нь "Ихтэйд нь илүү гарсангүй, багатайд нь дутсангүй" гэж бичигдсэнчлэн юм.

Гачигдагсдад туслах ажилд биднээс ер бусын чадвар шаардаад байхгүй олон арга зам бий. Бид нийгмийнхээ хүнд нөхцөл байдлыг арилгах оролдлого хийхдээ Бурханаас бидэнд ер бусын арга замаар хангаж өгөхийг хүлээгээд суух ёсгүй юм.

### **Шударга ёсыг дээдлэх**

Бурханы хаанчлалын нэг чухал хэсэг бол шударга ёс юм. Анхны чуулганыхан нийгмийн шударга ёсны асуудалд хэрхэн хандаж байсан бэ? Иудей удирдагчид Петр Иохан хоёрт дахиж Есүсийн нэрээр сургаал заахгүй байхыг тушаахад тэр хоёр сайнмэдээг номлох үүрэг авсан учраас дуулгавартай байхгүй гэдгээ эелдгээр хариу мэдэгдсэн юм. Тиймээс тэдгээр удирдагчдад хандан "Бид хүнээс илүүтэйгээр Бурханд дуулгавартай байх ёстой" гэжээ (Үйлс 5:29).

Паулыг Филиппой хотод хууль бусаар саатуулж, зодсоны дараа тэндхийн цэргийн дарга нар Паулыг сэмээрхэн явуулахыг оролдсон боловч, Паул тэднийг ирж гуйх хүртэл шоронгоос гарахаас татгалзсан юм. Энэ бол сайнмэдээний төлөө хийсэн үйлдэл байгаагүй. Паул энэ үйлдлээрээ тэдгээр хүмүүсийг Христ рүү ирүүлэх гээгүй. Харин энэ бол шударга ёсны төлөөх үйлдэл байсан юм. Паул эдгээр удирдагчийг нийгэмд шударга ёсны зарчмаар байлгахыг оролдож байсан хэрэг. Паул сайнмэдээ тарааж, чуулган байгуулах ажлыг л анхаарч байсан бус, харин өвчилсөн нийгэмд амьдарч байсан хүнийхээ хувьд тэрхүү эмгэгийг, тэр дундаа шударга бус байдлын өвчлөлийг эдгээхийн төлөө боломж бүрийг тийнхүү ашиглаж байжээ.

### **Эрүүл мэндийг сэргээх**

Паул яг Эзэн шигээ бусад хүмүүсийг ер бусын аргаар эдгээх чадвартай байлаа. Гэхдээ энэ бол түүний ашиглаж байсан цорын ганц хэрэгсэл байгаагүй. Паул Тимотод "Үүнээс хойш зөвхөн ус битгий уу. Харин ходоодныхоо байнгын өвчний улмаас бага зэрэг дарс хэрэглэ" гэсэн байдаг (1 Тимот 5:23). Усан үзмийн шүүсээр хийсэн дарсанд маш их төмөр агуулагддаг. Тиймээс бага хэмжээгээр уувал цусанд сайнаар нөлөөлнө. Паул Тимотыг өвчнөөсөө ангижрахад нь туслах энэхүү байгалийн аргыг зааж өгсөн байна.

Есүс дагалдагч нараа номлуулахаар илгээсний дараа тэдэнд "Та нар зэлүүд газарт оч. Жаахан амар" гэжээ (Марк 6:31). Эрүүл байхын тулд амрах хэрэгтэй гэдгийг Есүс ойлгодог байжээ.

Иаков эдгэрлийн талаар сонирхолтой үг хэлсэн байна.

Та нар дунд хэн нэг нь өвчтэй байна уу? Тэр нь чуулганы ахлагчдыг дуудаг. Тэд Эзэний нэрээр түүнийг тосоор тосолж, түүний төлөө залбираг. Итгэлийн залбирал нь өвчтэй нэгнийг эдгээж, Эзэн түүнийг босгоно. Тэр нүгэл үйлдсэн болвоос тэрээр уучлагдах болно (Иаков 5:14-15).

Тослох гэсэн утгатай хоёр өөр грек үг байдаг. Нэг үг нь ёслолын тосолгоо, нөгөөх нь эмчилгээний болон гоо сайхны зориулалтаар тос түрхэхэд хэрэглэгддэг. Эрт дээр үеийн энгийн хүмүүсийн анхны тусламжийн эм нь тос байжээ. Сайн самари хүн зэвсэгт дээрэмчдийн гарт шархадсан хүнийг олоод, шархан дээр нь тос асгасан байдаг. Эдгэрлийг гүйсан хүний залбиралд Бурхан ер бусын аргаар эдгээх замаар хариулж болно. Түүнчлэн эм ашиглан, хүнийг байгалийн аргаар эдгээхийг сонгож ч болдог.

### **Дүгнэлт**

Бурхан тэнгэр дэх шигээ хаанчлалыг газар дээр байгуулахыг хүсдэг. Энэ хаанчлал газар зүйн байрлал, хэл, улс төрийн шинжээр бус, харин зарчмаар удирдуулдаг хаанчлал юм. Бид Бурханы хаанчлалын зарчмуудыг зааж, хэрэгжүүлснээрээ амьдралынхаа тухайн талбарт Бурханы хаанчлалыг байгуулж байдаг.

## Санал болгох эх сурвалжууд

Энэхүү курс хичээлээр Есүсийн амьдрал, үйлчлэлийг өнөөгийн амьдрал, үйлчлэлийн үлгэр дуурайл болгон суралцдаг. Ингэхдээ Сайнмэдээний номуудыг бүхэлд нь авч үзэхгүй ч, Есүсийн үйлчлэлийг харуулдаг тодорхой хэсгүүдээс суралцаж, өнөөгийн үйлчлэлдээ сургамж авдаг. Хэрэв та Христийн амьдралыг илүү дэлгэрэнгүй судлахыг хүсвэл дараах номуудын жагсаалтыг үзнэ үү. Эдгээр номууд нь тус курсын үндсэн эх сурвалж юм.

Darrell Bock-ын *Jesus According to Scripture* болон J. Dwight Pentecost *The Words and Works of Jesus Christ* номууд нь Христийн амьдралыг бүрэн дүүрэн танилцуулдаг.

Ajith Fernando-ын *Jesus Driven Ministry* болон Robert Coleman-ны *The Master Plan of Evangelism* нь Есүсийн үйлчлэлийн хэв маягийг ойлгоход туслах хамгийн их санал болгодог номууд юм.

Blomberg, Craig. *Jesus and the Gospels*. Nashville: Broadman & Holman, 1997.

Bock, Darrell L. *Jesus According to Scripture*. Grand Rapids: Baker Academic, 2002.

Coleman, Robert E. *The Mind of the Master*. Colorado Springs: Waterbrook Press, 1977.

Coleman, Robert E. *The Master Plan of Evangelism*. Grand Rapids: Baker Books, 1993.

Fernando, Ajith. *Jesus Driven Ministry*. Wheaton, Illinois: Crossway, 2002.

Pentecost, J. Dwight. *The Words and Works of Jesus Christ*. Grand Rapids: Zondervan, 1981.

Robertson, A. T. *Harmony of the Gospels*. New York: Harper & Row Publishers, 1922.  
Available online at <http://www.gutenberg.org/files/36264/36264-h/36264-h.htm>



## Даалгаврын тэмдэглэл

Суралцагчийн нэр \_\_\_\_\_

Доорх хүснэгтэд даалгавруудыг бүрэн гүйцэтгэсэн суралцагчийн овог, нэрийн эхний үсгийг тэмдэглэнэ. Shepherds Global Classroom байгууллагаас гэрчилгээ авахын тулд бүх даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн байх ёстой.

Хичээл	Даалгавар 1	Даалгавар 2	Даалгавар 3
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			

Shepherds Global Classroom байгууллагаас төгсөлтийн гэрчилгээ авах өргөдлийг манай [www.shepherdsglobal.org](http://www.shepherdsglobal.org) вебсайтаар орж бөглөх боломжтой. Суралцагчдынхаа өмнөөс өргөдөл илгээсэн багш, сургагч багш нарт SGC-ийн ерөнхийлөгч төгсөлтийн гэрчилгээг цахим хэлбэрээр илгээх болно.